

САНАЛЫН ТОВЬЁОГ

Хөрөнгө оруулалтын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ирүүлсэн санал

№	Байгууллага	Ирсэн бичгийн огноо, дугаар	Ирүүлсэн санал	Тусгасан эсэх
1.	Олон улсын валютын сан	2023.04.28	<p><u>Татварын асуудал</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд туссан хэд хэдэн заалтууд нь тухай салбарын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шууд тусгасан нь илүү байна. (энэ хуульд тусгахгүйгээр) Үүнд татварын асуудал орно: эдгээрийг Татварын ерөнхий хуульд тусгасан нь илүү тохиромжтой байна. 2. 15 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэдэгт бид эргэлзсээр байгаа - ийм төрлийн урамшуулал нь хөрөнгө оруулалт орж ирэхийг шийдэхэд шийдвэрлэх хүчин зүйл болдоггүй. 3. Хэрэв ийм дэмжлэг олгох бол, дэмжлэгийг сунгах цаашдын боломж байхгүй гэдгийг тодорхой тэмдэглэж, төсвийн эрсдэлийг хязгаарлахыг бид уриалж байна. 4. Хөрөнгө оруулагчийн татварын үүргийг үл ялиг хойшлуулж байгаа эсвэл орлогыг нь чөлөөлөх санаа байгаа эсэхийг тодруулах хэрэгтэй. 5. Мөн урамшууллын тухай 15 дугаар зүйл болон тогтворжуулах тухай зүйл заалтуудын хоорондын хамаарал тодорхойгүй байна. Төслийн уншигдах байдлаас харахад татварын дэмжлэг нь тогтворжуулах гэрчилгээтэй холбоогүй юм шиг харагдаж байна - энэ нь татварын дэмжлэгийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй гэсэн үг юм (жишээлбэл, хэзээ эхлэх вэ, цуцлах боломжтой эсэх гэх мэт). 6. “Элэгдлийн тооцох хялбаршуулсан арга”-ыг тайлбарлах нэмэлт заавар хэрэгтэй байна. Татварын ерөнхий газрын зүгээс хөрөнгө оруулагчдад тодорхой зохицуулалт, зааварчилгаа өгөх хэрэгтэй. 7. 29 дүгээр зүйлд хөрөнгө оруулагчдыг тэнд заасан процессуудаас урьдчилсан сэргийлж, мөн оронд нь хэлэлцээрийн эсхүл арбитра хандах үүднээс одоо мөрдөж буй татварын хуулийн маргаан шийдвэрлэх механизмын чухлыг тэмдэглэх хэрэгтэй. 8. 17 дугаар зүйлд тогтворжиж байгаа татварын “хэмжээ” гэж юуг хэлээд байгаа нь тодорхойгүй байна. Энэ нь эрх бүхий байгууллагад тооцдог татварын өр төлбөрийн урьдчилсан тооцооллыг шаардаж болзошгүй. Энэ “хэмжээ” гэснийг хасаж, тогтворжуулах ажлыг зөвхөн татварын хувь гэдэг үгээр ашиглах. 9. 17-р зүйлийг сайжруулах боломж гэвэл захиргааны арга хэмжээг сайжруулах нь тогтворжуулагдахгүй гэдгийг тодорхой зааж (энэ нь шилжүүлгийн үнийн удирдамжийг шинэчлэх гэх мэт хөрөнгө оруулагчийн төлөгдөх татвар нэмэгдүүлж болзошгүй), мөн Засгийн газар олон улсын хөгжилтэй уялдуулан шинэ татварыг ногдуулах эрхээ хэвээр хадгалах (жишээ нь, Хүртээмжтэй тогтолцооны процессын дагуу аж ахуйн нэгжийн татварын доод хэмжээг хэрэгжүүлэх гэх мэт). 10. 23 дугаар зүйлд (тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох) Татварын ерөнхий газар 	<ol style="list-style-type: none"> 1. Саналыг авч, хуулийн төсөлд туссан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтыг хассан. Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд татвар төлөгчид үзүүлж болох дэмжлэгийг тодорхойлсон бөгөөд тухайлсан дэмжлэгүүд холбогдох татварын хууль тогтоомжид тодорхойлогдсон байгаа. 2. Саналыг авсан. Татвар төлөх хугацааг хойшлуулаагүй. 3. Саналыг авч, татвар төлөх хугацааг хойшлуулаагүй. 4. Саналыг авч, татвар төлөх хугацааг хойшлуулаагүй. 5. Саналыг авч, татварын дэмжлэгийг урамшуулал гэж нэрлэн, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд татварын хувь хэмжээг тогтворжуулах дэмжлэгийг л үзүүлэх, энэхүү дэмжлэг үзүүлэх хугацаа гэрчилгээ олгогдсон өдрөөс эхлэн, гэрчилгээний хүчинтэй хугацаанд үзүүлнэ гэж төсөлд тусгасан. 6. Санал 1-д заасны дагуу татварын харилцааг татварын хуулиар зохицуулахаар тусгасан. Энэ хүрээнд элэгдэл тооцох асуудлыг ААНОАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан зарчмаар тодорхойлно. 7. Захиргааны журмаар шүүхийн онцгой харьяалалтай маргааныг шууд арбитра хандахгүй тул санал туссан. 8. 8.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд татвар ногдуулах хувь гэснийг татварын хувь, хэмжээ гэж тодорхойлсон байдаг тул саналд

			<p>холбогдох бүх татварыг төлж, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдсөнийг баталгаажуулах ёстой гэсэн заалтыг оруулснаар сайжруулах боломжтой (8 дугаар зүйлд хөрөнгө оруулагчийн хүлээх үүрэгтэй уялдуулж).</p> <p><u>Бусад асуудлууд (татвартай холбоогүй)</u></p> <p>11. 18 дугаар зүйлд “үүсмэл орд” гэсэн тодорхойлолтыг (ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдуулах нөөц ашигласны төлбөрийн хүрээнд) тодорхой болгох.</p> <p>12. Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурын талаар нэмэлт заавар шаардлагатай байна. (жишээ нь: “нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл эрхлэн, үндсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа” хөрөнгө оруулагч гэж юуг ойлгох вэ).</p>	<p>дурдсан шиг татварын өрийн асуудал үүсэхгүй.</p> <p>9. Саналыг авсан ба зөвхөн татварын хуульд заасан татвар ногдуулах хувь хэмжээнээс бусад нөхцөл тогтворжих зохицуулалт тусаагүй. Бусад татварын харилцааг татварын хуулиар зохицуулна гэж заасан.</p> <p>10. Татварын асуудал нь хөрөнгө оруулалт хийгдэх хугацаанд олгогдох бөгөөд хөрөнгө оруулалтаа хийж чадаагүй бол татварын асуудал үүсэхгүй. Нөгөө талаас хууль бус үйлдлийн улмаас татвар тогтворжуулах гэрчилгээ авсан тохиолдолд энэ нь эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээх үндэслэл болох тохиолдолд улсад учруулсан хохирлыг нөхөн төлөх нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэнэ. Иймд энэ төрлийн заалт шаардлагагүй.</p> <p>11. Энэ тодорхойлолт нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.27-д тодорхойлогдсон тул давхардуулан тодорхойлох шаардлагагүй.</p> <p>12. Саналын дагуу тогтворжуулах гэрчилгээний нөхцөл, шаардлагыг илүү ойлгомжтой болгосон. Энэ төрлийн шалгуурыг төслөөс хассан.</p>
2.	Дэлхийн банк	2023.05.09	<p>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАМГААЛАЛТЫН НЭГЖ Нэр томьёоны тодорхойлолт</p> <p>1. Хуульд хамруулсан хөрөнгө оруулалт (шууд хөрөнгө оруулалт/ГШХО) болон хуульд хамруулаагүй (багцын хөрөнгө оруулалт) хоёрыг тодорхой ялгахын тулд “шууд” болон “багцын” гэсэн нэр томьёог оруулах нь зүйтэй. Багцын хөрөнгө оруулалт нь ГШХО-аас тэс өөр бодлого, зохицуулалтын асуудлуудыг бий болгодог бөгөөд ихэвчлэн хөрөнгө оруулалтын хуулийн ач холбогдолтой сэдэв биш юм.</p> <p>2. “Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн тодорхойлолтыг улам дэлгэрэнгүй болгох боломжтой. Шууд бус өмчлөлийн талаар илүү өргөн хүрээтэй тодорхойлолт оруулснаар Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өргөн хүрээг хамрах юм.</p> <p>Хөрөнгө оруулалт хийх эрх</p> <p>3. “Хөрөнгө оруулах эрх”-тэй холбоотой заалтуудыг нэг бүлэгт нэгтгэх (3.2, 7.1.1, 7.1.2, 7.1.3)</p> <p>4. Хуулийн төслийн “сөрөг жагсаалт”-ын хандлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг</p>	<p>1. Саналыг авч, шууд хөрөнгө оруулалтыг тодорхойлсон.</p> <p>2. Шууд бусаар эзэмших гэсэн ойлголт нь манай улсын хуульд татварын хууль тогтоомжид хэрэглэгдэж байгаа бөгөөд уг хэвшсэн ойлголтыг тусгайлан нэмж тодорхойлох шаардлага байхгүй.</p> <p>3. Саналыг авч, хуулийн төслийн бүтцэд өөрчлөлт оруулсан.</p> <p>4. Саналыг тусгасан бөгөөд сөрөг жагсаалтыг хуулиар батлах, улмаар уг жагсаалтын талаар мэдээлэх чиг үүргийг төсөлд тусгасан.</p> <p>5. Үндэсний нөхцөлд буюу үл ялгаварлах зарчмыг төсөлд тусгасан. Тодруулбал,</p>

		<p>тодорхой болгох нь зүйтэй. Үүнд жагсаалт гаргах, хэрэгжүүлэхэд анхаарах</p> <p>Хөрөнгө оруулалтын баталгаа</p> <ol style="list-style-type: none"> 5. Гадаадын хөрөнгө оруулагчдыг ялгаварлан гадуурхахаас хамгаалах үүднээс өргөн хүрээтэй үндэсний нөхцөл, нэн тааламжтай үндэсний нөхцөлийг хуульд тусгах нь зүйтэй. Хуулийн төслийн ялгаварлан гадуурхахгүй байх тухай заалтуудыг тодорхой болгох шаардлагатай. Бодлогыг хэрэгжүүлэх орон зайг хангах үүднээс тодорхой үл хамаарах зүйлсийг тусгах шаардлагатай. 6. Цаашид тус хуульд Шударга, эрх тэгш харьцах (ШЭТХ) заалтыг тусгах нь зүйтэй. ШЭТХ заалт нь гадаадын хөрөнгө оруулагчдад олгодог гол баталгаануудын нэг бөгөөд энэ нь хөрөнгө оруулалт авч буй улсуудын дур зоргоороо авирлах үйлдлүүд, ялгаварлан гадуурхах, зүй бус үйлдэл гаргах ноцтой тохиолдлуудаас хөрөнгө оруулагчдыг хамгаалах бөгөөд ил тод байдал, зохих журмын баталгааг хангадаг. Хөрөнгө оруулалтын баталгааны тодорхойлолтын өргөн хүрээнээс урьдчилан сэргийлэх үүднээс нэмэлт тайлбар, зөрчлийн жишээний жагсаалт эсвэл олон улсын хууль журмын стандартын лавлагааг агуулсан мэргэшлийг нэмэх шаардлагатай. Хуулийн төсөлд ШЭТХ-ын зарим зарчмуудыг тусгасан боловч нэр томъёоллын хувьд тодорхойгүй, гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй байх магадлалтай тул хөрөнгө оруулалтын хамгаалалтын түвшний талаар тодорхойгүй байдлыг үүсгэж болзошгүй юм. 7. Түгээмэл хэрэглэгддэг “Сайн туршлагын” заалтуудыг тусгаснаар хуулийн төсөлд өмч, хөрөнгийг дайчлан хураахаас сэргийлэх заалтуудыг цаашид улам бэхжүүлэх боломжтой. Ялгаварлан гадуурхахгүй байх тухай заалтыг хууль ёсны дагуу өмч, хөрөнгийг дайчлан хураах шалгуур болгон нэмж, нөхөн төлөлт нь шуурхай, хангалттай, үр дүнтэй байх тухай тусгах шаардлагатай. Түүнчлэн өнөөдрийн байдлаар хамгийн түгээмэл өмч хөрөнгө хураах хэлбэр болсон өмч хөрөнгийг шууд бусаар хураан авах үйл ажиллагаанаас хамгаалах заалтыг хуульд тодорхой тусгах хэрэгтэй. Энэ нь төрөөс тухайн эд хөрөнгийг битүүмжлээгүй, өмчлөх эрх хөндөгдөөгүй байсан тохиолдолд ч хөрөнгө оруулагч эд хөрөнгийг ашиглах, хөрөнгөөс ашиг хүртэхэд хөндлөнгөөс оролцох явдал юм. 8. Хуулийн төсөл дэх сэдвийн дэс дарааллыг илүү уялдаатай болгох үүднээс 3-р бүлгийн зарим заалтыг 2-р бүлэгт багтааж болно. Энэ нь ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдад санал болгож буй хөрөнгө оруулагчийн аливаа эрх/баталгааны тухай заалтуудад хамаарна (7.1.4, 7.1.5-д хөрөнгө, орлого шилжүүлэхтэй холбоотой; 7.1.8, 7.1.10-д заасан ШЭТХ-н ерөнхий стандартын ил тод байдал, мэдээлэл олж авах, зохих журмын дагуу ажиллахтай холбоотой). 9. Хязгаарлагдмал тооны нарийн боловсруулсан онцгой нөхцөлт заалтуудыг хуулийн төсөлд оруулж болно. Ийм заалтууд нь хөрөнгө оруулалтын хамгаалалтыг төрийн бодлогын зохицуулалттай тэнцвэржүүлэх зорилготой. 10. 6.1.4-д хөрөнгө оруулагчид болон төрийн байгууллагын хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг арбитрын шүүхэд өгөх эрхийг олгосон байна. Хөрөнгө оруулагчийн маргааны тухай тусгайлсан 10 дугаар бүлэг байгаа тул энэ заалтыг тус үндсэн бүлэгт багтаан шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. 11. 6.2.1.-т хөрөнгө оруулагчдад татварын тогтворжуулах гэрчилгээ олгох буюу Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын хувь хэмжээг тогтвортой байлгах 	<p>хөрөнгө оруулалтыг дайчлан авахад энэ төрлийн зарчмыг хангах нөхцөлийг хуульчилсан.</p> <ol style="list-style-type: none"> 6. Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулах тухай заалтыг тусгасан нь шударга, эх тэгш хандах нөхцөлийг тусгасан. 7. Саналыг авч, төсөлд тусгасан. 8. Саналыг авч, хуулийн төслийн бүтцэд өөрчлөлт оруулсан. 9. Тусгасан. 10. Тусгасан. 11. Тусгасан. 12. Тусгасан 13. Агуулгын хувьд тусгасан. 14. Агуулгын хувьд тусгасан. 15. Хөрөнгө оруулалтаас татгалзах нөхцөл нь хуульд заасан үндэслэл байхаар заасан. 16. Агуулгын хувьд тусгасан 17. Сөрөг жагсаалт гаргах эрх нь УИХ-хуулиар олгогдох ба энэ талаар нийтэд мэдээлдэг байхыг төсөлд тусгасан. 18. Агуулгын хувьд тусгасан 19. Саналыг авч, хөрөнгө оруулалтыг тусгайлсан нэмэлт урамшууллаас илүүтэй татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг тусгасан. 20. Агуулгын хувьд тусгасан 21. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу
--	--	--	--

		<p>баталгааг хангах тухай заасан байна. Хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах тухай тусгайлсан 6-р бүлэг байгаа тул энэ заалтыг үндсэн бүлэгт шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.</p> <p>Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг</p> <p>12. Хуулийн төсөл дэх сэдвийн дэс дарааллыг илүү уялдаатай байлгах үүднээс 3-р бүлгийн зарим заалтыг 2-р бүлэгт багтааж болно. Энэ нь ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдад санал болгож буй аливаа хөрөнгө оруулагчийн эрх/баталгаатай заалтуудад хамаатай.</p> <p>13. Мөнгөн хөрөнгийг чөлөөтэй шилжүүлэхтэй холбоотой 7.1.4, 7.1.5 заалтууд.</p> <p>14. Шударга, эрх тэгш хандах ерөнхий стандарттай холбоотой ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохих үйл явцтай холбоотой 7.1.8, 7.1.10 заалтууд</p> <p>Зах зээлд нэвтрэх</p> <p>15. Хуулийн төсөлд хөрөнгө оруулалт хийх ерөнхий эрхийг тусгасан байна. 7.1.1, 7.1.2, 7.1.3-р заалтууд нь Монгол Улсын хуулиар хориглоогүй салбар, үйлдвэрлэл, үйл ажиллагаа болон/эсвэл үйлчилгээнд хөрөнгө оруулагчид чөлөөтэй хөрөнгө оруулалт хийх боломжтойг төрөл бүрийн хэлбэрээр заасан байна. Энэ нь сайн туршлагатай нийцэж байгаа бөгөөд нийтлэг зарчмын дагуу хөрөнгө оруулах эрх байх тухай зөвлөдөг хэдий ч засгийн газрууд үл хамаарах зүйл болгон санал болгож буй хөрөнгө оруулалтыг хоёр үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж болно. Үүнд (i) төрийн үзэмжээр үндэсний аюулгүй байдлын тодорхой шаардлагуудтай нийцэхгүй байгаа хөрөнгө оруулалт; эсхүл (ii) улсын эдийн засгийн хөгжлийн зорилтууд эсвэл үндэсний ашиг сонирхлын хатуу шаардлагаас үүдэн тус улсын хууль тогтоомжоор зөвхөн тус улсын иргэдэд хамаарах салбаруудад хамаарах хөрөнгө оруулалтыг татгалзаж болно. Хуулийн хамрах хүрээний 3.3.2 дугаар заалт</p> <p>16. Мөн хуулийн хамрах хүрээний 3.3.2-т хөрөнгө оруулах эрхийн тухай тусгасан байна. Эдгээр заалтуудыг "Хөрөнгө оруулах эрх"-н тухай нэг бүлэгт нэгтгэх боломжтой.</p> <p>17. Өмнөх хуулийн төслийн найруулгад ГШХО-ыг хязгаарласан салбар, үйл ажиллагааны жагсаалтыг ("сөрөг жагсаалт" гэх) боловсруулах үйл явцын талаар дурдсан байсан. Одоогийн хуулийн төсөлд ийм заалт, хориглосон/хязгаарлагдсан салбарын жагсаалт багтаагүй байна. Ийм төрлийн "сөрөг жагсаалт" ба/эсвэл энэ төрлийн бодлого, зохицуулалтаар гадаадын хөрөнгө оруулалтыг хориглосон, хязгаарласан салбаруудын талаар тодорхой заалт нэмж оруулахыг зөвлөж байна. Сөрөг жагсаалт нь аль болох товч бөгөөд тодорхой байх ёстой бөгөөд хязгаарлалтыг цуцалсан тохиолдолд хуулийн нэмэлт өөрчлөлт оруулдаг байх шаардлагатай. Энэ нь статик биш харин динамик процесс байх нь зүйтэй. Сөрөг жагсаалт нь нарийн тодорхой заасан (ямар нэг байдлаар тайлбарлах, гуйвуулах боломжгүй байдлаар), хамрах хүрээ, салбараар хязгаарлагдмал байх ёстой.</p> <p>Хөрөнгө оруулагчийн үүрэг</p> <p>18. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг нь хөрөнгө оруулагчийн үүрэгтэй холбоотой хэсгийг дахин боловсруулах, ХООУГ-ний шинэ чиг хандлага, тэдгээрийг дотоодын хууль тогтоомжид хэрхэн хөрвүүлэх зөвлөмжийг дагах,</p>	<p>гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан.</p> <p>22. Саналыг хүлээн авч, хөрөнгө оруулалтын урамшуулал олгох нөхцөлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаанаас хамаарахаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>23. Саналыг хүлээн авч, хөрөнгө оруулалтын урамшуулал олгох нөхцөлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаанаас хамаарахаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>24. Хөрөнгө оруулалтын бодлого нь хөрөнгө оруулалт татахаас гадна, үйл ажиллагаа явуулж хөрөнгө оруулсан хуулийн этгээдүүдийн татварын ачааллыг тооцох явдал байдаг. Энэ ч агуулгаар Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, харилцагчийг сонгох хүрээ хязгаарлагдмал байдлаас хамаарч гадаад зах зээлээс худалдан авалт хийх тохиолдолд төлөх татварын зардал нь үндсэндээ дотоодын татвар төлөгч нарын зардал болдог ба энэ зардал хасагдах зардалд ч орж чадахгүй. Иймд, дотоод бизнес эрхлэгч нарын гадаад зах зээлтэй харьцах зардлыг бууруулах бодлогыг төрөөс хэрэгжүүлж, оршин суугч бусын суутган татварын хэмжээг бууруулахаар төсөлд тусгасан.</p> <p>25. Тогтворжуулах гэрчилгээ нь хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулагч нараас энэ талаар зохицуулалтыг хэвээр үлдээх саналыг тавьж байгаа урамшуулал юм.</p> <p>26. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан</p>
--	--	--	--

			<p>хариуцлагатай бизнес эрхлэх, хөрөнгө оруулахтай холбоотой заалтуудыг нэмж оруулах шаардлагатай. Сүүлийн үед улс орнууд хариуцлагатай бизнес эрхлэх зарчим, стандартыг дотоодын хууль тогтоомждоо тусгайлан тусгах нь олширсоор байна. ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдэд зориулсан удирдамжид хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааны талаар иж бүрэн зөвлөмжийг гаргасан бөгөөд эдгээрийг дагаж мөрддөг 49 орны засгийн газар өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд мэдээллийн ил тод байдал, хүний эрх, хөдөлмөр эрхлэлт ба үйлдвэрлэлийн харилцаа, байгаль орчин, хээл хахууль. мөн авлига, хэрэглэгчийн эрх ашиг, шинжлэх ухаан, технологи, өрсөлдөөн, татвар. гэсэн үндсэн чиглэлээр удирдамж өгсөн.</p> <p>Хөнгөлөлт, урамшуулал олгох</p> <p>19. Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, урамшуулал нь улам бүр ГШХО авах өрсөлдөөний түгээмэл ашиглагддаг хөшүүргийн хэрэгсэл болсон ч олон улсын судалгаанууд хөрөнгө оруулалтын урамшуулал нь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргахад нөлөөлдөг гол хүчин зүйлийн тоонд ордоггүй болохыг харуулсан байна. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахдаа тухайн улсын улс төрийн тогтвортой байдал, зах зээлийн хэмжээ, дэд бүтэц, хүний нөөцийн хүртээмж, хууль эрх зүйн зохицуулалтын бодлого, байгууллагын чадавх зэрэг өргөн хүрээний эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчны хүчин зүйлс дээр суурилдаг болохыг эмпирик судалгаа харуулж байна.</p> <p>20. Хэрэв хөнгөлөлт, урамшуулал нь зах зээлийн тодорхой доголдлыг арилгахад тохиромжтой хэрэгсэл гэж үзвэл урамшууллыг хуульд зааснаар олгох ба:</p> <ul style="list-style-type: none"> - Бодлогын зорилтуудыг тодорхой, нарийвчилсан байдлаар тусгасан байх; - Хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах ил тод, шударга шалгууртай байх; - Шуурхай, хялбар хэлбэрээр олгодог байх (татварын урамшууллын хувьд автомат системээр); - ДХБ-ын Татаас ба Нөхөх арга хэмжээний тухай хэлэлцээр (SCM) болон Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (TRIMS) зэрэг хөрөнгө оруулалтын олон улсын дэглэмийг дагаж мөрдөх; болон - Хөнгөлөлт, урамшууллын хөтөлбөрүүд нь үр дүнтэй, зорилгодоо хүрч байгаа эсэхийг үнэлэх, хянах тогтолцоотой байх. <p>21. Хөнгөлөлт, урамшууллыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд бус Татварын тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах нь зүйтэй. Хөнгөлөлт, урамшууллыг Татварын тухай хуульд тусгах нь жил бүрийн төсвийн үйл явцын нэг хэсэг болгон хянан шийдвэрлэх хууль тогтоох байгууллагын үүрэг, татварын албанаас урамшууллыг үр дүнтэй хянах, удирдах зэргийг баталгаажуулах ач холбогдолтой. Хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд холбогдох хуулиудыг дурдаж болно.</p> <p>22. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын хөшүүргийг зайлшгүй тусгах шаардлагатай гэж үзвэл урамшууллын зарчмыг тусгаж, дэлгэрэнгүй зүйлсийг хууль тогтоомж хэрэгжүүлэх журамд тусгах нь зүйтэй. Урамшууллын зохицуулалтын</p>	<p>татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан.</p> <p>27. Саналыг хүлээн авч, хөрөнгө оруулалтын урамшуулал олгох нөхцөлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаанаас хамаарахаар хуулийн төсөлд тусгасан. Өөр нэмэлт нөхцөл буюу хүний үзэмжээс хамаарч дүгнэх нөхцөл байхгүй.</p> <p>28. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Хөрөнгө оруулалтын урамшуулал олгох нөхцөлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаанаас хамаарахаар хуулийн төсөлд тусгасан.</p> <p>29. Татварын хувь хэмжээний тогтворжуулалт нь хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулагч нараас энэ талаар зохицуулалтыг хэвээр үлдээх саналыг тавьж байгаа урамшуулал юм. Энэ төрлийн урамшууллыг олон төсөл хэрэгжүүлэх этгээдийн хувьд төслийн үйл ажиллагааг туслаа тайлагнах нөхцөлийг ААНОАТ-ын тухай хуульд заасан. Энэ нь ашигт малтмал газрын тос болон эрчим хүчний төслийн хувьд төсөл тус бүрээр тайлагнах зохицуулалттай байдаг.</p> <p>30. Саналыг авч, хөрөнгө оруулалтыг дэмжлэг гэснийг хөрөнгө оруулалтын урамшуулал болгосон. Түүнчлэн</p>
--	--	--	---	--

		<p>үндсэн зарчмууд дараах зүйлсийг агуулна.</p> <p>23. Мөн хуулийн одоогийн төсөлд хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах салбар, хөрөнгө оруулагчдад тавигдах шаардлага, үндэслэлийн талаар тодорхой тусгаагүй байна. Урамшуулал олгох үйл явц нь үзэмжээр явагддаг байдал нь Монгол Улсад тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахгүй хэмээн үзэж байна.</p> <p>24. 2023 оноос эхлэн дэлхийн хэмжээнд татварын доод хэмжээний шинэ зарчим хэрэгжиж эхлэх тул Монгол Улс хөнгөлөлт, урамшууллын бодлогын хүрээгээ эргэн харж, өөрчлөгдөж буй эдийн засгийн орчинтой нийцүүлэх шаардлагатай. Үүнд (i) одоогийн хэрэгжиж буй татварын бүх хөнгөлөлт, урамшууллууд болон тэдгээрт хамрагдаж буй байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ, урамшууллын татварын орлогод нөлөөлсөн байдал зэргийг багтаасан зураглал, (ii) татварын доод хэмжээ хэрэгжиж эхлэхтэй холбоотой Монголын одоогийн хөрөнгө оруулагч нарт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, (iii) хөрөнгө оруулалтыг татах хөшүүргийн үр нөлөөг орлогын алдагдалтай харьцуулан авч үзэх, ялангуяа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд болон бусад урамшууллууд хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй болно (iv) тодорхой хугацаанд урамшуулал олгох, шаардлагатай бол хуулийн зөвлөгөө авах хуулийн үүрэг хүлээсэн бүх тохиолдлыг тодорхойлох. Сүүлийн (iv) зүйл буюу татварын хөнгөлөлт, урамшуулал гэдэгт одоо байгаа хөрөнгө оруулагчдад аль хэдийн олгосон татварын тогтворжуулалтын гэрчилгээг мөн хамруулсан болно.</p> <p>25. Дэлхийн татварын доод хэмжээний зарчимтай нөхцөлд татварын хувь хэмжээг тогтворжуулах гэрчилгээг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд тусгах нь үр дүнгүй бөгөөд улсын орлогыг үндэслэлгүй алдагдалд хүргэж болзошгүй тул эргэлзээтэй (доорх хэсгийг үзнэ үү).</p> <p>Хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах</p> <p>26. Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, урамшууллын тухай Хөрөнгө оруулалтын тухай хуульд бус Татварын тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах нь зүйтэй.</p> <p>27. Хуулийн төсөлд хөнгөлөлт, урамшууллын хяналт, удирдлагын хэд хэдэн зарчмыг тодорхой тусгаж болох бөгөөд үүнд урамшууллыг бодлогын тодорхой зорилтод хүрэхийн тулд боловсруулах, нарийн чиглүүлэх, урамшууллын ил тод зарчмуудтай байх, өөрийн үзэмжээр бус тодорхой шалгуур хангуулах, урамшууллыг оновчтой байдлаар удирдах, зардал/үр ашгийн шинжилгээнд үндэслэх болон Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг гэх мэт зарчмуудыг тусгаж болно.</p> <p>28. Хөнгөлөлт, урамшууллыг хөрөнгө оруулалтын тухай хуульд үлдээсэн тохиолдолд урамшуулалд хамрагдах салбар, тавигдах шаардлага, журмыг тодорхой болгох ёстой. Тогтворжуулалтын гэрчилгээ</p> <p>29. Бусад улс орнуудын туршлагаас үзэхэд итгэл үнэмшилтэй, үр дүнтэй татварын тогтворжуулалтын зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул татварын тогтворжуулалтыг эргэн харах хэрэгтэй. Ил тод үйл явцыг хангах, компани, хөрөнгө</p>	<p>хуулийн төсөл нь хөрөнгө оруулагч нарт үйлчлэх гэсэн гол үзэл баримтлалыг баримталж, төрийн байгууллагуудын хувьд бүрэн эрх биш, харин чиг үүргийн зохицуулалтыг бий болгож байгаа. Мөн төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхгүйг хянан шийдвэрлэх нарийвчилсан журмыг хуулийн төсөлд тусгасан.</p> <p>31. Саналыг авч, хөрөнгө оруулалтыг дэмжих гэсэн нэр томъёог тодорхойлж, улмаар энэ чиг үүргийг холбогдох төрийн байгууллагад даалгасан.</p> <p>32. Агуулгын хувьд тусгасан.</p> <p>33. Агуулгын хувьд тусгасан.</p> <p>34. Агуулгын хувьд тусгасан.</p> <p>35. Тусгасан. Хөнгөлөлт, урамшуулал нь холбогдох хууль тогтоомжийн дагуу олгогдох талаар тодорхой заасан.</p> <p>36. Саналыг тусгасан:</p> <p>37. Саналыг тусгаж, татварын бус урамшуулал нь холбогдох хуулийн дагуу олгогдохыг зааснаар хэрэгжүүлэх этгээдийг тодорхой болгосон.</p> <p>38. Саналыг тусгаж, төрийн байгууллага хөрөнгө оруулагчийн хооронд үүсэн үйл ойлголцлыг Засгийн газар сонсох, чиглэл өгөх асуудлыг хуулийн төсөлд тусгасан.</p> <p>39. Саналыг тусгасан. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, хэлэлцээрийн агуулга, чиглэл өгөх эрхийг Засгийн газарт, харин гэрээ байгуулах эрхийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон хөрөнгө оруулах салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батлахаар төсөлд тусгасан.</p> <p>40. Саналыг тусгасан. Мэдээллийг цуглуулах мэдээллийн санг хариуцах чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны</p>
--	--	---	--

			<p>оруулалт тус бүрд хамаарах тусгай хувь хэмжээг хянах нь ихэвчлэн бэрхшээлтэй байдаг.</p> <p>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГИЙН НЭГЖ</p> <p>Хөрөнгө оруулалтыг дэмжих болон хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагын үүргийг тодорхойлох</p> <p>Хөрөнгө оруулалтыг дэмжих:</p> <p>30. Нэр томъёоны бүлэгт Хөрөнгө оруулалтыг (“дэмжих” гэхээсээ илүү) Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, урамшуулал ” гэж өөрчлөхийг санал болгож байна . Мөн “Татварын болон татварын бус урамшуулал” гэхээсээ илүү өргөн хүрээтэй тодорхойлох ёстой гэж бид санал болгож байна. Дэлхийн татварын доод хэмжээ (GMT) зарчим нь татварт суурилсан хөрөнгө оруулалтын хөшүүргийн ач холбогдлыг багасгах тул олон улсад хөрөнгө оруулагчдад үйлчилгээний бусад хэлбэрийг санал болгоход илүү их анхаарал хандуулах болно. Иймд энэхүү тодорхойлолт болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд “хөрөнгө оруулагчийн үйлчилгээ”-г Монгол Улсын Засгийн газрын санал болгох гол зүйл гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж бид санал болгож байна. Мөн доорх саналуудыг үзнэ үү.</p> <p>31. Мөн 4 дүгээр бүлэгт “ Хөрөнгө оруулалтыг дэмжих гэж гадаадын шинэ хөрөнгө оруулалтыг татах, одоо байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг хадгалах, өсгөх зорилгоор явуулж буй маркетинг, мэдээллийн дэмжлэгийн үйл ажиллагааг ойлгоно” гэсэн шинэ тодорхойлолтыг нэмж оруулахыг санал болгож байна.</p> <p>Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (IPA):</p> <p>32. Хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагыг хууль ёсны дагуу бий болгохын тулд олон улсын шилдэг туршлагаар ихэвчлэн доорх хоёр аргын аль нэгийг ашигладаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагыг байгуулах, ажиллуулах санааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд ерөнхийд нь дурдах. Жишээ болгон 4-р бүлгийн нэг хэсэг болгон 11-р зүйлийг шинэчилснийг доор үзүүлсэн). Холбогдох хэрэгжүүлэх журмаар IPA-ийн нарийвчилсан чиг үүрэг, хэрхэн ажиллахыг нарийвчлан тодорхойлж болно; эсвэл - Хуульд IPA-г бий болгох тухай шинэ бүлэгт шаардлагатай бүх хэсгүүдийн хамт бүрэн зааж өгнө. <p>Сонголт i. Эхний хувилбар нь засгийн газарт анхан шатны хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр IPA-ны үйл ажиллагааны (нөхцөл өөрчлөгдөх тохиолдол бүрд зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд ихэвчлэн шаардлагатай байдаг) тохируулах илүү уян хатан боломжийг олгодог.</p> <p>33. 11 дүгээр зүйл нь шинээр санал болгож буй Хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэгтэй холбоотой юм шиг байна. Хэрэв тийм бол “Төрийн захиргааны байгууллага” гэсэн гарчиг нь ихээхэн төөрөгдүүлсэн. Энэ нь IPA-ийн үүрэг нь удирдлага, зохицуулалт байх болно гэдгийг хүчтэй илэрхийлж байгаа нь дээрх тодорхойлолт ноцтой зөрчилдөж байна. Дээр дурдсанчлан, дэлхийн хамгийн амжилттай IPA нь маркетинг, мэдээллийн дэмжлэг үзүүлэх байгууллагууд бөгөөд хөрөнгө оруулагчидтай идэвхтэй холбогдож, өөрсдийн байршлын ашиг тусын талаар ятгах чиг үүрэгтэй. Хөрөнгө оруулалтын тухай хуульд илүү үйлчилгээнд чиглэсэн IPA-г тусгах хэрэгтэй гэж бид зөвлөж байна.</p>	<p>байгууллагад олгосон бөгөөд, холбоотой мэдээллийг цуглуулах чиг үүргийг төрийн бусад байгууллагад мөн даалгасан.</p> <p>41. Саналыг авч, орон нутаг нь хөрөнгө оруулагчтай хамаатай асуудлыг шийдвэрлэх механизмыг төсөлд тодорхой болгов. Мөн орон нутаг нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироох бол энэ талаар дээд шатны байгууллага, Засгийн газрын түвшинд асуудлыг авч хэлэлцдэг байх журмыг тусгалаа.</p> <p>42. Саналыг авч, дипломат төлөөлөгчийн газар нь хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах нөхцөлийг тусгасан.</p> <p>43. Саналыг авсан. Сөрөг жагсаалт гаргах эрх нь УИХ-д хуулиар олгогдох ба энэ талаар нийтэд мэдээлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхаар төсөлд тусгасан.</p> <p>44. Саналыг зарчмын хувьд авсан. Хөрөнгө оруулалтыг оруулж ирэх татах тохиолдолд тавигдах шаардлагыг ТЭЗҮ түвшинд ирүүлэх боломжтой байхаар тусгасан. Харин хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хяналтыг холбогдох тайлан, мэдээллээр гаргуулдаг байхаар хялбаршуулсан.</p> <p>45. Саналыг авч, шууд бус хөрөнгө оруулалтын тодорхойлолтыг тусгасан бөгөөд богино хугацааны хөрөнгийн зах зээл дээрх худалдан авалтыг энэ төрлийн хөрөнгө оруулалтад хамаарахгүй байхаар төсөлд тусгасан.</p> <p>46. Санал зарчмын хувьд туссан. Өөрт хамаарах хөрөнгийг гэж тодорхойлсон.</p> <p>47. Саналыг хүлээн авч, засвар хийсэн.</p> <p>48. Саналыг авч, хөрөнгө оруулалтыг бодитоор хийсэн гэсний шалгуурыг</p>
--	--	--	---	---

		<p>34. 11-р зүйлийн хувьд бид дараах зүйлийг санал болгож байна.</p> <ul style="list-style-type: none"> - 11 дүгээр зүйлийг “Монгол Улсын Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн үүрэг хариуцлага” гэж нэрлэх (11.1 дэх заалтын нэрийг мөн өөрчлөх). - 11.1.1-д заасныг дараах байдлаар дэлгэрүүлэх: “гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. IPA нь хөрөнгө оруулагчдад чиглэсэн мэдээлэл бэлтгэж, Монгол Улсыг ирээдүйн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын газар болгон сурталчлахад ашиглана”. - IPA-аас хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэгийг мэдээлэл, тусламж, сурталчилгаа зэрэг хөрөнгө оруулагчийн үйлчилгээ хэлбэрээр илэрхийлэх шаардлагатай. Доорх хавсралт нь энэ сэдвээр нэмэлт мэдээллийг агуулсан болно. 11.1.3-т "хөрөнгө оруулалтыг төлөвлөх, байгуулах, ажиллуулах, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтаа хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар хөрөнгө оруулагчдыг дэмжих" гэсэн хэсгийг тусгах нь зүйтэй гэж бид зөвлөж байна. <p>35. 5-р бүлэгт хөрөнгө оруулалтыг дэмжих тухай тусгасан боловч энэ нь үнэн хэрэгтээ хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, урамшууллын тухай бүлэг юм. Дээр дурдсанчлан болон ДБГ-ын өмнөх санал, зөвлөмжүүдэд дурдсанчлан эдгээр хоёр зүйл ижил биш юм. Бид 5-р бүлгийг “ Хөрөнгө оруулалтын урамшуулал” гэж нэрлэхийг зөвлөж байна . Мөн энэ бүлэгт татварын хөнгөлөлтийг ямар “төрийн захиргааны байгууллага” хэрэгжүүлж, батлахыг тодорхой тусгах ёстой. Энэ нь IPA байж болохгүй.</p> <p>36. Дэлхийн шилдэг туршлагаар ихэвчлэн татвар, гаалийн хөнгөлөлт, урамшууллын нарийн зүйлийг, тэдгээрийг хэрхэн зохицуулахыг холбогдох Татварын тухай хууль, Гаалийн тухай хуулиудад тодорхойлдог. Бид дараах байдлаар өөрчлөлт оруулахыг санал болгож байна. Үүнд, "Хөрөнгө оруулалтын урамшуулал" нэртэй болгосон 5-р бүлэгт (i) үндэсний татвар, гаалийн хууль тогтоомжид заасан татварын болон татварын бус хөнгөлөлтийг хөрөнгө оруулагчдад санал болгоно гэсэн заалт, (ii). төрийн аль байгууллага энэ төрлийн хөнгөлөлт, урамшууллыг удирдаж, батлах талаар заалт оруулах. Энэ нь IPA байж болохгүй.</p> <p>37. Мөн 5-р бүлэгт татварын бус хөнгөлөлт, урамшууллыг аль байгууллага хэрэгжүүлж, батлах талаар тодорхой заах шаардлагатай.</p> <p>(iii) Бусад байгууллагууд:</p> <p>38. Засгийн газар хөрөнгө оруулалт, түүнтэй холбоотой бодлого боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавихын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад тулгамдаж буй чухал асуудлуудыг сонсож, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад манлайлан оролцох нь зүйтэй.</p> <p>39. Гэтэл Засгийн газар хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, хувь хүний Хөрөнгө оруулалтын гэрээг батлах зэрэг үйл ажиллагааны байгууллагаар ажиллах нь учир дутагдалтай хүнд суртлын хэлбэр юм. Тухайлбал, 24.10-т Засгийн газрын тогтоолоор батлах ёстой Хөрөнгө оруулалтын гэрээг батлах журмыг дээд түвшинд батлах болон төрийн захиргааны төв байгууллагад (IPA биш). шилжүүлэх ёстой хөрөнгө оруулагчидтай ганцаарчилсан гэрээг зөвшилцөх, батлах үйл ажиллагааны чиг үүргийг хооронд нь ялгах шаардлагатай.</p> <p>40. Үүний нэгэн адил, 10.2-т мэдээлэл цуглуулах журам, зохицуулалтыг Засгийн газрын холбогдох гишүүн (холбогдох хэлтэс хоорондын хамтын ажиллагааг хангахаас гадна)</p>	<p>төсөлд тусгасан.</p> <p>49. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшууллыг ААНОАТ болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тус тус заасан.</p> <p>50. Саналд тусгасан зөвшөөрөл нь төслийн 16.1.3-т тодорхойлогдсон.</p> <p>51. Хөрөнгө оруулалтыг төсөлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч хөрөнгө оруулалтыг урамшууллыг олгохоор заасан. Манай улсын хувьд олон төсөл хэрэгжүүлэх этгээдийн хувьд төслийн үйл ажиллагааг туслаа тайлагнах нөхцөлийг ААНОАТ-ын тухай хуульд заасан. Энэ нь ашигт малтмал газрын тос болон эрчим хүчний төслийн хувьд төсөл тус бүрээр тайлагнах зохицуулалттай байдаг. Иймд хөрөнгө оруулалт ихээхэн хийгдэх салбарын хувьд зохицуулалт тодорхой. Нөгөө талаар зөвхөн татвар ногдуулах хувь хэмжээний хувьд урамшуулал яригдах тул бусад төслийн хувьд энэ нь хүндрэл байхгүй. Тусгайлан хөрөнгө оруулагчид зориулсан татварын дэглэм гэж байхгүй.</p> <p>52. Саналыг хүлээн авч, тогтворжуулах гэрчилгээ олголтыг цахимаар хэрэгжүүлнэ.</p> <p>53. Хөрөнгө оруулалтын гэрээгээр тохирох асуудал нь татварын хувь хэмжээг хамгийн багадаа 20 ба түүнээс дээш жилийн хугацаанд буюу санал болгож байгаа төслийн хугацаанд тогтворжуулах нөхцөл гэж ойлгож болно. Энэ агуулгаар төрийн санхүү, төсвийн бодлогод 20 ба түүнээс дээш жил нөлөөлөх боломжтой төслийн талаар Засгийн газарт заавал танилцуулдаг байх нь зүйтэй бөгөөд</p>
--	--	--	--

		<p>батлах нь зүйтэй боловч тогтмол мэдээлэл цуглуулах үүргийг үйл ажиллагааны байгууллагад шилжүүлэх нь зүйтэй.</p> <p>41. 13 дугаар зүйлд орон нутгийн засаг захиргааны үүргийн талаар хоёр заалт нэмж оруулахыг санал болгож байна: Нэгдүгээрт, орон нутгийн зохицуулалтын өөрчлөлтөөр хөрөнгө оруулагчдад гомдол, маргааны түвшинд хүрэх хохирол учруулахгүй байхыг орон нутгийн засаг захиргаанаас дэмжих, хоёрдугаарт орон нутгийн засаг захиргааг гарч буй аливаа асуудлыг шийдвэрлэх, хурцадмал байдлаас зайлсхийхийн тулд үндэсний хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагатай хамтран ажиллах, дэмжихийг санал болгож байна.</p> <p>42. Үндэсний хөрөнгө оруулалтыг дэмжих төлөвлөгөөтэй нийцэхийн тулд 14-р зүйлд, Дипломат төлөөлөгчийн газруудын хөрөнгө оруулалтыг дэмжих, ялангуяа хөрөнгө оруулалтыг дэмжих аливаа арга хэмжээ, зорилтот зах зээлийн хөрөнгө оруулагчидтай харилцахтай холбоотой ажлыг үндэсний хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагатай уялдуулан зохицуулах ёстой. “ Монгол Улсаас хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрууд нь хөрөнгө оруулалтыг дэмжих үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан сурталчлах бүхий л үйл ажиллагааг явуулахын тулд хөрөнгө оруулалтыг дэмжих үндэсний байгууллагатай хамтран ажиллана ” гэсэн шинэ заалт оруулахыг зөвлөж байна .</p> <p>(iv) Бусад санал</p> <p>43. Хөрөнгө оруулалтыг анхлан оруулах: сөрөг жагсаалттай байх нь хамгийн сайн туршлага гэж тооцогддог. Гэсэн хэдий ч энэ жагсаалт юу болох талаар дурдаагүй байна. Сөрөг жагсаалтыг хаана, хэрхэн боловсруулах, нөхцөл байдал өөрчлөгдөхөд хэрхэн шинэчлэх тухай хуульд зааж өгөх шаардлагатай.</p> <p>44. Энэхүү хуулийн төсөлд хөрөнгө оруулалтыг шалгах буюу скринингийн ажлыг төрийн өндөр түвшинд хийхээр тусгасан. Энэ нь сайн туршлага биш юм. Шилдэг туршлагауд нь скрининг хийх шалгуурыг бодитой, бүрэн урьдчилан таамаглахуйц байдлаар тодорхойлсон байх бөгөөд ингэснээр нөхцөл хангагдсан тохиолдолд автомат зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагааны түвшинд ийм шалгуурын дагуу скрининг хийх боломжтой юм.</p> <p>45. Хөрөнгө оруулагчийн худалдан авсан хувьцаа, бонд болон бусад төрлийн үнэт цаас (5.1.2-р зүйл) нь нийт эзэмшлийн 10 хувиас хэтрэхгүй тохиолдолд гадаадын шууд хөрөнгө оруулалтад хамаарахгүй. Олон улсад ихэнх үндэсний Хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагууд ийм багцын хөрөнгө оруулалтыг сурталчилдаггүй, харин бодит салбарын хөрөнгө оруулалтад анхаарлаа хандуулдаг.</p> <p>46. Мөн 6.2.5-д бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтын төсөл эсвэл бүх компанийг худалдах замаар хөрөнгийг хөрөнгө оруулалт хүлээн авсан улсад нь бүрэн буцаан шилжүүлэх талаар тодорхой зааж өгөх ёстой.</p> <p>47. 6.2.6-р зүйл – бичвэрийн алдаа гэж бидний үзэж байгаа “үгүй” гэсэн үгийг сүүлийн мөрнөөс устгана уу.</p> <p>48. 8.1.8-д заасан “бодит” гэдэг үгийн утгыг тодруулахын тулд тодорхойлох шаардлагатай.</p> <p>49. Татварын тогтворжуулах нөхцөл, зохицуулалтын нарийн зүйлсийг Хөрөнгө оруулалтын тухай хууль гэхээсээ илүүтэй тус тусын Татварын хууль болон холбогдох хууль тогтоомжид тусгах нь зүйтэй.</p> <p>50. 16.1.6-д хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг нэмэх.</p>	<p>энэ талаар хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар шийдвэр гаргах нь Үндсэн хууль, Төсвийн хууль болон холбогдох бусад хуультай нийцэхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.</p> <p>54. Саналыг хүлээн авч, татварын зарчмын хувьд хүлээн авч хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгана гэж тодруулсан. Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшууллыг ААНОАТ болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тус тус заасан. ААНОАТ-ын хууль нь хөрөнгө оруулагчийг үл ялгаварлах зарчмаар бүх татвар төлөгчдөд ижил нөхцөлөөр хэрэгжих тул ялгаатай зохицуулалт тусгах нь тохиромжгүй. Нөгөө талаар татварын хасалт хийх, элэгдэл хорогдол тооцох зэрэг асуудлыг өөрчлөх бол энэ нь зарчмын шинжтэй өөрчлөлт бөгөөд сангийн яамны эрхлэх асуудал буюу татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх явцад хийгдэх учиртай. Хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар энэ төрлийн зохицуулалтын үр нөлөөний талаар судлаагүй тул татварын элэгдэл тооцох нөхцөл өөрчлөх нь хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй байна.</p> <p>55. Саналыг тусгаж, өөрчлөв.</p> <p>56. Уг зохицуулалт нь ашгийн төлөө бус үйл ажиллагааны зорилгоор ирүүлж буй мөнгөн хөрөнгө хандивыг хамаарахгүй байхаар заасан. Нэгэнт энэ хуульд хамаарахгүй тул энэ талаарх нарийвчилсан зохицуулалтыг хөрөнгө оруулалтын тухай хийх шаардлага байхгүй. Харин татварын зорилгоор энэ мэдээллийг татварын мэдээллийн системд бүртгэж байгаа.</p>
--	--	---	--

		<p>ТАТВАРЫН НЭГЖ Ерөнхий санал Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд хоёр том асуудал байгааг онцолж байна. Үүнд:</p> <p>51. Тус хуулийн төсөл нь хөрөнгө оруулалтын төслийг кэйс эсхүл төсөл тус бүрд үндэслэн урьдчилсан зөвшөөрөл олгох зарчимтай байдлаар боловсруулагдсан бөгөөд энэ нь олон улсын шилдэг туршлагад нийцэхгүй зарчим юм. Ийм тогтолцоо нь тухайн заалтыг буруугаар ашиглахад хүргэх, дагаж мөрдөхөд дарамт үүсгэх эрсдэлтэй.</p> <p>52. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд зааснаар хөрөнгө оруулагч нь “Тогтворжуулах гэрчилгээ” авах хүсэлтээ хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд 22 дугаар зүйлд зааснаар Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хуулийн төслийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хөрөнгө оруулалтад хамрагдах шалгуур, гэрчилгээ олгох хугацааг аль хэдий заасан байгаа тул тогтворжуулах гэрчилгээ олгох шаардлагагүй эсхүл эсвэл гэрчилгээг шалгуурыг хангасан тохиолдолд автоматаар хийдэг байх нь зүйтэй.</p> <p>53. Хөрөнгө оруулалтын төсөл нь 500 тэрбум төгрөгөөс дээш тохиолдолд төсөл тус бүрд харилцан тохиролцоо нөхцөл бүрдүүлэх Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах тухай хуулийн төсөлд заасан байна. Энэ хуулийн төслийн 24 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын төсөл нь Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтээ Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөлийг тохирох үүднээс хэлэлцээнд урих талаар Засгийн газарт танилцуулна гэж 24.4-т заасан байна. Ийм тогтолцоо нь нөхцөл байдлыг урвуулан ашиглах байдалд өртөмтгий, ил тод бус, шударга, эрх тэгш нөхцөлийг бүрдүүлдэггүй тул энэ төрлийн тогтолцоог олон улсад зөвлөмж болгодоггүй.</p> <p>54. Татварын дэмжлэгтэй холбоотой заалтууд нь татварын тухайн хуульд (хөрөнгө оруулалтын тухай хуульд бус) тусгагдах шаардлагатай бөгөөд татварын хөнгөлөлт, татварын хувь хэмжээг бууруулах зэрэг ашигт суурилсан татварын дэмжлэгээс илүүтэйгээр албан татвар ногдуулах орлогоос хасагдах зардалд суурилсан буюу элэгдэл болон хөрөнгө оруулалтыг түргэвчилсэн байдлаар хорогдуулах, зарлагдах гэх мэт урамшуулал, дэмжлэгээр солих нь зүйтэй. Түүнчлэн, ашигт суурилсан татварын хөнгөлөлт нь дэлхийн татварын доод хэмжээний шинэ зарчимтай нийцэхгүй байх магадлалтай тул хөрөнгө оруулагчдад татвар ногдуулахгүй байх эсвэл татварыг бага хувь хэмжээгээр ногдуулах зэргийг ашиглах боломжгүй болно. Тодруулбал,</p> <p>а. Хуулийн төслийн 15.1-т Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) төлөх үүргийг 3 жил хүртэл хугацаагаар хойшлуулна гэж заасан байна. Татвараас чөлөөлөхөөс илүүтэйгээр элэгдэл болон хөрөнгө оруулалтыг түргэвчилсэн байдлаар хорогдуулах, зарлагдах гэх мэт зардалд суурилсан татварын хөнгөлөлтийг авч үзэхийг зөвлөж байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлт нь нэмэлт хөрөнгө оруулалтын хөшүүрэг болдоггүйг олон улсын судалгаанууд харуулж байна. Учир нь хөрөнгө оруулагчийн гол зорилго нь хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх бус ашиг нэмэгдүүлэхэд оршдог. Түүнчлэн, татвараас чөлөөлөгдсөн болон чөлөөлөгддөггүй аж ахуйн нэгжүүдийн хооронд арбитрын хийх боломж үүсдэг тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг урвуулан</p>	<p>57. гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар нь Иргэний хуулийн дагуу хуулийн этгээдийн эрхгүй. Гэхлээ үйл ажиллагаа нь татвар ногдох орлогод хамаарах бол энэ ААНОАТ-ын тухай хуулийн дагуу төлөөний газарт тооцогдох бол холбогдох татварыг төлнө. Хөрөнгө оруулалтын хуулиар татвар төлөгчийг тодорхойлох нь зохимжгүй юм.</p> <p>58. Хөрөнгө оруулалтын хуулийн хууль тогтоомж хэсэгт олон улсын гэрээний заалт давуу үйлчлэх талаар тусгасан тул Монгол Улсын олон улсын гэрээ давуу үйлчилнэ. Харин татварын бус урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлэх бөгөөд энэ нь үл ялгаварлах зарчмаар хэрэгжих юм.</p> <p>59. Саналыг хүлээн авч төсөлд тусгасан.</p> <p>60. Дэмжсэн санал өгсөн байна.</p>
--	--	---	---

			<p>ашиглах нөхцөл үүсэж их хэмжээний татварын орлого алдахад хүргэдэг.</p> <p>b. 15.1.3-т элэгдэл хорогдлын хэмжээг тооцох түргэвчилсэн аргачлал тодорхой бус байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад тодорхой болгох үүднээс бодитой, үндэслэлтэй мэдээллээр хангах шаардлагатай.</p> <p>c. 15.1.4-т ажилтны мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцохоор заасан байна. Ийм төрлийн заалтууд нь бизнесийн бус үйл ажиллагаатай холбоотой зардлыг хасахыг зөвшөөрөх эсэх, мөн “супер хасалт” гэж нэрлэгддэг зардлын 100-аас дээш хувийг хасахыг зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байна.</p> <p>Бусад санал</p> <p>55. 3.3-т хөрөнгө оруулалтыг 18.1-д заасны дагуу зөвшөөрөл авна гэсэн заалт байна. Гэвч 18.1-д Тогтворжуулах татварын төрөл, тогтворжуулах гэрчилгээний талаар дурдсан байна. Үүнд зохих зохих өөрчлөлт оруулах шаардлагатай.</p> <p>56. Хуулийн төслийн 3.6-д хандив, тусламжийг хуульд хамрахгүй гэж заасан байна. Эрсдэл өндөртэй салбар, бус нутгийн хандив, тусламж зэргээс үүдэлтэй үүсэж болзошгүй саад бэрхшээлүүдээс сэргийлэх үүднээс энэ заалтыг дэлгэрэнгүй болгох, хөрөнгө оруулагчид хандив, тусламжтай холбоотой мэдээллийг цаг хугацааны давтамжтайгаар тайлагнаж байх, хандив тусламжийн босго хэмжээнээс хэтэрсэн тухай мэдээлэл солилцох автомат сувагтай байх зэрэг захиргааны журмыг тогтоож болно. Энэ нь ил тод байдлыг дэмжих, арбитрын ажиллагааг зогсоох BEPS-н тогтолцоог дагаж мөрдөхөд чухал ач холбогдолтой.</p> <p>57. 4.1.6-р заалтад Монгол Улсад итгэмжлэгдсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчөөр байгуулсан “гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар”-ын талаар дурдсан. Гэсэн хэдий ч “хуулийн этгээд”-н статусгүй гэж заасан байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийг Байнгын үйл ажиллагаа эрхлэх байгууллага гэж үзвэл татвар төлөх үүрэг хүлээх үр дагавартай байж болзошгүй тул энэ талаар илүү дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай байж болно. Уг заалтыг тодорхой болгосноор хөрөнгө оруулагчдад өөрсдийн олон улсын татварын тооцоолол гаргахад нь дэмжлэг болох юм.</p> <p>58. 4.1.9-д хөрөнгө оруулагчдад үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийн талаар дурдсан. Ийм төрлийн дэмжлэг үзүүлэхдээ, ялангуяа үр дүнд нь олон улсын томоохон худалдааны зорилттой тохиолдолд олон талт болон хоёр талт Хөрөнгө оруулалтын гэрээ, ДХБ-ын шаардлага, BEPS тогтолцоо болон Монгол Улсын нэгдэн орсон бусад олон улсын бусад гэрээ хэлэлцээрт нийцүүлэхийг зорих нь зүйтэй. Мөн 16.1.2-т заасан бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горим зэргийг бүх хөрөнгө оруулагчдад (хөрөнгө оруулалтын хуульд хамаарах эсэхээс үл хамааран) зөвшөөрөх нь зүйтэй.</p> <p>59. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын хэлбэрийг заасан байна. Тус зүйлийн 5.1.1–5.1.3-т шинээр аж ахуйн нэгж байгуулах, хувьцаа худалдан авах, компани нэгтгэх, нийлүүлэхийг хөрөнгө оруулалтад хамааруулна гэж заасан. Хуулийн төсөлд үйлдвэр, машин механизм, технологи шилжүүлэх, барилга байгууламж зэрэг биет болон үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийхийг дэмжсэн тодорхой заалт байхгүй байна. Хөрөнгө оруулалтын хэлбэрт ийм төрлийн капитал хөрөнгө оруулалтыг тусгахыг санал болгож байна. Түүнчлэн, хөрөнгө оруулагчдад хуулийн этгээдийн хэлбэрийг уян хатан байлгах, тухайлбал ХХК, нөхөрлөл, хөрөнгө оруулалтын итгэлцэл, хамтын</p>	
--	--	--	---	--

			<p>хөрөнгө оруулалт, Special Purpose Vehicle (SPV) буюу тусгай зориулалтын аж ахуйн нэгж гэх мэт уян хатан нөхцөлөөр хангахыг зөвлөж байна. Цаашлаад хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэрийн жагсаалт (5.1.8-д заасан) мөн нэмж тусгаж болно. Хөрөнгө оруулагчдын найдвартай байдлыг хангах үүднээс тусад нь нийтлэх эсвэл холбогдох хуулийг дурдаж болно.</p> <p>60. 7 дугаар зүйлд дурдсан хөрөнгө оруулагчдын эрх нь хөрөнгө оруулагчдын гадаад валютын хэрэгцээ, санхүүжилт, зээлийн хэрэгцээтэй холбоотой маш чухал асуудлыг тусгасан байна. АНУ-ын Төрийн департаментын тайланд дурдсанаар, банкны систем ерөнхийдөө хөрөнгийн дутагдалтай байгаа бол арилжааны банкны үйл ажиллагаа, зохицуулалтын хяналт нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад хангалтгүй байна. Монголд ч мөн адил хөрвөх чадваргүй банкнууд нэлээдгүй байна. Мөн ОУВС харьцангуй том банкны системтэй холбоотой макро зохистой байдлын асуудалд анхаарал хандуултал байхгүй талаар мэдээлсэн. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад арилжааны банкны үйл ажиллагаа, зохицуулалтын хяналт хангалтгүй байхад банкны систем ерөнхийдөө хөрөнгийн дутагдалтай байна. (US Department of State, 2022). 2021 онд эхлүүлсэн банкны салбарын шинэчлэлийг хурдасгах нь төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.</p>	
3.	Олон улсын санхүүгийн корпораци	2023.05.15	<ol style="list-style-type: none"> 1.1 дэх заалтыг давхардлыг арилгах, мөн үндэсний эрх ашиг, сонирхлыг заавал авч үздэг сүүлийн үеийн чиг хандлагыг үндэслэн “1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, хөрөнгө оруулагчид урамшуулал үзүүлэх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд нийцүүлэн хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж өөрчлөн найруулах 2.1 дэх заалтад олон хууль шууд хамааралтай тул Үндсэн хуулиас бусад хуулийг дурдахгүйгээр өөрчлөн найруулах 3-р зүйлд тайлбартай нэр томьёо байгаа, нөгөөтээгүүр хэрэглэхэд хялбар байх үүднээс энэ зүйлийн байршлыг дараагийн 4 дүгээр зүйлийн дараа оруулах, 3 болон 4 дүгээр зүйл рүү ишлэлд бараг байхгүй тул техникийн хувьд эрсдэл багатай. 3.2, 3.3-г “Хөрөнгө оруулалт хийх” гэсэн бүлэгт шилжүүлэх “3.7.Хувьцаа, бонд, үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхой хугацаанд өсгөж үр өгөөжийг нь хүртэх зорилгоор санхүүгийн деривативуудад (монгол оноосон нэр томьёо) байршуулсан шууд бус хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.” гэж нэмэх 4.1.4 Монгол Улсын иргэнийг “гадаадын хөрөнгө оруулагч” гэснийг анхаарах 4.1.5.“гадаадын хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хуулийн этгээд” гэж өөрчлөх 4.1.7.“гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” гэж нийт гаргасан хувьцааных нь 50 буюу түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж, компанийн төлөөлөн болон гүйцэтгэх удирдлагыг нь томилж саналын эрхийн 50 буюу түүнээс дээш хувийг хэрэгжүүлэхэд нь хяналт тавьж байгаа хуулийн этгээдийг; гэж өөрчлөн найруулах 4.1. ..”хөрөнгө оруулалтыг дэмжих” гэж гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр татах, одоо байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг хадгалах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор маркетинг, мэдээллийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг; гэж нэмэх 	<ol style="list-style-type: none"> 1. Саналыг тусгасан. 2. Саналыг тусгасан. 3. Хуулийн үйлчлэх хүрээ нь техникийн хувьд нэр томьёоноос өмнө байрших нь зүйтэй. 4. Саналыг тусгасан. 5. Саналыг тусгасан. 6. Одоогийн хөрөнгө оруулалтын хуулийн заалтыг хэвээр үлдээсэн бөгөөд энэ нь татварын суурьтай холбоотой. 7. Саналыг тусгасан. 8. Шууд бусаар эзэмших гэсэн ойлголт нь манай улсын хуульд татварын хууль тогтоомжид хэрэглэгдэж байгаа бөгөөд уг хэвшсэн ойлголтыг тусгайлан нэмж тодорхойлох шаардлага байхгүй. 9. Саналыг тусгасан. 10. Саналыг тусгасан 11. Шууд хөрөнгө оруулалтыг тодорхойлох нь 5 дугаар зүйлд заасан тодорхойлолтыг хязгаарлах эрсдэлтэй тул тусгайлан тодорхойлох шаардлага байхгүй. 12. Саналыг тусгасан. 13. Тусгайлан бүлэг болгоход зохицуулалтын хувьд хангалгүй цөөн байх тул н1 дүгээр бүлгээр

		<p>10. 4.1.9.“хөрөнгө оруулалтын урамшуулал дэмжлэг” гэж хөрөнгө оруулагчид төрөөс үзүүлэх татварын болон татварын бус урамшууллыг дэмжлэгийг;</p> <p>11. 4.1...”шууд хөрөнгө оруулалт” гэж энэ хуулийн 4.1.1-д зааснаас гадна хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээдийн удирдлагад нөлөөлөхүйц, эсхүл шууд удирдах саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг нийлүүлснийг;</p> <p>12. 4.1. ...”шууд бус хөрөнгө оруулалт (багцын)” гэж хувьцаа, бонд болон бусад санхүүгийн хөрөнгийн өгөөжийг хүртэх зорилгоор тэдгээрийг тодорхой хугацаанд эзэмшихийг хэлнэ. (үнэт цаасыг нь эзэмшиж буй хуулийн этгээдийн удирдлагад оролцдоггүй, эрх,үүрэггүй)</p> <p>13. Хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой зохицуулалтуудыг нэгтгэн нэг бүлэг болгох “Хоёрдугаар бүлэг. Хөрөнгө оруулалт хийх”</p> <p>14. 5.1.2. үйлдвэр, машин механизм, технологи дамжуулах, барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулалт хийх; нэмэх</p> <p>15. 5.1.7 гадаад гэдгийг анхаарах</p> <p>16. 5.1.8.хуулиар хөриглөөгүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр. хөрөнгө оруулалтын тодорхойлолтод хамаарах хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр</p> <p>17. . .дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</p> <p>..1. Хөрөнгө оруулагч Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад, нэг болон түүнээс дээш салбар, төсөл, үйлдвэрлэл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж болно.</p> <p>..2. Үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлаж болно.</p> <p>..3. Энэ хуулийн ..2 дах хэсэгт заасны дагуу Монгол Улсын хууль тогтоомжоор гадаадын шууд хөрөнгө оруулалт хийхийг хориглосон салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалтыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр гаргаж нийтэд мэдээлнэ.</p> <p>..4. Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 25.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан тохиолдолд хөрөнгө оруулалт хийж болно.</p> <p>..5.Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>18. Хөрөнгө оруулалтын баталгаа , хөрөнгө оруулагчийн эрхийг зааглах боломжгүй, ихэнхи тохиолдолд давхардаг тул хэрэглэхэд хялбар болгох үүднээс 2,3 бүлгүүдийг нэгтгэж, гуравдугааг бүлэг болгох</p> <p>19. 6.1 дэх хэсэг нь ИА/ВIT байгуулаагүй хөрөнгө оруулалтанд хамааралгүй байхаар, мөн зөвхөн эрх тэгш байдлыг хангахаар заасныг өөрчлөн найруулж олон улсын хөрөнгө оруулалтын хууль, гэрээнд хүлээн зөвшөөрөгдсөн баталгаа болох YTN/YNTH дийг тусгах</p> <p>20. 6 дугаар зүйл.Баталгаа хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах</p> <p>6.1.Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана:</p> <p>6.1.1.Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрх тэгш , шударгаар хамгаалах;</p> <p>6.1.2. ижил нөхцөлд байгаа дотоодын хөрөнгө оруулагчид болон бусад гадаадын</p>	<p>зохицуулахаар тусгав.</p> <p>14. Саналыг тусгасан.</p> <p>15. Саналыг авч бүх хөрөнгө оруулагчид хамаарахаар тусгав.</p> <p>16. Саналыг тусгасан.</p> <p>17. Саналыг тусгасан.</p> <p>18. Саналыг тусгасан.</p> <p>19. Саналыг тусгасан. Гэхдээ үндэсний нөхцөл нь зарим тохиолдолд хязгаарлагддаг тул шууд энэ заалтаар оруулах нь зохимжгүй.</p> <p>20. Зарчмын хувьд саналыг авсан. Харин үндэсний нөхцөл хийгээд санал авах процесст холбогдох бусад хуулийн зохицуулалтаас хамаарч шууд дэлгэрэнгүй заах нь тохиромжгүй байна.</p> <p>21. Саналыг тусгасан.</p> <p>22. Саналыг тусгасан.</p> <p>23. Саналыг тусгасан.</p> <p>24. Саналыг зарчмын хувьд тусгасан. Харин байгууллагын нэршлийн хувьд зөвхөн дэмжих бус бусад чиглэлээр ажиллах тул саналыг тусгах шаардлагагүй.</p> <p>25. Саналыг тусгав.</p> <p>26. Хөрөнгө оруулалтыг дэмжих стратеги төлөвлөгөө гэдэг нь хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид хамаарах тул дахин давтах шаардлагагүй.</p> <p>27. Саналыг тусгасан.</p> <p>28. Саналыг тусгасан.</p> <p>29. Санал өгөөгүй, хариу өгөөгүй үйлдэл дээр ямар албан тушаалтанд хариуцлага тооцох эсэх, албан бичгийн шат дамжлага бүрд хамаарах хүнд үү гэдэг ойлгомжгүй. Нөгөө талаас хариу өгөх хугацааны эцэст үйлдлийн үр дагавраар хариуцлага тооцох нь зүйтэй тул саналыг шууд авах боломжгүй.</p> <p>30. Саналыг тусгасан.</p> <p>31. Дэмжсэн санал өгсөн.</p>
--	--	---	---

			<p>хөрөнгө оруулагчид олгодог үндэсний тааламжтай болон нэн тааламжтай нөхцөлөөр гадаадын хөрөнгө оруулагчийг нэгэн адил хангах;</p> <p>6.1.3 Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд тогтоомжид заасны дагуу. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэрийн талаар урьдчилан мэдээлэх, хэлэлцүүлэх, саналаа илэрхийлэх боломж олгох, албан ёсоор хэвлэн нийтэлж нээлттэй болгох;</p> <p>6.1.4. энэ хуулийн 6.1.3-т заасан баталгааг хангахын тулд шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан дараах арга хэмжээ авна:</p> <p>6.1.4.а. ашиг сонирхол нь шууд хөндөгдөх хөрөнгө оруулагчид тухайн шийдвэрийн төсөл, үндэслэл, хүчин төгөлдөр болох хугацаа, уг шийдвэрийн улмаас хөрөнгө оруулагчид учирч болох хохирлыг хэрхэн тооцож барагдуулах зэрэг мэдээллийг хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн өмнө хүргүүлнэ;</p> <p>6.1.4.б. хөрөнгө оруулагчаас гаргасан тайлбар, нотолгоог судлан үзэж хэлэлцэх, саналд албан ёсоор хариу өгнө.</p> <p>6.2.Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах эдийн засгийн баталгааг хангана:</p> <p>6.2.1.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглоно.</p> <p>6.2.2.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмын дагуу, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр ялгаварлан гадуурхахгүйгээр.дайчлан авч болно.</p> <p>6.2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.2-т заасны дагуу дайчлан авсан хөрөнгийн нөхөн олговрыг тухайн хөрөнгийг дайчлан авсан үеийн буюу энэ тухай хөрөнгө оруулагчид, эсхүл нийтэд мэдэгдэх үеийн зах зээлийн үнэлгээгээр тооцож, үнийн хамт цаг тухайд нь шуурхай, төлнө.</p> <p>6.2.4.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрээр хөрөнгө оруулагчийн эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шууд ба шууд бусаар хязгаарласан, хураасан, үнэ цэнийг бууруулсан бол хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулна.</p> <p>6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй:</p> <p>6.2.5.а.үйл ажиллагаанаас олсон ашиг, ногдол ашиг;</p> <p>6.2.5.б.энэ хуулийн 5.1-д заасан үйл ажиллагаанаас бий болсон аливаа орлого, төлбөр;</p> <p>6.2.5.в.гадаад улсаас авсан зээлийн үндсэн төлбөр болон хүү;</p> <p>6.2.5.г.аж ахуйн нэгжийг татан буулгасны дараа өөрт ногдох хөрөнгө;</p> <p>6.2.5.д.хуулийн хүрээнд олсон буюу өмчилж байгаа бусад хөрөнгө;</p> <p>6.2.5.е.энэ хуулийн 6.2.4-т заасан нөхөх олговор, төлбөр;</p> <p>6.2.6.ё. маргаантай холбоотойгоор үүссэн аливаа төлбөр.</p> <p>6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй.</p>	<p>32. Саналыг тусгасан.</p> <p>33. Саналыг хэсэгчлэн тусгасан. Харин үүсгэн байгуулах баримт бичиг болон дүрэм, итгэмжлэл гм баримт бичгийг Монгол Улсын хуулийн шаардлагыг мөрдүүлэх үүрэгтэй. Уг шаардлагад нийцээгүй хийсэн хэлцэл, шийдвэр нь хууль бус байх эрсдэлтэй тул.</p>
--	--	--	---	--

		<p>6.2.7.Төлбөрийн тэнцлийн тодорхой нөхцөлөөс бусад тохиолдолд шилжүүлгийг цаг хугацаанд нь хийнэ.”</p> <p>21. 7.1.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан баталгаагаас гадна дараах нийтлэг эрхтэй: 7.1.1, 7.1.2 Энэ хэсгийг 2 Бүлэгт шилжүүлсэн, 7.1.1-тэй нийлүүлсэн (хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой зохицуулалтууд)</p> <p>22. 10.1... Хөрөнгө оруулалтын гэрээбайгуулах ажлыг зохион байгуулах, Хөрөнгө оруулалтын гэрээний биелэлтийг хянах;</p> <p>23. 10.1.5.гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;</p> <p>24. 11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа асуудал-эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.Хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.1.хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны стратеги төлөвлөж, хэрэгжүүлж төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; 11.1.2. хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээл, эдийн засгийн төлөвлөлт, хөгжлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах; 11.1.3.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөх, хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх;</p> <p>25. 12 дугаар зүйлийн 12.3-г хасаж, дараах байдлаар өөрчлөн найруулах “12.3. Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбоотой гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэхэд өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар тайлбар, мэдээлэл өгөх, санал, зөвлөмж, энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргана. Бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн, эсхүл эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн хөрөнгө оруулагчаас гаргасан санал, гомдлын талаарх мэдээллийг энэ хуулийн 28.-д заасан журмын дагуу хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ”</p> <p>26. Дипломат албаны тухай хуульд “гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагааг эдийн засаг, шинжлэх ухаан, техник, худалдаа, хүмүүнлэгийн хамтын ажиллагаатай уялдуулан зохицуулах;” “5.1.9. төр, засгийн газрын байгууллагын шугамаар хэрэгжүүлэх олон улсын харилцааны үйл ажиллагааг мэдээлэл-судалгаа, арга зүйн зөвлөмжөөр хангаж, үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах;” гэж заасан тул ДТГ-ын бүрэн эрх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулж, нэмэлт оруулах “14.1.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин, дотоод зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төсөл, хөтөлбөрийг хөрөнгө оруулалтыг дэмжих стратеги төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төсөл, хөтөлбөрийг сурталчлах чиглэлээр ажиллана. 14.2. Сурталчилгааны бүхий л үйл ажиллагааг явуулахад хөрөнгө оруулалтыг дэмжих үндэсний агентлагтай хамтран ажиллана.”</p> <p>27. 15, 16 дугаар бүлгийн “дэмжлэг” гэснийг урамшуулал болгох</p>	
--	--	--	--

		<p>28. 24.1-т үйл ажиллагааг явуулах орчныг тогтвортой байлгах гэдэгт юу хамаарах? Гол хүчин зүйл бол улс төр, эдийн засаг, эрх зүйн тогтвортой байдал тул гэрээгээр тогтворжуулах боломжгүйг анхаарах</p> <p>29. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тул эс үйлдэхүй байж болох эсэх? Хариуцлага яригдах тул 26.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 26.4-т заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтлахдаа холбогдох байгууллагаас санал, дүгнэлт гаргуулж болох ба холбогдох байгууллага нь асуудлыг 30 хоногийн дотор судлан үзэж, санал, дүгнэлтээ ирүүлнэ. Заасан хугацаанд санал бөгөөд уг хугацаанд ирүүлээгүй бол холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулах үндэслэл болно. тусгайлан өгөх саналгүйд төөцнө.</p> <p>30. 28.1 дэх заалтыг “Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль, олон улсын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан эрх ашиг, баталгаа нь зөрчигдсөн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.” гэж өөрчлөн найруулж, “Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх” зүйл нэмэх</p> <p>28.... маргаанаас урьдчилан сэргийлэхэд туслах зорилгоор төрийн эрх баригчид болон холбогдох хөрөнгө оруулагчидтай хамтран хөрөнгө оруулалтын асуудлаарх санал зөрөлдөөнийг шийдвэрлэх.</p> <p>28.4. Энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг шийдвэрлэх хүрээнд холбогдох байгууллагаас мэдээлэл, тайлбар авах, тусгай мэдлэг хөрөнгө оруулалтын баталгаа, олон улсын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээний биелэлттэй холбоотой асуудлаар шаардсан тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр шинжээч томилж, <u>холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас</u> дүгнэлт гаргуулж болно.</p> <p>28.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.</p> <p>28.5.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.4-т заасан шийдвэрийн <u>хэрэгжилтэд хяналт тавина.</u> жангуулна.</p> <p>28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг <u>цахимаар хүлээн авах, бүртгэх,</u> шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.</p> <p>31. Төр болон хөрөнгө оруулагчийн хоорондын хөрөнгө оруулалттай холбоотойгоор үүссэн маргааныг дараах арга замаар шийдвэрлэхээр тусгагдсан байдаг: Эв зүйгээр шийдвэрлэх (= харилцан тохиролцох, хэлэлцэх), эвлэрэн тохиролцох боломжгүй тохиолдолд:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн улсын үндэсний Шүүх байгууллагад хандах - Үндэсний эсвэл олон улсын арбитрад хандах. <p>Арбитр нь маргаан үүсэхээс өмнө эсвэл тухайн үед хоёр тал ямарваа нэгэн гэрээ хэлэлцээрт суурилсан байхыг шаарддаг.</p> <p>Төрийн зүгээс хөрөнгө оруулалтын актад урьдчилан зөвшөөрөл олгосон байх албагүй. Гэхдээ хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн хүрээнд арбитрад хандах боломж нөхцөлийг олгосон байх нь сайн туршлагын нэгэнд тооцогддог.</p>	
--	--	---	--

			<p>Арбитрт хамаарах олон улсын томоохон конвенцийн зүйл, заалтыг чандлан мөрдөх явдал нь нааштай дохио болж чаддаг (ICSID Convention, New York Convention, etc.). Энэ нь хөрөнгө оруулагчдын эдлэх эрх, хуулиар олгогдсон хамгаалалтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхэд тустай байдаг. Мөн төрийн зүгээс хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд түлхэц болж чаддаг.</p> <p>32. Дагалдах хуульд Барилгын тухай хуулийг “45.4.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд энэ хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсаргана.” Өөрчлөх</p> <p>33. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд дараах хэсэг нэмэх: “16.1.1 Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулж байгаа тохиолдолд энэ хуулийн 16.1.3, 16.1.4, 16.1.6 болон 16.1.7 дах хэсгүүдэд заасан бичиг баримтыг бүрдүүлэхдээ тухайн гадаадын хөрөнгө оруулагчийн харьяа улсад ашиглагддаг хэлбэрээр бэлдэж болно.” Тайлбар: Хуулийн этгээд үүсгэн байгуулах процесс, зохицуулалт өөр өөр байдаг ба хуулийн этгээдийг бүртгүүлэхэд шаардах баримт бичгийг, тухайлбал итгэмжлэл, үүсгэн байгуулах шийдвэр зэргийг заавал Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагын дагуу бүрдүүлэх боломжгүй. /16.1.3.үүсгэн байгуулах баримт бичиг буюу хуулийн этгээд байгуулах шийдвэр /тогтоол/, дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ;, 16.1.4.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл; 16.1.6.хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тохиолдолд нотлох баримт;/</p>	
4.	ОУСК	2023.06.07	<ol style="list-style-type: none"> 1. 1.1. Хасах 2. 3 дугаар зүйлд төслийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтуудыг найруулан оруулах. 3. 4.1. “..”шууд бус хөрөнгө оруулалт (багцын)” гэж хувьцаа, бонд болон бусад санхүүгийн хөрөнгийн өгөөжийг хүртэх зорилгоор тэдгээрийг нээлттэй зах зээлээс худалдан авч тодорхой хугацаанд эзэмшихийг хэлнэ. (үнэт цаасыг нь эзэмшиж буй хуулийн этгээдийн удирдлагад оролцдоггүй, эрх,үүрэггүй) 4. 4.1.7-д Дэмжлэг бол илүү өргөн хүрээтэй ойлголт тул энэ заалтыг дараах байдлаар найруулах: 4.1.9.“хөрөнгө оруулалтын урамшуулал” гэж хөрөнгө оруулагчид төрөөс үзүүлэх татварын болон татварын бус урамшууллыг гэж, үүнтэй уялдуулаад дараах нэр томъёо нэмэх: 4.1. “..”хөрөнгө оруулалтыг дэмжих” гэж гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр татах, одоо байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг хадгалах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор маркетинг, мэдээллийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг; 5. 5 дугаар зүйлийн нэрийг Энэ зүйлийн 5.4-5.7 дэх хэсгүүд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой тул гарчигт нэмэх 6. 5.2 дахь хэсгийн зохицуулалт хөрөнгө оруулалтын хэлбэрт хамаарахгүй, тухайлбал: “ 5.2.3.төрөөс ногдуулах татвар хураамж; 5.2.2.татаас, мөнгөн тэтгэлэг;..” Иймд хөрөнгө оруулалаттай холбоотой, гэхдээ энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй гэж дараах байдлаар оруулах “3.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу төрийн байгууллага, албан газарт улсын болон орон нутгийн төсвөөс хийх хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй. 3.3.Олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн өмчит аж ахуйн нэгж, иргэнээс 	<ol style="list-style-type: none"> 1. Саналыг тусгасан. 2. Саналыг тусгасан. 3. Саналыг тусгасан. 4. Саналыг тусгасан. 5. Саналыг тусгасан. 6. Саналыг тусгасан. 7. Саналыг тусгасан. 8. Саналыг тусгасан. 9. Нэн тааламжтай нөхцөлийг шууд төсөлд тусгах нь тохиромжгүй. 10. Саналыг тусгасан. 11. Саналыг тусгасан. 12. Саналыг тусгасан. 13. Саналыг тусгасан. 14. уг үүрэг нь агуулгын хувьд хуулийн төсөлд туссан тул тусгайлан заах шаардлагагүй. 15. Авлигын асуудал бие даасан хуультай тул тусгайлан хуульд заах шаардлага байхгүй. 16. Саналыг тусгасан. 17. Саналыг тусгасан. 18. Бүх төрлийн хөрөнгө оруулалтад

		<p>арилжааны нөхцөлгүйгээр олгох хандив, буцалтгүй тусламжид энэ хууль хамаарахгүй.</p> <p>3.4. Хувьцаа, бонд, үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхой хугацаанд өсгөж үр өгөөжийг нь хүртэх зорилгоор санхүүгийн деривативуудад (монгол оноосон нэр томъёо) байршуулсан шууд бус хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.”</p> <p>7. 5.2.4-г хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй гэж оруулах</p> <p>8. 5.3 дахь заалтыг 4 дүгээр зүйлд оруулах</p> <p>9. 6.1.1-д “эрх тэгш хангах” гэдгийг ИА/БИТ байгуулаагүй хөрөнгө оруулалтад хамаарахгүй, мөн зөвхөн эрх тэгш байдлыг хангахаар заасныг өөрчлөн найруулж, олон улсын хөрөнгө оруулалтын хууль, гэрээнд хүлээн зөвшөөрөгдсөн баталгаа болох ҮТН/ҮНТН-ийг “...ижил нөхцөлд байгаа дотоодын хөрөнгө оруулагчид болон бусад гадаадын хөрөнгө оруулагчид олгодог үндэсний тааламжтай болон нэн тааламжтай нөхцөлөөр гадаадын хөрөнгө оруулагчийг нэгэн адил хангах,” гэж тусгах</p> <p>10. Газрыг тусгай хамгаалалтад авах хэлбэрээр тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй, зөвшөөрлийг цуцалдаг – энэ шууд бус байдлаар хөрөнгийг хураан авч байгаа тод жишээ. Хөрөнгийг / оруулалтыг?/ төрийн өмчид хураан авч болно гэдэг нь Үндсэн хууль зөрчсөн томъёолол, энэ заалтыг заавал эргэн үзэх, хувийн өмчийг дайчлан авч болно. Гэмт хэрэг хийсэн, тэр нь шүүхээр тогтоогдсон бол гэмт хэргийн улмаас олсон орлого, ашгийн хураан авдаг. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. /олон улсын эрх зүйн хэм хэмжээ/ иймд 6.2-г “Төрөөс нийтийн ашиг сонирхлын үүднээс, үл ялгаварлах зарчмаар, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө оруулалтыг төрийн өмчид авах буюу албадан хураах /цаашид “Албадан хураах” гэх/ арга хэмжээг шууд болон шууд бус байдлаар хэрэгжүүлж болно.” гэж өөрчлөн найруулах</p> <p>11. 6.4-г “Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасны дагуу дайчлан авсан хөрөнгийн нөхөн олговрыг тухайн хөрөнгийг дайчлан авсан үеийн буюу энэ тухай хөрөнгө оруулагчид, эсхүл нийтэд мэдэгдэх үеийн зах зээлийн үнэлгээгээр тооцож, үнийн хамт цаг тухайд нь шуурхай, төлнө.” гэж өөрчлөн найруулах</p> <p>12. 6.5-д заасан “биет” хөрөнгө, “зохистой гэж үзвэл” гэдгийг тодруулах</p> <p>13. 6.6 дахь заалт 6.8-тай давхацсан тул хасах</p> <p>14. 8.1.9 чухал үүрэг</p> <p>15. 8.1.11 тусад нь хэсэг болгох</p> <p>16. 8.2.3 ойлгомжтой болгох</p> <p>17. 11.1.6 авах гэдгийг тодорхой болгох</p> <p>18. 16.1.1 Бүх төрлийн хөрөнгө оруулалтад хамааралтай байх уу? Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын 4 төрлөөс хамааран газар ашиглах хугацааг тогтоох уу?</p> <p>19. 16.1.3 бүгдийг чөлөөлөх үү?</p> <p>20. 24.1-д заасан “үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах” гэдэг нь олон жилээр тогтвортой байлгах? Орчинд юу юу хамаарах? Гол хүчин зүйл бол улс төр, эдийн засаг, эрх зүйн тогтвортой байдал зэргийг Гэрээгээр тогтворжуулах боломжгүйг анхаарах</p>	<p>хамааралтай.</p> <p>19. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлнэ.</p> <p>20. Саналыг тусгасан.</p> <p>21. Системээр шийдэх боломжтой. Гомдолд хамаарах зайлшгүй авах ёстой нөхцөл шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй бөгөөд тусгайлан журмаар процессын асуудлыг илүү зохицуулна.</p> <p>22. Цаасаар гаргасан ч холбогдох гомдлыг цахим системд төрийн байгууллага нь бүртгэнэ.</p> <p>23. Тийм</p> <p>24. Асуулт нь тодорхойгүй байна.</p> <p>25. Тагнуул, ҮАБЗ-ийн шийдвэртэй холбоотой гомдол болно.</p> <p>26. Шууд эрх ашигтай нь холбогдохгүй буюу нотлогдохгүй байхыг ойлгоно.</p> <p>27. Саналыг тусгасан.</p> <p>28. Саналыг хэсэгчлэн тусгасан. Харин үүсгэн байгуулах баримт бичиг болон дүрэм, итгэмжлэл гм баримт бичгийг Монгол Улсын хуулийн шаардлагыг мөрдүүлэх үүрэгтэй. Уг шаардлагад нийцээгүй хийсэн хэлцэл, шийдвэр нь хууль бус байх эрсдэлтэй тул.</p>
--	--	---	---

		<p>21. 28.3-т Гомдол гаргах процессыг хялбаршуулах үүднээс, ялангуяа цахимаар гаргаж байгаа нөхцөлд гомдлын маягтад дурдсан асуудлуудыг бөглөх замаар гаргах (Маягтад дурдсан асуултуудыг өөрчилж болно), Нөгөөтээгүүр систем нь эдгээр асуулт болон шийдвэрлэлтийн процессыг нэгтгэн зарим тайлан, мэдээлэл гаргахаар хөгжүүлсэн тул түүнийг ашиглан хөрөнгө оруулалтын орчны байдалд дүн шинжилгээ хийх, статистик мэдээлэл гаргахад дөхөм болно. Одоогийн хөгжүүлсэн IT системийг сайжруулах, хялбаршуулах боломж байгаа гэдгийг харгалзан үзнэ үү. Зарим процессын шинжтэй асуудлыг сайд батлахаар зохицуулалт хийх боломж байгаа юу?</p> <p>Хэрэв өгөх мэдээллийг заавал хуулиар зохицуулах нь зүйтэй хэмээн үзэж байгаа тохиолдолд Дарааллыг эргэн харах: гаргаж байгаа этгээдийн талаарх мэдээллээс эхлэх, түүнчлэн гомдлыг шийдвэрлэхэд /харьяалал тогтоохоос эхлээд ../ нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол хэрхэх талаар зохицуулалт нэмэх,</p> <p>22. 28.4-т Хэрэв цаасан хэлбэрээр илгээсэн бол гэж нэмэх</p> <p>23. 28.6.1-т Хэрэг бүртгэлийн , зөрчлийн хэргүүдийг хянан шалгах шатанд байгаа бол “ мөрдөө шалгах” ажиллагаанд хамрагдах уу?</p> <p>24. 28.6.2 Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар гаргасан гомдол энэ хуулийн 26.6.1, 26.6.2-т хамаарахгүй?</p> <p>25. 28.6.5 шууд хэрэгжүүлэхтэй холбоотой гомдол гэдгийг тодруулах</p> <p>26. 28.6.7. үзэмжийн асуудал болох магадлалтай байна. Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол гэдэгт ямар эрх, ашиг сонирхол хамаарах эсэх талаар тайлбар байхгүй байна</p> <p>27. Барилгын тухай хуулийн 45.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах саналыг эргэн хянан үзнэ үү: Гадаадын хөрөнгө оруулагч /хувь хүн, хуулийн этгээд нь тухайн улсдаа барилга угсралтын ажил эрхэлдэггүй бол, нөгөөтээгүүр тухайн улсад нь энэ үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардаггүй бол, хэд хэдэн улсын хөрөнгө оруулагч байвал тухай хөрөнгө оруулагч бүр өөрийн харьяалах улсдаа заавал энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байх эсэх зэрэг олон асуудлыг зохицуулах хэрэгтэй болно. Түүнчлэн энэ заалт Барилгын тухай хуулийн 20.3.-тай зөрчилдөж байна. Хэрэв энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах нь зүйтэй гэж үзвэл баримт бичиг шаардах хэлбэрээр бус, тусгай зөвшөөрөл олгох нэмэлт шаардлага хэлбэрээр зохицуулах нь зүйтэй. Энэ тохиолдолд Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлд нэмэлт оруулах ба 19 дүгээр зүйлд заасан 4 төрлийн үйл ажиллагаанд бүгд нь хамаарах эсэхийг хянан үзнэ үү.</p> <p>28. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд дараах хэсэг нэмэх: “16.1.1 Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулж байгаа тохиолдолд энэ хуулийн 16.1.3, 16.1.4, 16.1.6 болон 16.1.7 дах хэсгүүдэд заасан бичиг баримтыг бүрдүүлэхдээ тухайн гадаадын хөрөнгө оруулагчийн харьяа улсад ашиглагддаг хэлбэрээр бэлдэж болно.” Тайлбар. Хуулийн этгээд үүсгэн байгуулах процесс, зохицуулалт өөр өөр байдаг ба хуулийн этгээдийг бүртгүүлэхэд шаардах баримт бичгийг, тухайлбал итгэмжлэл, үүсгэн байгуулах шийдвэр зэргийг заавал Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагын дагуу бүрдүүлэх боломжгүй. /16.1.3.үүсгэн байгуулах баримт бичиг буюу хуулийн этгээд байгуулах шийдвэр /тогтоол/, дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ;, 16.1.4.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл; 16.1.6.хувь нийлүүлсэн хөрөнгөтэй</p>	
--	--	--	--

			тохиолдолд нотлох баримт;/	
5.	Японы ЭСЯ	2023.05.12	<ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой хориг хязгаарлалтыг сулруулах, хүчингүй болгох зэрэг нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмэр болно гэж бидний зүгээс үзэж байна. 2. Япон Улсын Засгийн газраас, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйлийн 2.2-ын (Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө) тухайд, “Эдийн засгийн түншлэлийн тухай Япон Улс, Монгол Улс хоорондын хэлэлцээр” (цаашид “Япон-Монголын ЭЗТХ” гэх) болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хооронд зөрүүтэй заалт байх тохиолдолд, “Япон-Монголын ЭЗТХ”-ийг давуу эрхтэйгээр дагаж мөрдөхийг нягталмаар байна. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон “Япон-Монголын ЭЗТХ”-т зөрүүтэй тусгасан байгаа заалтын жишээ болох “Хөрөнгө шилжүүлэлт”-ийн тухайд авч үзвэл, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвхөн тодорхой хэсэг хөрөнгө, орлогыг шилжүүлэх эрхийг тусгасан байхад “Япон-Монголын ЭЗТХ”-т бүхий л хөрөнгө шилжүүлэх эрхийг тусгасан байна (Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6.2.5-д, “Япон-Монголын ЭЗТХ”-ийн 10.11 дүгээр зүйлд). Мөн, “Хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг олон улсын арбитраг шилжүүлэх” тухайд авч үзвэл, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдсэнээс хойш 3 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гэж бичсэн байхад, “Япон-Монголын ЭЗТХ”-т талууд маргаан 120 хоногийн дотор шийдвэрлэгдээгүй тохиолдолд арбитраг шилжүүлнэ гэж тусгасан байна (Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 29.2-д, “Япон-Монголын ЭЗТХ”-ийн 10.13 дугаар зүйлд). 3. Монгол Улс дахь гадаад улсын дипломат байгууллагуудын саналыг тусган, өөрчлөлт оруулсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барихаас өмнө, дахин санал өгөх боломж олгохыг хүсэж байна. 	<ol style="list-style-type: none"> 1. Дэмжсэн санал 2. Олон улсын гэрээний заалт давуу үйлчилнэ. 3. Хүсэлт шийдвэрлэх боломжтой
6.	БНХАУ-ын ЭСЯ	2023.05.22	<ol style="list-style-type: none"> 1. Ажиллах хүчний тоог нэмэгдүүлж, гадаад ажилтны ажлын байрны жилийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх 2. Хөрөнгө оруулагчдад “татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ” олгох босгыг өндөр тогтоосон. Хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулж, тогтворжуулах гэрчилгээний хугацааг 2-3 жилээр уртасгах 3. Анхан шатны хайгуулын компаниуд нь уур уурхай олборлолтын аж үйлдвэрийн гинжин хэмжээнд тэргүүлэх байрыг эзэлдэг бөгөөд монголын уул уурхайн салбарыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ шаардлагатай бүх боловсон хүчин нь мэргэжлийн өндөр түвшний техникчид байдгаараа уул уурхай олборлолтын аж ахуй нэгжүүдээс эрс ялгаатай. Иймд учраас гаднын хайгуулын компаниудын хөрөнгө оруулалтад нийцүүлэн техникийн боловсон хүчнийг оруулах болон ажлын байрны төлбөр зэргийн хувьд дэд бүтэц, аж үйлдвэр, шинжлэх ухаан технологи, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслүүдийн адилаар татварын бус дэмжлэг авах боломжтой гэж үзэж байна. 4. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажилчдын эрүүл мэндийн даатгалд 	<ol style="list-style-type: none"> 1. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хууль тогтоомжийн хүрээнд холбогдох дэмжлэгийг эдлэх боломжтой. Засгийн газраас уг шийдвэрийг гаргадаг бөгөөд хуулийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой. 2. тогтворжуулах гэрчилгээний шаардлагыг бууруулж, хугацааг нэмэгдүүлсэн. 3. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хууль тогтоомжийн хүрээнд холбогдох дэмжлэгийг эдлэх боломжтой. Засгийн газраас уг шийдвэрийг гаргадаг бөгөөд хуулийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой.

		<p>татварын бус тодорхой дэмжлэгүүдийг үзүүлэхийг санал болгож байна.</p> <p>5. Гадаадын хөрөнгө оруулагчид болон хамтрагч түншүүдийн хувьд Монгол Улсад албан журмаар нийгмийн даатгал төлөх албагүй бөгөөд хятад ажилчдын Монголд төлдөг даатгал төлөх албагүй бөгөөд Хятад ажилчдын Монголд төлдөг нь даатгал нь БНХАУ-д төлсөн даатгалтай давхардаж байгаа болно. Хятад ажилчид Монголд өндөр насны тэтгэвэр авч амьдардаггүй тул нийгмийн даатгалын давхар төлөлтөөс зайлсхийхийг санал болгож байна.</p> <p>6. Хуулийн хэрэгжилтийг эрх тэгш, шударга, нээлттэй ил тод байлгаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах</p> <p>7. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн байдал болон хэвийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, нийгмийн бүлэг эвслүүд хөндлөнгөөс оролцохоос хамгаалах. Тэдгээрийн үйлдлийг зохицуулах нь хөрөнгө оруулагчдын бизнесийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжгүй бөгөөд улмаар Монгол Улсын Засгийн газар улсын төсвийн орлогыг бууруулах, Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтын орчин алдагдахад хүргэж болзошгүй юм. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, худал мэдээлэл тараасан, хэрүүл маргаан өдөөн хатгалга үүсгэсэн этгээдэд хатуу хариуцлага тооцох</p> <p>8. Хятадын хөрөнгө оруулагч Монгол улсад компани үүсгэн байгуулах бүртгэлийн мөнгийг монголын компанитай адил байх</p> <p>9. Газрын тосны хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн гаргасан саналууд:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын тосны салбар бол шингэн ашигт малтмалын онцлог салбар, Монгол Улсад газрын тосны нөөц хомс учраас хайгуул олборлолт хийхэд хүндрэлтэй, төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ их, хөрөнгө оруулалтын эрсдэл өндөр байдаг. Монгол Улс ХОТХ-д өөрчлөлт оруулахдаа газрын тосны томоохон хөрөнгө оруулалтыг төслүүдийн өвөрмөц шинжийг тодорхой болгох, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, газрын тосны хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдэд татварын талаар хөнгөлөлттэй таатай бодлого барих, гэрээний нийт хугацаанд тус татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн таатай нөхцөлийг өөрчлөхгүй хэвээр хадгалахыг санал болгож байна. - Гэрээний үзэл санааг тууштай баримталж, гэрээний тогтвортой байдлыг ханган, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах. ХОТХ-ийн дагуу өмнөх байгуулсан гэрээний хүчинтэй байдлыг баталгаажуулах. Хуучин гэрээний болон шинэ гэрээний зохицуулалтуудыг ганц өдөрт өөрчилж болохгүй бөгөөд гэрээг удаа дараа давтан зөрчих явдлыг зөвшөөрөхгүй - 2014 онд Газрын тосны тухай хуулийг шинэчлэн баталснаас хойш одоо хэрэгжиж буй газрын олборлолтын төслүүдийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа явагдахад хүндрэл бэрхшээлтэй, шинэ талбайд ахицтай олборлолт хийгдээгүй байгаа зэрэг нь газрын тосны тухай шинэ хуулийн холбогдох бодлого нь газрын тосны салбарын хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа төдийгүй Монгол Улсын газрын тосны аж үйлдвэрийн хөгжлийг ихээхэн хязгаарлаж, саад учруулж байгаагийн илрэл юм. Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгө оруулах итгэлийг баталгаажуулах үүднээс ХОТХ-ийг шинэчлэн найруулахын зэрэгцээ Газрын тосны тухай хуулийг дахин шинэчлэн найруулах асуудлыг авч үзэхийг санал болгож байна. 	<p>4. 4 болон 5 дахь асуултын хариу: Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгалын асуудал нь хөрөнгө оруулагчийн асуудал гэхээс илүү түүний бий болгох ажлын байртай холбоотой, ажилтны нийгмийн асуудал буюу хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал байна. Энэ харилцаа нь хөдөлмөрийн харилцаанд орж буй ажилтны нийгмийн асуудалд хамаарч байгаа. Энэ асуудал нь Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулагддаг.</p> <p>6. Шууд хөрөнгө оруулалтын нэг гол шинж нь тухайн улсад ажлын байр бий болгодог гэж тайлбарладаг. Энэ ч агуулгаар уг ажлын байр бий болгож байгаатай холбоотойгоор аж ахуйн нэгж нь нийгмийн даатгалын харилцаанд заавал ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг тодорхой хувиар хариуцахаар хуульчилсан бөгөөд энэ нь үндэсний аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай байх эсэхээс үл хамаарч ижил төлөх учиртай. Эдгээрт ялгамжтай хувь ногдуулах нь хөрөнгө оруулагчаас илүүтэй ажилтнуудын эрх ашгийг хохироор эрсдэлтэй. Нөгөө талаар Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж заасны дагуу манай улс хятад улстай энэ төрлийн асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ байгуулсан тохиолдолд нийгмийн даатгалыг давхардуулахгүй төлөх боломжийг бий болгох боломжтой. Харин үүнээс бусад тохиолдолд хөрөнгө оруулагчийн гарал, үүслээс хамаарч, даатгуулагчийн эрх ашигт</p>
--	--	--	--

				<p>нөлөөлөх асуудлыг нийгмийн даатгалын хуулиар шийдвэрлэх үндэс бүрдэхгүй.</p> <p>7. Саналыг тусгасан. ТББ иргэний нийгмийн үзэл бодлоо илэрхийлэх боломж нөхцөлийг Хөрөнгө оруулалтын хуулиар хязгаарлах боломжгүй. Гэхдээ эдгээр этгээдийн хууль бус тулган шаардалт хийгээд, орон нутаг, төрийн байгууллага дахь эс үйлдэхүйд хариуцлага тооцох механизмыг хуульчилсан. Хууль бусаар хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хохирол учруулсан, нэр хүндэд халдсан бол Зөрчлийн хууль болон Иргэний хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох механизм нээлттэй.</p> <p>8. Саналыг тусгасан</p> <p>9. Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Харин тухайлсан салбар эрх зүйн шинэчлэлтэй холбоотой асуудал нь Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдэх хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, Газрын тосны тухай хуулийг шинэчлэх шаардлага нь тус хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаанд үндэслэн хийгдэх учиртай. Иймд үзэл баримтлалын хүрээнд газрын тосны тухай хуулийг шинэчлэх боломжгүй байна.</p> <p>Монгол Улсад татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулах зорилгын хүрээнд татварын хууль тогтоомжийн хүрээнд аливаа төрлийн татварын дэмжлэг үзүүлэх учиртай. Өөрөөр хэлбэл, гэрээгээр өөрөөр зохицуулах боломжгүй. Монгол Улс газрын тосны салбарын онцлогийг харгалзан татварын дэмжлэгийг</p>
--	--	--	--	---

				<p>холбогдох татварын хууль тогтоомжийн дагуу олгож байгаа. Үүнд: ААНОАТ-ын тухай хуулийн 21.1.4.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн үйл ажиллагааны болон ногдол ашгийн орлого нь ААНОАТ-аас чөлөөлөгдөхөөр байна.</p> <p>15.1.13.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч, гэрээлэгчийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай сан, төрийн сан болон Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хасагдуулж тооцно. Гэсэн дэмжлэгүүдтэй.</p> <p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.25.гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл; 13.1.26.газрын тос болон уламжлалт бус газрын тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос; зэрэг нь холбогдох татвараас чөлөөлөгдөж байна.</p>
--	--	--	--	--

				Иймд ААНОАТ болон НӨАТ -аас тус ус чөлөөлөгдсөн хангалттай дэмжлэг байгаа гэж дүгнэж болно.
7.	Vitelli & Associates	2023.04.24	<p>1. Purpose of the Law. The stated purpose of the Law is to regulation relations pertaining to the promotion of the economic development of Mongolia through -</p> <ol style="list-style-type: none"> Supporting investment, Protection of legal rights and interests of investors, Establishment of guarantee for investment, Provision of tax and non-tax incentives for investors, Determination of rights and duties of investments, and Establishment of authorities and responsibilities of government institutions in regard to maintain and protection of investments in Mongolia. <p>Observation: The Law seeks to achieve a lot.</p> <p>2. Article 2: Legislation on Investment This Article states that “legislation on investment shall consist of the Constitution of Mongolia, the Civil Code, the Law on Company, the General Law on Taxation of Mongolia, this Law and other legislative acts enacted in conformity therewith. Observations: •It is not clear why this Law states with such specificity some laws but not all. •The allowance for other legislation “enacted in conformity therewith” is troublesome. •It is important that the Law does not limit legal application to investment beyond what is listed. Energy Law and other energy-related legislation may also address important investment aspects and should not be excluded from providing investment legal guidance – what is meant by “enacted in conformity therewith”? and is it in harmony with potential investment guidance that energy laws may include?</p> <p>3. Article 3: Scope of the Law Observations: a. Section 3.3 - with respect to investments from foreign state-owned legal entities, it would seem that additional parameters for these investments would be included in the law and not only allowance for tax stabilization. b. Section 3.5 – more information is needed/recommended in the event that state owned enterprises are corporatized and should no longer operate according to procurement legislation but rather, industry standard investment. It is understood that where budget funds are utilized, procurement laws apply but where non-budget funds are used, it would seem that this law should apply. c. Section 3.6 – unclear as to what is meant by “non-commercial terms”; equity investments as exist in renewable energy are on market terms (that may not be commercial) but other donor funds may support investments. More clarity needed to understand rationale and intent of this provision.</p> <p>4. Article 4: Definitions of terms of the Law Observations: Closer examination of the definitions is recommended; it would also seem that</p>	<p>1. Агуулгын хувьд тусгасан</p> <p>2. Агуулгын хувьд тусгасан</p> <p>3. Агуулгын хувьд тусгасан. Төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалт нь энэ хуульд хамаарна. Харин арилжааны буй буюу олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хандив тусалцаа нь бие даасан гэрээгээр зохицуулагдах бөгөөд уг хөрөнгийг төрөөс хураан авах биш, эсрэгээрээ төрд өгч байгаа явдал тул саналд дурдсан хүндрэл үүсэхгүй.</p> <p>4. Агуулгын хувьд тусгасан. Уг хөрөнгө оруулалтын хэлбэрийг хуулийн төслийн дугаар зүйлд тодруулсан. Мөн хөрөнгө хэлбэрээр оруулсан ч хөрөнгө оруулалт нь хуулийн этгээдийн балансад бүртгэгдэх учиртай. Харьялалгүй хүн гэдэг нь дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхойлогдсон ойлголт.</p> <p>5. Хөрөнгө оруулалтын хувьд хуулиар хориглосноос бусад асуудал нээлтэй байхаар хуульчилсан.</p> <p>6. Төр нь хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хориглодог зарчимтай. Иймд төрийн байгууллагад хариуцлагыг өндөржүүлэх нь хөрөнгө оруулагчийг татах чухал алхам юм.</p> <p>7. Хөрөнгө оруулагчийн эрхийг хангах заалт өргөн хүрээтэй байх нь хэрэгжүүлэх нөхцөл энэ хэмжээгээр өргөн хүрээтэй байна. Саналын дагуу нарийвчлан заах нь эрхийг хязгаарлах эрсдэлтэй.</p> <p>8. Хөрөнгө оруулалтын хууль бол бүх төрлийн бизнес эрхлэгчийн харилцаанд хамаарах хууль тус бизнес нэг бүрийн онцлогт тохирсон зохицуулалт хийх боломжгүй. Гол нь хөрөнгө оруулалтын урамшуулал авч,</p>

		<p>a number of additional definitions would be useful. This is not a full review; illustrative examples but more may be considered:</p> <p>a. 4.1.1 investment – this definition could be reassessed – it is not clear what are “intangible assets”; the definition limited to financial investment and will not include “in-kind” or infrastructure swaps, for example.</p> <p>b. 4.1.2-4.1.4 investor – definitions may be clarified – e.g., what is meant by “stateless person”?</p> <p>c. 4.1.5-4.1.7 – it is not clear why certain percentages are applied; definitions are not sufficiently clear and should be strengthened.</p> <p>d. 4.1.8 – investment project – why is this defined – is this actually a business? One project of many? Part of an investment in a project? This definition is murky.</p> <p>e. 4.1.9 – investment promotion – this definition is limited and may be expanded to include marketing, sales, publications and more to reflect industry standard.</p> <p>f. 4.1.10 – investment agreement – seems to (1) be a contract and (2) is limited to investment where government is a party.</p> <p>5. Section 5: Forms of Investment Seven forms of investment are listed in addition to “any other forms of investment which are not prohibited by law”. Observations: It would seem that more specificity and clarity on types of investment would be legally authorized under this law.</p> <p>6. Article 6: General investment guarantee Section 6.1 focuses on investment protection; Section 6.2 is on economic protection but actually, Section 6.2 provides broad economic-related guarantees that include tax stabilization, rules against expropriation, and right to transfer profits, etc. Observations: Language may be clarified, e.g., “economic guarantee” implies a financial commitment which is not what Section 6.2 describes. Overall, the language of Article 6 is sufficiently vague as to open government/state to liability, for example,</p> <p>a. 6.1.2 “If legal rights and legitimate interests of an investor are violated due to unlawful acts or demands, actions or omissions by government institutions or officials, the rights and legitimate interests of an investor shall be protected, and any losses suffered shall be indemnified pursuant to relevant laws and regulations.” The murky guidance on indemnification can open significant liability issues for government.</p> <p>b. 6.1.3 “The state and its authorized bodies shall protect intellectual rights and the rights of the intellectual property right holder, pursuant to applicable laws” This is VERY broad and can open up the state to considerable liability where an investor or a holder of a right believes they have been violated – how far will this liability go?</p> <p>c. 6.2 – provisions on expropriation are critical and should have a dedicated law on this topic, typically included under land laws.</p> <p>7. Article 7: Rights of investor Observations: The language of Article 7 is very general and may be strengthened. Concern on whether government actually support some provisions, e.g.,</p>	<p>төрөөс баталгаа авч буйн хувьд үүрэг хүлээх ёстой бөгөөд нарийн заах нь хариуцлагаас зайлсхийх эрсдэл бий болгоно. \</p> <p>9. Хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн байгууллагуудын чиг үүргийг тус тус тодорхойлох нь зүйтэй бөгөөд энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой үүрэгжүүлэх зохицуулалт юм. Харин хөрөнгө оруулагч нарт чиглэсэн зохицуулалт нь хуулийн төслийн заалтаар зохицуулагдана. Хяналт шалгалтын хувьд давхардалгүй хийхийг тусгасан. Мөн төрөөс хийх хяналт шалгалтын нэг төрөл төлөвлөгөөт хяналт шалгалт бөгөөд үүнийг жил төлөвлөдөг байхаар Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан. Энэхүү хяналт шалгалтын хувьд жилд 2-оос илүүгүй хяналт шалгалтыг хийхийг заасан нь хамгийн эрсдэлтэй хянах ёстой чиг үүргээ тодорхойлж байхыг төрд</p> <p>10. хөрөнгө оруулалтын урамшуулал нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжих бөгөөд хөрөнгө оруулагчийн хувьд дээрх боломжийг эдлэх боломжтойг хуульчилсан.</p> <p>11. Саналыг зарчмын хувьд авсан. Хөрөнгө оруулалтын хэмжээ болон хөрөнгө оруулсан төсөл хэрэгжих хугацааны доод хэмжээнээс өөр шалгуур тавиагүй. Харин хүсэлт хянан шийдвэрлэх ажиллагаа нь одоо хэрэгжиж байгаа хуулийн дагуу хийгдэг бөгөөд хугацааны хувьд асуудал үүсэж байгаагүй.</p> <p>12. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн сайд болон салбарын сайд гарын үсэг зурна. Гэрээний суурь загварыг Засгийн газар тогтоох бөгөөд хуульд зайлшгүй байх ёстой нөхцөлийг л тусгасан.</p> <p>13. Гадаадын төрийн өмчит компанийн</p>
--	--	--	--

		<p>7.1.4 “to satisfy own foreign currency needs by purchasing or selling foreign currencies through banks and non-banking institutions registered in Mongolia”</p> <ol style="list-style-type: none"> i. Does this mean Mongolian banks/non-banking institutions must service limitless foreign currency requests? ii. Does this mean Mongolian banks/non-banking institutions must keep all requested foreign currencies on hand? <p>7.1.9 “to receive state services freely and equally” – this is seemingly very broad – what exactly does this mean?</p> <p>8. Article 8: Obligations of investor Nine obligations are listed with the tenth broadly stated as “such other obligations as stipulated in the applicable laws”. Observations: The obligations are very broadly stated – this is a law so any obligation should be clearly defined and limited in order to be enforceable in court. For example, 8.1.6 “to improve knowledge, experience, and professional skills of their employees to focus on improvement of management style and to introduce principles of good corporate governance projects.”</p> <ol style="list-style-type: none"> i. How can this be measured to be legally enforceable? ii. Mixing important principles of corporate governance with skills/knowledge building is not recommended – these should be separate provisions. <p>9. Institutional review is included as follows.</p> <ol style="list-style-type: none"> i. Article 9: Powers of the Cabinet ii. Article 10: Powers of the State Central Administrative Body in Charge of Investment Affairs iii. Article 11: Responsibilities of State Administrative Body in Charge of Investment Affairs iv. Article 12: Responsibilities of other state bodies on investment v. Article 13: Powers of local government and local self-governing body on investment vi. Article 14: Powers of the Diplomatic mission to support investment <p>Observations: As drafted, this section can be confusing for investors and stakeholders to truly understand the hierarchy of institutional authority, time-based actions and scope of each institutions powers. Very troubling is reference to “inspections”; while inspections are limited to twice per year (Section 12.3) what are they inspections on and will this be read alongside potential inspections required for energy projects? The language and specificity should be strengthened to ensure predictability, avoid duplication of activities and set out a very clear institutional framework for investments.</p> <p>10. This chapter emphasizes incentives for investors, e.g.</p> <ol style="list-style-type: none"> i. Article 15: Tax incentives for investment ii. Article 16: Non-tax incentives for investment <p>Observations: Much of the language reads more as policy than as law. Whatever is stated here should be enforceable in a court of law – it does not seem possible to enforce some of these items, notably under Article 16.</p>	<p>хувьд үндэсний аюулгүй байдалд чухал гэж үзсэн үндсэн 3 салбарт хяналттай хөрөнгө оруулах зорилгоор энэ заалт байгаа. Бусад салбарт хөрөнгө оруулах тохиолдолд энэ нь хуулиар нээлттэй гэсэн үг. Хөрөнгө оруулалтын хувьд стратегийн чухал ач холбогдолтой салбарт гадаадын төрийн өмчит компанийн хяналт өндөр болохоос сэргийлэх зорилгоор Компанийн тухай хуульд заасан хяналтын багцын хэмжээгээр зөвшөөрөл авах босгыг тогтоосон. Хөрөнгө оруулалтын гэрээ нь тусгай зохицуулалттай салбарт хийгдэх гэрээнээс тусдаа бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчийн бусад салбар хуулиар хүлээсэн үүргийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.</p> <p>14. Санал туссан. Гэрчилгээ олгосон гэрээ байгуулсан этгээд нь хөрөнгө оруулалттай холбоотойгоор хяналт тавих ёстой бөгөөд хөрөнгө оруулалттай хамт бусад мэргэжлийн чиглэлийн төрийн байгууллагын оролцоог хангах асуудлыг хуулийн төсөлд тусгасан. Уг байгууллагууд нь өөрийн салбар хуулийн дагуу хяналт шалгалт хийх эрх нь мөн нээлттэй.</p> <p>15. Саналыг тусгасан. Гомдлыг хүлээн авах этгээд нь байнгын ажиллагаатай маргаан шийдвэрлэх зөвлөл байх ба энэ нь шийдвэр гаргасан төрийн байгууллагатай уулзаж эргэн холбоо үүсгэх ба энэ талаар зөвлөгөө өгөх шийдвэр гаргаж, уг зөвлөгөө биелэгдээгүй тохиолдолд гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэгч Засгийн газарт уламжлан асуудлыг эцэслэн шийдвэрлэх нөхцөлийг хуулийн төсөлд тусгасан.</p> <p>16. Агуулгын хувьд туссан бөгөөд арбитр, шүүх аль ч тохиолдолд гэрээгээр тусгайлан заагаагүй бол маргааныг</p>
--	--	--	---

		<p>11. These articles allow for stabilization of tax rates by issuance of stabilization certificates.</p> <ul style="list-style-type: none"> i. Article 17: Stabilization of tax rate and amount ii. Article 18: Types of tax to be stabilized iii. Article 19: Stabilization certificate iv. Article 20: Criteria and duration for issuing a stabilization certificate v. Article 21: Applying for stabilization certificate vi. Article 22: Issuing stabilization certificate vii. Article 23: Revoking a stabilization certificate <p>Specific figures are legislated under Article 20 with respect to economic sectors such as mining, heavy industry and infrastructure.</p> <p>Section 20.3 allows 1.5 times the duration of a stabilization certificate for certain investors implementing specific projects (e.g., domestic production, value-addition processing).</p> <p>Section 20.5 allows for investor to request extension of investment completion period for two years.</p> <p>Observations:</p> <ul style="list-style-type: none"> a. As drafted, it appears that virtually all investments except for tobacco and alcohol are entitled to tax stabilization. (note: cannabis is not tobacco). For example, the criteria is broad and allows a stabilization certificate where investment “creates stable workplaces” (20.1.3), or “introduces advanced technology (20.1.4). b. Tax stabilization provisions are typically applied to clearly defined categories of investment and for certain period of time. c. Tax stabilization provisions are commonly detailed in tax legislation, not investment legislation. d. Section 20.2 -By including specific figures for investment it is important to note that these figures may require amendment in years to come. e. Section 20.3 – stabilization shall be 1.5 longer for certain investors. f. Section 20.5 the idea of an “investment completion period” is not clear or understood – typically investments are ongoing. g. Section 22.1 – the state central administrative body in charge of investment has 30 days from electronic application from investor to determine whether to issue stabilization certificate – this seems fast. h. Articles 22 and 23 may be better detailed in regulations; should include clear time-based provisions and opportunities to appeal decisions. <p>12. Article 24: Investment agreement</p> <p>Eleven provisions are given to broadly explain an “investment agreement”; guidance is very general.</p> <p>Observations:</p> <ul style="list-style-type: none"> a. It is not clear why Article 24 is included under this Chapter. b. Rationale and objectives of these agreement are not sufficiently clear. c. This topic is important and should include greater detail. d. 24.9 includes specific provisions in the agreement but is limited – a template should be included in regulations. 	<p>шийдэхдээ үндэсний зөрчилдөөний хэм хэмжээний дагуу хууль хэрэглээний сонголт хийгдэнэ.</p> <p>17. Саналын дагуу хүлээлгэх хариуцлага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдох бөгөөд төрийн шийдвэрийг биелүүлээгүйтэй холбоотой асуудалд Эрүүл хууль, Зөрчлийн хуулийн хариуцлага яригдана. Харин иргэн хоорондын маргааны хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэний хууль болон түүнтэй холбоотой хуулийн хариуцлага хүлээнэ.</p>
--	--	---	--

		<p>e. There appears to be great opportunity for duplication and confusion of government roles – e.g., signature of Cabinet member in charge of investment affairs for all investments? What about Ministers of Energy and other areas?</p> <p>f. Role of Minister of Finance not clear here – it would seem some role would be included.</p> <p>g. For energy projects, it is important distinguish power purchase agreements and implementation agreements and interconnection agreements from this type of legislation.</p> <p>13. Article 25: Investment by foreign state-owned legal entity This provision specifically states that a foreign state-owned legal entity holding 33% or more equity in a Mongolian legal entity in certain sectors requires “permission” – Mining Banking and finance, Media and communication.</p> <p>Observations:</p> <p>a. It is not clear why only these three sectors are identified – e.g., energy and transport are not?</p> <p>b. It is not clear why a percentage limit is given – it would seem that any foreign state-owned investment should be assessed and receive permission.</p> <p>c. This is a big deal – the details and oversight requirements should be strengthened.</p> <p>d. This type of legal guidance is typically included under securities and exchange legislation.</p> <p>14. Article 27: Monitoring of Investment agreement and stabilization certificate implementation – the State Central Administrative Body in charge of investment affairs shall monitor investment agreements. Observations:</p> <p>a. This institutional approach may be reviewed with consideration of other ministries engaged in investment oversight as well as the Ministry of Finance responsible for administration of tax legislation.</p> <p>b. Language in this section is very general and should be more specific, e.g., 27.5 “investors shall comply with recommendation and directives....”</p> <p>15. This Chapter appears to centralize handling of complaints. Article 28: Investor complaints and resolving complaints Observations:</p> <p>a. It is not clear that relevant line ministries have any role in handling investor complaints – there can be constant issues for discussion, how will this be balanced and determined amongst the various government entities?</p> <p>b. Does the state administrative body have the requisite expertise to understand the investment structuring of various sectors?</p> <p>16. This provision appears to seek to replace what typically is included in a contract.</p> <p>a. Article 29: Investment disputes Observations: This is a very short but clear path for disputes with reliance on negotiations and arbitration; only use of Mongolian law where judicial review may be required.</p>	
--	--	---	--

			<p>More detail should be included or described in regulations.</p> <p>17. This section is extremely brief.</p> <p>a. Article 30: Sanctions for law violators</p> <p>b. Article 31: Entry into Force</p> <p>Observations:</p> <p>c. This section is far too limited to provide useful legal guidance; if this topic is to be addressed in this law, greater detail is essential.</p> <p>d. Typically, where sanctions are segregated in a law, there will be details on what are considered to be violations.</p> <p>e. It is very surprising to only see reference to criminal law; civil law may also apply in the case of violations, labor issues, land matters, etc.</p> <p>f. Mention of the law on civil service is relevant for government staff but not private sector workers.</p>	
8.	Commercial Law Development Program /CLDP/		<p>General Comments</p> <p>1. Consider whether the definitions and terms are sufficiently defined under the current or proposed legislation. It appears that the current and proposed laws are very broad and this may leave considerable room for disagreement on the interpretation of a term or definition. For example, compare how “investment” is defined in the following;</p> <p>Law of Mongolia on Investment 4.1.1. “investment” [emphasis added] shall mean tangible and intangible assets attributed to the share capital and reflected in financial statements of business entities established for profit generating purposes within the territory of Mongolia</p> <p>Mongolia – Canada BIT: “investment” means:</p> <ol style="list-style-type: none"> 1. an enterprise; 2. shares, stocks and other forms of equity participation in an enterprise; 3. bonds, debentures and other debt instruments of an enterprise; 4. a loan to an enterprise; 5. notwithstanding subparagraphs (c) and (d) above, a loan to or debt security issued by a financial institution is an investment only where the loan or debt security is treated as regulatory capital by the Party in whose territory the financial institution is located; 6. an interest in an enterprise that entitles the owner to a share in income or profits of the enterprise; 7. an interest in an enterprise that entitles the owner to share in the assets of that enterprise on dissolution; 8. interests arising from the commitment of capital or other resources in the territory of a Party to economic activity in such territory, such as under: <ol style="list-style-type: none"> 1. contracts involving the presence of an investor’s property in the territory of the Party, including turnkey or construction contracts, and concessions, or 2. contracts where remuneration depends substantially on the production, revenues or profits of an enterprise; 9. intellectual property rights; and 10. any other tangible or intangible, moveable or immovable, property and related property rights acquired in the expectation of or used for the purpose of economic benefit or other 	<ol style="list-style-type: none"> 1. Агуулгын хувьд тусгасан. 2. Агуулгын хувьд тусгасан бөгөөд хууль бусаар хөрөнгийг дайчлан авахын эсрэг зохицуулалтыг шийдвэр гаргагч нарт хүлээлгэх хариуцлагаар тогтоосон бол хууль ёсоор дайчлах шийдвэрийг үл ялгаварлах, нийтийн эрх ашгийн төлөө үйлдэх ба ингэхдээ нөхөх олговрыг олгох ёстойг нарийвчлан тодорхой заасан. 3. Хувь эзэмшилтэй холбоотой асуудалд хөрөнгө оруулалтын хуулиар хязгаарлалт тавиагүй. Зарим төрлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласныг нээлттэй болгосон. 4. Хөрөнгө оруулалттай холбоотой бүртгэл, зөвшөөрлийн асуудал зөвхөн хөрөнгө оруулалтын тухай хуульд л байна. Бусад этгээдийн шийдвэрээр хөрөнгө оруулагчаас нэмэлт зөвшөөрөл нэхэмжлэх бол энэ нь хууль бус болох ба энэ тохиолдолд уг албан тушаалтан хариуцлага хүлээхээр хуулийн төсөлд тусгасан. 5. Гадаадын хөрөнгө оруулагч нарт тавьдаг хязгаарлалтыг энэ хуулиар аль болох бууруулсан. Гэвч Генетик нөөцийн хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль гэх мэт зарим нэг салбарт дотоодын хөрөнгө оруулагчийн хувь

			<p>business purpose; but “investment” does not mean:</p> <p>11. claims to money that arise solely from:</p> <ol style="list-style-type: none"> 1. commercial contracts for the sale of goods or services by a national or enterprise in the territory of a Party to an enterprise in the territory of the other Party, or 2. the extension of credit in connection with a commercial transaction, such as trade financing, other than a loan covered by subparagraph (d); or 12. any other claims to money, that do not involve the kinds of interests set out in subparagraphs (a) to (j); <ol style="list-style-type: none"> 2. Analyze exchange and repatriation rules to determine a proper balance between investor and state. Nothing repels investors more quickly than concern about repatriation of profits (what the investors are hoping to achieve in the first instance) or their capital infusion. 3. Will investment laws allow up to 100% equity foreign ownership in Mongolian entities? What limits exist legally and practically? Are there license requirements or local or agency rules independent of national investment laws (for example, relating to natural resources including ore, oil, gas, and water). 4. Are there special investment rules, licenses, regulations from aimags bag or khoroo agencies? Are they consistent? What happens if there is some disagreement among them relating to an investment? 5. Depending on the industry and the entity, are there some limits on the extent of foreign investment in certain sectors? What about provisions requiring a minimum ownership by certain indigenous ethnic groups? Are there any restrictions or prohibitions on doing business with certain countries, jurisdictions, entities, organizations or individuals? <p>Other Comments</p> <p>The draft Law on Investment generally follows the 2013 Law on Investment. These comments (1) review the significant changes to the 2013 Law, and (2) address several specific sections.</p> <p>Significant Changes</p> <ol style="list-style-type: none"> 6. Article 6 General Investment Guarantee Several important new guarantees for investors are included in the draft law. Section 6.1.1 is a national treatment standard –investors are treated on the basis of non-discrimination. Section 6.1.2 provides investor protection against the “unlawful acts or demands, actions or omissions by government institutions or officials,” and states that “any losses suffered shall be indemnified pursuant to relevant laws and regulations.” Section 6.1.3 guarantees that an investor shall have a right to arbitration of investment disputes arising between the investor and government organizations as mutually agreed by the party. These provisions benefit foreign investors. Note that Section 6.1.3 requires mutual agreement for international arbitration, and may be inconsistent with the unilateral declaration in Section 29.2.1 that international arbitration will be available. 7. Article 7. Rights of Investor Two new rights have been included. Section 7.1.8 provides that investors have the right to submit petitions to authorities or file court cases where their rights or interests are violated due to acts or omissions of government institutions. Section 7.1.10 provides that investors have the right to obtain open access information on investment. 	<p>оролцоо зайлшгүй байх, гадаадын хөрөнгө оруулагчийн оролцоог хориглосон нөхцөл байгаа. Харин тухайлсан бүс нутагт үйл ажиллагаа явуулах тохиолдолд заавал нутгийн иргэд хувь эзэмших ёстой зохицуулалт байхгүй.</p> <ol style="list-style-type: none"> 6. Хуулиар арбитрын журмаар хандах эрхийг нээлттэй болгосноор иргэд, төрийн хооронд арбитрын журмаар маргаан шийдвэрлэх боломжийг бий болгож байгаа ба энэ нь олон улсын практикт байдаг. 7. Дэмжсэн санал өгсөн байна. 8. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл явц нь өргөн хүрээтэй, Засгийн газраас эрх авсны үндсэн дээр хийгдэх тул журмыг Засгийн газар батлах нь зүйтэй. Харин тухайлсан гэрээ бүрд иргэд, олон нийтээс санал авах асуудалд ач холбогдол тодорхойгүй. Нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдолд олон нийтээс санал авах нь зүйтэй. Хөрөнгө оруулагч нэг бүртэй хийх гэрээ бүрд олон нийтийн асуулга хийх тохиолдолд хөрөнгө оруулалтыг татах бус үргээх бодлого болно. 9. Төрийн хяналт шалгалт их байх нь бизнес эрхлэлтэд сөргөөр нөлөөлөх тул хяналт шалгалтыг тодорхой төлөвлөгөөтэй хийхдээ нэг байгууллагын үйл ажиллагаанд хэт ачаалал үүсгэхгүй байхаар тусгасан. Мэдээж зөрчил гаргасан бол гэнэтийн шалгалтууд хийгдэх асуудал нээлттэй. 10. Саналыг тусгасан бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчид үйлчлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байхад илүүтэй анхаарсан зохицуулалт болно. 11. Саналыг зарчмын хувьд тусгасан. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл явц нь өргөн хүрээтэй, Засгийн газраас эрх авсны үндсэн дээр хийгдэх
--	--	--	--	--

		<p>Both rights are beneficial to foreign investors.</p> <p>8. Article 9. Powers of the Cabinet The role of the Cabinet was not specified in the 2013 law. Section 9.1 provides that the Cabinet will have control over an integrated investment policy and all investment agreements. It also has the power to make decisions pertaining to the legitimate rights and interests of investors. Cabinet approval is required for procedures for submitting requests for an investment agreement, conducting negotiations, eligibility criteria, the signing of the investment agreement, monitoring regulations, and the template of an investment agreement. (Section 24.10). It also must approve procedures for investor complaint resolution (Section 28.6). Article 9 also states that the Cabinet shall “approve and enforce” the regulations and procedures. Cabinets do not normally have an enforcement arm and reference to the Ministry of Justice may be preferable. This Article clarifies the governance structure of the investment regime in Mongolia, and centralizes power with the Cabinet. To assure some transparency, the template of an investment agreement should be made available to the public for comment prior to approval.</p> <p>9. Article 12 Responsibilities of other state bodies on investment This article limits state inspection activities to no more than two per year. Note that in Section 12.1 the translation appears to omit language as the English version is incomplete.</p> <p>10. Article 13 Powers of local government and local self-governing body on investment. This article also is a governance design feature intended to ensure cooperation between the national investment authorities and sub-national units.</p> <p>11. Article 24. Investment Agreement The article in the 2013 Law on Investment has been substantially expanded to clarify the procedure for requesting and obtaining an investment agreement. This Article delineates the powers and functions of the State central administrative body in charge of investment affairs, the Member of the Cabinet in charge in investment affairs, and the Cabinet. It specifies mandatory provisions to be included in an investment agreement—investment purpose, amount, modality, completion date, scope of government support, guarantees, rights and responsibilities of parties to the agreement, scope of collaboration, applicable laws and dispute resolution. The investment agreement template to be developed should be presented to private sector/civil society groups prior to formal Cabinet approval for comment. This article should facilitate the ability of foreign investors to secure an investment agreement with Mongolia.</p> <p>12. Article 27 Monitoring of Investment Agreement and Stabilization Certificate Implementation This article establishes a mechanism for monitoring investment agreements and stabilization certificates (tax incentives). It specifies that investors must provide operational reports and audited financial statements on an annual basis, requires the State central administrative body in charge of investment affairs to monitor implementation and issue directives and recommendations on implementation, and requires investors to comply with the recommendations and directives.</p> <p>13. Chapter Nine Preliminary Resolution Procedure for investor Complaints Article 28. Investor complaints and resolving complaints This article provides a mechanism for investors to file a complaint electronically with the State administrative body in charge of investment affairs if the investor believes its “legitimate</p>	<p>тул журмыг Засгийн газар батлах, түүнд тусгах асуудлын талаар ерөнхий тавигдах шаардлагыг төсөлд заасан. Нөгөө талаас нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдолд олон нийтээс санал авах нь зүйтэй. Хөрөнгө оруулагч нэг бүртэй хийх гэрээ бүрд олон нийтийн асуулга хийх тохиолдолд хөрөнгө оруулалтыг татах бус үргээх бодлого болно.</p> <p>12. Тусгайлсан саналгүй, зохицуулалтыг дурдсан санал өгсөн байна.</p> <p>13. Дэмжсэн санал өгсөн байна.</p> <p>14. Хуулиар арбитрын журмаар хандах эрхийг нээлттэй болгосноор иргэд, төрийн хооронд арбитрын журмаар маргаан шийдвэрлэх боломжийг бий болгож байгаа ба энэ нь олон улсын практикт түгээмэл байдаг. Нөгөө талаар Иргэний хууль тогтоомжийн дагуу талууд гэрээний эрх чөлөөний зарчмыг тодорхойлсон. Энэ ч агуулгаар талууд хэрэглэх хууль, шүүхийн харьяаллыг сонгох эрх нь нээлттэй юм.</p> <p>15. Тусгайлсан саналгүй, зохицуулалтыг дурдсан санал өгсөн байна.</p> <p>16. Дэмжсэн санал өгсөн ба зарим нэг техникийн засварын шинжтэй санал өгснийг хүлээн авлаа.</p>
--	--	--	--

			<p>rights and interests are violated due to actions or inactions by government institutions and officials.” The State administrative body in charge of investment affairs “shall act to resolve the investor complaint.”</p> <p>The investor complaint system established by this article is beneficial to foreign investors and envisions a mechanism to help investors deal with the differing government (national and sub-national) units.</p> <p>Chapter 10 Investor Disputes</p> <p>14. Article 29. Investment Disputes</p> <p>This article provides that if there is a dispute between the investor and a government institution of Mongolia, the parties should first engage in negotiation, and if the dispute isn’t resolved within 3 months, the parties can submit the matter to arbitration before the International Centre for the Settlement of Investment Disputes (ICSID). Both Mongolia and the United States are parties to the international treaty establishing ICSID, and Mongolia, under Article 29, appears to consent to arbitration of investment disputes by a foreign investor of a party to the ICSID Convention.</p> <p>There have been investor-state arbitrations in the past where a state has argued that its unilateral declaration in a law did not constitute “consent” under the ICSID convention. Where an investment agreement is entered into, this consent will be explicit in the arbitration clause.</p> <p>Section 29.3 provides that an investor and Mongolian private parties (individuals or entities) may, by mutual agreement, agree to arbitrate disputes in Mongolia or in a foreign jurisdiction. The section should be revised to provide that the parties by mutual agreement, may select the law to govern the agreement. Section 29.3 further specifies that if there is no arbitration agreement, the dispute will be resolved pursuant to Mongolian law. This should be revised to provide that the parties may select the applicable law to govern the agreement, which may be Mongolian law or the law of a foreign jurisdiction.</p> <p>15. Other than the significant changes referred to above, the draft Law on Investments largely follows the structure and provisions of the 2013 law.</p> <p>16. Some specific comments follow:</p> <ul style="list-style-type: none"> • Section 2.1 The legislation on investment has been expanded to include the Civil Code and the Law on Company. • Section 3.3 The reference to Clause 18.1 is incorrect. • Article 4 New definitions have been added for “investment project”, “investment promotion”, “investment agreement”, “investor complaint”, and “investor dispute.” Adding these definitions is useful. • Article 5 Two new forms of investment have been included: investment in monetization of intellectual property rights, and issuance of convertible debt. Both of these expand the investments covered by the law. • Article 6.2.6 There appears to be an error—likely in translation—of the phrase “unless otherwise not specified in the law.” • Article 8 Obligations of the Investor. Note that the language is not precise in identifying the Investor’s obligation. Terms such as “international standards”, “activities that respect the interests of consumers, are friendly to the environment, and support human development” are goal-oriented. This language is not new and is in the 2013 Law on Investment. A new 	
--	--	--	--	--

			Section 8.1.9 has been added in the draft law to provide that investors have an obligation “to introduce good environmental, social and governance practices and approaches.”	
9.	Монголын Уул уурхайн үндэсний Ассоциаци /МУУУА/	2023.05.01 23/94	<p>1. 3.4. Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулахын тулд компани байгуулах шаардлагатай гэж ойлгогдож байна. Эсхүл, бүртгэлтэй компанид хувь эзэмших байдлаар хөрөнгө оруулахдаа улсын бүртгэлд бүртгүүлэхийг хэлээд байна уу? Тийм бол, хувь эзэмшихээс өөр бусад байдлаар хөрөнгө оруулахыг үгүйсгэсэн заалт болж байна. Санал: Өөрчлөн найруулах эсхүл хасах</p> <p>2. 4.1.1, 5.1. Төслийн 5.1-т заасан бусад хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийг үгүйсгэж, зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгө оруулсан тохиолдолд хөрөнгө оруулалт гэж ойлгогдохоор байна. Санал: Өөрчлөн найруулах эсхүл хасах</p> <p>3. 4.1.5. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хараат болон охин компани бүгд гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үзэх нөхцөл үүсгэж байна. (Компанийн 20%-ийг ГХО компани 80%-ийг Монгол компани эзэмшиж байхад ч тухайн компани ГХО-тай болох нь) Үргэлжилсэн хэлхээ холбоон дахь гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг нь хөөж бодсоны үр дүнд 25 буюу түүнээс дээш хувийн гадаадын хөрөнгө оруулалттай бол “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж тооцох нь зүйтэй болов уу. Санал: Өөрчлөн найруулах</p> <p>4. 6.2.1. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно гэсэн боловч Татварын орчныг тогтворжуулах гэдгийг тодорхойлсон зүйл алга байна. Санал болгоход: Татварын орчныг тогтворжуулах гэдэгт хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын төрөл, тэдгээрийн хувь хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх талаар зохицуулсан Монгол Улсын татварын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр, болон бусад эрх зүйн баримт бичгүүд тухайн Хөрөнгө оруулалтын гэрээ хүчинтэй байх хугацаанд ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хөрөнгө оруулагчид үйлчлэхийг ойлгоно. Иймд Татварын орчин гэж юуг ойлгох талаар Төсөлд тодорхойлж оруулах</p> <p>5. 6.2.4, 6.2.5 Нөхөн олговор VS нөхөх олговор Санал: Нийцүүлэх</p> <p>6. 8.1.9 хөрөнгө оруулагчийн нийтлэг үүрэгт “байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх” Олон улсын сүүлийн үеийн чиг хандлагаар “байгаль орчин, нийгэм, сайн засаглал” (цаашид “ESG” гэх)-ын тайлан гаргах санал санаачилга өргөжин тэлж байгаа нь тухайн хуулийн этгээд хөрөнгө оруулалт татах боломжоо нэмэхийн тулд санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна тогтвортой бөгөөд найдвартай байдлыг илтгэх санхүүгийн бус үзүүлэлтүүдээ үнэлэх, өөртөө давуу байдлыг үүсгэх сонирхолтой холбоотой гол төлөв томоохон групп компаниудын зүгээс гаргаж байгаа тайлан мэдээ байгаа. Энэ асуудлыг ямар нэг хэр хэмжээний шалгуургүйгээр нийтлэг байдлаар үүрэгжүүлэн шаардах нь эерэг үр дагавар үүсгэхээс илүүцээр хэлбэрийн төдий чирэгдэл дагуулсан</p>	<p>1. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай.</p> <p>2. 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>3. Саналыг тусгав.</p> <p>4. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжиж дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Түүнчлэн, давхар татварын гэрээний хувьд татварыг аль улсад төлөх ёстойг тодорхойлсон тусдаа баримт бичиг бөгөөд энэ нь 2 улсын засгийн газар хоорондын гэрээг УИХ дангаараа тогтворжуулах боломжгүй юм. Иймд, давхар татварын гэрээнд тогтворжуулах нөхцөл ярих нь зохимжгүй.</p>

		<p>ажиллагаа болж мэднэ. Санал: Сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж байгаа санал санаачилгыг хуулийн шаардлага болгох шаардлагагүй тул хасах</p> <p>7. 15.1.1. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, энэ заалтыг ААНОАТХ-д оруулаагүй тохиолдолд хэрэгжих боломжгүй тул энэхүү заалтыг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>8. 15.1.2. Энэ заалтыг “тогтворжуулах гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын орчныг тогтворжуулах” гэж Төслийн 6.2.1-тэй нийцүүлэх саналтай байна. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, Хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах тухай бусад хуулиудад тусгах шаардлагатай байна. Одоогийн татварын хуулиудад зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулахаар заасан байгаа: Татварын ерөнхий хууль 12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулах татварыг тогтворжуулах хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх; ААНОАТХ 20.3. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 35.6. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө. Ашигт малтиалын тухай хууль 47.15. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна. НӨАТХ-д тогтворжуулах заалт огт тусгагдаагүй байна. Санал: Өөрчлөн найруулах, мөн, Хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах зохицуулалтыг нэр бүхий хуулиудад оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах -Татварын ерөнхий хууль -ААНОАТХ -Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль -Ашигт малтмалын тухай хууль -НӨАТХ</p> <p>9. 15.1.3, 15.1.4. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, эдгээр татварын дэмжлэгийн ААНОАТХ-д оруулах</p>	<p>5. Саналыг тусгаж, нөхөх олговор гэж тодорхойлов.</p> <p>6. Саналыг тусгасан. Харин компанийн удирдлагын сайн засаглал нэвтрүүлэх, стандарт нөхцөлийг мөрдөж ажиллах гэсэн агуулгаар ажиллахыг үүрэг болгов.</p> <p>7. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан.</p> <p>8. Саналын дагуу өөрчлөлтийг холбогдох хуулиудад оруулсан. Гэхдээ татвар тогтворжуулах асуудал нь Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зааснаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг татварын хуульд заахгүй байхыг хуульчилсан. Түүнчлэн татварын орчин бус татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг төсөлд тусгасан. Үүнтэй холбоотой тогтворжуулах гэрчилгээгээр татвар тогтворжуулах нөхцөлийг НӨАТ хуульд тусгасан.</p> <p>9. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд</p>
--	--	--	--

		<p>Мөн, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, улмаар ажил гүйлгээгээ НББ-ийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд “Хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэдгийг үзүүлэх татварын дэмжлэг гэдэгт нэмж оруулах. Санал: Эдгээр татварын дэмжлэгийг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>10. 18.1.Доорх татваруудыг нэмж оруулж болох: Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр Үл хөдлөх хөрөнгийн татвар Онцгой албан татвар Санал: Доорх татваруудыг нэмж оруулж болох: Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр Үл хөдлөх хөрөнгийн татвар Онцгой албан татвар</p> <p>11. Хөрөнгө оруулагчид татварын тогтвортой орчноос гадна Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан үйл ажиллагааны орчин тогтвортой байх нь чухал ач холбогдолтой байдаг. Иймд төслийн 24 дүгээр зүйлд дараахыг нэмж оруулах саналтай байна. “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын гэрээний хүрээнд талуудын хооронд тодорхой асуудлаар Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан зохицуулалт нь тухайн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөрөнгө оруулагчид тогтвортой үйлчилнэ.” Санал: Нэмэх</p> <p>12. 27.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах талаар зөвлөмж, чиглэл өгч болно. Санал: Төрийн байгууллагаас аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд чиглэл өгөх нь зохимжгүй тул тэр үгийг хасах саналтай байна.</p> <p>13. 28.1. Энэхүү урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой хугацаа зааж өгөх шаардлагатай байна. Эсхүл, Төслийн 29.2-т зааснаар “Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн” гэдгийг энэхүү урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж ойлгоод 3 сарын хугацааг баримтлах уу? Эсхүл, ерөнхий 30 хоног баримтлах уу? Санал: Тодорхой болгох</p> <p>14. 28.2. Хөрөнгө оруулагчийн гомдол нь Хөрөнгө оруулалтын гэрээ, татварын тогтворжуулалттай холбоотой аливаа асуудлаар байж болох тул зөвхөн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоотойгоор гомдлыг шийдвэрлэх нь учир дутагдалтай юм. Иймд “Гомдлыг шийдвэрлэх арга хэмжээнд хөрөнгө оруулагчийн гаргасан гомдолд хамаарах төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.” гэж нэмэх саналтай байна. Түүнчлэн хөрөнгө оруулалттай холбоотой л бол ямар ч тохиолдолд хэлэлцээ хийх боломжийг олгохын тулд</p>	<p>туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Харин хөнгөлөлт, чөлөөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтаар тооцож баталгаажуулах, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө гэж заасантай зөрчилдөхөөр байх тул хүлээн авах боломжгүй.</p> <p>10. Татвар тогтворжуулах бодлого нь төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийг тооцох учиртай. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийн зорилго нь хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахад илүүтэй анхаарсан бөгөөд дээрх санал болгож буй татварын хувь хэмжээг тогтворжуулснаар хөрөнгө оруулалтыг хэрхэн татах нь тодорхойгүй бөгөөд олон улсын байгууллагуудаас өгч буй зөвлөмжид энэ төрлийн дэмжлэгийг нэмэгдүүлэхгүй байхыг зөвлөмж болгож байгаа.</p> <p>11. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин хууль, тогтоомжийг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хууль өөрчлөгдөх бүрэн боломжтой. Энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй</p>
--	--	--	--

		<p>“Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол” гэсэн хязгаарлалтыг хасах саналтай байна.</p> <p>Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газартай байгуулдаг тул гэрээний нэг тал болох Монгол Улсын Засгийн газар эсхүл Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага нь хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийнэ гэдгийг тодруулах саналтай байна. “Хөрөнгө оруулалтын гэрээний талууд” гэж тодруулж болох юм.</p> <p>Санал: Хөрөнгө оруулагчийн гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд Татварын ерөнхий газрыг оролцуулах талаар Төсөлд тусгах</p> <p>15. 29.2. Хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн гэдэгт юуг ойлгох вэ? Төслийн 28-д заасан гомдол урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэлж байна уу эсхүл тусдаа ажиллагаа юу? Зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд ч биш арбитрт хэрэг маргаан үүсгэсний дараа ч талуудад хэлэлцээр хийх боломжийг олгох. Тухайлбал “Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотойгоор олон улсын шүүх, арбитрт маргаан үүссэн тохиолдолд хэлэлцээр хийх, эвлэрэх журмыг Засгийн газар/Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж оруулж болох юм.</p> <p>Санал: Тодорхой болгох</p> <p>16. Хуулийн төсөлд заалт тус бүр тодорхой байх, дотоод болон гадаад хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсны зарчмыг оруулах саналтай байна. Зарчмын асуудлыг тусгаж өгөхийн зэрэгцээ аливаа заалтуудыг “болно” “боломжтой” гэдэг байдлаар биш тодорхой байдлаар буюу үүрэгжүүлсэн байдлаар оруулж өгөх.</p> <p>17. Баримтлах зарчим оруулж өгөх /Одоогоор байхгүй, шинээр тусгаж өгөх/</p> <p>18. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг буцаан хэрэглэх зохицуулалтыг шинээр тусгах.</p> <p>“Шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын хууль нь Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийг буцаан хэрэглэнэ.” гэж нэмэх</p> <p>19. Хуулийн төсөлд “татварын орчин”-ы тодорхойлолтыг одоогийн хуулийн адилаар хэвээр тусгах, хуулийн төслөөс хасахгүй байх саналтай байна.</p> <p>3.1.7.“татварын орчин” гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, өгөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг ойлгохоор хуульчилсан байгаа бөгөөд уг тодорхойлолт нь татварын орчныг тогтвортой байлгах төрийн баталгааны үндэслэл болж байгаа.</p> <p>Өөрөөр хэлбэл, тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээгээр олгож буй татварын орчныг тогтвортой байлгах баталгааны цар хүрээг тодорхойлж буй туйлын чухал тодорхойлолтыг хасах нь зарчмын хувьд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах бус дордуулахаар байх тул дэмжих боломжгүй байна.</p> <p>Ялангуяа, нэг талд тогтворжуулах гэрчилгээгээр гэрчилгээнд заасан хугацаанд татварын хувь болон хэмжээг тогтвортой байлгах төрийн баталгааг өгсөн хэр нь нөгөө талд татвар ногдуулах, тайлагнах болон төлөхтэй холбоотой дүрэм журам, арга аргачлалыг өөрчлөх замаар ногдох татварын хувь болон хэмжээг нэмэх үр дагавар үүсгэж ирсэн хөрөнгө оруулагчдын итгэлийг хөсөрдүүлж ирсэн хандлага улам газар</p>	<p>зардал гаргахыг хориглоно. Хуулийг хэрэгжүүлэхгүй байх баталгааг бус харин эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах баталгааг энэ төрлийн гэрээгээр олгох нь зүйтэй. Нөгөө талаар давхар татварын гэрээний хувьд татварыг аль улсад төлөх ёстойг тодорхойлсон тусдаа баримт бичиг бөгөөд энэ нь 2 улсын засгийн газар хоорондын гэрээг УИХ дангаараа тогтворжуулах боломжгүй юм. Иймд, давхар татварын гэрээнд тогтворжуулах нөхцөл ярих нь зохимжгүй.</p> <p>12. Хөрөнгө оруулагч нэг бүртэй бус харин тогтворжуулах гэрээ авсан, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж төрөөс урамшуулал авсан хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор зөвлөмж, чиглэл өгөх нь зүйтэй. Энэхүү чиглэлийг дагаж мөрдөөгүйгээс хуулийн зөрчил үүсэх тохиолдолд хариуцлага хүлээх үндэслэл болно.</p> <p>13. Саналыг тусгаж, гомдол шийдвэрлэх процессыг үе шат бүрт нь нарийн тодорхойлсон.</p> <p>14. Хөрөнгө оруулалтын гомдлыг хянан шийдвэрлэх эрх хэмжээ Маргаан шийдвэрлэх зөвлөлд байх ба үүнд төрийн байгууллагуудын төлөөллийг хамруулсан байна. Гомдлыг эцэслэн шийдвэрлэх журмыг дахин боловсруулж, Засгийн газарт танилцуулан чиглэл өгөх зохицуулалтыг бий болгосон</p> <p>15. Гомдлыг урьдчилан хянан шийдвэрлэх журмыг хэлэлцээний журамд хамааруулж тоолох бөгөөд эдгээр хугацааны нийт хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна. Түүнчлэн арбитрын шатанд хэлэлцээ хийх асуудал нь холбогдох журмын дагуу</p>
--	--	---	---

			<p>авахаар байна гэж харж байна. Хэрэв дээр байдлыг зөвшөөрсөн байдлаар татварын хувь болон хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгож, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гэж тооцож байгаа бол уг баталгаа нь бүрэн хэмжээний баталгаа болж чадахгүй буюу хөрөнгө оруулалт татах хэмжээнд эрх зүйн баталгааг бүрдүүлж чадахгүй.</p> <p>20. Хуулийн төслийн хамтаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд өнгөрсөн хугацаанд олгоод байгаа тогтворжуулах гэрчилгээ болон байгуулсан байгаа Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа дуусаагүй байгаатай холбоотойгоор дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, тэдгээрийн хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.</p> <p>21. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2 дахь хэсгийг хуулийн төсөлд хэвээр тусгах саналтай байна. Монгол Улсын эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий дээрх салбарт хэрэгжих төслийн барилга угсралтын үе шатанд импортлох техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох тухай дээрх заалт нь тухайн төслийн хувь ямар ч орлого олж эхлээгүй байгаа барилга угсралтын үеийн зардлыг бууруулах бодит ач холбогдолтой тул хөрөнгө оруулалт оруулах хөшүүрэг болохоос гадна уг заалтын хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлаас тухайлсан хууль гаргаж хугацааны хязгаарыг тогтоож өгөх бөгөөд Засгийн газраас чөлөөлөгдөх бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг Энэ хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2 дахь хэсгийг хуулийн төсөлд хэвээр тусгах саналтай байна. Үүнд: <i>Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013)-ийн заалт:</i> <i>11.2 Доор дурдсан тохиолдолд импортлох техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</i> <i>11.2.1 Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i> <i>11.2.2 Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i> <i>11.2.3 Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих.</i></p>	<p>нээлттэй.</p> <p>16. Саналыг хүлээн авч, тусгасан.</p> <p>17. Хуульд тусгайлан зарчмын талаар тусгаагүй ч хөрөнгө оруулагчийн баталгаа хэсэг нь зарчимтай ижил агуулгатай.</p> <p>18. Хууль хоорондын хэрэглээ, хугацааг зохицуулах зорилгоор дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулсан.</p> <p>19. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжиж дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Иймд татварын орчин гэсэн ойлголтыг үл ойлголцол үүсгэхээр сэргийлж хасах нь зүйтэй байна.</p> <p>20. Саналыг тусгаж, дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан.</p> <p>21. Саналыг зарчмын хувьд тусгасан. Хөрөнгө оруулалт хийх эхний 2 жилийн хугацаанд төлөх гааль, НӨАТ-ын татварыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2-т зааснаар хойшлуулах нөхцөлийг хуульчилсныг хэвээр үлдээсэн.</p>
10.	АмЧам	2023.05.01 2023/16	<p><i>I. Хуулийн төслийн ололттой зохицуулалт</i> Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах ололттой зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:</p>	<p><i>I. Хуулийн төслийн ололттой зохицуулалт</i> Дэмжсэн санал өгсөн.</p>

		<ul style="list-style-type: none"> • Хуулийн төслийг англи хэлээр орчуулж, монгол, англи хэлээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд болон Ил тод байдлын хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэх тал дээр чухал алхам болж байна. • “Хөрөнгө оруулагч аж ахуй нэгжид хийх төрийн хяналт шалгалтын тоо жилд 2-оос ихгүй байна” гэж зохицуулж, төрөөс хийгдэх хяналт шалгалтын хэмжээг бууруулсан. • Хөрөнгө оруулагч “төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл” гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргах эрхийг олгосон. • Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн эсхүл гадаадын хөрөнгө оруулагч болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх боломжийг зохицуулсан. • Хөрөнгө оруулагчид дараах шинэ татварын дэмжлэгийг үзүүлэхээр тусгасан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах; - 15.1.2.тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах; - 15.1.3.албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдэл хорогдлын хэмжээг түргэвчилсэн аргаар тооцох; - 15.1.4.ажилтны мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох; - Одоогийн мөрдөгдөж буй хуулинд буй 100 ам.долларын хөрөнгө оруулалтын босгыг хуулийн төслөөс хассан. - “Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх” нийт хугацаа 45+5 хоног байсан нь 30 хоногийн дотор болж богиноссон. <p><i>II. Зарчмын болон Ерөнхий саналууд</i></p> <p>Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд дараах ерөнхий саналуудын дагуу холбогдох зохицуулалтуудыг нэмж тусгах шаардлагатай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол улс бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц хөрөнгө оруулалт татах улс болоход урамшууллын төрөл хэтэрхий цөөн, татварын дэмжлэгүүд хангалттай бус байна гэж АмЧам Монгол үзэж байна. Иймд урамшууллын төрлүүдийг нэмэх, татварын хөнгөлөлтүүдийг хангалттай хэмжээнд тусгах шаардлагатай. Хуулийн төсөлд тусгагдсан хөшүүргийг харвал гадаадын хөрөнгө оруулагчид Монгол улсаас илүү бүс нутгийн БНСУ, Казахстан, Вьетнам, Камбож г.м. орнуудад хөрөнгө оруулалт хийхээр байна. Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа улсад хөрөнгө оруулахдаа эхний ээлжид татварын болон татварын бус дэмжлэгүүдийг хүсэж байдаг тул хуулийн төсөлд Монгол Улсын санал болгох хөрөнгө оруулалтын урамшуулал, хөшүүргүүдийг улам нэмэгдүүлж, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц болгох шаардлагатай байна. Жишээлбэл, Үндэсний Хөгжлийн Газраас 2020 онд хийлгэсэн “Гадаад орнуудын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”-нд дурдсанаар “БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили улсын Засгийн газраас хөрөнгө оруулалтын урамшууллыг голдуу татварын хөнгөлөлт хэлбэрээр, бизнесийн үйл ажиллагааг явуулж эхлэхэд олгож байна. 	<p><i>II. Зарчмын болон Ерөнхий саналууд</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой. 2. Саналын дагуу олон нийтэд ил тод танилцуулж байна. 3. Саналын дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан. Нийтэд ил тод мэдээл байгаа. 4. Саналыг тусган хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх Маргаан
--	--	---	--

		<p>Үүнд, компанийн татвар, орлогын татвар, орон нутгийн татвар/үл хөдлөх хөрөнгийн татвар/ зэргийг хөнгөлдөг байна. Мөн бараа бүтээгдэхүүнийг гаалийн хураамж, нэмүү өртгийн татвараас чөлөөлөн үзүүлдэг. Хэрэв гадаадын хөрөнгө оруулалт тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд, төв засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас мөнгөн дэмжлэг үзүүлэх боломж байдаг. Тухайлбал, газар худалдан авах өртөг, түрээсийн төлбөр, ажилтны сургалт, боловсролд зарцуулсан төлбөрт татаас өгөх зэрэг болно. Дээрх улс орнууд хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлэхдээ салбар тус бүр өөр өөр байх ба ихэвчлэн эхний 3 жил татвараас чөлөөлөх, жижиг хот болон алслагдсан дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хөнгөлөлт чөлөөлөлт түлхүү хамруулахаар заасан нь нийтлэг байна” гэжээ. Жижиг хотод бий болгосон барилга, худалдан авсан тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгийн нийт өртгийн 20-25 хүртэлх хувийг төрөөс татаас хэлбэрээр олгож болохоор БНСУ-ын хуульд заасан бол Чех улсад Засгийн газраас баталсан салбарт үйлдвэрлэл явуулах, шинэ ажлын байр бий болгосон төсөлд, технологийн салбарт 200,000,000 короны үйл ажиллагааны зардалтай, түүнээс 100,000,000 короныг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан, бусад төсөлд урамшуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлт хүртэхэд 20 ба түүнээс дээш ажлын байр бий болгосон байх, 3.6-4 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн бол эхний 10 хүртэлх жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх, бэлэн мөнгөний урамшуулал олгож болохоор заасан ба төрөөс авч болох нийт урамшууллын хэмжээг 45.75 сая крон хүртэл буюу нийт зардлын 19 хувь хүртэл байж болохоор заажээ. Казахстан улсын Засгийн газар уул уурхай, төмөр замын тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, барилга, төмөрлөгийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эм, мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч, салхины болон нарны эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай урамшуулалтай.</p> <p>2. Одоогийн байдлаар хууль санаачлагч, хуулийн төсөл боловсруулагч Засгийн газрын зүгээс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг нийтэд ил болгоогүй байх тул үүнийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу олон нийтэд нээлттэй болгох.</p> <p>3. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг мөн адил нийтэд ил болгох. Ингэхдээ 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд өнгөрсөн хугацаанд олгоод байгаа тогтворжуулах гэрчилгээ болон нэгэнт байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа дуусаагүй байгаатай холбоотойгоор эдгээрийн хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дараах харилцааг зохицуулах. Үүнд:</p> <p>i. 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хууль үйлчлэх хугацаанд үүссэн харилцааны хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол, үүргийг уг хуулийн шинэчилсэн найруулгын дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх талаар;</p> <p>ii. хөрөнгө оруулагчид учрах сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл байдал, арга зам;</p> <p>iii. хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах, гүйцэтгэх нөхцөл; болон</p> <p>iv. хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдол зэргийг зохицуулах.</p> <p>4. Татварын маргаан таслах зөвлөлийн адилаар “Хөрөнгө оруулалтын маргаан таслах</p>	<p>шийдвэрлэх зөвлөлийг байгуулж байгаа.</p> <ol style="list-style-type: none"> 5. 1 дэх саналын дагуу татварын дэмжлэгийг үзүүлсэн. 6. 1 дэх хэсэгт заасны дагуу татварын урамшууллыг үзүүлэх бөгөөд, гааль, НӨАТ-ын хувьд одоо хэрэгжиж байгаа татвар хойшлуулах Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн холбогдох урамшуулал хэвээр байгаа. 7. Дээр дурдсан 6 дахь заалтын дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гааль, НӨАТ-ын урамшууллыг хэвээр үлдээж байгаа. 8. Хөрөнгө оруулалтын маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх боломжийг хуулийн төсөлд тусгасан. Харин дагнасан шүүх байгуулах асуудал нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийн үзэл баримтлалаас тусдаа шүүхийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд холбогдох тооцоо, судалгаанд хийгдэх учиртай. 9. Хөрөнгө оруулалтын хууль нь нийтлэг хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн, хөрөнгө оруулалтын нийтлэг баталгааны талаар зохицуулах бөгөөд аливаа салбараар ялгаварлах боломжгүй. Харин салбарын асуудлыг холбогдох салбарын хууль тогтоомжийн хүрээнд ялгамжтай тогтоох асуудал нээлттэй. 10. Саналыг тусгаж, хөрөнгө оруулалтын урамшуулал зэргийг шууд үзүүлэхээр тусгасан. Мөн үл ялгаварлах, хууль дээдлэх, эрх тэгш, шударга байх зарчмын агуулгыг хуулийн төсөлд тусгасан. 11. Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт илүү нийцсэн зохицуулалттай болсон. Гэсэн ч хууль хэрэглээний шилжилтийн үеийг зохицуулах зорилго бүхий дагаж
--	--	---	--

		<p>зөвлөл” бүтцийг байгуулах: Хуулийн төсөлд тусгагдсан арбитраар маргаан шийдвэрлэх зохицуулалт нь зарим хөрөнгө оруулагчдын хувьд цаг хугацаа болон өртгийн хувьд өндөр зардалтай тул уг механизмаар маргаан шийдвэрлүүлэх нь ач холбогдол бага. Иймд хуулийн төсөлд урьдчилсан байдлаар хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх тухай заалт нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай байна. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байдгаас үүдэлтэйгээр нэг төрийн байгууллагын шийдвэрийг өөр нэг төрийн байгууллага хэрэгжүүлэхгүй, үгүйсгэх тохиолдол гардаг тул шүүх, арбитра зарга үүсгэхээс өмнө маргаан шийдвэрлэх хөндлөнгийн зөвлөлтэй байх шаардлагатай байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн гадаадын хөрөнгө оруулалттай компани, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтаахаар зохицуулж болно.</p> <p>5. Хөрөнгө оруулалтын татварын дэмжлэгийн зохицуулалтуудыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд уялдуулах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны нэгдмэл байдлыг хангах үүднээс татварын шинэчлэл хийх.</p> <p>6. Энэхүү шинэчилсэн найруулга нь одоо мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын хуульд буй татварын үндсэн хөшүүргийг хассанаар хөрөнгө оруулалтын орчныг улам дордуулж байна гэж бид үзэж байна. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад одоо мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан гаалийн албан татвар, НӨАТ-ын хувь хэмжээний дараах татвараас чөлөөлөх тухай (11.2) хэсгийг бүхэлд нь хасжээ.</p> <p>а. “Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <p>b. 11.2.1.барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>c. 11.2.2.нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>d. 11.2.3.эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих.”</p> <p>7. Энэхүү заалтын ачаар ЕСБХБ-ны санхүүжилтээр Монголд цементийн шинэ үйлдвэр баригдсан. Харамсалтай нь тухайн компани нь импортолсон техник, тоног төхөөрөмжөө барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлнэ гэж ойлгосон боловч энэ заалт амьдрал дээр хэрэгжээгүй. Тиймээс эдгээр бодит татварын чөлөөлөлтүүдийг шинэчилсэн найруулгад тусгаж, заавал мөрддөг байх шаардлагатай.</p> <p>8. Маргаан шийдвэрлэх. Бизнесийн эрх зүй, арилжааны эрх зүйн маргааны шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах, шүүгчдийг бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх нь хөрөнгө оруулалтын маргааны хурдан шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулагчдад хүндрэл чирэгдэл учруулахгүй байх давуу талтай. Иймд, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, тухайлбал:</p> <p>i. Шүүхийн тухай хууль,</p> <p>ii. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,</p> <p>iii. Арбитрын тухай хууль болон</p>	<p>мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан.</p> <p><i>III. Нарийвчилсан санал</i></p> <p>1. Агуулгын хувьд туссан.Монгол Улсын бүх хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэх тул хуулийг тоочих нь чухал шаардлагатай бусад хуулийг орхигдуулах эрсдэлтэй тул Үндсэн хуульд нийцсэн акт гэсэн агуулгыг төсөлд тусгалаа.</p> <p>2. Агуулгын хувьд дээрх зарчмууд тусгагдаж, хэрэгжилтийг хангуулах хүрээнд хөрөнгө оруулагчийн нийтлэг баталгаа, эрх, үүрэг болон төрийн байгууллагуудын чиг үүрэг гэсэн зүйлүүдэд тодорхой тусгасан.</p> <p>3. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай.</p> <p>4. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>5. Саналыг тусгав.</p> <p>6. Саналыг тусгав.</p> <p>7. Холбогдох маргаан нь зөвхөн татвартай холбоотой маргаан байх боломжгүй тул хөрөнгө оруулалтын маргаан гэснийг саналын дагуу тодорхойлох нь бусад асуудлаар үүсгэх маргааныг хязгаарлах эрсдэлтэй байна.</p> <p>8. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн</p>
--	--	---	--

		<p>iv. Эвлэрүүлэн зуучлах тухай хууль</p> <p>9. Салбарын дэмжлэг. Эдийн засгаа төрөлжүүлэх, уур уурхайн салбараас хэт хараат байдлыг бууруулах үүднээс Хөрөнгө оруулалтын хуулийн хүрээнд (i) нэн тэргүүнд дэмжих чиглэл болон (ii) тодорхой хүрээнд дэмжих эдийн засгийн чиглэлүүдийг тодорхойлж, тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн талаар тусгах.</p> <p>10. Хуулийн төсөлд тодорхой байх, дотоод болон гадаад хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсны зарчмыг оруулах: зарчмын асуудлыг тусгаж өгөхийн зэрэгцээ аливаа заалтуудыг “болно” “боломжтой” гэдэг байдлаар биш тодорхой байдлаар буюу үүрэгжүүлсэн байдлаар оруулж өгөх.</p> <p>11. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг буцаан хэрэглэх зохицуулалтыг шинээр тусгах: Шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын хууль нь Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийг буцаан хэрэглэнэ. гэж нэмэх</p> <p>Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудтай холбогдуулан дараах нарийвчилсан саналуудыг гаргаж байна.</p> <p>1. 2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар олгосон хөрөнгө оруулалтын дэмжлэг, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид уялдуулж, нарийвчилсан зохицуулаагүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалтын дэмжлэг бодит байдал дээр хэрэгжихгүй, улмаар хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөхөд хүрдэг. Иймд, хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийг зохицуулсан хуулиудыг нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: “2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Газрын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”</p> <p>2. Төрөөс хөрөнгө оруулалтын салбарт баримтлах зарчмуудыг тодорхойлж хуулийн төсөлд тусгах Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, хөрөнгө оруулалтыг татах, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд дараах зарчмуудыг “Төрөөс хөрөнгө оруулалтын талаар баримтлах зарчим” болгон хуулийн төсөлд тусгах: "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:</p>	<p>байгууллагын тайлагналын систем цахимжиж дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Иймд уг татварын орчин гэсэн заалтыг эргэлзээ үүсгэхгүйн тул хасах нь зүйтэй байна.</p> <p>9. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ. энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно.</p> <p>10. Саналыг тусгаж, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах асуудлыг дахин тодорхойлсон. Хууль тогтоомжийн хуулиар ч мөн зохицуулагдаж байгаа.</p> <p>11. Саналын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны сонирхлыг зөрчсөн төрийн байгууллага албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, учирсан хохирлыг барагдуулах, албан тушаалаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авахаар төсөлд тусгасан.</p> <p>12. Саналын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны сонирхлыг зөрчсөн төрийн байгууллага албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, учирсан</p>
--	--	---	---

		<p>- Хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах; - Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах; - Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах; - Тогтвортой хөгжлийг хангах; - Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.”</p> <p>3. 3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ. Уг заалтын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагын хүрээнд зөвхөн хуулийн этгээд байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хязгаарлаж, хувь хүн өөрөө хөрөнгө оруулагч байх боломжийг үгүйсгэсэн байна. Иймд, уг заалтыг хуулийн төслийн 5.1.2, 5.1.4, 5.1.6 болон 5.1.7 дахь хэсгүүдтэй уялдуулан дараах байдлаар өөрчлөн найруулах: “3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.”</p> <p>4. 4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг; Уг заалтын дагуу зөвхөн “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг хөрөнгө оруулалт гэж тооцохоор байна. Түүнчлэн уг заалт нь 5.1-д заасан хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй зөрчилдөж байна. Хөрөнгө оруулалтыг зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулах байдлаар хязгаарлах нь улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлэх хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Цаашлаад төслийн санхүүжилт зэрэг бусад хэлбэрээр хийх хөрөнгө оруулалтыг үгүйсгэдэг, татварын хувьд маргаан дагуулдаг заалт юм. Иймд, уг заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулах: “4.1.16 “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдэд хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;”</p> <p>5. 4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж хуульд заасан тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”- гэдэгт ... тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээний... гэж нэмэх</p> <p>6. 4.1.5. “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компани, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг; Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хараат болон охин компани бүгд гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үзэх нөхцөл үүсгэж байна. (Компанийн 20%-ийг ГХО компани 80%-ийг Монгол компани эзэмшиж байхад ч тухайн компани ГХО-тай болох нь). Хөрөнгө оруулалтын босго тогтоосон нь хөрөнгө оруулалтыг татах зорилготой нийцэхгүй тул хуучин заалтыг хэвээр үлдээж</p>	<p>хохирлыг барагдуулах, албан тушаалаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авахаар төсөлд тусгасан.</p> <p>13.Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжих дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Иймд уг татварын орчин гэсэн заалтыг эргэлзээ үүсгэхгүйн тул хасах нь зүйтэй байна. Нөгөө талаар давхар татварын гэрээний хувьд татварыг аль улсад төлөх ёстойг тодорхойлсон тусдаа баримт бичиг бөгөөд энэ нь 2 улсын засгийн газар хоорондын гэрээг УИХ дангаараа тогтворжуулах боломжгүй юм. Иймд, давхар татварын гэрээнд тогтворжуулах нөхцөл ярих нь зохимжгүй.</p> <p>14.Саналыг авч, хөрөнгө дайчлах тохиолдолд хуульд заасан, нийтийн эрх ашгийн төлөө болон үл ялгаварлах зарчмыг баримлах нөхөн төлөх нөхцөлтэй хэрэгжүүлэхийг төсөлд тусгасан.</p> <p>15.Саналыг тусгаж, нөхөх олговор гэж тодорхойлсон.</p> <p>16.Саналыг агуулгын хувьд тусгаж, гомдол шийдвэрлэх журмыг нарийвчлан</p>
--	--	--	---

		<p>дараах байдлаар өөрчлөн найруулах “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компанийг, түүний хараат бөлөн өхин компани, компанийн нэгдлийг;”</p> <p>7. 4.1.15-д “Хөрөнгө оруулалтын маргаан гэж хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллага болон хөрөнгө оруулагч нарын хооронд үүссэн маргааныг хэлнэ”. 4.1.15-д Хөрөнгө оруулалтын маргаан гэж хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллага болон хөрөнгө оруулагч нарын хооронд үүссэн болон хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, холбогдох татварын хуулиудтай энэ хуулийн заалт зөрчилдсөнөөс хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирснаас бий болсон маргааныг хэлнэ.” гэж маргааны агуулгыг тодотгон оруулах</p> <p>8. “Татварын орчин”-ы тодорхойлолтыг одоогийн хуулийн адилаар шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр тусгах 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7-д заасан “Татварын орчин” гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг хэлнэ гэсэн тодорхойлолтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаагүй орхижээ. Уг заалтыг хассан нь зарчмын хувьд одоо байгаа зохицуулалтыг дордуулсан байна. Учир нь, уг тодорхойлолт нь татварын орчныг тогтвортой байдлыг хангах төрийн баталгааны үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл, тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээгээр олгож буй татварын орчныг тогтвортой байлгах баталгааны цар хүрээг тодорхойлж буй чухал тодорхойлолтыг хасах нь зарчмын хувьд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах бус дордуулахаар байна. Ялангуяа нэг талд тогтворжуулах гэрчилгээгээр гэрчилгээнд заасан хугацаанд татварын хувь болон хэмжээг тогтвортой байлгах төрийн баталгааг өгсөн хэр нь нөгөө талд татвар ногдуулах, тайлагнах болон төлөхтэй холбоотой дүрэм журам, арга аргачлалыг өөрчлөх замаар ногдох татварын хувь болон хэмжээг нэмэх үр дагавар үүсгэх хандлага улам нэмэгдэхээр байна. Хэрэв уг байдлаар татварын хувь болон хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгож, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гэвэл уг баталгаа нь хөрөнгө оруулалт татах хэмжээнд эрх зүйн баталгаа бүрдүүлж чадахгүй. Иймд, хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “татварын орчин”-ны тодорхойлолтыг одоо үйлчилж байгаа хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7 дахь хэсэгт заасан агуулгаар дараах байдлаар нэмж тусгах: “4.1.**. "татварын орчин" гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг;”</p> <p>9. 6.1. Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана: 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 64 заалтад 110 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан бол 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 27 заалтад 40 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. Ийнхүү Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн орчин тогтворгүй байх нь хөрөнгө оруулагчийн хувьд итгэлийг бууруулах,</p>	<p>заасан.</p> <p>17. Агуулгын хувьд туссан. ААНОАТ хуулиар татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>18. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан</p>
--	--	---	--

		<p>эрсдэлийг нэмэгдүүлэх, тодорхой бус байдал үүсгэдэг бол улсын хувьд хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулах, хөрөнгө оруулагчдыг алдах, хөрөнгө оруулалтын маргаан гарах эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. Иймд, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой зохицуулалтыг тогтворжуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд дараах заалтыг нэмэлтээр оруулах:</p> <p>“6.1.**. Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар холбогдох хуулийн зохицуулалтуудыг тогтвортой байлгах баталгаа олгоно.”</p> <p>10. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явцыг хөрөнгө оруулагчдад ил тод мэдээлэх, олон нийт, хөрөнгө оруулагчдын саналыг тусгах үүднээс дараах заалтыг нэмэлтээр оруулах:</p> <p>“6.1.**. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд хөрөнгө оруулагчид болон олон нийтэд нээлттэй мэдээлж, хуулийн төслийг нийтэд ил тод байршуулж, хөрөнгө оруулагчид болон олон нийтийн саналыг хүлээн авч, нээлттэй хэлэлцүүлэх боломжоор хангах ба хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцдаа хөрөнгө оруулагчдын саналыг тусгана.”</p> <p>11. Хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, нийгэмд хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын талаар сөрөг мэдээлэл түгээх, олон нийтийг төөрөгдүүлэх, хөрөнгө оруулагчийн нэр хүндэд халдах явдлаас урьдчилан сэргийлэх үүднээс дараах заалтыг нэмж хуульчлах:</p> <p>“6.1.**. Төрийн байгууллага, албан тушаалтан нь хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх худал мэдээ мэдээлэл тараах, олон нийтийг төөрөгдүүлэхийг хориглоно.”</p> <p>12. 6.1.2“төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, хуульд заагаагүй шаардлага, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулна.” Одоогийн мөрдөгдөж буй хуулийн 11.2.1-т заасан заалтыг хэвээр нь үлдээх. /шинээр нэмэгдсэн заалт/</p> <p>13. 6.2.1 Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтворжуулах баталгаа олгоно. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно гэсэн боловч татварын орчныг тогтворжуулах гэдгийг тодорхойлсон зүйл алга байна. Иймээс татварын орчин гэж юуг ойлгох талаар төсөлд тодорхойлж оруулах.</p> <p>Санал болгоход: Татварын орчныг тогтворжуулах гэдэгт хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын төрөл, тэдгээрийн хувь хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх талаар зохицуулсан Монгол Улсын татварын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр, болон бусад эрх зүйн баримт</p>	<p>бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Харин хөнгөлөлт, чөлөөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтаар тооцож баталгаажуулах, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө гэж заасантай зөрчилдөхөөр байх тул хүлээн авах боломжгүй. Саналын дагуу өөрчлөлтийг холбогдох хуулиудад оруулсан. Гэхдээ татвар тогтворжуулах асуудал нь Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зааснаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг татварын хуульд заахгүй байхыг хуульчилсан. Түүнчлэн татварын орчин бус татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг төсөлд тусгасан. Үүнтэй холбоотой тогтворжуулах гэрчилгээгээр татвар тогтворжуулах нөхцөлийг НӨАТ хуульд тусгасан.</p> <p>19. Саналыг тусгасан. Хөрөнгө оруулалтын гэрээнд холбогдох татварын урамшууллын зохицуулалтыг тусгана.</p> <p>20. Агуулгын хувьд туссан бөгөөд гэрчилгээ, гэрээний хугацаанд тогтворжуулах нөхцөл үйлчилнэ.</p> <p>21. Агуулгын хувьд туссан бөгөөд нөхцөл шаардлага хангасан этгээд уг эрхийг шилжүүлэн авах эрхтэй байна.</p> <p>22. Агуулгын хувьд туссан бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд татварын хувь хэмжээг тогтворжуулахыг тодорхой заасан. Татварын ерөнхий хуулийн 4.1-д зааснаар холбогдох хувь хэмжээ тогтворжих нөхцөл нь баталгаажсан. Тогтворжуулсан татварын хувь хэмжээг</p>
--	--	--	---

		<p>бичгүүд тухайн хөрөнгө оруулалтын гэрээ хүчинтэй байх хугацаанд ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хөрөнгө оруулагчид үйлчлэхийг ойлгоно.</p> <p>14. 6.2.3.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авахад (i) нийтийн ашиг сонирхлын үүднээс (ii) хуульд заасан журмын дагуу (iii) үл ялгаварлах зарчмын хүрээнд (iv) зах зээлийн үнэлгээ бүхий нөхөн төлбөртэйгөөр хураан авах зарчим үйлчилдэг. Иймд, уг заалтад “үл ялгаварлах зарчмыг” нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: “6.2.3. хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно.”</p> <p>15. 6.2.5, 6.2.4. Нөхөн олговор VS нөхөх олговор гэж нийцүүлэх</p> <p>16. 7.1.8.Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах; Уг заалтын хүрээнд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах замаар гомдол нэхэмжлэлээ шийдүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс дараах байдлаар нэмж найруулах: “7.1.8. Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандан шийдвэрлүүлэх;”</p> <p>17. “15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар чөлөөлөх;” Энэхүү заалтыг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>18. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, эдгээр татварын дэмжлэгийн ААНОАТХ-д оруулах Мөн, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, улмаар ажил гүйлгээгээ НББ-ийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд “Хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэдгийг үзүүлэх татварын дэмжлэг гэдэгт нэмж оруулах. Эдгээр татварын дэмжлэгийг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>15.2-т Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хууль тогтоомжоор зохицуулна” гэснийг Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг энэхүү хөрөнгө олруулалтын тухай хуулиар зохицуулна” гэж өөрчлөх саналтай. Энэ заалтыг “тогтворжуулах гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах , эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын орчныг тогтворжуулах” гэж Төслийн 6.2.1-тэй нийцүүлэх саналтай байна.</p>	<p>өөрчлөх нь тогтворжуулах нөхцөлийг зөрчих тул Засгийн газарт энэхүү эрх хэмжээг олгох нь хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөнө.</p> <p>23.Хөрөнгө орлогыг гадаад улсад шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтаа татах тохиолдолд яригдах зохицуулалт юм. Иймд татварын өр төлбөр болон бусад этгээдэд өр төлбөртэй бол түүнийг барагдуулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.</p> <p>24.Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Ийнхүү заах нь ач холбогдолгүй юм.</p> <p>25.Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Банк, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой харилцааг ийнхүү заах нь ач холбогдолгүй юм.</p> <p>26.Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийн эрхийг хангахтай уг зохицуулалтын хүрээнд хуулиар л хязгаарлалт тогтоож болно.</p> <p>27.Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийн эрх нь дотоод гадаадын хөрөнгө оруулагч байхаас үл хамаараад ижил тэгш боломжоор хангагдана.</p> <p>28.Төрийн байгууллага нь хуульд заагдаагүй мэдээллийг шаардах нь хууль бус асуудал болно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч мэдээллийг өгөхгүй байх, ийнхүү гаргаж буй төрийн байгууллагын хууль зөрчсөн шаардлагын талаар гомдол гаргах эрхтэй.</p> <p>29.Хөрөнгө оруулагч шударгаар өрсөлдөх асуудлын төсөлд тусгаж, саналыг хүлээн авсан.</p> <p>30.Саналыг тусгаж, хөрөнгө оруулалт бодитоор хийсэн байх гэснийг тодорхойлсон.</p> <p>31.Саналыг тусгасан. Харин компанийн</p>
--	--	--	---

		<p>Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг.</p> <p>Одоогийн татварын хуулиудад зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулахаар заасан байгаа:</p> <ul style="list-style-type: none"> • Татварын ерөнхий хууль 12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулах татварыг тогтворжуулах хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх; • ААНОАТХ 20.3. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна. • Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 35.6. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө. • Ашигт малтиалын тухай хууль 47.15. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна. • НӨАТХ-д тогтворжуулах заалт огт тусгагдаагүй байна. <p>Иймд, хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах тухай бусад хуулиудад тусгах шаардлагатай байна.</p> <p>Мөн, хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах зохицуулалтыг нэр бүхий хуулиудад оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>-Татварын ерөнхий хууль -ААНОАТХ -Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль -Ашигт малтмалын тухай хууль -НӨАТХ</p> <p>19. Мөн 17.3-т татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна гэж байгаа боловч Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагч хуулийн 17.4, 18.1-д дэх заалт үйлчлэхгүй гэж үзвэл тус хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулах харилцаа татварын дэмжлэг нь тодорхойгүй байна.</p> <p>20. 17.4 Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг бууруулах өөрчлөлт орсон тохиолдолд тогтворжуулах “Тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд ...” -гэж нэмж оруулах</p> <p>21. 17.5.Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэрээс нь хамааран тогтворжуулах гэрчилгээг дараах этгээдэд олгоно: 17.5.1.хөрөнгө оруулалтын төслийг нэг хуулийн этгээд дангаар хэрэгжүүлэх бол тогтворжуулах гэрчилгээг тухайн хуулийн этгээдэд; 17.5.2.хөрөнгө оруулалтын төслийг харилцан хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хэрэгжүүлэх бол тэдгээрийн толгой компанид.</p>	<p>удирдлагын сайн засаглал нэвтрүүлэх, стандарт нөхцөлийг мөрдөж ажиллах гэсэн агуулгаар ажиллахыг үүрэг болгов.</p> <p>32.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын хөгжлийн аливаа бодлогыг УИХ батлахаар заасан. Иймд хөрөнгө оруулалтын бодлогыг УИХ батлахаар байна.</p> <p>33.Агуулгын хувьд зохицуулалт байгаа. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийг 10 жил тутам дүгнэдэг байхаар заасан.</p> <p>34.Санал нь агуулгын хувьд зохицуулалттай бөгөөд өмчийн хэлбэрээс үл хамаарч шударга өрсөлдөөний зарчим үйлчилнэ. Харин санал дурдсан энэ талаарх арга хэмжээ гэдэг нь хэт ерөнхий хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалт байна.</p> <p>35.Агуулгын хувьд туссан. Засгийн газрын тухай хуульд заасны дагуу холбогдох чиг үүргийн хүрээнд бодлогын санал боловсруулж өгөн барих эрх нээлттэй.</p> <p>36.Саналыг тусгасан.</p> <p>37.Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p> <p>38.Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p> <p>39.Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p>
--	--	---	---

		<p>Уг заалтын дагуу төслийн 17.5.1, 17.5.2-т заасан хуулийн этгээд тус бүрийн хувьд зохион байгуулалтын хэлбэрээс бусад нөхцөлийг үл харгалзан тогтворжуулах гэрчилгээ олгохоор тусгасан байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгож, ямар шаардлагыг хангасны үндсэн дээр тогтворжуулах гэрчилгээ олгох тухай зохицуулалтыг оруулах: “Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр, хөрөнгө оруулалтын хэмжээнээс нь хамааран тогтворжуулах гэрчилгээг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан дараах этгээдэд олгоно:”</p> <p>22. “Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд хуулийн 18.1-т заасан тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-иас тусгайлан эрх олгосон тохиолдолд, тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар татварын хувь, хэмжээг тогтоож болно” гэж нэмэх 18.1-д “Тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна.” -гэсний дараа энэхүү заалтад “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид нэгэн адил үйлчилнэ” гэж нэмэх 18-р зүйлд тогтворжуулах татварын төрөл буюу 18.1-д зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна гэж заасан байна. Үүнээс харахад хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүдэд хуулийн 18.1 дэх заалт үйлчлэхгүй харагдаж байна.</p> <p>Мөн татварын хувь хэмжээг бууруулах асуудал нь төслийн 17.4-т зааснаар “тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд татварын тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь уг өөрчлөлтөд хамаарагдахаар байна. Үүнд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан Хөрөнгө оруулагч хамаарахгүй харагдаж байна.</p> <p>Татварыг тогтворжуулах /бууруулах/ дэмжлэг нь хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд гэж байгаа нь Татварын ерөнхий хуулийн 4.1 дэх заалт буюу “...татварыг УИХ татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй”, мөн хуулийн 10-р зүйлийн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 10.1.2- т татварын хувь, хэмжээг бууруулах зохицуулалт үйлчлэхээр харагдаж байна. тусгасан байна.Үүнээс харахад хуулийн төслийн 18.1-д зааснаар тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь аж ахуй нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын албан татварын тухай хуульд албан татвар, төлбөрийн хувь хэмжээг бууруулах хуулийн өөрчлөлт буюу УИХ-аас хөнгөлөх, чөлөөлөх /бууруулах/ хууль баталсан тохиолдолд тус дэмжлэгийн авах эрх үүсэж байна.</p> <p>23. 6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй: “Татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсэн” гэдэг үндэслэлийг хэрхэн тогтоох нь тодорхой бус байна. Татварын хяналт шалгалтын явцад хожим нь татварын өр төлбөр илэрсэн нь хөрөнгө оруулагчийг ногдох хөрөнгө, орлогоо гадаад улсад гаргах үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгох.</p> <p>24. 6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон</p>	<p>40. Саналыг тусгасан.</p> <p>41. Хуулийн төсөлд агентлагийн хэрэгжүүлэх чиг үүргийг хэтэрхий нарийвчлан заах нь хуулийн хэрэгжилтийг хязгаарлах эрсдэлтэй.</p> <p>42. Агуулгын хувьд туссан. Хяналт шалгалт нь Төрийн хяналт шалгалтын хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулагддаг бөгөөд хяналт шалгалтыг зохион байгуулах нарийвчилсан харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжгүй.</p> <p>43. Саналыг тусгасан.</p> <p>44. Саналыг тусгаж, 3 жилээр хойшлуулах заалтыг болиулсан.</p> <p>45. Саналыг тусгасан. Татварыг татварын хуулиар зохицуулах зарчмын хүрээнд элэгдэл хорогдол тооцох, хасагдах зардал зэргийг ААНОАТ-ын хуулиар зохицуулна.</p> <p>46. ААНОАТ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар алдагдал ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт хэвээр байна. Татварыг татварын хуулиар зохицуулах шаардлагын хүрээнд хөрөнгө оруулалтын хуульд энэ талаар тусгах шаардлага байхгүй.</p> <p>47. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн</p>
--	--	---	---

		<p>улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй. "Хуульд өөрөөр заасан" гэх үндэслэлээр хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлогоо мөнгөн хэлбэрээр гадаад валютад хөрвүүлж шилжүүлэхийг хүндэтгэн үзэх онцгой шалтгаангүйгээр хязгаарлах эрсдэлтэй байна. Иймд, хууль заасан үндэслэл гэдгийн өмнө тодорхой зорилгыг тусгаж дараах байдлаар өөрчлөн найруулах: "6.2.6. хөрөнгө оруулагч нь үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй."</p> <p>25. 7.1.4.Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Бусад хууль тогтоомжийн хүрээнд гадаад валютаар гүйлгээ хийх, гадаад валютын шилжүүлэг, худалдан авалтыг хязгаарлах тохиолдол гардаг. Иймд, гадаадын мөнгөн тэмдэгт худалдах, худалдан авах харилцааг хязгаарлахгүй тохиолдлыг тусгаж уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: "7.1.4. Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Тус үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа байдлаар хязгаарлахгүй."</p> <p>26. 7.1.5.хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Бусад хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааг үндэслэн гадаад руу хийх шилжүүлгийг хязгаарлах эрсдэлтэй тул дараах байдлаар өөрчлөн найруулах. "7.1.5. хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Уг шилжүүлэгт хуульд зааснаас бусад тохиолдолд хязгаарлалт тогтоохыг хориглоно."</p> <p>27. 7.1.3.Хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох; Хөрөнгө оруулагч тухайн үед Монгол Улсад үйлчилж буй хөнгөлөлт, урамшуулал, таатай бодлогыг дотоодын аж ахуй нэгж, байгууллагын нэгэн адилаар эдлэх боломжийг бүрдүүлэх үүднээс дараах байдлаар өөрчлөн найруулах: "7.1.3. хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох; Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй шийдвэр, эрх зүйн баримт бичгийн дагуу импортлох, экспортлох үйл ажиллагаанд хөнгөлөлт, урамшуулал, бусад нөхцөлийг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын нэгэн адил эдлэх."</p> <p>28. 8.1.3.татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд</p>	<p>хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>48.Саналын дагуу Тогтворжуулах гэрчилгээний хугацааг уртасгасан.</p> <p>49.Саналын дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур нөхцөлийг бууруулсан.</p> <p>50.Тогтворжуулах гэрчилгээ олгохоос үндэслэлгүй татгалзахгүй бөгөөд ийнхүү үндэслэлгүй татгалзсан тохиолдолд уг зөрчлийг Маргаан шийдвэрлэх зөвлөлд мэдэгдэх, улмаар Засгийн газарт гомдол гаргах үндэслэл болно. Иймд уг хугацаанд багтаж шийдвэр гаргаагүй нь шууд эрх авах нөхцөл болох нь тохиромжгүй байна.</p> <p>51.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь татварын хууль тогтоомжоор зохицуулах тул хөрөнгө оруулалтын хуульд энэ төрлийн заалтыг хассан. Төрөөс хөрөнгө оруулалтын хуулийн дээрх татварын хөнгөлөлт, урамшууллыг олгох зорилгоор гаалийн болон НӨАТ- төлөх хугацааг 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулахаар Гаалийн тариф, гаалийн татварын</p>
--	--	---	--

		<p>гаргаж өгөх; Практикт, татварын байгууллага хуульд нарийвчлан тусгаагүй өргөн хүрээний мэдээллийг гаргуулах шаардлага тавих тохиолдолд гардаг. Энэ тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар учруулдаг. Иймд, татварын байгууллага гагцхүү "хуульд заасан үндэслэлийн дагуу" мэдээлэл шаардах эрхтэй байхаар уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: "8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан үндэслэлийн дагуу шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;"</p> <p>29. 8.1.4.хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих; Уг заалтад тусгагдсан "хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх" нэр томъёоны хувьд бизнесээс шууд хэрэглэгчид чиглэсэн (B-C) үйлчилгээнд хамааралтай ба бизнесээс бизнест чиглэсэн (B-B) үйл ажиллагаанд нь төдийлөн хамааралгүй байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: "8.1.4. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж зах зээлд шударгаар өрсөлдөх, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих;"</p> <p>30. 8.1.8.хөрөнгө оруулалтаа бодитоор хийсэн байх; Хөрөнгө оруулалтаа "бодитоор" хийснийг үнэлэх, хэмжих шалгуур тодорхой бус байгаа тул үүнийг тодорхой болгох. Бусад улсуудад дараах аргыг түгээмэл хэрэглэдэг. Үүнд: • Хөрөнгөд суурилсан: хөрөнгө оруулалтын явцад шаардагдаж байгаа эсхүл бий болгосон хөрөнгийн үнэлгээ • Орлогод суурилсан: хөрөнгө оруулалтын орлогоор бий болсон хөрөнгө • Ажлын байр бий болгох эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлт: бий болгосон ажлын байр болон орон нутагт үзүүлсэн эдийн засгийн үр нөлөө • Хяналт: Хөрөнгө оруулалтаа анхны зорилгын дагуу хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих • Нийтэд мэдээлэх шаардлага: Хөрөнгө оруулалтын хариуцлагатай, ил тод байдлын талаар олон нийтэд мэдээлэх</p> <p>31. 8.1.9.байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх Уг заалт нь сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх ажил тул хуулийн этгээдэд үүрэг ногдуулж зайлшгүй тусгах шаардлагагүй байна. Олон улсын сүүлийн үеийн чиг хандлагаар "байгаль орчин, нийгэм, сайн засаглал" (цаашид "ESG" гэх)-ын тайлан гаргах санал санаачилга өргөжин тэлж байна. Энэ нь тухайн хуулийн этгээд хөрөнгө оруулалт татах боломжоо нэмэхийн тулд санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна тогтвортой, найдвартай байдлыг илтгэх санхүүгийн бус үзүүлэлтүүдээ үнэлэх, өөртөө давуу байдлыг үүсгэх сонирхолтой холбоотойгоор гол төлөв томоохон групп компаниудын зүгээс сайн дурын үндсэн дээр гаргаж буй тайлан мэдээ юм. Энэ асуудлыг ямар нэг тодорхой шалгуургүйгээр нийтлэг байдлаар үүрэгжүүлэн шаардах нь эерэг үр дагавар үүсгэхээс илүүцээр хэлбэрийн төдий чирэгдэл дагуулсан ажиллагаа болж мэдэх тул хуулийн төслийн уг заалтыг хасах саналтай байна.</p>	<p>тухай хуульд өөрчлөлт оруулж байсан. Энэхүү заалт нь хэвээр үйлчилэх болно.</p> <p>52.Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ.</p> <p>53.Саналыг тусгаж, Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгах нөхцөлийг хуулийн төсөлд тодорхой заасан. Харин хууль тогтоомж тогтвортой мөрдөх зохицуулалтын хувьд дээр дурдсан шалтгаанаар боломжгүй.</p> <p>54.Агуулгын хувьд туссан. Гэрээ байгуулахтай холбоотой ерөнхий нөхцөлийг хуульд шууд заасан. Нөгөө талаар хууль нь хэрэгжиж эхлэх үед бүх дүрэм, журам батлагдсан байх шаардлагатай тул журам батлах хугацааг тавих шаардлага байхгүй.</p> <p>55.Саналыг тусгасан.</p> <p>56.Холбогдох хууль тогтоомжуудад тусгайлсан горим хэрэгжих нөхцөлийг хуульчилсан. Уг горимын дагуу холбогдох урамшууллыг хүртэнэ.</p> <p>57.Агуулгын хувьд зохицуулалт байгаа. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх эрх хэмжээ нь Засгийн газрын эрх хэмжээнд хамаарч байна.</p> <p>58. Инновацийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт төрийн дэмжлэгийн асуудлыг тодорхой заасан. Түүнчлэн, санхүүжилт дээр төрөөс дэмжлэг үзүүлэхээс гадна, татварын бодлогоор дэмждэг бөгөөд энэ чиглэлийн салбарт НӨАТ чөлөөлөлтийн дэмжлэг мөн үзүүлдэг.</p> <p>59.Агуулгын хувьд туссан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай</p>
--	--	---	--

			<p>“8.1.9. байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх”</p> <p>32. 9.1. Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх. Монгол Улсын УИХ, Засгийн газраас хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлалыг тусгайлан баталж байгаагүй бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай хуулиас бусдаар хөрөнгө оруулалтын суурь бодлогыг бүхэлд нь илэрхийлэх баримт бичиг байхгүй юм. Харин Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэгт хөрөнгө оруулалтын талаар цухас дурдагдсан байдаг. Иймд, хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтын салбарын суурь үзэл баримтлалыг Засгийн газраас баталж, түүнийг хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтад нөлөө үзүүлэх шийдвэр гаргагч төрийн байгууллагын бүх шатлал, түвшинд сурталчлан таниулж, улмаар Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг төрийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа нэг мөр тайлбарлаж, хэрэглэхэд ач холбогдолтой. Хөрөнгө оруулалтын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогоор хөрөнгө оруулалтын салбарын зорилго, хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, хөрөнгө оруулалтад үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, хөрөнгө оруулалтын салбарын зохицуулалт, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар, хяналт үнэлгээ зэргийг тодорхойлох боломжтой. Иймд хуулийн заалтыг дараах байдлаар нэмж найруулах: “9.1.1.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.”</p> <p>33. 9.1.**.Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үнэлэх, сайжруулах үүднээс дараах заалтыг нэмж тусгах: "9.1.**. Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хөндлөнгийн дүгнэлтийг хоёр жил тутамд нэг удаа хийлгэх бөгөөд дүгнэлтэд туссан зөвлөмж, саналын дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.”</p> <p>34. 9.1.**.Хөрөнгө оруулалтын салбарт хөрөнгө оруулагчидтай төрийн өмчит компаниуд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараах заалтыг нэмж тусгах: “9.1.**. Төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтын орчинд шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангаж, хөрөнгө оруулалтын орчныг сааруулах аливаа үйл ажиллагаа явуулах, хөрөнгө оруулалтыг хязгаарлах нөхцөлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Төрийн өмчит компаниудын жагсаалтыг бүрэн гаргаж, олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлнэ. ”</p> <p>35. 10.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.1.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх; Төслийн 9.1.1-т өөрчлөн тусгуулах дээр дурдсан заалттай уялдуулан дараах байдлаар өөрчлөх:</p>	<p>хуулийн 9.2.1. Засгийн газар нь Монгол Улсын визийн ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсын виз олгох журам батлах; гэж заасны дагуу саналд дурдсан асуудлыг хуулийн хүрээнд бус журмын дагуу зохицуулах боломжтой байна.</p> <p>60.Хөрөнгө оруулалтын урамшуулал нь холбогдох салбар хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын хувьд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй шууд холбогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим ёсоор төрийн алба нь хууль дээдлэх зарчмыг баримтлах бөгөөд төрийн албан хаагчаас хэрэгжүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын хуулиар бус салбар хуулиар тодорхойлно. Иймд тус хуулийг зөрчиж шийдвэр гаргах боломжгүй тул эргэлзээ үүсгэхгүйн тулд хөрөнгө оруулалтын хуульд энэ төрлийн хуулийн зөрчил үүсгэх зохицуулалт оруулах шаардлагагүй.</p> <p>61. Саналыг тусгаж, хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх асуудлыг үе шат бүрээр тодорхойлж, хугацааг заалаа.</p> <p>62.Саналыг тусгасан бөгөөд хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэлтийн талаар нийтэд мэдээлнэ.</p> <p>63.Саналыг тусгасан. Хөрөнгө оруулалтын гомдол шийдвэрлэх чиг үүргийг Маргаан шийдвэрлэх зөвлөл байхаар төсөлд тусгасан бөгөөд энэ нь хараат бус гишүүн болон төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. Түүнчлэн хэлэлцээ хийх журмыг Засгийн газар батлахаар заасан бөгөөд энэ хүрээнд хэлэлцээ хийх этгээд зэргийг нарийвчлан зохицуулна.</p> <p>64.Гомдлыг урьдчилан хянан шийдвэрлэх журмыг хэлэлцээний журамд хамааруулж тоолох бөгөөд эдгээр хугацааны нийт хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна. Түүнчлэн арбитрын</p>
--	--	--	--	---

		<p>“10.1.2.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх”</p> <p>36. 10.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх; Зарим тохиолдолд төрийн байгууллагууд хөрөнгө оруулагчийн өмнө Засгийн газрын хүлээсэн үүргийн талаар төдийлөн сайн мэдлэг, мэдээлэлгүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргахдаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих тохиолдол гардаг. Иймд, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн байгууллагын бүхий л түвшин, салбар, шатлалд холбогдох албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс шаардлагатай мэдээлэл, дэмжлэгийг хөрөнгө оруулалт хариуцсан захиргааны байгууллагаас авах боломжийг бүрдүүлэхийн тулд уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“10.1.3. хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт өгөх, сургалт, мэдээллээр хангах;”</p> <p>37. 12. Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллын чиг үүрэг 12.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн бусад байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“12.1. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр шаардлагатай тохиолдолд чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авна.”</p> <p>38. 13. Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх 13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ. Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p>	<p>шатанд хэлэлцээ хийх асуудал нь холбогдох журмын дагуу нээлттэй.</p> <p>65.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчийн нийтлэг баталгаа, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад илүүтэй чиглэсэн ба аль нэг салбарыг тусгайлан дэмжих бодлогыг баримтлаагүй. Нөгөө талаас хөрөнгө оруулалтыг татах бодлогод татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нөлөөлөхгүй гэсэн зөвлөмжийг олон улсын байгууллагуудаас өгөөд байгаа. Иймд тухайлсан салбарыг дэмжих бодлогын асуудалд шаардлагатай тооцоо судалгааг хийж, төсөвт үзүүлэх нөлөөллийг бодитой тооцсоны үндсэн дээр хэлэлцүүлэх нь зүйтэй.</p> <p>66. 65 дахь хэсгийн хариултыг үзнэ үү. Хөрөнгө оруулалтын хуулиар үзүүлж буй татварын хувь хэмжээний зохицуулалт нь Татварын ерөнхий хуулийн 4.1-д зааснаар хөрөнгө оруулалтын хуулийн дагуу хэрэгжихээр заасан. Иймд уг асуудлыг заавал татварын хуульд тусгах шаардлага байхгүй.</p> <p>67. Хөрөнгө оруулалтын хуулиар үзүүлж буй татварын хувь хэмжээний зохицуулалт нь Татварын ерөнхий хуулийн 4.1-д зааснаар хөрөнгө оруулалтын хуулийн дагуу хэрэгжихээр заасан. Иймд уг асуудлыг заавал татварын хуульд тусгах шаардлага байхгүй.</p>
--	--	--	---

		<p>“13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэгийг үзүүлэх, Засгийн газрын хүлээсэн үүргийг орон нутагт Засгийн газрын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хэрэгжүүлэх, хамгаалах чиглэлээр Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хандан заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авах, сургалт, мэдээлэл авах ба тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.”</p> <p>39. 13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.</p> <p>Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулахгүй байх, хөрөнгө оруулалтын гэрээний үүрэг болох Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>"13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх төрийн бүхий л үйлчилгээг тасалдалгүй явуулах ба хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихүйц шийдвэр, үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.”</p> <p>40. 11.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1. хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх</p> <p>Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтыг татахаас гадна нэгэнт орж ирсэн хөрөнгө оруулалтыг хамгаалах, түүн дээр суурилан хөрөнгө оруулалтын урсгалыг тогтвортой нэмэгдүүлэх нь нэн чухал. Иймд, уг заалтыг дараах байдлаар нэмж найруулах:</p> <p>“11.1.1. хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, дэмжих цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх”</p> <p>41. 11.1.3.-11.1.6.</p> <p>11.1.3. хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p> <p>11.1.4. хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх</p> <p>11.1.5. хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх</p> <p>11.1.6. хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, төслийн мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>Эдгээр заалтыг бодит нөхцөл байдал дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар процессын</p>	
--	--	--	--

		<p>зохицуулалт тодорхой бус байна. Тодруулбал, хэрхэн "төлөвлөлт хийх", "дэмжлэг үзүүлэх", "үйлчилгээний талаар зөвлөх", "үйлчилгээ үзүүлэх", "төслийг хөгжүүлэх", "бэлэн байдлыг хангах" зэрэг процессын зохицуулалт тодорхой бус байгаа нь эдгээрийг бодит байдал дээр хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хүргэнэ.</p> <p>Иймд, уг заалтуудыг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, процессын үе шатыг тодорхой болгох.</p> <p>42. 12.2.Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлнэ.</p> <p>Төрийн байгууллагын давтамжтай, олон төрлийн хяналт шалгалтын улмаас хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хэвийн байдал тасалдах, гарах зардлын хэмжээ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай тул уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “12.2. Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг тасалдалгүй байдлыг хангаж, хяналт шалгалттай холбогдуулан хөрөнгө оруулагчид учрах аливаа зардлыг хамгийн бага түвшинд байлгах зарчмыг баримтална.”</p> <p>43. 15.1. Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг үзүүлнэ: 15.1.2. тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах; Хуулийн заалтыг илүү ойлгомжтой болгох үүднээс дараах байдлаар өөрчлөн найруулах: “15.1.2.тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг уг гэрчилгээ, гэрээнд заасан хугацаагаар тогтворжуулах;”</p> <p>44. 15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах; Албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах нь татварын дэмжлэг гэхээс илүүгээр татварын гурван жилийн хугацааны татварыг овооруулж төлснөөр хөрөнгө оруулагчид санхүүгийн дарамт үзүүлэхээр байна. Түүнчлэн уг дэмжлэгийг хөрөнгө оруулагч бүрд үзүүлэх үү эсхүл зөвхөн тодорхой шаардлага хангасан хөрөнгө оруулагчид үзүүлэх үү гэдэг нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “15.1.1. () шаардлагыг хангасан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах эсхүл чөлөөлөх;”</p> <p>45. 15.1.3.албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдэл хорогдлын хэмжээг түргэвчилсэн аргаар тооцох; Уг заалтын дагуу ямар шалгуур, шаардлага, нөхцөлийг хангасан хөрөнгө оруулагч аж ахуй нэгжид татварын дэмжлэг үзүүлэх нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг илүү тодорхой болгох: “15.1.3. шаардлагыг хангасан аж ахуй нэгжийн ажилтны мэргэжлийн</p>	
--	--	--	--

		<p>боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох;"</p> <p>46. 15.1.**.Алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1.4-т “Албан татвар ногдох орлогоос хасагдах алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох” тухай заасныг энэхүү шинэ төсөлд тусгаагүй орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төслийн судалгаа, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын шатанд хугацаа болох хөрөнгө их шаардагддаг мега төслүүдийн тухайд алдагдлыг ирээдүйд шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. Иймд, уг асуудлыг мега төслийн хүрээнд татварын хуульд тогтоомжид заасан нийтлэг горимоос илүү тааламжтай нөхцөл олгох боломжийг нээсэн байдлаар өндөр шалгууртайгаар тусгах.</p> <p>47. 12.2.Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эдгээр нь татварын дэмжлэг бүхий зохицуулалтуудтай уялдуулан Татварын ерөнхий хууль болон Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулах өөрчлөлтийг тусгаагүй байх тул бодитоор хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байна. Иймд, уг хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгахаас гадна уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна.”.</p> <p>48. 20.3.Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 1.5 дахин уртасгаж тооцож олгоно. Зарим төслүүд томоохон хөрөнгө оруулалт шаардаж, урт хугацаанд хэрэгждэг тул уг заалтыг хэмжээг 2 дахин уртасгаж тооцоноор үр нөлөөтэй дэмж болж чадахаар байна. Иймд уг заалтад дараах байдлаар өөрчлөлт оруулах: “20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 2 дахин уртасгаж тооцож олгоно.”</p> <p>49. 20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг энэ хуулийн 20.2-т заасан хугацааг 1.5 дахин уртасган тооцож олгоно: 20.3.1. улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр;</p>	
--	--	---	--

			<p>Уг заалтын хүрээнд тогтворжуулах гэрчилгээ олгох салбаруудыг ялгамжтай тодорхойлж, түүнд олгох хөрөнгө оруулалтын хэмжээг 500 тэрбум төгрөгөөс бууруулж шатлалтай тогтоох.</p> <p>50. 22.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг цахимаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>Уг хугацаанд хариу өгөөгүй бол цаашид авах арга хэмжээ, санкци хариуцлага нь тодорхой бус байдгаас үүдэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 ба түүнээс дээш хугацаагаар хүсэлтэд хариу өгөхгүй байх тохиолдолд гардаг. Иймд, уг заалттай холбогдуулан дараах хэсгийг нэмж тусгах:</p> <p>“22.1. ... Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тогтворжуулах гэрчилгээ олгох эсэх шийдвэрийг гаргаагүй тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан гэж үзнэ.”</p> <p>51. Эдийн засгийн хараат байдал, валютын гадагш урсгалд жин дардаг гадаад худалдааны тэнцэлд чухал ач холбогдолтой салбарын бүтээн байгуулалтын явцад татварын бодлогоор дэмжих боломжийг хэвээр үлдээх</p> <p>2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2-т “Доор дурдсан тохиолдолд импортлох техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <p>11.2.1 Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>11.2.2 Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>11.2.3 Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих” гэж заасан.</p> <p>Монгол Улсын эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий дээрх салбарт хэрэгжих төслийн барилга угсралтын үе шатанд импортлох техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох тухай дээрх заалт нь тухайн төслийн хувьд ямар ч орлого олж эхлээгүй байгаа барилга угсралтын үеийн зардлыг бууруулах бодит ач холбогдолтой. Иймд уг зохицуулалт нь хөрөнгө оруулалт оруулах хөшүүрэг болохоос гадна уг заалтын хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлаас тухайлсан хууль гаргаж хугацааны хязгаарыг тогтоож өгөх бөгөөд Засгийн газраас чөлөөлөгдөх бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг батлах тул уг заалтыг доорх байдлаар хуулийн төсөлд нэмж оруулах:</p> <p>“23.1.**. Доор дурдсан тохиолдолд импортлох техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <p>23.1.**.1. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>23.1.**.2. Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</p> <p>23.1.**.3. Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих”</p>	
--	--	--	--	--

		<p>52. Хөрөнгө оруулагчид татварын тогтвортой орчноос гадна хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан үйл ажиллагааны орчин тогтвортой байх нь чухал ач холбогдолтой байдаг. Иймд төслийн 24 дүгээр зүйлд дараахыг нэмж оруулах саналтай байна. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын гэрээний хүрээнд талуудын хооронд тодорхой асуудлаар хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан зохицуулалт нь тухайн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөрөнгө оруулагчид тогтвортой үйлчилнэ.</p> <p>53. Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээнд иргэний эрх зүйн зарчим дараах зарчмыг баримтлах ёстой боловч баримталдаггүй. Үүнээс үүдэн Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөд хүрдэг.</p> <p>5. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх 5.2. Шинээр батлагдсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна. 5.3. Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.</p> <p>Хэрэв иргэний хуулийн дээрх зарчмыг Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгавал Хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон хөрөнгө оруулагчид сөрөг нөлөөтэй аливаа зохицуулалтыг дагаж мөрдөх шаардлагагүй болно. Иймд, уг заалтад доорх хэсгийг нэмж найруулах: “24.9. Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээнд хамааралтай шинээр батлагдсан эсхүл нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, холбогдох зохицуулалт нь хөрөнгө оруулагч талын ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байх бөгөөд хөрөнгө оруулагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомж, зохицуулалтаас илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан зохицуулалтыг хэрэглэж болно.”</p> <p>54. 24.10.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар батална. Хууль батлагдсаны дараа холбогдох журам батлах ажиллагаа удаашралтай байдаг. Иймд, уг заалтад журам батлах хугацааг тодорхой болгох эсхүл дагаж мөрдөх журмын тухай хуульд нарийвчлан тусгах: “24.10. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар энэхүү хууль</p>	
--	--	--	--

		<p>батлагдсанаас хойш _____ хугацааны дотор батална.”</p> <p>55. 27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p> <p>Хөндлөнгийн аудитын байгууллагын зүгээс зарим нэг учир шалтгааны улмаас тайлан баталгаажуулахад хугацаа орох тохиолдол багагүй гардаг тул хугацааг 05 сарын 31-ний өдрийн байдлаар болгож дараах байдлаар өөрчлөх:</p> <p>“27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”</p> <p>56. 16.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх;</p> <p>Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Чөлөөт бүсийн тухай хууль болон Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, эдгээр хуулиудад хөрөнгө оруулагчид бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх дэмжлэгийн зохицуулалтыг нарийн тодорхой хуульчлах.</p> <p>57. 16.1.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх;</p> <p>Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбогдуулан хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>58. 16.1.5.экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>Уг дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Иймд, хөрөнгө оруулагчийн экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг Инновацийн тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>59. 16.1.6.Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг олгох;</p>	
--	--	--	--

		<p>Уг зөвшөөрөл олгох харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хэдий ч уг төсөлд "гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд оршин суух зөвшөөрөл олгох"-той холбогдсон харилцааг нарийвчлан тусгаагүй байна. Иймд, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд оршин суух зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг нарийвчлан тусгах.</p> <p>60. 16.2.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн хүрээнд холбогдох нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудын уялдаа холбоог хангах үүднээс дараах байдлаар уг заалтыг өөрчлөн найруулах: "16.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна."</p> <p>61. 28.1. Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.</p> <p>28.2. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Энэхүү гомдлыг шийдвэрлэх хугацааг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Уг заалтад хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр томъёолсон боловч тухайн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хүргүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн байж болзошгүй хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэхгүй байх, тодорхойгүй хугацаагаар хойшлуулах гэх мэт бусад процессын алдаа гарах магадлалтай тул гомдлыг хүлээн авснаас хойш шийдвэрлэх хугацааг тодорхой болгох үүднээс 30 хоногийн дотор саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад</p>	
--	--	---	--

		<p>хүргүүлэх байдлаар доорх байдлаар өөрчлөн найруулах: “28.2 Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хүргүүлнэ.”</p> <p>62. 28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална. Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, сайжруулах үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа болон хугацааг тогтоосон журмыг Засгийн газар батлах ба журмын хэрэгжилт, хөрөнгө оруулагчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэсэн байдалд холбогдуулан жил тутам хяналт шалгалт хийж тайлан гаргах ба түүнийг нийтэд ил мэдээлнэ.”</p> <p>63. 29.1.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэнэ. Хөрөнгө оруулагчийн гомдол нь хөрөнгө оруулалтын гэрээ, татварын тогтворжуулалттай холбоотой аливаа асуудлаар байж болох тул зөвхөн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоотойгоор гомдлыг шийдвэрлэх нь учир дутагдалтай юм. Иймд “Гомдлыг шийдвэрлэх арга хэмжээнд хөрөнгө оруулагчийн гаргасан гомдолд хамаарах төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.” гэж нэмэх саналтай байна. Түүнчлэн хөрөнгө оруулалттай холбоотой л бол ямар ч тохиолдолд хэлэлцээ хийх боломжийг олгохын тулд “Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол” гэсэн хязгаарлалтыг хасах саналтай байна. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газартай байгуулдаг тул гэрээний нэг тал болох Монгол Улсын Засгийн газар эсхүл Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага нь хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийнэ гэдгийг тодруулах саналтай байна. “хөрөнгө оруулалтын гэрээний талууд” гэж тодруулж болох юм.</p> <p>64. 29.2.Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш 3 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дараах олон улсын гэрээний дагуу арбитра хандах эрхтэй: Хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн гэдэгт юуг ойлгох вэ? Төслийн 28-д заасан гомдол урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэлж байна уу эсхүл тусдаа ажиллагаа юу? Зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд ч биш арбитра хэрэг маргаан үүсгэсний дараа ч талуудад хэлэлцээр хийх боломжийг олгох. Тухайлбал “Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотойгоор олон улсын шүүх, арбитра маргаан үүссэн тохиолдолд хэлэлцээр хийх, эвлэрэх журмыг Засгийн газар/Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж оруулж болох юм.</p> <p>65. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 15-р бүлэг, 11-р зүйлд 11.3-т Барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортолсон техник, тоног төхөөрөмж, импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн</p>	
--	--	--	--

			<p>түлшний албан татвар тооцох үнэлгээнд 0-10 хувиар ногдуулна.</p> <p>66. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 15-р бүлэг, 11-р зүйлд 11.4-т Барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортолсон техник, тоног төхөөрөмж, импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татварын хувийг энэ хуулийн 11.3-т заасан хязгаарт багтаан салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.-гэж нэмэх</p> <p>Дээрх нэмэлт өөрчлөлт орсноор Засгийн Газар нь УИХ-аас олгосон хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд НӨАТ-ын хувь хэмжээг тогтоох нөхцөл бүрдэнэ гэж харж байна.</p> <p>67. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 35 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар ногдуулах</p> <p>“35.6.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээ, хөрөнгө оруулалтын гэрээтэй бол уг гэрээ, гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө” гэж өөрчлөн найруулах</p>	
11.	АмЧам	2023.05.12	<p>1. Хөрөнгө оруулалтын хууль эрхзүйн орчны эко тогтолцоог бүрдүүлэх: татварын таатай орчин бүрдүүлэх, хуулийн заалтууд бүрэн хэрэгждэг байх, хөрөнгө оруулалт хийх урамшуулал, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг шинэчилж, маргааныг шударгаар, үр дүнтэй шийдвэрлэдэг болгох</p> <p>2. Хөрөнгө оруулалтын хуулийн дагуу дагалдах хуулиудад шаардлагатай өөрчлөлүүдийг яаралтай оруулах</p> <p>3. Хөрөнгө оруулалтын хуулийг бүрэн хэрэгжүүлэх, бусад хуулиудтай уялдуулах</p> <p>4. Нэмэлт заалт оруулах санал / Хуулийн төслийн 2 дугаар зүйлд дараах нэмэлт заалтыг оруулах саналтай байна: “2.3. Хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.4-т зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ: 2.3.1. Монгол Улсын олон улсын гэрээ; 2.3.2. Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ; 2.3.3. энэ хууль, 2.3.4. Монгол Улсын бусад хууль; 2.3.5. захиргааны хэм хэмжээний акт. 2.4. Энэ хуулийн 2.3-т заасан хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл хөрөнгө оруулагчид илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ.”</p> <p>Тайлбар: Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангахад дээрх нэмэхээр санал болгож буй заалт онцгой ач холбогдолтой. Жишээлбэл, хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хуулиар зохицуулаагүй гэсэн үндэслэлээр хэрэгжүүлэхгүй явж ирсэн асуудлыг энэхүү заалтыг нэмж оруулснаар шийдвэрлэх, мөн хуулийн төсөлд тусгах татварын болон татварын бус дэмжлэгийн хэрэгжилтийг бодитоор хангах нөхцөл бүрдэх юм. Эрх зүйн хэм</p>	<p>1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой санал хүсэлт байна.</p> <p>2. Санал туссан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагалдаж 20 төрлийн хууль, тогтоолын төслийг боловсруулаад байна.</p> <p>3. Саналыг тусгаж, дагалдах 20 хууль, тогтоолын төсөл боловсруулсан.</p> <p>4. Хууль хэрэглээний хувьд саналд туссан эрэмбээр хэрэгжих боломжгүй. Хуулиас давсан гэрээ байхгүй. Мөн хөрөнгө оруулалтын хууль нь бусад хуулиас давуу үйлчлэх боломжгүй.</p> <p>5. Саналыг зарчмын хувьд тусгасан. Гэхдээ нөхөх олговрыг олгох асуудалд олон улсын нийтлэг зарчмын хүрээнд олгохоор хуулийн төсөд тусгасан.</p> <p>6. Алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох асуудал нь ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд уг асуудлаар зөрчил үүсгэх хэлбэрээр хөрөнгө оруулалтын хуульд тусгахгүй байх нь зүйтэй. Нөгөө талаар алдагдал ирээдүйд шилжүүлэх тооцох асуудал нь татварын хөөн хэлэлцэх хугацаатай уялдах шаардлагатай тул 4 жилээр тогтоодог бөгөөд саналын дагуу 10 жилээр тодорхойлох боломжгүй. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай</p>

		<p>хэмжээний актуудыг эрэмбэлсэн төсөөтэй заалт Хөдөлмөрийн хуульд мөн байдаг.</p> <p>5. Нэмэлт өөрчлөлт оруулах санал: 6.1.2.төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, хуульд заагаагүй шаардлага, эс үйлдэхүй, шийдвэрийн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, буруутай байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, хөрөнгө оруулагчийн зөрчигдсэн эрхийг сэргээж, хууль ёсны итгэлийг нь хамгаалж, хөрөнгө оруулагчийн хохирол, үүнд бодит болон эрх зөрчигдсөнөөс үүдэн гарах хохирол, олох ёстой байсан ашиг орлого, алдагдсан боломжийн өртгийг хуульд заасны дагуу төр хариуцан барагдуулна.</p> <p>Тайлбар: Зарим төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрээс болж хөрөнгө оруулагчийн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох, үйл ажиллагааг нь зогсоох гэх мэт ноцтой үр дүнд хүргэхүйц захиргааны шийдвэр гардаг. Иймд буруутай этгээдэд хариуцлага тооцох болон Захиргааны ерөнхий хуулийн гол зарчмуудын нэг болох “хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг хөрөнгө оруулалтын тухай хуульд ил тод тусгаснаар төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа илүү хариуцлагатай болно. Түүнчлэн хохирлыг хэн барагдуулах нь тодорхойгүй байсныг төр хариуцан барагдуулах тухай нэмэлтийг оруулснаар хөрөнгө оруулагчдад бодит хамгаалалт болно.</p> <p>Одоогийн байдлаар төрийн албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гэм хор учруулсан бол гэм хорыг төр хариуцан арилгах тухай жишиг заалт Иргэний хуулийн 498.2- т, мөн түүнчлэн хөдөлмөрийн маргаанаас үүдэлтэй төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх заалт Төрийн албаны тухай хуулийн 50-д зааснаар тус тус мөрдөгдөж байна. Иймд хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг төр барагдуулах нь зүй ёсны бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд тусгай хохирол барагдуулах сан байгуулж болох юм.</p> <p>6. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд дараах нэмэлт заалтыг оруулах саналтай байна: 15.1.5. Ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан арван жилийн хугацаанд хасаж тооцох.</p> <p>Тайлбар: Боломжтой бол дээрх өөрчлөлтийг санал болгох, эсхүл 2013 оны хуулийн 11.1.4-т заасан дэмжлэгийг хэвээр үлдээж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.2-т 10 жилийн туршид алдагдлыг ирээдүйд шилжүүлэн хасаж тооцохоор өөрчлөлт оруулах саналтай байна.</p> <p>15.1.6. Дор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <ul style="list-style-type: none"> • чухал/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; • нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; • эрчим хүчний үйлдвэр, төмөр зам, дэд бүтэц барих. <p>Тайлбар: Энэхүү дэмжлэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2013 оны хуулийн 11.2-т тусгагдсан бөгөөд Хуулийн төсөлд энэ дэмжлэгийг хэвээр үлдээн, чухал стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, дэд бүтэц зэргийг нэмэх саналтай байна.</p>	<p>хуулийн гааль, НӨАТ-ын дэмжлэгийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2 дахь заалт хэвээрээ бөгөөд энэ нь төлөх ёстой гааль, НӨАТ-ыг 2 жилийн хугацаанд хойшлуулан төлөх боломжийг бий болгосон.</p> <p>7. Татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулах зарчим нь Үндсэн хуулийн ойлголттой холбогддог. Иймээс ч Хөрөнгө оруулалтын хуулиар татварын асуудлыг тусгайлан зохицуулах боломжгүй.</p> <p>8. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн</p>
--	--	---	--

		<p>Мөн, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, улмаар ажил гүйлгээгээ НББ-ийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд “Хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэдгийг үзүүлэх татварын дэмжлэгт нэмж оруулах саналтай байна.</p> <p>7. 15.2-т “Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хууль тогтоомжоор зохицуулна” гэснийг “15.2. Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг энэ хуулиар зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд журмаар эсвэл татварын тухай хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулна” өөрчлөн найруулах</p> <p>8. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол улс бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц хөрөнгө оруулалт татах улс болоход урамшууллын төрөл хэтэрхий цөөн, татварын дэмжлэгүүд хангалттай бус байна гэж АмЧам Монгол үзэж байна. Иймд урамшууллын төрлүүдийг нэмэх, татварын хөнгөлөлтүүдийг хангалттай хэмжээнд тусгах шаардлагатай. Хуулийн төсөлд тусгагдсан хөшүүргийг харвал гадаадын хөрөнгө оруулагчид Монгол улсаас илүү бүс нутгийн БНСУ, Казахстан, Вьетнам, Камбож г.м. орнуудад хөрөнгө оруулалт хийхээр байна. Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа улсад хөрөнгө оруулахдаа эхний элжинд татварын болон татварын бус дэмжлэгүүдийг хүсэж байдаг тул хуулийн төсөлд Монгол Улсын санал болгох хөрөнгө оруулалтын урамшуулал, хөшүүргүүдийг улам нэмэгдүүлж, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц болгох шаардлагатай байна. Жишээлбэл, Үндэсний Хөгжлийн Газраас 2020 онд хийлгэсэн “Гадаад орнуудын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”-нд дурдсанаар “БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили улсын Засгийн газраас хөрөнгө оруулалтын урамшууллыг голдуу татварын хөнгөлөлт хэлбэрээр, бизнесийн үйл ажиллагааг явуулж эхлэхэд олгож байна. Үүнд, компанийн татвар, орлогын татвар, орон нутгийн татвар/үл хөдлөх хөрөнгийн татвар/ зэргийг хөнгөлдөг байна. Мөн бараа бүтээгдэхүүнийг гаалийн хураамж, нэмүү өртгийн татвараас чөлөөлөн үзүүлдэг. Хэрэв гадаадын хөрөнгө оруулалт тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд, төв засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас мөнгөн дэмжлэг үзүүлэх боломж байдаг. Тухайлбал, газар худалдан авах өртөг, түрээсийн төлбөр, ажилтны сургалт, боловсролд зарцуулсан төлбөрт татаас өгөх зэрэг болно. Дээрх улс орнууд хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлэхдээ салбар тус бүр өөр өөр байх ба ихэвчлэн эхний 3 жил татвараас чөлөөлөх, жижиг хот болон алслагдсан дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хөнгөлөлт чөлөөлөлт түлхүү хамруулахаар заасан нь нийтлэг байна” гэжээ. Жижиг хотод бий болгосон барилга, худалдан авсан тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгийн нийт өртгийн 20-25 хүртэлх хувийг төрөөс татаас хэлбэрээр олгож болохоор БНСУ-ын хуульд заасан бол Чех улсад Засгийн газраас баталсан салбарт үйлдвэрлэл явуулах, шинэ ажлын байр бий болгосон төсөлд, технологийн салбарт 200,000,000 короны үйл ажиллагааны зардалтай, түүнээс 100,000,000 короныг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан, бусад төсөлд урамшуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлт хүртэхэд 20 ба түүнээс дээш ажлын байр бий болгосон байх, 3.6-4 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн бол эхний 10 хүртэлх жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх, бэлэн мөнгөний урамшуулал олгож болохоор заасан ба төрөөс авч болох нийт урамшууллын хэмжээг 45.75 сая крон хүртэл буюу нийт зардлын 19 хувь хүртэл байж</p>	<p>тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>9. Саналын дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан. Нийтэд ил тод мэдээл байгаа.</p> <p>10. Саналыг тусган хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх Маргаан шийдвэрлэх зөвлөлийг байгуулж байгаа.</p> <p>11. 1 дэх саналын дагуу татварын дэмжлэгийг үзүүлсэн.</p> <p>12. хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гааль, НӨАТ-ын урамшууллыг хэвээр үлдээж байгаа.</p> <p>13. Хөрөнгө оруулалтын маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх боломжийг хуулийн төсөлд тусгасан. Харин дагнасан шүүх байгуулах асуудал нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийн үзэл баримтлалаас тусдаа шүүхийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд холбогдох тооцоо, судалгаанд хийгдэх учиртай.</p> <p>14. Хөрөнгө оруулалтын хууль нь нийтлэг хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн, хөрөнгө оруулалтын нийтлэг баталгааны талаар зохицуулах бөгөөд аливаа салбараар ялгаварлах боломжгүй. Харин салбарын асуудлыг холбогдох салбарын хууль тогтоомжийн хүрээнд ялгамжтай тогтоох асуудал нээлттэй.</p> <p>15. Саналыг тусгаж, хөрөнгө оруулалтын урамшуулал зэргийг шууд үзүүлэхээр тусгасан. Мөн үл ялгаварлах, хууль дээдлэх, эрх тэгш, шударга байх зарчмын агуулгыг хуулийн төсөлд</p>
--	--	---	---

		<p>болохоор заажээ. Казахстан улсын Засгийн газар уул уурхай, төмөр замын тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, барилга, төмөрлөгийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эм, мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч, салхины болон нарны эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай урамшуулалтай.</p> <p>9. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг мөн адил нийтэд ил болгох. Ингэхдээ 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд өнгөрсөн хугацаанд олгоод байгаа тогтворжуулах гэрчилгээ болон нэгэнт байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа дуусаагүй байгаатай холбоотойгоор эдгээрийн хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дараах харилцааг зохицуулах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> i. 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хууль үйлчлэх хугацаанд үүссэн харилцааны хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол, үүргийг уг хуулийн шинэчилсэн найруулгын дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх талаар; ii. хөрөнгө оруулагчид учрах сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл байдал, арга зам; iii. хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах, гүйцэтгэх нөхцөл; болон iv. хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдол зэргийг зохицуулах. <p>10. Татварын маргаан таслах зөвлөлийн адилаар “Хөрөнгө оруулалтын маргаан таслах зөвлөл” бүтцийг байгуулах: Хуулийн төсөлд тусгагдсан арбитраар маргаан шийдвэрлэх зохицуулалт нь зарим хөрөнгө оруулагчдын хувьд цаг хугацаа болон өртгийн хувьд өндөр зардалтай тул уг механизмаар маргаан шийдвэрлүүлэх нь ач холбогдол бага. Иймд хуулийн төсөлд урьдчилсан байдлаар хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх тухай заалт нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай байна. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байдгаас үүдэлтэйгээр нэг төрийн байгууллагын шийдвэрийг өөр нэг төрийн байгууллага хэрэгжүүлэхгүй, үгүйсгэх тохиолдол гардаг тул шүүх, арбитраар зарга үүсгэхээс өмнө маргаан шийдвэрлэх хөндлөнгийн зөвлөлтэй байх шаардлагатай байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн гадаадын хөрөнгө оруулалттай компани, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтахар зохицуулж болно.</p> <p>11. Хөрөнгө оруулалтын татварын дэмжлэгийн зохицуулалтуудыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд уялдуулах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны нэгдмэл байдлыг хангах үүднээс татварын шинэчлэл хийх.</p> <p>12. Энэхүү заалтын ачаар ЕСБХБ-ны санхүүжилтээр Монголд цементийн шинэ үйлдвэр баригдсан. Харамсалтай нь тухайн компани нь импортолсон техник, тоног төхөөрөмжөө барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлнэ гэж ойлгосон боловч энэ заалт амьдрал дээр хэрэгжээгүй. Тиймээс эдгээр бодит татварын чөлөөлөлтүүдийг шинэчилсэн найруулгад тусгаж, заавал мөрддөг байх шаардлагатай.</p>	<p>тусгасан.</p> <p>16. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай.</p> <p>17. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>18. Саналыг тусгав.</p> <p>19. Саналыг тусгав.</p> <p>20. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ. энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно.</p> <p>21. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын хөгжлийн аливаа бодлогыг УИХ батлахаар заасан. Иймд хөрөнгө оруулалтын бодлогыг УИХ батлахаар байна.</p> <p>22. Саналыг тусгасан бөгөөд хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэлтийн талаар нийтэд мэдээлнэ.</p> <p>23. Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p>
--	--	--	---

		<p>13. Маргаан шийдвэрлэх. Бизнесийн эрх зүй, арилжааны эрх зүйн маргааны шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах, шүүгчдийг бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх нь хөрөнгө оруулалтын маргааны хурдан шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулагчдад хүндрэл чирэгдэл учруулахгүй байх давуу талтай. Иймд, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> i. Шүүхийн тухай хууль, ii. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, iii. Арбитрын тухай хууль болон iv. Эвлэрүүлэн зуучлах тухай хууль <p>14. Салбарын дэмжлэг. Эдийн засгаа төрөлжүүлэх, уур уурхайн салбараас хэт хараат байдлыг бууруулах үүднээс Хөрөнгө оруулалтын хуулийн хүрээнд (i) нэн тэргүүнд дэмжих чиглэл болон (ii) тодорхой хүрээнд дэмжих эдийн засгийн чиглэлүүдийг тодорхойлж, тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн талаар тусгах.</p> <p>15. Хуулийн төсөлд тодорхой байх, дотоод болон гадаад хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсны зарчмыг оруулах: зарчмын асуудлыг тусгаж өгөхийн зэрэгцээ аливаа заалтуудыг “болно” “боломжтой” гэдэг байдлаар биш тодорхой байдлаар буюу үүрэгжүүлсэн байдлаар оруулж өгөх.</p> <p>16. 3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ. Уг заалтын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагын хүрээнд зөвхөн хуулийн этгээд байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хязгаарлаж, хувь хүн өөрөө хөрөнгө оруулагч байх боломжийг үгүйсгэсэн байна. Иймд, уг заалтыг хуулийн төслийн 5.1.2, 5.1.4, 5.1.6 болон 5.1.7 дахь хэсгүүдтэй уялдуулан дараах байдлаар өөрчлөн найруулах: “3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.”</p> <p>17. 4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг; Уг заалтын дагуу зөвхөн “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг хөрөнгө оруулалт гэж тооцохоор байна. Түүнчлэн уг заалт нь 5.1-д заасан хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй зөрчилдөж байна. Хөрөнгө оруулалтыг зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулах байдлаар хязгаарлах нь улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлэх хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Цаашлаад төслийн санхүүжилт зэрэг бусад хэлбэрээр хийх хөрөнгө оруулалтыг үгүйсгэдэг, татварын хувьд маргаан дагуулдаг заалт юм. Иймд, уг заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулах: “4.1.16 “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдэд хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;”</p>	<p>24. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг тодорхой тусгасан. Харин хөнгөлөлт, чөлөөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтаар тооцож баталгаажуулах, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө гэж заасантай зөрчилдөхөөр байх тул хүлээн авах боломжгүй. Саналын дагуу өөрчлөлтийг холбогдох хуулиудад оруулсан. Гэхдээ татвар тогтворжуулах асуудал нь Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д зааснаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг татварын хуульд заахгүй байхыг хуульчилсан. Түүнчлэн татварын орчин бус татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг төсөлд тусгасан. Үүнтэй холбоотой тогтворжуулах гэрчилгээгээр татвар тогтворжуулах нөхцөлийг НӨАТ хуульд тусгасан.</p> <p>25. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ.</p>
--	--	---	---

		<p>18. “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг” гэж тусгасан. 4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж хуульд заасан тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”- гэдэгт ... тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээний... гэж нэмэх</p> <p>4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээний эсхүл хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”-... гэж өөрчлөх</p> <p>19. 4.1.5. “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компани, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг; Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хараат болон охин компани бүгд гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үзэх нөхцөл үүсгэж байна. (Компанийн 20%-ийг ГХО компани 80%-ийг Монгол компани эзэмшиж байхад ч тухайн компани ГХО-тай болох нь). Хөрөнгө оруулалтын босго тогтоосон нь хөрөнгө оруулалтыг татах зорилготой нийцэхгүй тул хуучин заалтыг хэвээр үлдээж дараах байдлаар өөрчлөн найруулах</p> <p>“гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компанийг, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг;”</p> <p>20. 6.1. Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана:</p> <p>1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 64 заалтад 110 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан бол 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 27 заалтад 40 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. Ийнхүү Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн орчин тогтворгүй байх нь хөрөнгө оруулагчийн хувьд итгэлийг бууруулах, эрсдэлийг нэмэгдүүлэх, тодорхой бус байдал үүсгэдэг бол улсын хувьд хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулах, хөрөнгө оруулагчдыг алдах, хөрөнгө оруулалтын маргаан гарах эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. Иймд, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой зохицуулалтыг тогтворжуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд дараах заалтыг нэмэлтээр оруулах:</p> <p>“6.1.**. Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар холбогдох хуулийн зохицуулалтуудыг тогтвортой байлгах баталгаа олгоно.”</p> <p>21. 9.1. Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.</p>	<p>26. Хөрөнгө орлогыг гадаад улсад шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтаа татах тохиолдолд яригдах зохицуулалт юм. Иймд татварын өр төлбөр болон бусад этгээдэд өр төлбөртэй бол түүнийг барагдуулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.</p> <p>27. Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Ийнхүү заах нь ач холбогдолгүй юм.</p> <p>28. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжих дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Иймд уг татварын орчин гэсэн заалтыг эргэлзээ үүсгэхгүйн тул хасах нь зүйтэй байна.</p> <p>29. ААНОАТ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар алдагдал ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт хэвээр байна. Татварыг татварын хуулиар зохицуулах шаардлагын хүрээнд хөрөнгө оруулалтын хуульд энэ талаар тусгах шаардлага байхгүй.</p> <p>30. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь татварын хууль тогтоомжоор зохицуулах тул хөрөнгө оруулалтын</p>
--	--	--	---

		<p>Монгол Улсын УИХ, Засгийн газраас хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлалыг тусгайлан баталж байгаагүй бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай хуулиас бусдаар хөрөнгө оруулалтын суурь бодлогыг бүхэлд нь илэрхийлэх баримт бичиг байхгүй юм. Харин Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэгт хөрөнгө оруулалтын талаар цухас дурдагдсан байдаг.</p> <p>Иймд, хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтын салбарын суурь үзэл баримтлалыг Засгийн газраас баталж, түүнийг хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтад нөлөө үзүүлэх шийдвэр гаргагч төрийн байгууллагын бүх шатлал, түвшинд сурталчлан таниулж, улмаар Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг төрийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа нэг мөр тайлбарлаж, хэрэглэхэд ач холбогдолтой.</p> <p>Хөрөнгө оруулалтын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогоор хөрөнгө оруулалтын салбарын зорилго, хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, хөрөнгө оруулалтад үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, хөрөнгө оруулалтын салбарын зохицуулалт, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар, хяналт үнэлгээ зэргийг тодорхойлох боломжтой. Иймд хуулийн заалтыг дараах байдлаар нэмж найруулах:</p> <p>“9.1.1.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.”</p> <p>22. Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална. Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, сайжруулах үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа болон хугацааг тогтоосон журмыг Засгийн газар батлах ба журмын хэрэгжилт, хөрөнгө оруулагчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэсэн байдалд холбогдуулан жил тутам хяналт шалгалт хийж тайлан гаргах ба түүнийг нийтэд ил мэдээлнэ.”</p> <p>23. 10.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх; Зарим тохиолдолд төрийн байгууллагууд хөрөнгө оруулагчийн өмнө Засгийн газрын хүлээсэн үүргийн талаар төдийлөн сайн мэдлэг, мэдээлэлгүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргахдаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих тохиолдол гардаг.</p> <p>Иймд, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн байгууллагын бүхий л түвшин, салбар, шатлалд холбогдох албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс шаардлагатай мэдээлэл, дэмжлэгийг хөрөнгө оруулалт хариуцсан захиргааны байгууллагаас авах боломжийг бүрдүүлэхийн тулд уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“10.1.3. хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт өгөх, сургалт, мэдээллээр хангах;”</p> <p>Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллын чиг үүрэг</p> <p>12.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан</p>	<p>хуульд энэ төрлийн заалтыг хассан. Төрөөс хөрөнгө оруулалтын хуулийн дээрх татварын хөнгөлөлт, урамшууллыг олгох зорилгоор гаалийн болон НӨАТ- төлөх хугацааг 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулахаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулж байсан. Энэхүү заалт нь хэвээр үйлчилэх болно.</p> <p>31. Саналыг тусгаж, хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх асуудлыг үе шат бүрээр тодорхойлж, хугацааг заалаа.</p> <p>32. Саналыг тусгасан. Хөрөнгө оруулалтын гомдол шийдвэрлэх чиг үүргийг Маргаан шийдвэрлэх зөвлөл байхаар төсөлд тусгасан бөгөөд энэ нь хараат бус гишүүн болон төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. Түүнчлэн хэлэлцээ хийх журмыг Засгийн газар батлахаар заасан бөгөөд энэ хүрээнд хэлэлцээ хийх этгээд зэргийг нарийвчлан зохицуулна.</p> <p>33. Гомдлыг урьдчилан хянан шийдвэрлэх журмыг хэлэлцээний журамд хамааруулж тоолох бөгөөд эдгээр хугацааны нийт хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна. Түүнчлэн арбитрын шатанд хэлэлцээ хийх асуудал нь холбогдох журмын дагуу нээлттэй.</p> <p>34. Агуулгын хувьд туссан.Монгол Улсын бүх хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэх тул хуулийг тоочих нь чухал шаардлагатай бусад хуулийг орхигдуулах эрдэслтэй тул Үндсэн хуульд нийцсэн акт гэсэн агуулгыг төсөлд тусгалаа.</p> <p>35. Төрийн байгууллага нь хуульд заагдаагүй мэдээллийг шаардах нь хууль бус асуудал болно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч мэдээллийг өгөхгүй байх, ийнхүү гаргаж буй төрийн байгууллагын хууль</p>
--	--	---	---

		<p>Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө.</p> <p>Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн бусад байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“12.1. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр шаардлагатай тохиолдолд чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авна.”</p> <p>13. Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх</p> <p>13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.</p> <p>Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэгийг үзүүлэх, Засгийн газрын хүлээсэн үүргийг орон нутагт Засгийн газрын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хэрэгжүүлэх, хамгаалах чиглэлээр Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хандан заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авах, сургалт, мэдээлэл авах ба тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.”</p> <p>24. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, эдгээр татварын дэмжлэгийн ААНОАТХ-д оруулах</p> <p>Мөн, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, улмаар ажил гүйлгээгээ НББ-ийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд “Хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэдгийг үзүүлэх татварын дэмжлэг гэдэгт нэмж оруулах.</p> <p>Эдгээр татварын дэмжлэгийг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>15.2-т Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хууль тогтоомжоор</p>	<p>зөрчсөн шаардлагын талаар гомдол гаргах эрхтэй.</p> <p>36. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>37. Хөрөнгө оруулалтын урамшуулал нь холбогдох салбар хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын хувьд хэрэгжүүлэх чиг</p>
--	--	---	--

		<p>зохицуулна” гэснийг Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг энэхүү хөрөнгө олруулалтын тухай хуулиар зохицуулна” гэж өөрчлөх саналтай.</p> <p>Энэ заалтыг “тогтворжуулах гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах , эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын орчныг тогтворжуулах” гэж Төслийн 6.2.1-тэй нийцүүлэх саналтай байна.</p> <p>Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг.</p> <p>Одоогийн татварын хуулиудад зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулахаар заасан байгаа:</p> <ul style="list-style-type: none"> • Татварын ерөнхий хууль 12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулах татварыг тогтворжуулах хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх; • ААНОАТХ 20.3. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна. • Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 35.6. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө. • Ашигт малтмалын тухай хууль 47.15. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна. • НӨАТХ-д тогтворжуулах заалт огт тусгагдаагүй байна. <p>Иймд, хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах тухай бусад хуулиудад тусгах шаардлагатай байна.</p> <p>Мөн, хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах зохицуулалтыг нэр бүхий хуулиудад оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> -Татварын ерөнхий хууль -ААНОАТХ -Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль -Ашигт малтмалын тухай хууль -НӨАТХ <p>25. Хөрөнгө оруулагчид татварын тогтвортой орчноос гадна хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан үйл ажиллагааны орчин тогтвортой байх нь чухал ач холбогдолтой байдаг. Иймд төслийн 24 дүгээр зүйлд дараахыг нэмж оруулах саналтай байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын гэрээний хүрээнд талуудын хооронд тодорхой асуудлаар хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан зохицуулалт нь тухайн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөрөнгө оруулагчид тогтвортой үйлчилнэ.</p> <p>26. 6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй:</p> <p>"Татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсэн" гэдэг үндэслэлийг хэрхэн тогтоох нь тодорхой бус</p>	<p>үүрэгтэй шууд холбогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим ёсоор төрийн алба нь хууль дээдлэх зарчмыг баримтлах бөгөөд төрийн албан хаагчаас хэрэгжүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын хуулиар бус салбар хуулиар тодорхойлно. Иймд тус хуулийг зөрчиж шийдвэр гаргах боломжгүй тул эргэлзээ үүсгэхгүйн тулд хөрөнгө оруулалтын хуульд энэ төрлийн хуулийн зөрчил үүсгэх зохицуулалт оруулах шаардлагагүй.</p> <p>38. Саналыг тусгасан.</p>
--	--	---	---

		<p>байна. Татварын хяналт шалгалтын явцад хожим нь татварын өр төлбөр илэрсэн нь хөрөнгө оруулагчийг ногдох хөрөнгө, орлогоо гадаад улсад гаргах үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгох.</p> <p>27. 6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй. "Хуульд өөрөөр заасан" гэх үндэслэлээр хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлогоо мөнгөн хэлбэрээр гадаад валютад хөрвүүлж шилжүүлэхийг хүндэтгэн үзэх онцгой шалтгаангүйгээр хязгаарлах эрсдэлтэй байна. Иймд, хууль заасан үндэслэл гэдгийн өмнө тодорхой зорилгыг тусгаж дараах байдлаар өөрчлөн найруулах: "6.2.6. хөрөнгө оруулагч нь үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй."</p> <p>28. Маргаан шийдвэрлэх. Бизнесийн эрх зүй, арилжааны эрх зүйн маргааны шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах, шүүгчдийг бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх нь хөрөнгө оруулалтын маргааны хурдан шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулагчдад хүндрэл чирэгдэл учруулахгүй байх давуу талтай. Иймд, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> i. Шүүхийн тухай хууль, ii. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, iii. Арбитрын тухай хууль болон iv. Эвлэрүүлэн зуучлах тухай хууль <p>29. 15.1.**.Алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1.4-т "Албан татвар ногдох орлогоос хасагдах алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох" тухай заасныг энэхүү шинэ төсөлд тусгаагүй орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төслийн судалгаа, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын шатанд хугацаа болох хөрөнгө их шаардагддаг мега төслүүдийн тухайд алдагдлыг ирээдүйд шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. Иймд, уг асуудлыг мега төслийн хүрээнд татварын хуульд тогтоомжид заасан нийтлэг горимоос илүү тааламжтай нөхцөл олгох боломжийг нээсэн байдлаар өндөр шалгууртайгаар тусгах.</p> <p>30. Эдийн засгийн хараат байдал, валютын гадагш урсгалд жин дардаг гадаад худалдааны тэнцэлд чухал ач холбогдолтой салбарын бүтээн байгуулалтын явцад татварын бодлогоор дэмжих боломжийг хэвээр үлдээх 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2-т "Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно: 11.2.1 Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын</p>	
--	--	--	--

		<p>бүтээгдэхүүний үйлдвэр барих; 11.2.2 Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; 11.2.3 Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих” гэж заасан.</p> <p>Монгол Улсын эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий дээрх салбарт хэрэгжих төслийн барилга угсралтын үе шатанд импортлох техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох тухай дээрх заалт нь тухайн төслийн хувьд ямар ч орлого олж эхлээгүй байгаа барилга угсралтын үеийн зардлыг бууруулах бодит ач холбогдолтой. Иймд уг зохицуулалт нь хөрөнгө оруулалт оруулах хөшүүрэг болохоос гадна уг заалтын хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлаас тухайлсан хууль гаргаж хугацааны хязгаарыг тогтоож өгөх бөгөөд Засгийн газраас чөлөөлөгдөх бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг батлах тул уг заалтыг доорх байдлаар хуулийн төсөлд нэмж оруулах:</p> <p>“23.1.**. Доор дурдсан тохиолдолд импортлох техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <p>23.1.**.1. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; 23.1.**.2. Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; 23.1.**.3. Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих”</p> <p>31. 28.1. Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.</p> <p>28.2. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p> <p>Энэхүү гомдлыг шийдвэрлэх хугацааг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Уг заалтад хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр томьёолсон боловч тухайн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хүргүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн байж болзошгүй хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэхгүй байх, тодорхойгүй хугацаагаар хойшлуулах гэх мэт бусад процессын алдаа гарах магадлалтай тул гомдлыг хүлээн авснаас хойш шийдвэрлэх хугацааг тодорхой болгох үүднээс 30 хоногийн дотор саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх байдлаар доорх байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>“28.2 Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хүргүүлнэ.”</p>	
--	--	--	--

		<p>32. 29.1.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэнэ. Хөрөнгө оруулагчийн гомдол нь хөрөнгө оруулалтын гэрээ, татварын тогтворжуулалттай холбоотой аливаа асуудлаар байж болох тул зөвхөн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоотойгоор гомдлыг шийдвэрлэх нь учир дутагдалтай юм. Иймд “Гомдлыг шийдвэрлэх арга хэмжээнд хөрөнгө оруулагчийн гаргасан гомдолд хамаарах төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.” гэж нэмэх саналтай байна. Түүнчлэн хөрөнгө оруулалттай холбоотой л бол ямар ч тохиолдолд хэлэлцээ хийх боломжийг олгохын тулд “Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол” гэсэн хязгаарлалтыг хасах саналтай байна. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газартай байгуулдаг тул гэрээний нэг тал болох Монгол Улсын Засгийн газар эсхүл Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага нь хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийнэ гэдгийг тодруулах саналтай байна. “хөрөнгө оруулалтын гэрээний талууд” гэж тодруулж болох юм.</p> <p>33. 29.2.Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш 3 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дараах олон улсын гэрээний дагуу арбитрт хандах эрхтэй: Хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн гэдэгт юуг ойлгох вэ? Төслийн 28-д заасан гомдол урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэлж байна уу эсхүл тусдаа ажиллагаа юу? Зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд ч биш арбитрт хэрэг маргаан үүсгэсний дараа ч талуудад хэлэлцээр хийх боломжийг олгох. Тухайлбал “Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотойгоор олон улсын шүүх, арбитрт маргаан үүссэн тохиолдолд хэлэлцээр хийх, эвлэрэх журмыг Засгийн газар/Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж оруулж болох юм.</p> <p>34. 2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар олгосон хөрөнгө оруулалтын дэмжлэг, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид уялдуулж, нарийвчилсан зохицуулаагүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалтын дэмжлэг бодит байдал дээр хэрэгжихгүй, улмаар хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөхөд хүрдэг. Иймд, хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийг зохицуулсан хуулиудыг нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: “2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Газрын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”</p>	
--	--	--	--

		<p>35. 8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;</p> <p>Практикт, татварын байгууллага хуульд нарийвчлан тусгаагүй өргөн хүрээний мэдээллийг гаргуулах шаардлага тавих тохиолдолд гардаг. Энэ тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар учруулдаг. Иймд, татварын байгууллага гагцхүү "хуульд заасан үндэслэлийн дагуу" мэдээлэл шаардах эрхтэй байхаар уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>"8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан үндэслэлийн дагуу шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;"</p> <p>36. 12.2. Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна.</p> <p>Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эдгээр нь татварын дэмжлэг бүхий зохицуулалтуудтай уялдуулан Татварын ерөнхий хууль болон Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулах өөрчлөлтийг тусгаагүй байх тул бодитоор хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байна.</p> <p>Иймд, уг хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгаахаас гадна уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p>"Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна."</p> <p>37. 16.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.</p> <p>Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн хүрээнд холбогдох нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудын уялдаа холбоог хангах үүднээс дараах байдлаар уг заалтыг өөрчлөн найруулах:</p> <p>"16.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх,</p>	
--	--	---	--

			<p>хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна.”</p> <p>38. 27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p> <p>Хөндлөнгийн аудитын байгууллагын зүгээс зарим нэг учир шалтгааны улмаас тайлан баталгаажуулахад хугацаа орох тохиолдол багагүй гардаг тул хугацааг 05 сарын 31-ний өдрийн байдлаар болгож дараах байдлаар өөрчлөх:</p> <p>“27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”</p>	
12.	УБХТ	2023.05.12	<p>1. Хуулийн төслийн 3.4 дүгээр заалтыг хасах.</p> <p>Тайлбар: Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулахын тулд компани байгуулах шаардлагатай гэж ойлгогдож байна. Хэрэв улсын бүртгэлд бүртгэлтэй компанид хувь эзэмших байдлаар хөрөнгө оруулбал холбогдох хуулиудаар тус заалтад тусгагдсан шиг шинээр бүртгүүлэх ёсгүй байдаг. Түүнчлэн хувь эзэмшихээс өөр бусад хэлбэрээр хөрөнгө оруулалт оруулах явдлыг хязгаарласан, эсхүл дутуу орхигдуулсан заалт болсон байна.</p> <p>2. “4.1.1. “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт тус хуулийн 5.1 дүгээр заалтад тусгагдсан хэлбэрээр оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг” гэж өөрчлөн найруулах</p> <p>Тайлбар: Хуулийн төслийн өмнөх заалт нь хөрөнгө оруулалтын олон төрлүүдээс зөвхөн нэгийг нь л хөрөнгө оруулалт гэж үзэж байгаа мэтээр бичигдсэн байсан тул ийнхүү өөрчлөн найруулав.</p> <p>3. “4.1.5 дугаар заалтыг өөрчлөн найруулах</p> <p>Тайлбар: Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хараат болон охин компани бүгд гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үзэх нөхцөл үүсгэж байна. (Компанийн 20%-ийг ГХО компани 80%-ийг Монгол компани эзэмшиж байхад ч тухайн компани ГХО-тай болох нь) Компанийн зохион байгуулалтын үргэлжилсэн хэлхээ холбоон дахь гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг нь хөөж бодсоны үр дүнд 25 буюу түүнээс дээш хувийн гадаадын хөрөнгө оруулалттай бол “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж тооцох шаардлагатай байгаа тул ийнхүү өөрчлөн найруулах нь зүйтэй.</p> <p>4. “4.1.15. ... хөрөнгө оруулагч” гэдгийн ард “эсхүл хөрөнгө оруулагч, иргэн, аж ахуйн нэгжийн” гэж нэмж найруулах.</p> <p>Тайлбар: Хөрөнгө оруулалтын маргаан зөвхөн төр болон хөрөнгө оруулагч нарын хооронд гардаггүй. Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалт авсан иргэн, аж ахуйн нэгжийн хооронд ч гарна. Иймд ингэж өргөн хүрээнд тодорхойлох нь зүйтэй.</p> <p>5. “4.1.16. “татварын орчин” гэж хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын төрөл, тэдгээрийн хувь хэмжээг тодорхойлох,</p>	<p>1. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай зохицуулалт юм.</p> <p>2. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>3. Саналыг тусгав.</p> <p>4. Агуулгын хувьд туссан. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч гэдэгт иргэн, хуулийн этгээд гэснийг тодруулсан.</p> <p>5. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ. Иймд татварын орчин гэсэн тодорхойлолт гаргаж эргэлзээ үүсгэхгүй байх нь зүйтэй байна.</p> <p>6. Агуулгын хувьд тусгахдаа нэр томъёог нөхөх олговор гэж өөрчиллөө.</p>

		<p>ногдуулах, төлөх талаар зохицуулсан Монгол Улсын татварын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, Монгол Улсаас бусад улстай байгуулсан татвартай холбоотой гэрээ, хэлэлцээр, болон бусад эрх зүйн баримт бичгүүд тухайн Хөрөнгө оруулалтын гэрээ хүчинтэй байх хугацаанд ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хөрөнгө оруулагчид үйлчлэхийг” гэсэн заалтыг нэмэх.</p> <p>Тайлбар: Татварын орчин гэдэгт юуг ойлгож, тооцох нь тодорхой бус байгаа тул ийнхүү тодорхой болгож өгөх шаардлагатай.</p> <p>6. “6.2.5.е. ... нөхөн олговор” гэж засах Тайлбар: 6.2.4-т нөхөн олговор гэж бичсэн байгаа тул энэ заалтад мөн адил бичив.</p> <p>7. “6.2.7. хууль бусаар хөрөнгө оруулагчийн хөрөнгийг царцаах, данс хаах, гадаад, дотоод гүйлгээг хориглох зэрэг арга хэмжээ авахыг хориглоно.” гэж нэмэх. Тайлбар: Дээрх тохиолдол зөвхөн хөрөнгө оруулагчид гэлтгүй дотоодын аж ахуйн нэгжүүд дээр маш олон тохиолддог бөгөөд энэ нь бизнесийн тогтвортой үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөө учруулдаг тул энэ заалтыг нэмж оруулснаар хөрөнгө оруулагчдад эерэг дохио өгөх болно.</p> <p>8. “6.2.8. нутгийн захиргааны байгууллагуудын зүгээс дээд шатны төрийн байгууллагуудын гаргасан шийдвэрийн дагуу хөрөнгө оруулалт хийж байгаа хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг хязгаарлах, хориг, хязгаарлалт тавих, хүнд суртал үүсгэхийг хориглоно” гэж нэмэх. Тайлбар: Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийхээр Засгийн газартай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийг тухайн газартаа очиж үйл ажиллагаагаа явуулах гэхээр нутгийн захиргааны байгууллагууд авлига нэхэх, хүнд суртал гаргах, төрөл бүрийн хандив тусламж нэхэх, зарим этгээдүүдийн зүгээс иргэдийг турхирах зэргээр төслийг удаашруулах ажиллагаа байнга гардаг тул эдгээрийг шийдвэрлэх чиглэлээр эрх бүхий нутгийн захиргааны байгууллагууд ажиллах, дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай. Учир нь нутгийн захиргааны байгууллагууд Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй байгууллагууд юм. Харин нутгийн иргэдийн саналыг авах зэрэг асуудлуудыг урьдчилан Засгийн газар гэрээ байгуулах, хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийхээсээ өмнө зохион байгуулсан байх шаардлагатай.</p> <p>9. “7.1.8. төрийн байгууллага, хөрөнгө оруулалт хүлээн авсан иргэн, аж ахуйн нэгжийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн, эдийн болон эдийн бус хохирол хүлээсэн гэж үзвэл эрх бүхий дээд шатны байгууллага, хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөл, шүүх, арбитраг гомдол гаргах, шийдвэрлүүлэх” гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Хуулийн төслийн одоогийн заалтаар хөрөнгө оруулагч зөвхөн төрийн байгууллагатай холбоотой маргаанаа шийдвэрлүүлэх юм шиг өрөөсгөл орсон байна. Иймд иргэн, аж ахуйн нэгжтэй үүссэн маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй гэж тодорхой зааж өгөх шаардлагатайгаас гадна энэ төрлийн маргааныг бас “Хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөл”-өөр урьдчилан хэлэлцүүлж заавал шүүх, арбитраг руу хандахгүй байх нээлттэй тогтолцоог бүрдүүлж өгөх нь зүйтэй.</p>	<p>7. Агуулгын хувьд туссан. Хууль бус үйлдэл хийж, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчсөн бол учруулсан хохирлыг барагдуулах, буруутай албан хаагчийг ажлаас чөлөөлөхөөр заасан.</p> <p>8. Агуулгын хувьд туссан. Энэ нь төрийн байгууллагуудын чиг үүрэгт туссан бөгөөд хууль бус үйлдлийн улмаас учрах хохирлыг барагдуулах, хариуцлага тооцох механизмыг хуульчилсан.</p> <p>9. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагч төр хоорондын маргаанд төрөөс гомдол хянан шийдвэрлэх журам болон арбитраг журмаар гомдол гаргах боломжийг хөрөнгө оруулалтын хуульд тусгах боломжтой. Иргэд хоорондын маргааны хувьд хөрөнгө оруулалтын хуулиар шууд хатуу харьяалал заах нь гэрээний эрх чөлөөний зарчимд нийцэхгүй тул энэ талаар хөрөнгө оруулалтын хуулиар хязгаар тавих нь боломжгүй.</p> <p>10. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын хөгжлийн аливаа бодлогыг УИХ батлахаар заасан. Иймд хөрөнгө оруулалтын бодлогыг УИХ батлахаар байна.</p> <p>11. Саналыг тусгасан.</p> <p>12. Саналыг авч, хуулийн нийцлийг хангав. Хөрөнгө оруулалтын хуулиар татварын хууль тогтоомжийг бус харин хувь хэмжээг л тогтворжуулна.</p> <p>13. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө гэж заасантай зөрчилдөхөөр байх тул хүлээн авах боломжгүй.</p> <p>14. Энэхүү хуулийн хүрээнд уг асуудлыг</p>
--	--	--	--

		<p>10. “9.1.1. хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх” гэж энэ заалтыг өөрчлөн найруулах. Тайлбар: Засгийн газар хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогоо тодорхойлохоос гадна аль салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх вэ гэдэг бодлогоо гарган, тухайн салбарт хөрөнгө оруулалт хийвэл илүү хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх замаар бодлогоо цогцоор нь хэрэгжүүлэх боломжтой болох болно.</p> <p>11. “11.1.6. хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах” гэсэн үгийг хасах Тайлбар: Хөрөнгө оруулалт хайж буй төслүүдийг нь боловсруулах, ТЭЗҮ-г нь хийх, хөгжүүлэх, бэлэн байдлыг нь хангах үйл ажиллагаа бол мэргэжлийн баг, экспертүүдийн хийдэг ажил болохоос биш төрийн хэн нэгэн албан хаагчийн хийх ажил биш, хийж чадах ч үгүй, ажлын ачаалал нь хүрэх ч үгүй. Иймд Засгийн газраас баримталж байгаа “төрийн зарим ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ” гэсэн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд ийм ажлуудыг мэргэжлийн зөвлөхүүд, экспертүүдээр хийлгэдэг болох нь илүү үр ашигтай, цаг хэмнэх, илүү чанартай бүтээгдэхүүн гаргах болно. Хөрөнгө оруулалтын агентлаг харин эдгээр бэлэн төслүүдийг хөрөнгө оруулагчдад танилцуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх ажлыг хийж болох юм.</p> <p>12. “15.1.2. тогтворжуулах гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын орчныг тогтворжуулах” гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Хуулийн төслийн 6.2.1-р заалттай уялдуулав.</p> <p>13. “15.1.5. хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, санхүүгийн бүртгэл, тооцоогоо нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэсэн заалт нэмэх. Тайлбар: Гадаадын хөрөнгө оруулагч нарын хувьд гадаад валютын ханшийн эрсдэл томоохон хувийг эзэлж хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж байдаг тул энэ эрсдэлийг нь бууруулахад энэ дэмжлэг тодорхой эерэг нөлөө үзүүлэх болно.</p> <p>14. “16.1.8. Хөрөнгө оруулалтын гэрээ, түүний хугацаатай уялдуулан гадаад валютаар хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчийг оруулсан хөрөнгө оруулалтынхаа хэмжээнээс хэтрэхгүй хэмжээгээр гадаад валютын фьючерс зах зээлд оролцох эрх олгох.” гэж нэмэх. Тайлбар: Гадаад валютын ханш дандаа чангарч байдаг манай зах зээлд гадаад валютаар хөрөнгө оруулалт хийхэд өндөр эрсдэлтэй байдаг тул энэ эрсдэлийг нь бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад валютын фьючерс зах зээлийг бий болгож, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Иймд энэ төрлийн зах зээлийг хөгжүүлэн, үүнд аж ахуйн нэгжүүдийг оролцох эрхтэй болгон оролцоог нь нэмэгдүүлснээр гадаадын хөрөнгө оруулагч нарт манай улсын зүгээс учруулж байгаа томоохон эрсдэлийг нь бууруулахад ихээхэн чухал нөлөөтэй.</p>	<p>оруулахын тулд тодорхой тооцоо судалгаа шаардлагатай бөгөөд санхүүгийн зах зээлийн боломж нөхцөл зэргийг тооцож үзсэний үндсэн дээр хуулийн өөрчлөлт хийх нь зүйтэй. Гэхдээ Хөрөнгө оруулалтын тухай хуулиар бус холбогдох нарийвчилсан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой.</p> <p>15. Татвар тогтворжуулах бодлого нь төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийг тооцох учиртай. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийн зорилго нь хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахад илүүтэй анхаарсан бөгөөд дээрх санал болгож буй татварын хувь хэмжээг тогтворжуулснаар хөрөнгө оруулалтыг хэрхэн татах нь тодорхойгүй бөгөөд олон улсын байгууллагуудаас өгч буй зөвлөмжид энэ төрлийн дэмжлэгийг нэмэгдүүлэхгүй байхыг зөвлөмж болгож байгаа.</p> <p>16. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал нь хөрөнгө оруулагчаас илүүтэй ажилтны нийгмийн баталгаатай холбоотой асуудал бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын хуулийн шинэчлэлээр хийгдэх ажил биш.</p> <p>17. Тогтворжуулах гэрчилгээнд тавигдах шаардлагыг хялбаршуулсан бөгөөд хүнээс үл хамаарах нөхцөлөөр уг гэрчилгээг олгоно.</p> <p>18. Тогтворжуулах гэрчилгээнд тавигдах шаардлагыг хялбаршуулсан бөгөөд хүнээс үл хамаарах нөхцөлөөр уг гэрчилгээг олгоно.</p> <p>19. Зарчмын хувьд туссан. Гэрчилгээ олгох журам нь цахимаар олгогдох бөгөөд олгогдсон өдрөөс эхлэн үр дагавар үүсгэнэ.</p> <p>20. Агуулгын хувьд туссан. Ажлын хэсэгт хувийн хэвшлээс төлөөлөл оролцох</p>
--	--	---	--

		<p>15. “18.1.5. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр”, “18.1.6. үл хөдлөх хөрөнгийн татвар”, “18.1.7. онцгой албан татвар” гэсэн заалтуудыг нэмэх. Тайлбар: Монгол улсын хувьд ойрын хугацаанд уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой салбар хэвээр байх тул эдгээр төлбөр, татварын хувь хэмжээг тогтворжуулна гэдэг нь хөрөнгө оруулагчдад эерэг нөлөө үзүүлэх болно.</p> <p>16. “16.1.9. хөрөнгө оруулалттай компанийн монгол ажилтнууд хэрэв хүсвэл байгууллагаас төлж байгаа болон суутгуулж байгаа нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээ бууруулж тооцуулж болно.” гэж нэмэх. Тайлбар: Аж ахуйн нэгжүүдийн хувьд ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэхэд тулгардаг хамгийн том бэрхшээл бол нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ байдаг бөгөөд энэ нь хөрөнгө оруулагч нарт ч ихээхэн хэмжээний зардал болж байдаг. Иймээс энэ зохицуулалтыг нэмж өгснөөр ажлын байрыг илүү олноор бий болгох, дотоодын ажилчдад төлөх цалингийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлөх болно.</p> <p>17. “20.3.1. улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий” гэдэг үгний оронд “20.3.1. УИХ, Засгийн газраас тодорхойлсон эдийн засгийн тэргүүлэх салбарт болон” гэж оруулж өөрчлөн найруулах. Тайлбар: “Улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий” гэдэг нь яг ямар шалгуур хангасныг хэлж байгаа нь тодорхойгүй буюу тунхаглалын шинж чанартай байна. Иймд хуулийн зүйл, заалтыг тодорхой бичих ёстой гэсэн үндсэн шалгуурын дагуу бодлого тодорхойлогчдын “эдийн засгийн тэргүүлэх салбар” гэж тодорхойлсон салбар гэж оруулбал шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэн ч ойлгоход хялбар болох болно.</p> <p>18. “20.5. ...үндэслэлтэй гэж үзвэл ...” гэснийг илүү тодорхой болгон 20.5-р заалтаа “дараах үндэслэлээр” гэж үндэслэлүүдийг нь жагсаан тодорхой зааж өгөх. Тайлбар: “үндэслэлтэй гэж үзвэл” гэдэг нь ямар нэгэн төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол орж ирэх магадлалыг нэмэгдүүлэх субъектив шинж чанартай байна. Ийм субъектив шинж чанартай заалтууд нь авлига, хээл хахууль, хүнд суртлыг нэмэгдүүлэх, өөгшүүлэх сөрөг үзэгдлүүдийг бий болгодог тул үндэслэлийг нь тодорхой хуульчилж зааж өгөх нь хөрөнгө оруулагчид ч, төрийн албан хаагчид ч хэн хэнд нь нөхцөлүүдийг тодорхой болгох болно.</p> <p>19. “22.2. ...холбогдох бичилтийг” гэдгийн дараа “ажлын таван өдөрт багтаан хийж” гэж нэмж оруулан найруулах. Тайлбар: Тус хуулийн төслийн 22.1-р заалтад 30 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасан нь сайшаалтай хэдий ч шийдвэр гарснаас хойш удах магадлалтай тул ийнхүү гэрчилгээ олголтын өдрийг тодорхой зааж өгөх нь зүйтэй.</p> <p>20. “24.5.1. Ажлын хэсэгтэй хэлэлцээр хийхэд хөрөнгө оруулагч өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалуулах зорилгоор хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагын төлөөлөлтэй хамтран хэлэлцээрт орж болно.” гэсэн заалт нэмэх.</p>	<p>асуудал нээлттэй бөгөөд уг оролцогчийг хуулиар нарийвчлан заах нь зохимжгүй юм.</p> <p>21. Хөрөнгө оруулалтын гэрээгээр зөвхөн татварын хувь хэмжээ л тогтворжих боломжтой. Харин хууль тогтоомжтой холбоотой процессыг 20 ба түүнээс дээш жилийн хугацаанд тогтворжуулах боломжгүй. Хууль нь төрийн бодлого, чиглэлээс хамаарч өөрчлөгдөх боломжтой бөгөөд энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно.</p> <p>22. Агуулгын хувьд энэ зохицуулалт байгаа. Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн дагуу хийгдэх төслийн үнэлгээгээр эдгээр хүчин зүйлийг шалган тогтоох бөгөөд хөрөнгө оруулалтын хуулиар нэмэлт шаардлага болгон тавих шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>23. Зөвшөөрөлтэй холбоотой асуудал нь Зөвшөөрлийн хуулийн хүрээнд хэрэгжих нь зүйтэй бөгөөд энэ талаар нэмэлт шаардлагыг хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлтээр тусгах шаардлагагүй.</p> <p>24. Саналыг тусгаж, Маргаан шийдвэрлэх зөвлөл нь төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг хүлээн авна.</p> <p>25. Маргаан шийдвэрлэх зөвлөл нь эвлэрүүлэн зуучлах хүрээний байгууллага тул асуудлыг эцэслэн шийдвэрлэх чиглэлгүй. Иймд тусгайлан шинжээч томилох гэх хугацаа, цаг хугацаа хөрөнгө шаардсан шаардлагыг төслөөс хаслаа.</p> <p>26. Агуулгын хувьд туссан. Энэхүү гомдол шийдвэрлэх процесс нь өөрөө хэлэлцээний журмаар асуудлыг</p>
--	--	--	---

		<p>Тайлбар: Төр ямагт давамгай эрх мэдэлтэй байдаг тул хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх гуравдагч этгээд болох хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөллийн дэмжлэг авах боломжийг нээж өгөх хэрэгтэй.</p> <p>21. “24.12. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед талуудын хооронд тодорхой асуудлаар харилцан тохиролцож Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан зохицуулалтууд нь тухайн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөрөнгө оруулагчид тогтвортой үйлчилнэ” гэсэн заалтыг нэмэх. Тайлбар: Хөрөнгө оруулагчдад бизнес, татварын тогтвортой орчноос гадна Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан үйл ажиллагааны орчин тогтвортой байх нь чухал ач холбогдолтой байдаг тул энэ заалтыг нэмэв.</p> <p>22. “26.4.5. хөрөнгө оруулалт нь эсхүл төсөл нь Монгол Улсын эсхүл тухайн бүс нутгийн байгаль орчны өнөөгийн байдал болон нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эсэх;”, “26.4.6. Монголын түүх, уламжлалт соёл, соёлын дурсгал, соёлын өв, үндэсний шашин шүтлэгт сөргөөр нөлөөлөх эсэх” гэсэн заалтуудыг нэмэх. Тайлбар: Аливаа хөрөнгө оруулалт нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийлгэж ямар сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг үнэлүүлдэг нь олон улсын практик болоод удаж байгаатай адил гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтад ч мөн энэ шаардлагыг заавал хангуулах хэрэгтэй. Ялангуяа гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт нь томоохон хэмжээтэй, далайцтай байх магадлалтайгаас гадна гадаад улсын төрийн бодлогоор хийгдэх нь элбэг байдаг тул өөрийн улсын уламжлалт соёл, түүх, түүхийн болон соёлын өвөө хадгалах, нийгмийн тогтвортой байдлыг хангах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байлгахад онцгой анхаарах шаардлагатай.</p> <p>23. “26.6. Тус хуулийн 25.1 дүгээр заалтад тусгагдсан зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд жилд 1 удаа тус хуулийн 26.4 дүгээр заалтад тусгагдсан нөхцөлүүд үүсэж байгаа эсэхэд холбогдох байгууллагууд хяналт тавина.”; “26.7. Тус хуулийн 26.6 дугаар заалтад тусгагдсан хяналт тавьж байх явцад зөрчил үүссэн нь илэрсэн тохиолдолд дараах арга хэмжээг Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шат дараалан авна: 26.7.1. үүссэн нөхцөл байдлыг дахин үүсгэхгүй байх талаар анхааруулж сөрөг үр дагаврыг арилгуулах; 26.7.2. дээрх нөхцөл байдал дахин үүссэн, эсхүл ноцтой хор уршиг тарьсан бол үйл ажиллагааг нь зогсоох, зөвшөөрлийг цуцлах.” гэж нэмэх. Тайлбар: Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулсан төслүүдийг зөвшөөрлийн дагуу, урьдчилан хийсэн үнэлгээний дагуу явж байгаа эсэхэд зайлшгүй хяналт тавьж хамтран ажиллах нь чухал тул энэ заалтыг нэмэв.</p> <p>24. “28.1. ...захиргааны” гэсний дараа “байгууллага, эсхүл хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөлд гаргана” гэж нэмж өөрчлөн найруулах. Тайлбар: “төрийн байгууллагатай үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр бас нэг төрийн байгууллагад гомдол гаргах, тухайн гомдлыг хэрхэн шийдвэрлэх саналыг төрийн албан</p>	<p>шийдвэрлэх үе шатад хамаарна. Иймд эргэлзээ үүсгэхгүйн тулд тусгайлан хугацаа тавьсангүй. Гэвч, асуудлыг хэлэлцээний журмаар шийдэхтэй холбоотой эхлэлтийн гомдолтой танилцах үйл явцыг нарийн зааж, хугацааг тодорхой болгосон.</p> <p>27. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын хуулиар оруулж зарчмын том өөрчлөлт нь хөрөнгө оруулалтын маргааныг шууд арбитрын журмаар шийдвэрлүүлэх боломжийг нээлттэй болгосон. Хөрөнгө оруулагч нь шүүхэд хандах эрх нээлттэй боловч мөн арбитрад хандах төрийн зөвшөөрлийг энэ хуулиар бий болгосон. Маргааныг шийдвэрлэх үе шатыг тодорхой заах нь хөрөнгө оруулагчид цаг хугацааг хэмнэх давуу тал болно.</p> <p>28. Татварын хяналт шалгалт, хураалтын процесс нь Татварын ерөнхий хуулийн хүрээнд зохицуулагддаг, нийгмийн даатгалын асуудал нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд зэрэг дурдсан асуудал нэг бүр нь өөрийн салбар хуулийн хүрээнд хэрэгжих тул эдгээр хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судлалгүйгээр шууд хөрөнгө оруулалтын хуультай хамт өөрчлөх боломжгүй.</p>
--	--	---	---

		<p>хаагч боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх” гэсэн энэ үйл явц нь хэт удаан, хүнд сурталтай үйл явц болохоор байна. Түүнчлэн төрийн байгууллагатай холбоотой гомдол маргааныг тухайн харьяалах төрийн байгууллага (хөндлөнгийн бус нэг тал гэсэн үг) шийдвэрлэхээс өөр гарц, арга байхгүй байгаа нь хөрөнгө оруулагч нарыг төрийн хүнд суртлаас зугтаах бас нэг шалтгаан болох болно. Ө.х хөрөнгө оруулагчдыг үргээж байгаа төрийн хүнд суртлын механизмтай дахин нүүр тулахаас өөр аргагүй байдалд хүргэх заалт байна. Иймд хөрөнгө оруулагчдад дахин өөр сонголтыг гаргаж өгч маргаан, хянан шийдвэрлэх зөвлөлийг энд нэмж оруулж өгснөөр хөндлөнгийн механизмаар аль аль нь асуудлаа шийдвэрлүүлэх боломжийг бий болгох болно.</p> <p>25. “28.3. ... Засгийн газрын гишүүний” гэсний дараа “эсхүл хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрээр шинжээч томилж, дүгнэлт гаргуулж болно” гэж оруулан шинэчлэн найруулах. Тайлбар: 28.1-р заалтад оруулсан өөрчлөлттэй уялдуулан энэ заалтад энэ үгийг нэмж оруулан дахин найруулах шаардлагатай.</p> <p>26. “28.4. Хөрөнгө оруулагчийн төрийн байгууллагад гаргасан гомдлыг шийдвэрлэж эргэж мэдэгдэх нийт хугацаа 30 хоногоос хэтрэхгүй” гэсэн заалт нэмэх. Тайлбар: Хуулийн төслийн 28 дугаар зүйлд тусгагдсаны дагуу хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх энэ үйл явц хэт удаашрахаар олон шат дамжлагатай байгаагаас гадна хэдий хугацаанд шийдвэрлэх талаар тодорхой заалт байгаагүй тул иргэн, аж ахуйн нэгжийн гаргасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжиж байгаа хуулийн заалттай уялдуулан 30 хоногийн дотор шийдвэрлэж эргэж хариу мэдэгдэж байх энэ заалтыг нэмэв.</p> <p>27. “Аравдугаар бүлэг. Хөрөнгө оруулалтын маргаан” бүлгийг дараах байдлаар шинэчлэн найруулах: “29 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх тогтолцоо 29.1. Хөрөнгө оруулалтын маргаан гарсан тохиолдолд талууд дараах байгууллагуудаас сонгон гомдлоо гаргаж маргаанаа хянан, шийдвэрлүүлж болно: 29.1.1. хариуцагчийн дээд шатны удирдлага, байгууллага; 29.1.2. Хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөл; 29.1.3. Эвлэрүүлэн зуучлах төв; 29.1.4. Шүүх; 29.1.5. Арбитр; 29.1.6. Бусад олон улсын хөрөнгө оруулалттай холбоотой маргаан шийдвэрлэх төв, арбитр, байгууллагууд. 29.2. Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг Хөрөнгө оруулалтын гэрээний талууд хэлэлцээний замаар шийдвэрлэхийг тэргүүнд үзнэ. 29.3. Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш 1 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн 29.1.2 дугаар заалтад тусгагдсан “Хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөл”-д эсхүл холбогдох шүүх, арбитрт хандаж гомдол гаргаж болно.</p>	
--	--	---	--

		<p>30 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх зөвлөл</p> <p>30.1. Хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь хөрөнгө оруулалттай холбоотой аливаа маргааныг шүүх болон арбитрын бус аргаар шийдвэрлэх зорилготой албан ёсны зөвлөл байна.</p> <p>30.2. Зөвлөлийг Монгол Улсын Шадар сайдаар толгойлуулан төр болон хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагуудын тэнцүү тооны төлөөлөлтэйгөөр Засгийн газар байгуулна.</p> <p>30.3. Зөвлөл ажлын албатай байх бөгөөд ажлын албаны үүргийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.</p> <p>30.4. Зөвлөл дэргэдээ шинжээч, үнэлгээчин, экспертүүдээс бүрдсэн “Шинжээчийн баг”-тай байж болно.</p> <p>30.5. Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг Зөвлөл хүлээн авч зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд Зөвлөлийн шийдвэрийг талуудад хүргүүлэн шийдвэрийг биелүүлэхийг шаардах эрхтэй.</p> <p>30.6. Зөвлөлийн гаргасан шийдвэрийг төрийн бүх байгууллагууд хэрэгжүүлэх, дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>31 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх бусад аргууд</p> <p>31.1. Талууд хүсвэл тус хуулийн 29.1.1, 29.1.2 дугаар заалтад тусгагдсан байгууллагуудад хандахгүйгээр шууд эвлэрүүлэн зуучлах төв эсхүл шүүх эсхүл арбитрад хандаж хөрөнгө оруулалттай холбоотой гомдол гаргаж болно.</p> <p>31.2. Талууд шүүх эсхүл арбитрад гомдол гаргахаасаа өмнө Эвлэрүүлэн зуучлах төвд хандан эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдолд шүүх, арбитрад хандан гомдол гаргахгүй.</p> <p>31.3. Хөрөнгө оруулалтын гэрээнд арбитрын хэлэлцээр тусгагдаагүй ч Арбитрын тухай Монгол улсын хуулийн 8-р зүйлд заасан шаардлага хангасан хэлэлцээрийг арбитрын хэлэлцээр хийгдсэнд тооцож гадаад, дотоодын сонгосон арбитрад хандан гомдол гаргаж болно.</p> <p>31.4. Арбитрын тусгайлсан хэлэлцээргүй, хэрэглэгдэх хуулийг гэрээнд тусгайлан зааж баталгаажуулаагүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.</p> <p>Тайлбар: Олон улсын сайн туршлагаар ихэвчлэн хөрөнгө оруулалттай холбоотой маргаан хянан шийдвэрлэх механизм нь дараах дараалалтай байдаг:</p> <ul style="list-style-type: none"> - Харилцан ойлголцож зөвшилцөж шийдвэрлэх; - Холбогдох дээд байгууллагад нь хандан шийдвэрлүүлэх; - Эвлэрэх; - Маргаан хянан шийдвэрлэх механизмаар шийдвэрлүүлэх; - Арбитр болон шүүх. <p>Өөрөөр хэлбэл арбитр болон шүүхээр маргаан шийдвэрлүүлэхээс илүү өмнө нь аль болох бусад механизмаар гомдол, маргаанаа шийдвэрлэх нь цаг хугацаа, зардлын хувьд харьцангуй хямд, хурдан байдаг. Эдгээрээс одоогоор манай улсад “Хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх зөвлөл/механизм” байхгүй байгаа бөгөөд үүнийг бий болгож гаргасан шийдвэр нь заавал биелэгдэх хүчин төгөлдөр байх нь маш чухал юм. Ингэж зөвлөлийг байгуулж ажиллуулж чадсан тохиолдолд маргаан, гомдол заавал арбитр, шүүх рүү явах шаардлагагүй болно.</p> <p>Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалын төвд хандан талууд эвлэрэх боломжтой бөгөөд үүнийг “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-аар зохицуулдаг. Гэхдээ энэ хуулийн төсөлтэй</p>	
--	--	---	--

		<p>уялдуулан “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан тус хуулийн 8-р зүйлд тусгагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн ажиллагааг шүүхээр хүлээн зөвшөөрүүлэх үйл явцыг баталгаажуулах шаардлагатай.</p> <p>Шүүхийн ачаалал, шүүгч нарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын талаарх мэдлэг, ур чадвар дутмаг байгаа өнөө үед арбитраар маргааныг шийдвэрлүүлж болох бөгөөд талууд гэрээндээ дотоодын эсхүл гадаадын аль арбитраар маргааныг шийдвэрлүүлэх талаар хэлэлцээр хийн тусгасан тохиолдолд тухайн хэлэлцээрт тусгагдсан байнгын болон түр аль ч арбитраар маргааныг шийдвэрлүүлж болно. Мөн тухайн үед гэрээнд арбитраар хэлэлцээр хийгдээгүй байсан ч талууд нөхөж хэлэлцээр хийх, эсхүл Арбитрын тухай хуулийн 8-р зүйлд тусгагдсан шаардлага хангасан бичиг, харилцаа хийгдсэн бол арбитраар хэлэлцээр хийгдсэнд тооцож арбитраар хэргийг шийдвэрлүүлж болно.</p> <p>“Хөрөнгө оруулалтын маргаан хянан, шийдвэрлэх зөвлөл”-өөр хөрөнгө оруулагч, төрийн байгууллага хоорондын маргааныг хэлэлцэх нь шүүхийн өмнөх шатанд маргаан шийдвэрлэх хамгийн хурдан бөгөөд хялбар арга зам гэж үзэж байна.</p> <p>28. Тус хуулийн төсөлтэй холбоотойгоор дараах хуулиудад дараах утгатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах:</p> <p>-Татварын багц хуульд:</p> <ul style="list-style-type: none"> • Татварын хяналт шалгалтыг хөнгөвчлөх • Татварын байцаагчийн актаар данс хаадгийг зогсоох • Татварын хувь хэмжээний заалтуудыг уялдуулах. Ж нь: тус хуулийн төслийн 15.1-р заалтад тусгагдсан татварын холбогдолтой арга хэмжээнүүдийг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт хийх замаар тусгах. <p>-Нийгмийн даатгалын тухай хуульд:</p> <p>3. Хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дотоодын (монгол) ажилтнуудад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт эдлүүлэх</p> <p>-Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд:</p> <p>4. Шүүхээс бусад байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төвүүдийн эвлэрлийн гэрээ, шийдвэрийг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг болгох баталгааг бий болгох</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд:</p> <p>5. Хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгийг буруутай этгээд (хөрөнгө оруулалт хүлээн авсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн албан хаагч, төрийн албан тушаалтан)-ээр бүрэн нөхөн төлүүлдэг болгох</p> <p>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хохирлыг нөхөн төлүүлэх хугацааг түргэсгэх</p> <p>7. Буруутай этгээдийн аж ахуйн нэгжийн хөрөнгө хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхгүй байгаа тохиолдолд авах арга хэмжээнүүд</p> <p>-Захиргааны ерөнхий хуульд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдлээс үүссэн хохирлыг 	
--	--	--	--

			<p>буруутай этгээдээр нөхөн төлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагч, албан тушаалтны буруутай шийдвэрээс үүссэн хор хохирлыг тухайн этгээдээр бүрэн нөхөн төлүүлдэг хариуцлагын тогтолцоог чангатгах <p>-Төрийн хяналт шалгалтын тухай хуульд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид хийгдэх хяналт шалгалтыг хөнгөвчлөх ➢ Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжийн хийсэн хөрөнгө оруулалттай компанийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт <p>-Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллах гадаад ажилтны тоо хэмжээ, төлөх төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх <p>Тайлбар: Дээрх дагалдах хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хуулийн төслийн заалтууд болон УБХТ-ын зүгээс оруулахаар санал болгож буй заалтуудтай холбоотойгоор хуулиудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор зайлшгүй оруулах шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүд юм.</p>	
13.	Монголын бизнесийн зөвлөл	2023.05.12	<p>1. Төрөөс хөрөнгө оруулалтын салбарт баримтлах зарчмуудыг тодорхойлж хуулийн төсөлд тусгах</p> <p>Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, хөрөнгө оруулалтыг татах, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд дараах зарчмуудыг “Төрөөс хөрөнгө оруулалтын талаар баримтлах зарчим” болгон хуулийн төсөлд тусгах:</p> <p><i>“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:</i></p> <ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах; - Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах; - Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах; - Тогтвортой хөгжлийг хангах; - Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.” <p>2. 2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>Хөрөнгө оруулалтын тухай хуулиар <u>олгосон</u> хөрөнгө оруулалтын <u>дэмжлэг</u>, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн <u>зохицуулалтуудыг</u> бусад хууль тогтоомжид уялдуулж, нарийвчилсан зохицуулаагүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалтын дэмжлэг бодит байдал дээр хэрэгжихгүй, улмаар хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөхөд хүрдэг. Иймд, хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийг зохицуулсан хуулиудыг нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Газрын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Үйлдвэрлэл</i></p>	<p>1. Хуулийн төсөлд агуулгын хүрээнд туссан. Тусгайлан зарчим гэхээс илүүтэй хөрөнгө оруулагчийн баталгаа, эрх үүрэг, төрийн байгууллагаас хэрэгжүүлэх чиг үүрэг зэргээр процессын харилцаанд тусгасан.</p> <p>2. Агуулгын хувьд туссан.Монгол Улсын бүх хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэх тул хуулийг тоочих нь чухал шаардлагатай бусад хуулийг орхигдуулах эрсдэлтэй тул Үндсэн хуульд нийцсэн акт гэсэн агуулгыг төсөлд тусгалаа.</p> <p>3. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай.</p> <p>4. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>5. Хөрөнгө оруулалтын гэрээгээр зөвхөн</p>

		<p><i>технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”</i></p> <p>3. 3.1.1. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>Уг заалтын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагын хүрээнд зөвхөн хуулийн этгээд байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хязгаарлаж, хувь хүн өөрөө хөрөнгө оруулагч байх боломжийг үгүйсгэсэн байна. Иймд, уг заалтыг хуулийн төслийн 5.1.2, 5.1.4, 5.1.6 болон 5.1.7 дахь хэсгүүдтэй уялдуулан дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.”</i></p> <p>4. 4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг; Уг заалтын дагуу зөвхөн “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг <u>хөрөнгө оруулалт</u> гэж тооцохоор байна. Түүнчлэн уг заалт нь 5.1-д заасан хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй зөрчилдөж байна. Хөрөнгө оруулалтыг зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулах байдлаар хязгаарлах нь улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлэх хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Цаашлаад төслийн санхүүжилт зэрэг бусад хэлбэрээр хийх хөрөнгө оруулалтыг үгүйсгэдэг, татварын хувьд маргаан дагуулдаг заалт юм. Иймд, уг заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулах: <i>“4.1.16 “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдэд хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;”</i></p> <p>5. “Татварын орчин”-ы тодорхойлолтыг одоогийн хуулийн адилаар шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр тусгах 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7-д заасан <u>“Татварын орчин” гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг хэлнэ</u> гэсэн тодорхойлолтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаагүй орхижээ. Уг заалтыг хассан нь зарчмын хувьд одоо байгаа зохицуулалтыг дордуулсан байна. Учир нь, уг тодорхойлолт нь татварын орчныг тогтвортой байдлыг хангах төрийн баталгааны үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл, тогтворжуулах гэрчилгээ болон ХОГээр олгож буй татварын орчныг тогтвортой байлгах баталгааны цар хүрээг тодорхойлж буй чухал тодорхойлолтыг хасах нь зарчмын хувьд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах бус дордуулахаар байна. Ялангуяа нэг талд тогтворжуулах гэрчилгээгээр гэрчилгээнд заасан хугацаанд татварын хувь болон хэмжээг <u>тогтвортой байлгах төрийн баталгааг өгсөн хэр нь</u> нөгөө талд татвар ногдуулах, тайлагнах болон төлөхтэй холбоотой дүрэм журам, арга аргачлалыг өөрчлөх замаар ногдох татварын хувь болон хэмжээг нэмэх</p>	<p>татварын хувь хэмжээ л тогтворжих боломжтой. Харин хууль тогтоомжтой холбоотой процессыг 20 ба түүнээс дээш жилийн хугацаанд тогтворжуулах боломжгүй. Хууль нь төрийн бодлого, чиглэлээс хамаарч өөрчлөгдөх боломжтой бөгөөд энэхүү хуулийг гэрээ байгуулсан этгээд нэг бүртэй өөр өөрөөр хэрэгжүүлэх тохиолдол төрд асар их захиргааны зардал гарна. Төрийн зардал бол татварын төлөгчийн төлсөн татвар тул үргүй зардал гаргахыг хориглоно. Эргэлзээ үүсгэхгүйн тулд дээрх тодорхойлолтыг хасах нь зүйтэй.</p> <p>6. Саналыг тусгаж, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн охин хараат компанийг гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд гэсэн тодорхойлолтоос хаслаа.</p> <p>7. 6 дахь саналыг авсантай холбоотойгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй болсон. Засгийн газрын тусгай сангийн хуульд заасан сангийн эх үүсвэрийн асуудалд тодорхой судалгаа, шинжилгээ хийгдээгүй тул тус хуульд өөрчлөлт оруулах үндэслэл бүрдэхгүй байна. Хяналт шалгалтын хувьд хөрөнгө оруулагчид хийх хяналт шалгалт болно.</p> <p>8. Агуулгын хувьд туссан. Гэхдээ нэр томьёоны хувьд зохицуулалт хэсгээс ишлэл авах нь хууль зүйн техникийн хувьд тохиромжгүй байна.</p> <p>9. Хөрөнгө оруулалтын маргаан гэснийг тодорхойлох нь хүрээг хэт хумих эрсдэлтэй тул нэр томьёогоор тодорхойлох нь эрсдэлтэй байна.</p> <p>10. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль</p>
--	--	---	--

		<p>үр дагавар үүсгэх хандлага улам нэмэгдэхээр байна. Хэрэв уг байдлаар татварын хувь болон хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгож, ХОГ байгуулна гэвэл уг баталгаа нь хөрөнгө оруулалт татах хэмжээнд эрх зүйн баталгаа бүрдүүлж чадахгүй. Иймд, хуулийн төслийн 4 дүгээр зүйлд "татварын орчин"-ны тодорхойлолтыг одоо үйлчилж байгаа хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7 дахь хэсэгт заасан агуулгаар дараах байдлаар нэмж тусгах: "4.1.**. "татварын орчин" гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг;"</p> <p>6. 4.1.5-т "гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компани, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг" гэж өөрчилж байгаа нь Мобиком Корпораци ХХК-ийн хууль ёсны эрх ашгийг шууд хөндөхөөр заалт болж байна. Мобиком Корпораци ХХК нь олон суваг дамжуулах үйлчилгээ болох "VOO" үйлчилгээг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3-т заасан "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах этгээдэд олгохыг хориглоно" гэсэн заалтад нийцүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5 дахь заалтыг баримтлан. өөрийн охин компани болох Мобинет ХХК-аар дамжуулан тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. 4.1.5-д шинээр тодорхойлсон тодорхойлолт нь Мобинет ХХК-ийн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.3 заалтын дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхэлж байсныг хязгаарлахаар болж, бидний нэгэнт оруулсан хөрөнгө оруулалтад хууль эрх зүйн хувьд эрсдэлд оруулахаар байна.</p> <p>7. Дагалдах хуулиудын төсөлд: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг хамруулан уг хуулийн 7.3.3 заалтыг хүчингүйд тооцох, эс бөгөөс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 заалтыг Хэвээр үлдээж, төслийн 4. 1.5 заалтыг хасах, Төслийн 5.1.6 заалтыг хасах. Учир нь хөрөнгө оруулагч нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг явуулахдаа тухайлсан оюуны өмч /контент/-ийг эрх бүхий этгээдээс хууль ёсны дагуу худалдан авч дамжуулан түгээх, борлуулах нөхцөлд энэ нь тухайн компанийн үйл ажиллагааны зардал болохоор байна.</p> <p>Төслийн 6.2.5 болон одоогийн мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6.7-д "хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй" гэж заасан нь хөрөнгө оруулагчийн захирах зарцуулах хөрөнгө орлого байх атал Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.3 дахь заалт "Энэ хуулийн 9.2-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна"-аар хөрөнгө оруулагчийн хөрөнгө орлогоос дахин татвар хураамж авсан зөрчилтэй зохицуулалт болохоор байна.</p> <p>Дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.3 дахь заалтыг "Энэ хуулийн 9.2-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь тухайн этгээдийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү байна" гэж өөрчлөн найруулж, хуулийн нийцлийг хангах нь зүйтэй байна.</p> <p>Төслийн 12.3-т "Хөрөнгө оруулагч ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтын тоо жилд 2-оос ихгүй байна." гэж заасан нь төрийн эрх бүхий байгууллагаас хийгдэх нийт хяналт</p>	<p>ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ.</p> <ol style="list-style-type: none"> 11. Саналыг тусгаж, уялдааг хангасан. 12. Саналыг тусгаж, дайчлан авахад үл ялгаварлах зарчим баримтлахыг нэмж тусгасан. 13. Энэ заалт нь хөрөнгө оруулалтаа буцаан татах үйл явцад яригдах баталгаа бөгөөд энэ тохиолдолд татвар болон холбогдох бусад өр төлбөрийг бүрэн төлсөн байх үүрэгтэй. 14. Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Ийнхүү заах нь ач холбогдолгүй юм. 15. Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Банк, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой харилцааг ийнхүү заах нь ач холбогдолгүй юм. 16. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийн эрхийг хангахтай уг зохицуулалтын хүрээнд хуулиар л хязгаарлалт тогтоож болно. 17. Саналыг тусгасан бөгөөд төрийн байгууллагад хандах асуудлыг хэлэлцээний журмаар шийдвэрлэх боломж нөхцөлийг нарийн тогтоосон. 18. Төрийн байгууллага нь хуульд заагдаагүй мэдээллийг шаардах нь хууль бус асуудал болно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч мэдээллийг өгөхгүй байх, ийнхүү гаргаж буй төрийн байгууллагын хууль зөрчсөн шаардлагын талаар гомдол гаргах эрхтэй. 19. Хөрөнгө оруулагч шударгаар өрсөлдөх асуудлын төсөлд тусгаж, саналыг хүлээн авсан. 20. Саналыг тусгаж, хөрөнгө оруулалт бодитоор хийсэн байх гэснийг тодорхойлсон. 21. Саналыг тусгасан. Харин компанийн
--	--	---	---

		<p>шалгалтын тоо хэмжээг ойлгох уу, эсхүл зөвхөн хөрөнгө оруулагч этгээдэд хийгдэж байгаа хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой хяналт шалгалтыг ойлгох уу гэдгийг зааглаж тодорхой тусгах саналтай байна.</p> <p>8. Төслийн 4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж хуульд заасан тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”- гэдэгт ... тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээний... гэж нэмэх</p> <p>9. 4.1.15-д Хөрөнгө оруулалтын маргаан гэж хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллага болон хөрөнгө оруулагч нарын хооронд үүссэн болон хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, холбогдох татварын хуулиудтай энэ хуулийн заалт зөрчилдсөнөөс хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирснаас бий болсон маргааныг хэлнэ.”- гэж маргааны агуулгыг тодотгон оруулах</p> <p>10. 6.1. Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана: 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 64 заалтад 110 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан бол 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 27 заалтад 40 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. Ийнхүү Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн орчин тогтворгүй байх нь хөрөнгө оруулагчийн хувьд итгэлийг бууруулах, эрсдэлийг нэмэгдүүлэх, тодорхой бус байдал үүсгэдэг бол улсын хувьд хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулах, хөрөнгө оруулагчдыг алдах, хөрөнгө оруулалтын маргаан гарах эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. Иймд, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой зохицуулалтыг тогтворжуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд дараах заалтыг нэмэлтээр оруулах: <i>“6.1.**. Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох, эсхүл түүнтэй ХОГ байгуулах замаар холбогдох хуулийн зохицуулалтуудыг тогтвортой байлгах баталгаа олгоно.”</i></p> <p>11. <i>Хуулийн төслийн 6.1.4, 29 дүгээр зүйл хэрхэн харилцан уялдаатай байгаа нь тодорхойгүй байна</i></p> <p>12. 6.2.3.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авахад (i) нийтийн ашиг сонирхлын үүднээс (ii) хуульд заасан журмын дагуу (iii) үл ялгаварлах зарчмын хүрээнд (iv) зах зээлийн үнэлгээ бүхий нөхөн төлбөртэйгөөр хураан авах зарчим үйлчилдэг. Иймд, уг заалтад “<i>үл ялгаварлах зарчмыг</i>” нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“6.2.3. хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно.”</i></p>	<p>удирдлагын сайн засаглал нэвтрүүлэх, стандарт нөхцөлийг мөрдөж ажиллах гэсэн агуулгаар ажиллахыг үүрэг болгов.</p> <p>22. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын хөгжлийн аливаа бодлогыг УИХ батлахаар заасан. Иймд хөрөнгө оруулалтын бодлогыг УИХ батлахаар байна.</p> <p>23. Агуулгын хувьд туссан. Засгийн газрын тухай хуульд заасны дагуу холбогдох чиг үүргийн хүрээнд бодлогын санал боловсруулж өгөн барих эрх нээлттэй.</p> <p>24. Саналыг тусгасан.</p> <p>25. Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p> <p>26. Хуулийн төсөлд агентлагийн хэрэгжүүлэх чиг үүргийг хэтэрхий нарийвчлан заах нь хуулийн хэрэгжилтийг хязгаарлах эрсдэлтэй.</p> <p>27. Агуулгын хувьд тусгасан. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, түүний үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт зэргийг төсөлд тодорхой заасан. Хүлээлгэх хариуцлага, нөхөн төлөх хохирол зэргийг тусгасан.</p> <p>28. Агуулгын хувьд туссан. Хяналт шалгалт нь Төрийн хяналт шалгалтын хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулагддаг бөгөөд хяналт шалгалтыг зохион байгуулах нарийвчилсан харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжгүй.</p> <p>29. Агуулгын хувьд тусгасан. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, түүний үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт зэргийг төсөлд тодорхой заасан. Хүлээлгэх хариуцлага, нөхөн</p>
--	--	---	--

		<p>13. 6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй: <i>"Татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсэн"</i> гэдэг үндэслэлийг хэрхэн тогтоох нь тодорхой бус байна. Татварын хяналт шалгалтын явцад хожим нь татварын өр төлбөр илэрсэн нь хөрөнгө оруулагчийг ногдох хөрөнгө, орлогоо гадаад улсад гаргах үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгох.</p> <p>14. 6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй. <i>"Хуульд өөрөөр заасан"</i> гэх үндэслэлээр хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлогоо мөнгөн хэлбэрээр гадаад валютад хөрвүүлж шилжүүлэхийг хүндэтгэн үзэх онцгой шалтгаангүйгээр хязгаарлах эрсдэлтэй байна. Иймд, хууль заасан үндэслэл гэдгийн өмнө тодорхой зорилгыг тусгаж дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"6.2.6. хөрөнгө оруулагч нь үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй."</i></p> <p>15. 7.1.4.Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Бусад хууль тогтоомжийн хүрээнд гадаад валютаар гүйлгээ хийх, гадаад валютын шилжүүлэг, худалдан авалтыг хязгаарлах тохиолдол гардаг. Иймд, гадаадын мөнгөн тэмдэгт худалдах, худалдан авах харилцааг хязгаарлахгүй тохиолдлыг тусгаж уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"7.1.4. Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Тус үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа байдлаар хязгаарлахгүй."</i></p> <p>16. 7.1.5.хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Бусад хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааг үндэслэн гадаад руу хийх шилжүүлгийг хязгаарлах эрсдэлтэй тул дараах байдлаар өөрчлөн найруулах. <i>"7.1.5. хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Уг шилжүүлэгт хуульд зааснаас бусад тохиолдолд хязгаарлалт тогтоохыг хориглоно."</i></p> <p>17. 7.1.8.Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах;</p>	<p>төлөх хохирол зэргийг тусгасан.</p> <p>30. Агуулгын хувьд тусгасан. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, түүний үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт зэргийг төсөлд тодорхой заасан. Хүлээлгэх хариуцлага, нөхөн төлөх хохирол зэргийг тусгасан.</p> <p>31. Саналыг тусгаж, хуулийн нийцлийг хангасан. ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: - 300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, -гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. иймээс энэ төрлийн татварт нэмэлт урамшуулал шаардлагатай бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтыг татах бодлого биш гэснийг олон улсын байгууллагуудаас зөвлөж байгаа.</p> <p>32. Агуулгын хувьд туссан бөгөөд Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар хөрөнгө оруулалтын хуульд татварын хувь хэмжээг өөрөөр зохицуулж болно гэж заасан.</p>
--	--	---	--

		<p>Уг заалтын хүрээнд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах замаар гомдол нэхэмжлэлээ шийдүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс дараах байдлаар нэмж найруулах: <i>"7.1.8. Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандан шийдвэрлүүлэх;"</i></p> <p>18. 8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх; Практикт, татварын байгууллага хуульд нарийвчлан тусгаагүй өргөн хүрээний мэдээллийг гаргуулах шаардлага тавих тохиолдолд гардаг. Энэ тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар учруулдаг. Иймд, татварын байгууллага гагцхүү "хуульд заасан үндэслэлийн дагуу" мэдээлэл шаардах эрхтэй байхаар уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан үндэслэлийн дагуу шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;"</i></p> <p>19. 8.1.4. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих; Уг заалтад тусгагдсан "хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх" нэр томъёоны хувьд бизнесээс шууд хэрэглэгчид чиглэсэн (В-С) үйлчилгээнд хамааралтай ба бизнесээс бизнест чиглэсэн (В-В) үйл ажиллагаанд нь төдийлөн хамааралгүй байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"8.1.4. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж зах зээлд шударгаар өрсөлдөх, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих;"</i></p> <p>20. 8.1.8. хөрөнгө оруулалтаа бодитоор хийсэн байх; Хөрөнгө оруулалтаа "бодитоор" хийснийг үнэлэх, хэмжих шалгуур тодорхой бус байгаа тул үүнийг тодорхой болгох. Бусад улсуудад дараах аргыг түгээмэл хэрэглэдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <u>Хөрөнгөд суурилсан:</u> хөрөнгө оруулалтын явцад шаардагдаж байгаа эсхүл бий болгосон хөрөнгийн үнэлгээ • <u>Орлогод суурилсан:</u> хөрөнгө оруулалтын орлогоор бий болсон хөрөнгө • <u>Ажлын байр бий болгох эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлт:</u> бий болгосон ажлын байр болон орон нутагт үзүүлсэн эдийн засгийн үр нөлөө • <u>Хяналт:</u> Хөрөнгө оруулалтаа анхны зорилгын дагуу хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих • <u>Нийтэд мэдээлэх шаардлага:</u> Хөрөнгө оруулалтын хариуцлагатай, ил тод байдлын талаар олон нийтэд мэдээлэх <p>21. 8.1.9. байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх Уг заалт нь сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх ажил тул хуулийн этгээдэд үүрэг ногдуулж зайлшгүй тусгах шаардлагагүй байна. Олон улсын сүүлийн үеийн чиг хандлагаар "байгаль</p>	<p>33. ААНОАТ-ын тухай хуулиар татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон байдлаар хэрэгжүүлэх боломжийг хуульчилсан.</p> <p>34. Алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох асуудал нь ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд уг асуудлаар зөрчил үүсгэх хэлбэрээр хөрөнгө оруулалтын хуульд тусгахгүй байх нь зүйтэй. Нөгөө талаар алдагдал ирээдүйд шилжүүлэх тооцох асуудал нь татварын хөөн хэлэлцэх хугацаатай уялдах шаардлагатай тул 4 жилээр тогтоодог бөгөөд хөрөнгө оруулалтын хуулиар тусгайлан зохицуулах шаардлага байхгүй.</p> <p>35. Агуулгын хувьд туссан бөгөөд татварын холбогдох дэмжлэгүүд нь татварын хууль тогтоомжийн дагуу эдлэхээр байна. Саналыг тусгаж, хуулийн нийцлийг хангасан. ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн</p>
--	--	---	--

		<p>орчин, нийгэм, сайн засаглал” (цаашид “ESG” гэх)-ын тайлан гаргах санал санаачилга өргөжин тэлж байна. Энэ нь тухайн хуулийн этгээд хөрөнгө оруулалт татах боломжоо нэмэхийн тулд санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна тогтвортой, найдвартай байдлыг илтгэх санхүүгийн бус үзүүлэлтүүдээ үнэлэх, өөртөө давуу байдлыг үүсгэх сонирхолтой холбоотойгоор гол төлөв томоохон групп компаниудын зүгээс сайн дурын үндсэн дээр гаргаж буй тайлан мэдээ юм. Энэ асуудлыг ямар нэг тодорхой шалгуургүйгээр нийтлэг байдлаар үүрэгжүүлэн шаардах нь эерэг үр дагавар үүсгэхээс илүүцээр хэлбэрийн төдий чирэгдэл дагуулсан ажиллагаа болж мэдэх тул хуулийн төслийн уг заалтыг хасах саналтай байна.</p> <p>“8.1.9. байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх”</p> <p>22. 9.1. Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх. Монгол Улсын УИХ, Засгийн газраас хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлалыг тусгайлан баталж байгаагүй бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай хуулиас бусдаар хөрөнгө оруулалтын суурь бодлогыг бүхэлд нь илэрхийлэх баримт бичиг байхгүй юм. Харин Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэгт хөрөнгө оруулалтын талаар цухас дурдагдсан байдаг.</p> <p>Иймд, хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтын салбарын суурь үзэл баримтлалыг Засгийн газраас баталж, түүнийг хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтад нөлөө үзүүлэх шийдвэр гаргагч төрийн байгууллагын бүх шатлал, түвшинд сурталчлан таниулж, улмаар Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг төрийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа нэг мөр тайлбарлаж, хэрэглэхэд ач холбогдолтой.</p> <p>Хөрөнгө оруулалтын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогоор хөрөнгө оруулалтын салбарын зорилго, хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, хөрөнгө оруулалтад үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, хөрөнгө оруулалтын салбарын зохицуулалт, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар, хяналт үнэлгээ зэргийг тодорхойлох боломжтой. Иймд хуулийн заалтыг дараах байдлаар нэмж найруулах:</p> <p><i>“9.1.1.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.” Хөрөнгө оруулалтын бодлого;</i> <i>Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үнэлэх, сайжруулах үүднээс дараах заалтыг нэмж тусгах:</i> <i>“9.1.**. Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хөндлөнгийн дүгнэлтийг хоёр жил тутамд нэг удаа хийлгэх бөгөөд дүгнэлтэд туссан зөвлөмж, саналын дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.”</i> <i>Хөрөнгө оруулалтын салбарт хөрөнгө оруулагчидтай төрийн өмчит компаниуд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараах заалтыг нэмж тусгах:</i> <i>“9.1.**. Төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтын орчинд шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангаж, хөрөнгө оруулалтын орчныг сааруулах аливаа үйл ажиллагаа явуулах, хөрөнгө оруулалтыг хязгаарлах нөхцөлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Төрийн өмчит компаниудын жагсаалтыг бүрэн гаргаж, олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлнэ. .”</i></p>	<p>зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. иймээс энэ төрлийн татварт нэмэлт урамшуулал шаардлагагүй бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтыг татах бодлого биш гэснийг олон улсын байгууллагуудаас зөвлөж байгаа. Мөн гааль , НӨАТ-ын дэмжлэгийг холбогдох хууль бүрд тодорхойлсон байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой. Засгийн газар нь хуулиар тогтоосон татварын хувь хэмжээг тогтоох эрх хэмжээ байхгүй тул Хөрөнгө оруулалтын гэрээний хувь хэмжээг тогтоох боломжгүй.</p> <p>36. Хуулийн нийцлийг хангах, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан.п</p> <p>37. Чөлөөт бүс болон үйлдвэрлэл технологийн паркийн хуулиар тухайлсан дэмжлэгүүдийг заасан бөгөөд хөрөнгө оруулагч нарын хувьд тус хуулиудад заасан дэмжлэг авах боломжийг заасан.</p> <p>38. Агуулгын хувьд зохицуулалт байгаа. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх эрх хэмжээ нь Засгийн газрын эрх хэмжээнд хамаарч байна.</p>
--	--	--	---

		<p>23. 10.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.1.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх; Төслийн 9.1.1-т өөрчлөн тусгуулах дээр дурдсан заалттай уялдуулан дараах байдлаар өөрчлөх: <i>"10.1.2.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх"</i></p> <p>24. 10.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх; Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн байгууллагын бүхий л түвшин, салбар, шатлалд холбогдох албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс шаардлагатай мэдээлэл, дэмжлэгийг хөрөнгө оруулалт хариуцсан захиргааны байгууллагаас авах боломжийг бүрдүүлэхийн тулд уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"10.1.3. хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт өгөх, сургалт, мэдээллээр хангах;"</i></p> <p>25. 11.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.1. хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтыг татахаас гадна нэгэнт орж ирсэн хөрөнгө оруулалтыг хамгаалах, түүн дээр суурилан хөрөнгө оруулалтын урсгалыг тогтвортой нэмэгдүүлэх нь нэн чухал. Иймд, уг заалтыг дараах байдлаар нэмж найруулах: <i>"11.1.1. хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, дэмжих цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх"</i></p> <p>26. 11.1.3.-11.1.6. 11.1.3. хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх 11.1.4. хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх 11.1.5. хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх 11.1.6. хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, төслийн мэдээллийн сан бүрдүүлэх Эдгээр заалтыг бодит нөхцөл байдал дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар процессын зохицуулалт тодорхой бус байна. Тодруулбал, хэрхэн <i>"төлөвлөлт хийх"</i>, <i>"дэмжлэг үзүүлэх"</i>, <i>"үйлчилгээний талаар зөвлөх"</i>, <i>"үйлчилгээ үзүүлэх"</i>, <i>"төслийг хөгжүүлэх"</i>, <i>"бэлэн байдлыг хангах"</i> зэрэг процессын зохицуулалт тодорхой бус байгаа нь эдгээрийг бодит байдал дээр</p>	<p>39. Инновацийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт төрийн дэмжлэгийн асуудлыг тодорхой заасан. Түүнчлэн, санхүүжилт дээр төрөөс дэмжлэг үзүүлэхээс гадна, татварын бодлогоор дэмждэг бөгөөд энэ чиглэлийн салбарт НӨАТ чөлөөлөлтийн дэмжлэг мөн үзүүлдэг.</p> <p>40. Хөрөнгө оруулалтын урамшуулал нь холбогдох салбар хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын хувьд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй шууд холбогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим ёсоор төрийн алба нь хууль дээдлэх зарчмыг баримтлах бөгөөд төрийн албан хаагчаас хэрэгжүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын хуулиар бус салбар хуулиар тодорхойлно. Иймд тус хуулийг зөрчиж шийдвэр гаргах боломжгүй тул эргэлзээ үүсгэхгүйн тулд хөрөнгө оруулалтын хуульд энэ төрлийн хуулийн зөрчил үүсгэх зохицуулалт оруулах шаардлагагүй.</p> <p>41. Саналын дагуу Тогтворжуулах гэрчилгээний хугацааг уртасгасан.</p> <p>42. Саналын дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур нөхцөлийг бууруулсан.</p> <p>43. Саналыг хүлээн авч, тогтворжуулах гэрчилгээ олголтыг цахимаар хэрэгжүүлнэ.</p> <p>44. Хөрөнгөө бүхэлд нь татаж, монгол улсад үйл ажиллагаа явуулахгүй болохыг ойлгоно.</p> <p>45. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан.</p> <p>46. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын</p>
--	--	---	---

		<p>хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хүргэнэ. Иймд, уг заалтуудыг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, процессын үе шатыг тодорхой болгох.</p> <p><i>27. 12. Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллын чиг үүрэг</i> 12.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн бусад байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “12.1. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр шаардлагатай тохиолдолд чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авна.”</p> <p>28. 12.2.Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлнэ. Төрийн байгууллагын давтамжтай, олон төрлийн хяналт шалгалтын улмаас хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хэвийн байдал тасалдах, гарах зардлын хэмжээ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай тул уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “12.2. Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг тасалдалгүй байдлыг хангаж, хяналт шалгалттай холбогдуулан хөрөнгө оруулагчид учрах аливаа зардлыг хамгийн бага түвшинд байлгах зарчмыг баримтална.”</p> <p><i>29. 13. Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх</i> 13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь ХОГ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ. Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь ХОГ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх</p>	<p>хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин хууль тогтоомжийг тогтворжуулах буюу хууль буцаан хэрэглэх журмыг 20, 30 жилийн хугацаанд үйлчлэх гэрээгээр тогтворжуулах нь хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай.</p> <p>47. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө бүх журмыг баталж мөрдүүлсэн байх ёстой.</p> <p>48. Саналыг тусгасан.</p> <p>49. Саналыг тусгасан. Хөрөнгө оруулагчийг гомдол шийдвэрлэх журам, хугацааг нарийвчлан тодорхойлсон.</p> <p>50. Агуулгын хувь туссан.Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нөхөн төлбөрийг гаргуулах буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг механизмыг хуулийн төсөлд тусгасан.</p> <p>51. Саналыг тусгасан ба гомдол, түүнийг хянан шийдвэрлэсэн талаарх шийдвэрийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлнэ.</p> <p>52. Хөрөнгө оруулагч хувь хүн, хуулийн этгээд хоорондын маргаан шийдвэрлэхэд шууд арбитраар шийдвэрлүүлэх ёстой гэж хуульчлах боломжгүй. Арбитр бол талуудыг хүсэл зоригоороо сонгох сонголт бөгөөд маргаанд төр оролцохоос бусад тохиолдол арбитраар заавал шийдвэрлүүлэнэ гэж хуульчлах боломжгүй.</p>
--	--	---	--

		<p><i>төрлийн дэмжлэгийг үзүүлэх, Засгийн газрын хүлээсэн үүргийг орон нутагт Засгийн газрын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хэрэгжүүлэх, хамгаалах чиглэлээр Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хандан заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авах, сургалт, мэдээлэл авах ба тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.”</i></p> <p>30. 13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.</p> <p>Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулахгүй байх, ХОГний үүрэг болох Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх төрийн бүхий л үйлчилгээг тасалдалгүй явуулах ба хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихүйц шийдвэр, үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.”</i></p> <p>31. 15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах;</p> <p>Албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах нь татварын дэмжлэг гэхээс илүүгээр татварын гурван жилийн хугацааны татварыг овооруулж төлснөөр хөрөнгө оруулагчид санхүүгийн дарамт үзүүлэхээр байна. Түүнчлэн уг дэмжлэгийг хөрөнгө оруулагч бүрд үзүүлэх үү эсхүл зөвхөн тодорхой шаардлага хангасан хөрөнгө оруулагчид үзүүлэх үү гэдэг нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“15.1.1. () шаардлагыг хангасан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах эсхүл чөлөөлөх;”</i></p> <p>32. 15.1. Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг үзүүлнэ:</p> <p>15.1.2. тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл ХОГ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах;</p> <p>Хуулийн заалтыг илүү ойлгомжтой болгох үүднээс дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“15.1.2.тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл ХОГ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг уг гэрчилгээ, гэрээнд заасан хугацаагаар тогтворжуулах;”</i></p> <p>33. 15.1.3.албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдэл хорогдлын хэмжээг түргэвчилсэн аргаар тооцох;</p> <p>Уг заалтын дагуу ямар шалгуур, шаардлага, нөхцөлийг хангасан хөрөнгө оруулагч аж ахуй</p>	
--	--	--	--

		<p>нэгжид татварын дэмжлэг үзүүлэх нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг илүү тодорхой болгох: <i>“15.1.3. _____ шаардлагыг хангасан аж ахуй нэгжийн ажилтны мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох;”</i></p> <p>34. 15.1.**.Алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1.4-т “Албан татвар ногдох орлогоос хасагдах алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох” тухай заасныг энэхүү шинэ төсөлд тусгаагүй орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төслийн судалгаа, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын шатанд хугацаа болох хөрөнгө их шаардагддаг мега төслүүдийн тухайд алдагдлыг ирээдүйд шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. Иймд, уг асуудлыг мега төслийн хүрээнд татварын хуульд тогтоомжид заасан нийтлэг горимоос илүү тааламжтай нөхцөл олгох боломжийг нээсэн байдлаар өндөр шалгууртайгаар тусгах.</p> <p>35. Татварын дэмжлэг нь тус хуулиар тухайн татварыг хувь, хэмжээнд нь хэвээр хадгалах, эсхүл бууруулах зохицуулалт бөгөөд 2 хэлбэрээр давхардуулахгүйгээр тус дэмжлэгийг авахаар байна. 17.1-д зааснаар тогтворжуулах гэрчилгээтэй аж ахуй нэгж татварын хувь, хэмжээг тогтворжуулна. 17.3-т татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна. / Татварын дэмжлэгийг тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагч эдлэх эрхтэй байна./ Гэвч 18-р зүйлд тогтворжуулах татварын төрөл буюу 18.1-д зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна гэж заасан байна. Үүнээс харахад хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүдэд хуулийн 18.1 дэх заалт үйлчлэхгүй харагдаж байна. Мөн татварын хувь хэмжээг бууруулах асуудал нь төслийн 17.4-т зааснаар “тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд татварын тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь уг өөрчлөлтөд хамаарагдахаар байна. Үүнд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан Хөрөнгө оруулагч хамаарахгүй харагдаж байна. Татварыг тогтворжуулах /бууруулах/ дэмжлэг нь хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд гэж байгаа нь Татварын ерөнхий хуулийн 4.1 дэх заалт буюу “...татварыг УИХ татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй”, мөн хуулийн 10-р зүйлийн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 10.1.2-т татварын хувь, хэмжээг бууруулах зохицуулалт үйлчлэхээр харагдаж байна. тусгасан байна. Үүнээс харахад хуулийн төслийн 18.1-д зааснаар тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь аж ахуй нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын албан татварын тухай хуульд албан татвар, төлбөрийн хувь хэмжээг бууруулах хуулийн өөрчлөлт буюу УИХ-оос хөнгөлөх, чөлөөлөх /бууруулах/ хууль</p>	
--	--	--	--

		<p>баталсан тохиолдолд тус дэмжлэгийн авах эрх үүсэж байна.</p> <p>Мөн 17.3-т татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна гэж байгаа боловч Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагч хуулийн 17.4, 18.1-д дэх заалт үйлчлэхгүй гэж үзвэл тус хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулах харилцаа татварын дэмжлэг нь тодорхойгүй байна.</p> <p>15.1.1-15.1.4 хүртэлх заалтууд нь ялангуяа 15.1.1 нь бодитой дэмжлэг үзүүлэх үйлдэл огт байхгүй байна. Татварыг хойшлуулах нь дэмжлэг үзүүлэх явдал биш 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1, 11.2- дахь заалтыг хэвээр үлдээх /Энэ тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид зөвхөн хамаарахгүйгээр хуульд заасан тухайлсан зохицуулалтын дагуу Тухайлбал Барилгын материалын үйлдвэрлэл барихад импортлосон техник, тоног төхөөрөмжийг 11.2 дахь заалтыг баримтлан гаалийн албан татвараас чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэл хувь бууруулах боломж нь хэвээр хадгалагдана./</p> <p>3 дахь санал: Мөн 15.2-т Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хууль тогтоомжоор зохицуулна” гэснийг Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг энэхүү хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна” гэж өөрчлөх саналтай.</p> <p>4 дэх санал: Төслийн 4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж хуульд заасан тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”- гэдэгт ... тогтворжуулах гэрчилгээ болон хөрөнгө оруулалтын гэрээний... гэж нэмэх</p> <p>5 дахь санал: Төслийн 17.4-т Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд татварын тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлт хамаарахгүй”-гэж заасанд ... “Тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд ...” -гэж нэмж оруулах</p> <p>6 дахь санал: Мөн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна.” -гэсний дараа энэхүү заалтад Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид нэгэн адил үйлчилнэ” гэж нэмэх</p> <p>7 дахь санал: Мөн хуулийн 17 дугаар зүйлд Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд хуулийн 18.1-т заасан тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-аас тусгайлан эрх олгосон тохиолдолд, тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар татварын хувь, хэмжээг тогтоож болно. гэж нэмэх</p> <p>36. 16.1.1. газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах Тайлбар: Энэ зүйл заалт нь Газрын тухай хуультай зөрчилдөж байгаа бөгөөд маргаан гарахад Газрын тухай хуулийг уу, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баримтлах уу? Аль хууль нь давуу эрхтэй вэ?</p> <p>37. 16.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө</p>	
--	--	--	--

		<p>оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх; Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Чөлөөт бүсийн тухай хууль болон Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, эдгээр хуулиудад хөрөнгө оруулагчид бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх дэмжлэгийн зохицуулалтыг нарийн тодорхой хуульчлах.</p> <p>38. 16.1.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх; Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбогдуулан хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>39. 16.1.5.экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; Уг дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Иймд, хөрөнгө оруулагчийн экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг Инновацийн тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>40. 16.2.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн хүрээнд холбогдох нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудын уялдаа холбоог хангах үүднээс дараах байдлаар уг заалтыг өөрчлөн найруулах: <i>“16.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна.”</i></p>	
--	--	--	--

		<p>41. 20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 1.5 дахин уртасгаж тооцож олгоно. Зарим төслүүд томоохон хөрөнгө оруулалт шаардаж, урт хугацаанд хэрэгждэг тул уг заалтыг хэмжээг 2 дахин уртасгаж тооцсоноор үр нөлөөтэй дэмж болж чадахаар байна. Иймд уг заалтад дараах байдлаар өөрчлөлт оруулах: <i>“20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 2 дахин уртасгаж тооцож олгоно.”</i></p> <p>42. 20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг энэ хуулийн 20.2-т заасан хугацааг 1.5 дахин уртасган тооцож олгоно: 20.3.1. улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр; Уг заалтын хүрээнд тогтворжуулах гэрчилгээ олгох салбаруудыг ялгамжтай тодорхойлж, түүнд олгох хөрөнгө оруулалтын хэмжээг 500 тэрбум төгрөгөөс бууруулж шатлалтай тогтоох.</p> <p>43. 22.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг цахимаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ. Уг хугацаанд хариу өгөөгүй бол цаашид авах арга хэмжээ, санкци хариуцлага нь тодорхой бус байдгаас үүдэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 ба түүнээс дээш хугацаагаар хүсэлтэд хариу өгөхгүй байх тохиолдолд гардаг. Иймд, уг заалттай холбогдуулан дараах хэсгийг нэмж тусгах: <i>“22.1. ... Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тогтворжуулах гэрчилгээ олгох эсэх шийдвэрийг гаргаагүй тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан гэж үзнэ.”</i></p> <p>44. 23.1. Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан үндэслэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно: 23.1.3. тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд Монгол Улсад оруулсан хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс бүрэн татаж, шилжүүлсэн; Уг заалтын дагуу оруулсан хөрөнгөө “бүрэн татаж”, “шилжүүлсэн” гэсэн зохицуулалтыг хэрхэн тайлбарлаж, хэрэглэх нь тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдээс анх тогтворжуулах гэрчилгээ авах үед оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээ бууруулсан эсхүл хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх зэргээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ багассан тохиолдолд үүнийг хөрөнгөө шилжүүлсэн гэж үзэх үү гэдэг нь эргэлзээтэй байна. Иймд уг заалтыг тодорхой тусгах.</p> <p>45. Эдийн засгийн хараат байдал, валютын гадагш урсгалд жин дардаг гадаад худалдааны</p>	
--	--	--	--

		<p>тэнцэлд чухал ач холбогдолтой салбарын бүтээн байгуулалтын явцад татварын бодлогоор дэмжих боломжийг хэвээр үлдээх</p> <p>2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2-т <i>“Доор дурдсан тохиолдолд импортлолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</i></p> <p><i>11.2.1 Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>11.2.2 Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>11.2.3 Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих”</i> гэж заасан.</p> <p>Монгол Улсын эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий дээрх салбарт хэрэгжих төслийн барилга угсралтын үе шатанд импортлох техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох тухай дээрх заалт нь тухайн төслийн хувьд ямар ч орлого олж эхлээгүй байгаа барилга угсралтын үеийн зардлыг бууруулах бодит ач холбогдолтой. Иймд уг зохицуулалт нь хөрөнгө оруулалт оруулах хөшүүрэг болохоос гадна уг заалтын хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлаас тухайлсан хууль гаргаж хугацааны хязгаарыг тогтоож өгөх бөгөөд Засгийн газраас чөлөөлөгдөх бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг батлах тул уг заалтыг доорх байдлаар хуулийн төсөлд нэмж оруулах:</p> <p><i>“23.1.**. Доор дурдсан тохиолдолд импортлолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</i></p> <p><i>23.1.**.1. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>23.1.**.2. Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>23.1.**.3. Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих”</i></p> <p>46. 24.9.ХОГ-нд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна.</p> <p>ХОГ-нд иргэний эрх зүйн зарчим дараах зарчмыг баримтлах ёстой боловч баримталдаггүй. Үүнээс үүдэн ХОГ-нд тусгагдсан хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөд хүрдэг.</p> <p><i>5. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх</i></p> <p><i>5.2. Шинээр батлагдсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.</i></p> <p><i>5.3. Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.</i></p> <p>Хэрэв иргэний хуулийн дээрх зарчмыг ХОГ-нд тусгавал Хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон хөрөнгө оруулагчид сөрөг нөлөөтэй аливаа зохицуулалтыг дагаж мөрдөх</p>	
--	--	---	--

		<p>шаардлагагүй болно. Иймд, уг заалтад доорх хэсгийг нэмж найруулах: <i>“24.9. ХОГ-нд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна. ХО-Гнд хамааралтай шинээр батлагдсан эсхүл нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, холбогдох зохицуулалт нь хөрөнгө оруулагч талын ашиг сонирхолд хохирол учруулахаар бол ХОГ-ний нөхцөл хүчин төгөлдөр байх бөгөөд хөрөнгө оруулагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомж, зохицуулалтаас илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан зохицуулалтыг хэрэглэж болно.”</i></p> <p>47. 24.10.ХОГ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, ХОГ-г байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, ХОГ-ний загварыг Засгийн газар батална. Хууль батлагдсаны дараа холбогдох журам батлах ажиллагаа удаашралтай байдаг. Иймд, уг заалтад журам батлах хугацааг тодорхой болгох эсхүл дагаж мөрдөх журмын тухай хуульд нарийвчлан тусгах: <i>“24.10. ХОГ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, ХОГ-г байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, ХО-Гний загварыг Засгийн газар энэхүү хууль батлагдсанаас хойш _____ хугацааны дотор батална.”</i></p> <p>48. 27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Хөндлөнгийн аудитын байгууллагын зүгээс зарим нэг учир шалтгааны улмаас тайлан баталгаажуулахад хугацаа орох тохиолдол багагүй гардаг тул хугацааг 05 сарын 31-ний өдрийн байдлаар болгож дараах байдлаар өөрчлөх: <i>“27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”</i></p> <p>49. 28.1. Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана. 28.2. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Энэхүү гомдлыг шийдвэрлэх хугацааг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Уг заалтад хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө</p>	
--	--	--	--

			<p>оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр томъёолсон боловч тухайн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хүргүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн байж болзошгүй хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэхгүй байх, тодорхойгүй хугацаагаар хойшлуулах гэх мэт бусад процессын алдаа гарах магадлалтай тул гомдлыг хүлээн авснаас хойш шийдвэрлэх хугацааг тодорхой болгох үүднээс 30 хоногийн дотор саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх байдлаар доорх байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“28.2 Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хүргүүлнэ.”</i></p> <p>50. 28.1-д заасны дагуу МУ-ын ЗГ-ын эсрэг шүгэл үлээгчийг хөрөнгө оруулагчийг халдлагаас сэргийлж нууцлалыг хадгалж хамгаалах ёстой. Үүнд нөхөн төлбөрийг оруулах гэх мэт, хохирлыг хамгаалах зүйл заалт оруулах.</p> <p>51. 28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална. Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, сайжруулах үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа болон хугацааг тогтоосон журмыг Засгийн газар батлах ба журмын хэрэгжилт, хөрөнгө оруулагчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэсэн байдалд холбогдуулан жил тутам хяналт шалгалт хийж тайлан гаргах ба түүнийг нийтэд ил мэдээлнэ.”</i></p> <p>52. 29.3. Гадаадын хөрөнгө оруулагчид болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу Монгол Улсын арбитр, түүнчлэн гадаадын арбитрт хандан шийдвэрлүүлж болно. Хэрэв ийм арбитрын хэлэлцээргүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.</p> <p>Санал: Тус хуулийн гол зүйл бол Хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах хамгаалалт бөгөөд аливаа маргааныг МУ-д шийдвэрлэх бус арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гэрээнд тусгаагүй ч ОУ-ын маргаан шийдвэрлэх боломжийн талаар хуульд тодорхой тусгаж өгөх;</p> <p>29 дүгээр зүйлд МУ-ын ЗГ болон хөрөнгө оруулагч нарын байгуулсан тодорхой гэрээний нөхцөлүүдийг хүчингүйд тооцно гэж тодорхой тусгаж өгөх.</p>	
14.	Австралийн Худалдаа аж үйлдвэрийн танхим	2023.05.15 03/5-23	<p>1. 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>Манай гишүүд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зорилгыг нарийвчлан тусгаж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, хадгалах үүргийг ЭЗХЯ-нд (мөн Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн гишүүнд) тодорхой олгохыг хүсч байна. Манай гишүүд ЭЗХЯ-наас дараах зүйлийг хийхийг хүсэж байна:</p> <ul style="list-style-type: none"> Монголын хөрөнгө оруулалтын зах зээлийг гадаад зах зээлтэй харьцуулахад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, сурталчлах мөн бусад яамдад хөрөнгө 	<p>1. Агуулгын хувьд туссан бөгөөд хуулийн төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, таниулах, урамшуулах, баталгаа гаргах болон хөрөнгө оруулагчид үйлчлэх чиг үүргийг хуульд заасан.</p> <p>2. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийг үл ялгаварлах, эрх тэгш</p>

		<p>оруулагчдыг сурталчлах, дэмжих.</p> <ul style="list-style-type: none"> • Шинээр орж ирэх болон одоо байгаа хөрөнгө оруулагчдад зөвлөгөө өгөх, маргааныг зуучлах, дэмжих зэрэг хөрөнгө оруулагчдад өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чадавхыг бий болгохоос гадна хөрөнгө оруулагчдыг шинээр үүсгэн байгуулах, бүртгэх үйлчилгээ үзүүлэх • Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулагчдыг урамшуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг уг бодлогын зорилттой уялдуулан хэрэгжүүлэх. Энэхүү бодлого нь эдийн засгийн салбар бүрийг тус тусад нь тусгаж, тухайн салбарын өсөлт, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дэмждэг байх • Олон улсын жишигт нийцэхгүй байгаа хөрөнгө оруулагчдын зан үйлийг хянаж, судлан, хөрөнгө оруулагчдын зан үйлийн өндөр стандартыг мөрдүүлэхийн тулд Засгийн газрын хуралдаанд сурталчлах. • Олон нийт болон орон нутагт дэмжлэг үзүүлсэн хөрөнгө оруулагчдыг шагнаж, онцлон тэмдэглэн, компанийн нийгмийн хариуцлагыг сайн биелүүлсэн хөрөнгө оруулагчдыг сурталчлах. • Монгол Улсын эдийн засгийн бүтээмж, нийт үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын өгөөж, авлигын индексийг (жишээлбэл) дотоод үнэлгээ ба/эсвэл зорилтот бусад үзүүлэлтүүдтэй хийсэн харьцуулалтыг эдийн засгийн орчныг дэмжих гол үзүүлэлт болгон тайлагнаж, тодорхой төлөвлөгөө, бодлогоор дэмжин сайжруулах. <p>2. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4 дүгээр зүйл Манай гишүүдийн үзэж байгаагаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулагчдыг ялгаж салгаж болохгүй, бүх хөрөнгө оруулагчид (гадаад, дотоодын хувь хүн, аж ахуйн нэгж) тэгш эрх, үүрэг хариуцлага хүлээх ёстой. Үүний хүрээнд: 4.1.3, 4.1.4, 4.1.5-ыг хасах</p> <p>3. Гадаадын иргэн, аж ахуйн нэгжид тавьсан аливаа хязгаарлалтыг Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль гэх мэт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусад нь шийдвэрлэх;</p> <p>4. Улсын бүртгэлийн ерөнхий хууль зэрэг бусад хууль тогтоомжид энэ зарчмыг тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах.</p> <p>5. 6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын ерөнхий баталгаа Болзошгүй татварын маргаантай холбогдуулан хөрөнгө оруулагчдын хөрөнгийг битүүмжлэх, татварын албанаас хөрөнгө оруулагчдын дансыг царцаахаас өмнө тухайн асуудлыг хянан шийдвэрлэх механизм нэвтрүүлэх (ЭЗХЯ-с уг асуудлыг шалгах гэх мэт).</p> <p>6. 8 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн үүрэг Хөрөнгө оруулагчдад дараах үүргийг санал болгож байна:</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт хийх, компанийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа явуулах амлалтаа жилийн санхүүгийн тайланд тусгаж, тайлагнах. • Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцсэн санхүүгийн тайланг татварын албанд тушаадаг байх. • ЭЗХЯ-нд дүн шинжилгээ, судалгааны зорилгоор санхүүгийн тайлан гаргаж өгөх, 	<p>хандах нөхцөлийг хуулийн төсөлд тусгасан.</p> <ol style="list-style-type: none"> 3. Агуулгын хувьд туссан бөгөөд хөрөнгө оруулалтын хуулиар ийм төрлийн хязгаарлалт байхгүй. 4. Агуулгын хувьд туссан. Аль болох хөрөнгө оруулагчид ялгамжтай хандахгүй байх, ижил нөхцөлөөр хандах зорилгоор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. 5. Татварын асуудал нь бие даасан хуулийн хүрээнд тусдаа агентлаг хариуцдаг. Иймд энэ чиг үүрэгт хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн байгууллага хөндлөнгөөс оролцох нь хууль ёсны байх, хараат бус байх зарчмыг алдагдуулна. 6. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын урамшуулал авч буй хөрөнгө оруулагч нь тайлан гаргах үүрэгтэй. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг мөн ирүүлэхээр байгаа. Энэ нь санхүүгийн тайлангийн суурь бүтцийг өөрчлөхгүйгээр хийнэ. 7. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт гомдол хянах маргаан шийдвэрлэх зөвлөлийг байгуулах, түүний үр дүнг Засгийн газарт танилцуулах чиг үүрэг байна. 8. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчдад үйлчлэх нэг цэг бүхий цахим портал байгуулах асуудлыг төсөлд тусгасан. 9. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын хуулиас татварын урамшууллыг хассан ч холбогдох татварын хууль тогтоомжид уг дэмжлэгүүд зохицуулагдаж байна. ААНОАТ хуулиар татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -
--	--	---	--

			<p>салбарын бүтээмжийг дэмжих чиглэлээр хөрөнгө оруулалтын сурталчилгаа явуулахад ЭЗХЯ-нд дэмжлэг үзүүлэх. Энэ нь хөрөнгө оруулалтын орчны сонирхол татахуйц, өрсөлдөх чадварыг хянах гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийн хянахад цаашид дэмжлэг болох юм.</p> <p>Санхүү, бүтээмжийн талаар тайлагнах ийм үүрэг нь хөрөнгө оруулагч болон компаниудын гүйцэтгэлийг жил бүр хэвлэн нийтлэх, ил тод байдлыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн хэлэлцүүлэг, төлөвлөгөөг сайжруулах боломжийг олгох юм.</p> <p>7. 10 дугаар бүлэг.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> • 10.2-т заасан хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх, Эдийн засгийн хөгжлийн сайд нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчийн бүртгэлийг удирдлагаар хангах, Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөрөнгө оруулалтын тухай хуультай холбоотой болон хөрөнгө оруулагчдад нөлөөлөх чиглэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хандах. • Үүнээс гадна зөвхөн захиргааны маргаантай холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг зохицуулах зорилгоор ЭЗХЯ-наас удирддаг, эдгээр маргааныг шийдвэрлэх эрх бүхий, Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн маргаан шийдвэрлэх байгууллагыг бий болгох. Ингэснээр хөрөнгө оруулагчдад зориулсан шударга өмгөөллийн үйл ажиллагааг хангах ба цаашид Шүүхийн шийдвэр болгон өргөжүүлэх талаар бодолцож үзэх. <p>8. Бүлэг 5. Хөрөнгө оруулалтыг дэмжих</p> <p>Доорх саналыг анхаарч үзнэ үү:</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрүүд, томоохон аж үйлдвэрийн танхимууд, ЭЗХЯ, төрийн захиргааны төлөөллийг оролцуулсан “хөрөнгө оруулалтыг сайжруулах хороо” эсвэл түүнтэй төстэй нэр бүхий хөрөнгө оруулагчдын форумыг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын дэмжих судалгаа зэргийг багтаах. • Хөрөнгө оруулагчдын үйлчилгээний цахим порталыг цаашид хөгжүүлж, сурталчлах. <p>9. 15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг</p> <p>Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжих татварын хөнгөлөлтийг гишүүд маань сайшааж байгаа юм. Гэвч 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдөр болсон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэлэлцүүлгээр 15.2-т заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуульд татварын талаар тодорхой татварын заалт тусгаагүй бөгөөд ийм хөнгөлөлтийг зөвхөн холбогдох татварын хуулийн хүрээнд л тодорхойлохоор тусгасан. Үүнтэй холбогдуулан:</p> <ul style="list-style-type: none"> • ЭЗХЯ-наас хөрөнгө оруулагчдын итгэл, баталгааг сайжруулахын тулд татварын журамд өөрчлөлт оруулах тухай бодлого, зөвлөмж болон/эсвэл нөлөөллийн баримт бичгийг боловсруулж Татварын албанд хүргүүлэхийг хүсэж байна; • 15 дугаар зүйлд Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Татварын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд (санхүүгийн тайлагналын хугацаа бүрийн дараа тогтоосон хугацаанд) хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого ба Засгийн газрын хуралдаанаар нэгэн зэрэг дэмжигдсэн мэдээлэл, 	<p>300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, -гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>10. Санал туссан бөгөөд Газрын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг тусгасан.</p> <p>11. Тогтворжуулах гэрчилгээ олгох үзүүлэлтийг хялбаршуулсан.гэхдээ хөрөнгө оруулалтын хувьд 10 тэрбумаас эхлэхээр төсөлд тусгасан.</p> <p>12. Агуулгын хувьд туссан. Олон улсын эрх зүй, практикийн дагуу арбитраар маргаан шийдвэрлэх бол энэ талаар</p>
--	--	--	---	---

			<p>зөвлөмжийг Татварын тухай хуульд оруулах санал, өөрчлөлтийн хамт хүргүүлэх үүргийг тусгах.</p> <p>10. 16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> 16.1.1-р заалтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд, энэхүү Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан урамшууллыг хүртээмжтэй, хэрэгжихүйц байлгах үүднээс Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд нөлөөлөх тодорхой эрх мэдлийг олгох нь зүйтэй гэж үзэж байна. <p>11. 20 дугаар зүйл. Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур, хугацаа Босгыг (20.2.2-т зааснаар) дээд тал нь 5 тэрбум төгрөг болгон бууруулж, хангасан тохиолдолд татвар тогтворжуулах гэрчилгээ олгох.</p> <p>12. 28 болон 29 дүгээр зүйл Арбитрын шүүхийг ашиглах нь маргааныг шийдвэрлэх цаг хугацааг сайжруулах нийтлэг бөгөөд амжилттай арга юм. Манай гишүүд үүн дээр дараах саналыг нэмж оруулахыг хүсэж байна:</p> <ul style="list-style-type: none"> Маргааныг захиргааны байгууллагад гаргахдаа талууд маргааныг иргэний шүүх эсвэл олон улсын арбитрад шийдвэрлэх талаар тохиролцсон байр суурийг тусгасан байх ёстой. Үүний дараа хоёр тал арбитрад шүүхийн шийдвэрийг хүндэтгэх болно. Арбитрын шүүхийн шийдвэр гарсны дараа иргэний хэргийн шүүх ашиглахыг хязгаарлах. Үүнийг анхны Хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд ч тусгаж болох ба ингэснээр маргаан гарахаас өмнө уг арга замыг тодорхойлсон байх бөгөөд маргааны анхны бүртгэлд оруулсан байх. Хөрөнгө оруулагч талуудын хооронд ямар маргаан шийдвэрлэх үйл явцыг баримтлах ёстойг тодорхойлох эрх мэдлийг ЭЗХЯ-нд олгох. Эвлэрүүлэн зуучлах шатандаа Засгийн газар шийдэх нь тийм ч зөв сонголт биш юм. <p>ЭЗХЯ нь хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх, зөвлөхөд идэвхтэй оролцох эрх мэдэл бүхий, магадгүй арбитрад тогтолцооны нэг хэсэг болох ёстой. Харийн маргаан цаашид үргэлжилж арбитрад шүүх эсвэл иргэний шүүхэд очих тохиолдолд ЭЗХЯ-аас гаргасан аливаа зөвлөмжийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах.</p>	<p>хуульд зааснаар төрийн хүсэл зориг бичгээр илэрхийлэгдсэнд тооцогддог. Иймд заавал бичгээр үйлдсэн зөвшилцөл байх шаардлагагүй.</p>
15.	Европ Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхим	2023.05.16 16/23	<p>1. Хуулийн төслийн 2 дугаар зүйлд дараах өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд: “Хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээг тогтоосон актууд энэ хуулийн 2.4-т зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ. Үүнд:</p> <p>2.3.1.Монгол Улсын олон улсын гэрээ;</p> <p>2.3.2.Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ;</p> <p>2.3.3. энэ хууль,</p> <p>2.3.4.Монгол Улсын бусад хууль;</p> <p>2.3.5.захиргааны хэм хэмжээний акт.</p> <p>2.4. Энэ хуулийн 2.3-т заасан хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл хөрөнгө оруулагчид илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ.”</p>	<p>1. Хууль хэрэглээний хувьд саналд туссан эрэмбээр хэрэгжих боломжгүй. Хуулиас давсан гэрээ байхгүй. Мөн хөрөнгө оруулалтын хууль нь бусад хуулиас давуу үйлчлэх боломжгүй.</p> <p>2. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p>

		<p>2. 4.1.1 дүгээр зүйлд “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд этгээдэд энэ хуулийн 5.1-т заасан хэлбэрээр оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг” хэмээн тодотгох;</p> <p>3. 4.1.11 дүгээр зүйлд “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээний эсхүл хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг” хэмээн дурдах;</p> <p>4. 6.1.2 дугаар зүйлд “төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, хуульд заагаагүй шаардлага, эс үйлдэхүй, шийдвэрийн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, буруутай байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, хөрөнгө оруулагчийн зөрчигдсэн эрхийг сэргээж, хууль ёсны итгэлийг нь хамгаалж, хөрөнгө оруулагчийн хохирол, үүнд бодит болон эрх зөрчигдсөнөөс үүдэн гарах хохирол, олох ёстой байсан ашиг орлого, алдагдсан боломжийн өртгийг хуульд заасны дагуу төр хариуцан барагдуулна” хэмээн дурдах.</p> <p>5. Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд дурдсан Хөрөнгө оруулалтыг дэмжих Дипломат төлөөлөгчийн газруудын эрх, үүргийг, үүнд Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хэрхэн уялдаж ажиллахыг тодруулах.</p> <p>6. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд дараах нэмэлт заалтыг оруулах саналтай байна. Үүнд: 15.1.5. Ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан арван жилийн хугацаанд хасаж тооцох. 15.1.6. Дор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно. Үүнд: - чухал/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; - нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; - эрчим хүчний үйлдвэр, төмөр зам, дэд бүтэц барих.</p> <p>7. 28.1 дүгээр зүйлд “Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана” хэмээн тусгасан. Энэ зүйлд “хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах эсэхийг хөрөнгө оруулагч сонгох бөгөөд хууль ёсны ашиг, сонирхлоо сэргээхийн тулд шүүх болон бусад байгууллагад хандах эрхтэй” гэх агуулгыг нэмэлтээр оруулах саналтай байна.</p> <p>8. 28.4 дүгээр зүйлд “Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд</p>	<p>3. Агуулгын хувьд туссан.</p> <p>4. Агуулгын хувьд туссан. Буруутай үйлдлээс шалтгаалж учруулсан хохирлыг төлүүлэх ажлаас чөлөөлөх хариуцлага тооцох нөхцөлийг төсөлд тусгасан.</p> <p>5. Агуулгын хувьд тусгаж, хамтран ажиллах талаар нэмэлт зохицуулалт нэмсэн.</p> <p>6. Алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох асуудал нь ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд уг асуудлаар зөрчил үүсгэх хэлбэрээр хөрөнгө оруулалтын хуульд тусгахгүй байх нь зүйтэй. Нөгөө талаар алдагдал ирээдүйд шилжүүлэх тооцох асуудал нь татварын хөөн хэлэлцэх хугацаатай уялдах шаардлагатай тул 4 жилээр тогтоодог бөгөөд саналын дагуу 10 жилээр тодорхойлох боломжгүй. Гааль, НӨАТ дэмжлэг нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд тодорхойлогдсон.</p> <p>7. Агуулгын хувьд туссан бөгөөд гомдол хянах ажиллагаа нь захиргааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бус харин эвлэрлийн журам юм. Хөрөнгө оруулагчийн хувьд сонголт хийх боломжтой.</p> <p>8. Засгийн газрын шийдвэрийг зөвшөөрөөгүй бол хөрөнгө оруулагч шүүхэд хандах эрх нээлттэй.</p> <p>9. Засгийн газраас хөрөнгө оруулагчид тулгарсан асуудлаар тодорхой чиглэлийг төрийн байгууллагад олгох тохиолдолд түүний хэрэгжилтийг хянах чиг үүргийг тодорхойлж буй явдал юм.</p> <p>10. Саналын дагуу туссан.</p> <p>11. Санал агуулгын хувьд туссан. Энэ хугацааны хамгийн дээд хугацааг 6 сар байхаар төсөлд заасан.</p>
--	--	---	---

			<p>Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ” хэмээн заасныг тодотгох, энэ тохиолдолд Засгийн газрын гүйцэтгэх үүрэг нь шүүх эрх мэдэлтэй хэрхэн уялдахыг тодруулах саналтай байна.</p> <p>9. 28.5 дугаар зүйлд “Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.4-т заасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна” хэмээн заасныг тодруулах саналтай байна.</p> <p>10. 29.1 дүгээр зүйлд “Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд эхний ээлжид хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ” гэж тусгах саналтай байна.</p> <p>11. 29.2 дугаар зүйлд “Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлэхээр тохиролцсон тохиолдолд хэлэлцээ хийх хугацаагаа харилцан тохиролцох бөгөөд тохиролцсон хугацаанд багтаан шийдвэрлэж чадаагүй тохиолдолд олон улсын арбитра хандах эрхтэй” хэмээн оруулах саналтай байна.</p>	
16.	МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр	2023.05.30 4/808	<p>“Хөрөнгө оруулалтын маргаан” бүлэгт дараах саналтай байна:</p> <p>1. Гэрээний талууд нь маргаан шийдвэрлэх журам, харьяаллаа өөрсдөө харилцан тохиролцох эрхтэй байх нь Олон улсын эрх зүйн зарчим юм. Иймд талуудын тохиролцоог харгалзахгүйгээр маргаан шийдвэрлэх арбитраг хуульд заах нь гэрээний чөлөөт байдлын зарчим болон талуудын маргаан шийдвэрлэх байгууллагаа харилцан тохиролцох эрхийг хөндөж байна гэж үзэж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулж буй хамгийн түгээмэл олон улсын эрх зүйн арга баримт бичиг бол Засгийн газар хоорондын хоёр талт гэрээ бөгөөд 1991 оноос хойш өнөөдрийг хүртэл Монгол Улсад Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр нийт 44 хоёр талт хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна. Дээрх хэлэлцээрүүдэд төр-хөрөнгө оруулагч хооронд хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх харьяаллын эхний сонголт “Хөрөнгө оруулалтын гэрээний маргаан шийдвэрлэх журамд заасан арбитра” гэсэн заалтыг нэмж, 29.2.1, 29.2.2 дэх заалтыг 29.2.2, 29.2.3 болгох саналтай байна.</p> <p>2. Буурай хөгжилтэй буюу хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулагчид заль, мэх гарган, дураар авирлан хөрөнгө оруулалт хүлээн авагч улсын эсрэг өөрийн орны болон Олон улсын арбитра нэхэмжлэл гарган их хэмжээний өр төлбөрт оруулдаг явдал сүүлийн хэдэн жилд гарах болсон нь Монгол Улсын Засгийн газар арбитра хариуцагчаар татагдан ялагдсан олон жишээнээс харж болно. Иймд хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын арбитраар хэргийн удирдлагыг хийлгэх нь зохимжтой гэж үзэж байх тул хуулийн төслийн 29.2.2 дахь заалт дахь хэргийг удирдах арбитраар Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр гэж өөрчлөх саналтай байна.</p> <p>3. Маргаан шийдвэрлэх харьяаллыг тогтоохдоо хөрөнгө оруулагч талыг гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч хэмээн ялгамжтай хандах нь дотоодын хөрөнгө оруулагчийн эрх хөндөж байх тул төслийн 29.3 дахь зүйлийн “гадаадын” гэснийг хасах саналтай байна.</p>	<p>1. Агуулгын хувьд тусгасан. Арбитраар маргааныг шийдвэрлэх тохиолдолд төрөөс хуульд энэ талаар зохицуулалт хийсэн тохиолдолд төрийн зөвшөөрөл өгсөнд тооцогддог. Энэ зарчим олон улсад ч байдаг.</p> <p>2. Хөрөнгө оруулагч нарын хувьд хүлээн зөвшөөрөх нөхцөл нь гуравдагч улсын арбитра байх тул үндэсний арбитраг сонгох нь тохиромжгүй. Нөгөө талаар монгол улс уг арбитра дагуу маргаан шийдвэрлүүлэх боломжтой арбитраг сонгох зорилгоо холбогдох арбитраг сонголоо.</p> <p>3. Гадаад улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх арбитра үндэсний хөрөнгө оруулагч болон төр хоорондын маргааныг шийдвэрлэдэггүй.</p>
17.	Зунхуа нийгэмлэг	2023.06.07	1. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд	1. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх

		029	<p>татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгт дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлээч хэмээн хүсэж байна: Үйл ажиллагаа явуулах салбараас үл хамаарч 2 жилийн дотор үйл ажиллагаа тогтворжих хүртэл ажиллах хүчний тоог нэмэгдүүлж, ажлын байрны төлбөрийг тухайн жилд хөнгөлөх.</p> <p>2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12.1.5-д Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүл, ТӨРӨЛ САДАН-д Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох гэж оруулж өгөх.</p> <p>3. Татварын хувь хэмжээг тогтворжуулах гэрчилгээг авахад хуульд маш өндөр шалгуур тавьдаг. Хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах, эсхүл тогтворжуулах гэрчилгээ олгох хугацааг 2-3 жилээр нэмэгдүүлэх.</p> <p>4. Анхан шатны хайгуулын компаниуд уул уурхайн бүтээн байгуулалтын салбарын тэргүүн эгнээнд байрлаж, Монголын уул уурхайн салбарыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ үүнд шаардлагатай бүх боловсон хүчин нь мэргэжлийн өндөр түвшний техникчид байдгаараа уурхайн бүтээн байгуулалтын үйлдвэрүүдээс эрс ялгаатай. Иймд хилийн чанад дахь хайгуулын компаниудын хөрөнгө оруулалтад дэд бүтэц, аж үйлдвэр, технологи, боловсрол болон бусад төслүүдэд техникийн боловсон хүчний оруулсан хувь нэмэр, ажлын байрны төлбөрийн хувьд татварын бус дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.</p> <p>5. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компаниудын хятад ажилчдын цалинг Монголд тавьдаг бөгөөд тэдний төлж буй эрүүл мэндийн даатгал нь Хятадын эрүүл мэндийн даатгалтай холбох, хүлээн зөвшөөрөхөд хүндрэлтэй байдаг. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажилчдын эрүүл мэндийн даатгалд татварын бус тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</p> <p>6. "Хөрөнгө оруулалтын тухай хууль"-д "Ашигт малтмал + дэд бүтцийн бүтээн байгуулалт" хамтарсан хөгжлийн загварыг дэмжих. Тэр нь эрдэс баялгаа "үндэсний санхүү" болгож дэд бүтцийн бүтээн байгуулалтад гадаадын хөрөнгө оруулалтыг татах, уул уурхайн бүтээн байгуулалтаас олсон ашгаараа гадаадын хөрөнгө оруулалтыг эргүүлэн төлөх явдал юм.</p> <p>7. Гадаадын бизнес эрхлэгчдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх механизмыг бий болгох, эсхүл хөрөнгө оруулагчид, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалдаг хэлтсийг хуулийн хэлбэрээр тусгаж, энэ хэлтсийн чиг үүргийг бий болгох. Гадаадын бизнесменүүдийг хууль бус аргаар хэлмэгдүүлсэн хуулийн байгууллага, хувь хүмүүст хатуу хариуцлага тооцох.</p> <p>8. Төрийн аливаа байгууллага, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, хувь хүн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хэвийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, зөвшөөрөлгүйгээр худал сурталчилгаа явуулахыг хориглох. Гарах үр дагаварт суурилсан ял торгуулийн стандартыг тодорхой болгож, шийтгэлийг нэмэгдүүлэх.</p> <p>9. Хөрөнгө оруулалтыг тогтворжуулах гэрчилгээг хариуцах хэлтсийг эрх зүйн хэлбэрээр зааж өгөх.</p> <p>10. Монгол Улсын Засгийн газраас байгуулсан 97PSC гэх мэт хөрөнгө оруулалтын гэрээний хувьд гэрээнд тусгагдсан хөнгөлөлттэй нөхцөлийг хүндэтгэн хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөрөнгө оруулалтыг тогтворжуулах гэрчилгээ хэлбэрээр хамгаалсан байх ёстой.</p> <p>11. 5-р бүлэгт заасан тогтвортой татварын ангиллыг нэгдэн орсон гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын түншүүдийн хувь хүний орлогын албан татварыг Монгол Улсад</p>	<p>асуудал нь холбогдох Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу Засгийн газраас шийдвэрлэдэг. Заавал хуулиар өөрчлөлт оруулах шаардлага байхгүй.</p> <p>2. Саналыг тусгасан. Энэ төрлийн дэмжлэг нь холбогдох хуульд туссан байгаа.</p> <p>3. Тогтворжуулах гэрчилгээ авах шалгуурыг бууруулж, хялбаршуулсан.</p> <p>4. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх асуудал нь холбогдох Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу Засгийн газраас шийдвэрлэдэг. Заавал хуулиар өөрчлөлт оруулах шаардлага байхгүй.</p> <p>5. Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгалын асуудал нь хөрөнгө оруулагчийн асуудал гэхээс илүү түүний бий болгох ажлын байртай холбоотой, ажилтны нийгмийн асуудал буюу хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал байна. Энэ харилцаа нь хөдөлмөрийн харилцаанд орж буй ажилтны нийгмийн асуудалд хамаарч байгаа. Энэ асуудал нь Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулагддаг. Шууд хөрөнгө оруулалтын нэг гол шинж нь тухайн улсад ажлын байр бий болгодог гэж тайлбарладаг. Энэ ч агуулгаар уг ажлын байр бий болгож байгаатай холбоотойгоор аж ахуйн нэгж нь нийгмийн даатгалын харилцаанд заавал ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг тодорхой хувиар хариуцахаар хуульчилсан бөгөөд энэ нь үндэсний аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай байх эсэхээс үл хамаарч ижил төлөх учиртай. Эдгээрт ялгамжтай хувь ногдуулах нь хөрөнгө оруулагчаас илүүтэй ажилтнуудын эрх ашгийг хохироор эрсдэлтэй.</p>
--	--	-----	--	---

		<p>болон бусад улс оронд татвараа төлж болох байдлыг нэмж тусгах.</p> <p>12. Гадаадын хөрөнгө оруулагчид болон түншүүдийн хувьд Монгол Улсад тэтгэвэр тогтоолгож чадахгүй учраас Монгол Улсад нийгмийн даатгал заавал төлөх шаардлагагүй байх.</p> <p>13. Төслийн төсвийн үнийг цаг тухайд нь тохируулах. Төслийн тендерийн төсөвт үндэслэлгүй төсвийн үнийг тендерийн хугацаатай уялдуулан хугацаанд нь өөрчлөх шаардлагатай. Тухайлбал, зарим төслүүд 2016 оноос өмнө төсвөө гаргасан байсан бөгөөд 2022 онд тендерт оролцоходоо анхны төсөвт үнийг ашигласан хэвээр байгаа нь үнийн санал хэт бага байсан, нэг ч компани тендерт оролцож зүрхлээгүйгээс олон тооны тендер бүтэлгүйтсэн.</p> <p>14. Хөрөнгө оруулалтын төрөлжилтийг хийх. Монгол Улсын дэд бүтцийн зах зээл асар том бөгөөд нэн шаардлагатай байгаа ч Засгийн газрын төсвийн хөрөнгө хүрэлцэхгүй байгаа тул дэд бүтцийн төслүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар найдах нь олон төслүүдийг хугацаанд нь хэрэгжүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Илүү их баригдах төслүүдийг ВТ буюу бартер хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Засгийн газар төслийг сурталчлахын тулд ВОТ загварыг ашиглахыг илүүд үзэж байгаа ч ААН-ийн хувьд ВОТ загварын ашиглалтын явцад гарах эрсдэл, хөрөнгө оруулалтыг хүлээгдэж буй байдлаар нөхөж чадах эсэхэд илүү анхаарах ёстой. Иймээс Монгол Улсад ВОТ загварыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа нь мөн зарим төслийн хэрэгжилтийг удаашруулахад хүргэнэ.</p> <p>15. Монголын талтай “босго” шаардлагыг буулгах талаар хэлэлцэнэ гэж найдаж байна. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хувь хүмүүс БНХАУ-аас хөрөнгө оруулалтын түнш, томилолтын баг, техникийн ажилчдыг урихдаа урьсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн тайланд тавигдах шаардлага, нийгмийн даатгал, татварын шаардлага "босго" зэрэг асуудлуудтай тулгардаг. Гурван жил үргэлжилсэн тахал, аж ахуйн нэгжүүдийн менежмент муу байсан тул олон аж ахуйн нэгж урилга илгээх шаардлагыг хангаж чадахгүй байна.</p> <p>16. Монголын талын холбогдох байгууллагуудтай Хятадын аж ахуйн нэгжүүдийн дүрмийн сантай холбоотой асуудлыг хялбарчлах талаар хэлэлцээ хийнэ гэж найдаж байна. БНХАУ-ын компани, иргэн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, компаниа бүртгүүлэх, бүртгэлтэй компани хувьцаа эзэмшигчээ нэмэх шаардлагатай бол “БНХАУ-аас бүртгэлийн хураамж болох 100 мянган ам.доллар шилжүүлэх ёстой”. Энэ шаардлага нь бүртгэлтэй мөнгийг өмнөх шигээ Монгол улсаас шилжүүлэх боломжийг олгох.</p>	<p>Нөгөө талаар Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. гэж заасны дагуу манай улс хятад улстай энэ төрлийн асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ байгуулсан тохиолдолд нийгмийн даатгалыг давхардуулахгүй төлөх боломжийг бий болгох боломжтой. Харин үүнээс бусад тохиолдолд хөрөнгө оруулагчийн гарал, үүслээс хамаарч, даатгуулагчийн эрх ашигт нөлөөлөх асуудлыг нийгмийн даатгалын хуулиар шийдвэрлэх үндэс бүрдэхгүй.</p> <p>6. Уг салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэсний үндсэн дээр дээрх дэмжлэгийн талаар бодлогын өөрчлөлтийг тусгаж болно.</p> <p>7. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтыг дэмжих буюу мэдээлэл зөвлөгөө хангах төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчилсан.</p> <p>8. Агуулгын хувьд энэ төрлийн зохицуулалт байгаа. Нэр төрд халдсан, гүтгэлэг явуулсан нь холбогдох хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болдог.</p> <p>9. Саналыг тусгасан.</p> <p>10. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл болон тогтворжуулах гэрчилгээ нь хуулиар олгогдсон хэмжээ хязгаарын хүрээнд заавал дагаж мөрдөх шинжтэй.</p> <p>11. Хувь хүний орлогын албан татвар нь хөрөнгө оруулагчийн үндсэн ашиг орлогод төдийлөн нөлөөлөхгүй тул саналыг авах боломжгүй.</p> <p>12. 5 дахь асуултын хариултыг харах.</p> <p>13. Төрийн худалдан авах ажиллагааны</p>
--	--	--	---

				<p>асуудал нь хөрөнгө оруулалтын хуульд хамаарахгүй.</p> <p>14. Асуудал нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хамрах хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын хуулийн үндсэн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал.</p> <p>15. Хувь этгээд хоорондын харилцаанд нөлөөлөх боломжгүй. Хөрөнгө оруулалтын хуулийн хүрээнд тогтоосон хөрөнгө оруулагчийн босгыг байхгүй болгож байгаа.</p> <p>16. Санал туссан.</p>
18.	Монголын хүнд үйлдвэрийн эрдэс холбоо	2023.05.10 05-03	<p>1. Хуулийн төслийн 18.2 дахь хэсэгт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/-ийн тогтворжуулалтыг боловсруулах үйлдвэр, түүнчлэн бага агуулгатай түүхий эдийг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж буй бүтээгдэхүүнд ногдох АМНАТ хамаарахгүй байхаар заасан нь “Олборлолтоос-Боловсруулалтад” шилжих төрийн бодлоготой нийцэхгүй байна. Цаашид ашигт малтмалыг баяжуулж, боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хаасан, энэ чиглэлд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломжийг хаасан заалтыг хасах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>2. Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.28-д “... олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалыг дахин боловсруулж” буй нь нөөцийг сорчлохгүй, ашиглаж боловсруулалтын түвшнийг, ахиулж эдийн засгийг дэмжиж байгааг алагчлах ёсгүй.</p> <p>3. Төслийн 20.2.1-д “... хөрөнгө оруулалт дуусах хүнд үйлдвэрийн хувьд ялгамжтай авч үзэх зүйтэй. Учир нь, Хүнд болон боловсруулах үйлдвэрийн анхны хөрөнгө оруулалт өндөр, тохируулга, зүгшрүүлгийн хугацаа урт тул эргэн төлөгдөх хугацааг нэмэх саналтай байна.</p> <p>4. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь технологио сайжруулах, хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилгоор дахин нэмэлт хөрөнгө оруулалт хийх тохиолдол байдаг бөгөөд нэмэлт хөрөнгө оруулалт нь хуулийн шаардлага хангаж байгаа тохиолдолд оруулсан хөрөнгийн хэмжээгээр тогтворжуулах гэрчилгээний хугацааг сунгах зориулалтыг шинээр нэмэх нь боловсруулалтын түвшнийг сайжруулах, тогтвортой байх нөхцөлийг хангахад хөрөнгө оруулагчийг татах нэг үндэслэл болно.</p> <p>5. Үйлдвэр нь нөөцөө нэмэгдүүлэхээр техник, эдийн засгийн үндэслэлээ тодотгох зохих шаардлага, шалгуур хангасан бол тогтворжуулах гэрчилгээг сунгах боломжийг шинээр тусгах нь хөрөнгө оруулагч урт хугацаанд, тогтвортой үйл ажиллагаа явуулах үндсийг бүрдүүлнэ.</p> <p>6. Төслийн 20.1.2-т “... тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэх”-ээр заажээ. Хүнд үйлдвэр нь Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /БОНУ/-г хуулийн дагуу хийлгэдэг тул давхардуулах бус БОНУ-ний тайлан нь шаардлага хангаж байвал тус тайланг үндэслэхээр тусгах нь үйл ажиллагааны /давхардал/ хүндрэлийг багасгана.</p>	<p>1. Үүсмэл ордын АМНАТ хувь хэмжээг тогтворжуулах эсэх асуудлыг холбогдох тооцоолол, хэрэгжилт, үр нөлөөг сударснаар тодорхойлогдоно. Энэ хувь хэмжээний өөрчлөлтөөс хамаарч хөрөнгө оруулалтад өөрчлөлт орох эсэхийг тогтоох.</p> <p>2. 1 дэх асуултын хариуг харах.</p> <p>3. Санал туссан. Тогтворжуулах гэрчилгээний хугацаа, тавигдах шаардлагыг хялбаршуулсан.</p> <p>4. Агуулгын хувьд туссан. Тогтворжуулах гэрчилгээг сунгах асуудал тусгаагүй. Харин гэрчилгээний хугацааг сунгасан.</p> <p>5. Агуулгын хувьд туссан 4 дэх асуултыг хариуг харах. Улмаар хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх бол хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой.</p> <p>6. Агуулгын хувьд туссан. Тусдаа тайлан бус хуулиар шаардсан тохиолдолд гэж тодруулсан.</p>
19.	“Мобиком Корпораци” ХХКп	2023.04.21 1/3775	1. УИХ-аас 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр баталсан ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ хуулийн 3.1.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэсэн тодорхойлолтыг шинээр боловсруулсан төслийн 4.1.5-т “... гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол	1. Саналыг тусгаж, гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн охин, хараат компанийг уг ангилалд

			<p>Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компани, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг” гэж өөрчилж байгаа нь Мобиком Корпораци ХХК-ийн хууль ёсны эрх ашгийг шууд хөндөхөөр заалт болж байна. Учир нь Мобиком Корпораци ХХК нь олон суваг дамжуулах үйлчилгээ болох “VOO” үйлчилгээг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3-т заасан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах этгээдэд олгохыг хориглоно” гэсэн заалтад нийцүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5 дахь заалтыг баримтлан, өөрийн охин компани болох Мобинет ХХК-аар дамжуулан тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. Гэвч төслийн 4.1.5-д шинээр тодорхойлсон тодорхойлолт нь Мобинет ХХК-ийн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.3 заалтын дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхэлж байсныг хязгаарлахаар болж, бидний нэгэнт оруулсан хөрөнгө оруулалтад хууль эрх зүйн хувьд эрсдэлд оруулахаар байна. Иймд дагалдах хуулиудын төсөлд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг хамруулан уг хуулийн 7.3.3 заалтыг хүчингүйд тооцох, эс бөгөөс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 заалтыг хэвээр үлдээж, төслийн 4.1.5 заалтыг хасах,</p> <p>2. Төслийн 5.1.6 заалтыг хасах. Учир нь хөрөнгө оруулагч нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг явуулахдаа тухайлсан оюуны өмч /контент/-ийг эрх бүхий этгээдээс хууль ёсны дагуу худалдан авч дамжуулан түгээх, борлуулах нөхцөлд энэ нь тухайн компанийн үйл ажиллагааны зардал болохоор байна.</p> <p>3. Төслийн 6.2.5 болон одоогийн мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6.7-д “хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй” гэж заасан нь хөрөнгө оруулагчийн захирах зарцуулах хөрөнгө орлого байх атал Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.3 дахь заалт “Энэ хуулийн 9.2-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна”-аар хөрөнгө оруулагчийн хөрөнгө орлогоос дахин татвар хураамж авсан зөрчилтэй зохицуулалт болохоор байна. Иймд дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн хуулийн 9.3 дахь заалтыг “Энэ хуулийн 9.2-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь тухайн этгээдийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү байна” гэж өөрчлөн найруулж, хуулийн нийцлийг хангах нь зүйтэй байна /2006 оны Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн заалтаар/.</p> <p>4. Төслийн 12.3-т “Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтын тоо жилд 2-оос ихгүй байна.” гэж заасан нь төрийн эрх бүхий байгууллагаас хийгдэх нийт хяналт шалгалтын тоо хэмжээг ойлгох уу, эсхүл зөвхөн хөрөнгө оруулагч этгээдэд хийгдэж байгаа хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой хяналт шалгалтыг ойлгох уу гэдгийг зааглаж тодорхой тусгах саналтай байна.</p>	<p>хамааруулаагүй.</p> <ol style="list-style-type: none"> 2. төслийн 5 дугаар зүйл нь хөрөнгө оруулалтын хэлбэр бөгөөд оюуны өмчийг бүтээгчийн хувьд хөрөнгө оруулалт татах боломжтой бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэлбэр. 3. Засгийн газрын тусгай сангийн хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсны үндсэн дээр уг хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй. 4. Хөрөнгө оруулагчид хийж болох хяналт шалгалтын тооны хамгийн дээд хэмжээг тодорхойлсон.
20.	“Оюу Толгой” ХХК	2023.04.27	<ol style="list-style-type: none"> 1. 3.4. Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулахын тулд компани байгуулах шаардлагатай гэж ойлгогдож байна. Эсхүл, бүртгэлтэй компанид хувь эзэмших байдлаар хөрөнгө оруулахдаа улсын 	<ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани

		<p>бүртгэлд бүртгүүлэхийг хэлээд байна уу? Тийм бол, хувь эзэмшихээс өөр бусад байдлаар хөрөнгө оруулахыг үгүйсгэсэн заалт болж байна. Санал: Өөрчлөн найруулах эсхүл хасах</p> <p>2. 4.1.1, 5.1. Төслийн 5.1-т заасан бусад хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийг үгүйсгэж, зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгө оруулсан тохиолдолд хөрөнгө оруулалт гэж ойлгогдохоор байна. Санал: Өөрчлөн найруулах эсхүл хасах</p> <p>3. 4.1.5 Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хараат болон охин компани бүгд гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үзэх нөхцөл үүсгэж байна. (Компанийн 20%-ийг ГХО компани 80%-ийг Монгол компани эзэмшиж байхад ч тухайн компани ГХО-тай болох нь) Үргэлжилсэн хэлхээ холбоон дахь гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг нь хөөж бодсоны үр дүнд 25 буюу түүнээс дээш хувийн гадаадын хөрөнгө оруулалттай бол “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж тооцох нь зүйтэй болов уу. Санал: Өөрчлөн найруулах</p> <p>4. 6.2.1 Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно гэсэн боловч Татварын орчныг тогтворжуулах гэдгийг тодорхойлсон зүйл алга байна. Санал болгоход: Татварын орчныг тогтворжуулах гэдэгт хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын төрөл, тэдгээрийн хувь хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх талаар зохицуулсан Монгол Улсын татварын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр, болон бусад эрх зүйн баримт бичгүүд тухайн Хөрөнгө оруулалтын гэрээ хүчинтэй байх хугацаанд ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хөрөнгө оруулагчид үйлчлэхийг ойлгоно. Иймд Татварын орчин гэж юуг ойлгох талаар Төсөлд тодорхойлж оруулах</p> <p>5. 6.2.4, 6.2.5 Нөхөн олговор VS нөхөх олговор Санал: Нийцүүлэх</p> <p>6. 15.1.1. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, энэ заалтыг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>7. 15.1.2. Энэ заалтыг “тогтворжуулах гэрчилгээ авсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын орчныг тогтворжуулах” гэж Төслийн 6.2.1-тэй нийцүүлэх саналтай байна. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар</p>	<p>байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай.</p> <p>2. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.</p> <p>3. Саналыг тусгаж, гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн охин, хараат компанийг уг ангилалд хамааруулаагүй.</p> <p>4. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маягт зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжих дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Иймд уг татварын орчин гэсэн заалтыг эргэлзээ үүсгэхгүйн тул хасах нь зүйтэй байна.</p> <p>5. Саналыг тусгаж, нөхөх олговор гэж томъёолсон.</p> <p>6. Агуулгын хувьд туссан. ААНОАТ хуулиар татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, -гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл</p>
--	--	--	--

		<p>зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, Хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах тухай бусад хуулиудад тусгах шаардлагатай байна. Одоогийн татварын хуулиудад зөвхөн тогтворжуулах гэрчилгээгээр аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулахаар заасан байгаа:</p> <ul style="list-style-type: none"> • Татварын ерөнхий хууль 12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулах татварыг тогтворжуулах хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх; • ААНОАТХ 20.3. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна. • Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 35.6. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө. • Ашигт малтмалын тухай хууль 47.15. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна. • НӨАТХ-д тогтворжуулах заалт огт тусгагдаагүй байна. <p>Санал: Өөрчлөн найруулах, мөн, Хөрөнгө оруулалтын гэрээгээр татвар тогтворжуулах зохицуулалтыг нэр бүхий хуулиудад оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>-Татварын ерөнхий хууль -ААНОАТХ -Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль -Ашигт малтмалын тухай хууль -НӨАТХ</p> <p>8. 15.1.3, 15.1.4. Төслийн 15.2-т хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан. Мөн, татварын асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэсэн ерөнхий зарчмыг татварын алба дагаж мөрддөг. Иймд, эдгээр татварын дэмжлэгийн ААНОАТХ-д оруулах</p> <p>Мөн, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад гадаад валютаар хөрөнгө оруулж, улмаар ажил гүйлгээгээ НББ-ийн олон улсын стандартын дагуу тухайн гадаад валютаар хөтөлдөг тохиолдолд “Хөрөнгө оруулагчийн эдлэх хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож, баталгаажуулах” гэдгийг үзүүлэх татварын дэмжлэг гэдэгт нэмж оруулах.</p> <p>Санал: Улаанаар оруулсан дэмжлэгийг оруулах, мөн, эдгээр татварын дэмжлэгийг ААНОАТХ-д оруулахаар дагалдах хуулийн төсөл боловсруулах</p> <p>9. 18.1 Доорх татваруудыг нэмж оруулж болох:</p> <ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр • Үл хөдлөх хөрөнгийн татвар • Онцгой албан татвар <p>Санал: Доорх татваруудыг нэмж оруулж болох:</p>	<p>хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - програм хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах програми хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>7. Агуулгын хувьд туссан бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээгээр татварын хувь хэмжээг тогтворжуулахыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд тодорхой заасан. Татварын ерөнхий хуулийн 4.1-д зааснаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу холбогдох татварын хувь хэмжээг тогтворжуулах ба үүнийг татварын хуулиар зохицуулахгүй байх нөхцөлийг хуульчилсан. Иймд татварын хуулиудад өөрчлөлт оруулах шаардлага байхгүй.</p> <p>8. Саналыг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын хуульд тусгахаар заасан. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын урамшуулал нь ААНОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд туссан. Тодруулбал, татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, улмаар элэгдэл хорогдлыг тооцох</p>
--	--	---	--

		<ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр • Үл хөдлөх хөрөнгийн татвар • Онцгой албан татвар <p>10. Хөрөнгө оруулагчид татварын тогтвортой орчноос гадна Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан үйл ажиллагааны орчин тогтвортой байх нь чухал ач холбогдолтой байдаг. Иймд төслийн 24 дүгээр зүйлд дараахыг нэмж оруулах саналтай байна. “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын гэрээний хүрээнд талуудын хооронд тодорхой асуудлаар Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгайлан заасан зохицуулалт нь тухайн гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хөрөнгө оруулагчид тогтвортой үйлчилнэ.” Санал: Нэмэх</p> <p>11. 28.1. Энэхүү урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой хугацаа зааж өгөх шаардлагатай байна. Эсхүл, Төслийн 29.2-т зааснаар “Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн” гэдгийг энэхүү урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж ойлгоод 3 сарын хугацааг баримтлах уу? Эсхүл, ерөнхий 30 хоног баримтлах уу? Санал: Тодорхой болгох</p> <p>12. 28.2. Хөрөнгө оруулагчийн гомдол нь Хөрөнгө оруулалтын гэрээ, татварын тогтворжуулалттай холбоотой аливаа асуудлаар байж болох тул зөвхөн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоотойгоор гомдлыг шийдвэрлэх нь учир дутагдалтай юм. Иймд “Гомдлыг шийдвэрлэх арга хэмжээнд хөрөнгө оруулагчийн гаргасан гомдолд хамаарах төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.” гэж нэмэх саналтай байна. Түүнчлэн хөрөнгө оруулалттай холбоотой л бол ямар ч тохиолдолд хэлэлцээ хийх боломжийг олгохын тулд “Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол” гэсэн хязгаарлалтыг хасах саналтай байна. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газартай байгуулдаг тул гэрээний нэг тал болох Монгол Улсын Засгийн газар эсхүл Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага нь хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийнэ гэдгийг тодруулах саналтай байна. “Хөрөнгө оруулалтын гэрээний талууд” гэж тодруулж болох юм. Санал: Хөрөнгө оруулагчийн гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд Татварын ерөнхий газрыг оролцуулах талаар Төсөлд тусгах</p> <p>13. 29.2. Хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлсэн гэдэгт юуг ойлгох вэ? Төслийн 28-д заасан гомдол урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэлж байна уу эсхүл тусдаа ажиллагаа юу? Зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд ч биш арбитрт хэрэг маргаан үүсгэсний дараа ч талуудад хэлэлцээр хийх боломжийг олгох. Тухайлбал “Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотойгоор олон</p>	<p>нөхцөлийг тодорхой тусгасан. Харин хөнгөлөлт, чөлөөлөлтийг оруулсан хөрөнгө оруулалтын валютаар тооцож баталгаажуулах нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө гэж заасантай зөрчилдөхөөр байх тул хүлээн авах боломжгүй.</p> <p>9. Тусгаагүй. Татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэж Татварын ерөнхий хуульд тусгасан. Хөрөнгө оруулалтын хууль нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгох хууль биш татварын орчныг тогтворжуулах зорилготой тул шийдвэрлэх боломжгүй.</p> <p>10. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин хууль, тогтоомжийг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хууль өөрчлөгдөх бүрэн боломжтой. хуулийг хэрэгжүүлэхгүй байх баталгааг бус харин эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах баталгааг энэ төрлийн гэрээгээр олгох нь зүйтэй.</p> <p>11. Агуулгын хувьд тусгасан. Хэлэлцээ хийх журмыг Засгийн батална.</p> <p>12. Агуулгын хувьд туссан. Маргаан шийдвэрлэх зөвлөл нь төрийн захиргааны байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.</p> <p>13. Агуулгын хувьд туссан. Хэлэлцээ хийх журмыг Засгийн газар батлах ба энэхүү хэлэлцээнд гомдол хянан шийдвэрлэх хугацааг хамруулан тооцно. Энэ хүрээнд шийдэлд</p>
--	--	---	--

			улсын шүүх, арбитра маргаан үүссэн тохиолдолд хэлэлцээр хийх, эвлэрэх журмыг Засгийн газар/Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж оруулж болох юм. Санал: Тодорхой болгох	хүрээгүй бол хөрөнгө оруулагчийн арбитрын журмаар гомдол нөхцөлийг бий болгоно. Нөгөө талаар арбитрын хэргийн явцад талууд эвлэрэх боломж нээлттэй.
21.	“Монголжин” ХХК	2023.05.01	<p>Comments on the Lack of Overall Concept in the Revised Legislation</p> <ol style="list-style-type: none"> 1. Mongoljin shares the concerns of AmCham regarding the lack of an overall concept for the Investment Law. It is not clear what the Government of Mongolia is seeking to achieve and the overall impression is one of tinkering at the margins rather than a wholesale root and branch effort to reset relationships with foreign investors. However, if Mongolia is serious about attracting significant levels of Foreign Direct Investment then the competitiveness benchmark should be global rather than regional. There is a need for a sincere and concerted effort to tackle the three Cs of Competitiveness, Corruption and Currency. <p>Mongoljin Comments on the General Chapter (1)</p> <ol style="list-style-type: none"> 2. New Article 3: Civil nuclear energy might be an option to reduce the severity of air pollution long term. It is good that there is now no longer a prohibition should future governments determine that it is in the best interests of the citizens to pursue nuclear energy options. 3. New Article 4: It is notable that the \$100,000 minimum investment requirement has finally been removed after years of urging by the international community. It is interesting to see if the text will remain the same or whether discrimination against foreign investors will continue. The \$100,000 threshold has deterred competition, innovation and the bringing of new ideas and created an unlevel playing field given the practically zero requirements on Mongolian citizens. If implemented properly then there could well be a significant increase in enterprise in Mongolia (including the attraction of digital nomads). 4. New Article 5: Comments have been made above that PPP seems to be the new “flavour of the month” but the issue of trust has to be resolved. The Government of Mongolia even struggles with the implementation of PPPs with Mongolian companies... <p>Mongoljin Comments on Chapter 2</p> <ol style="list-style-type: none"> 5. Old Article 6: It is to be hoped that investor protections will actually continue to exist and be enforced. 6. New Article 7: Enforcement is the key here. There is a concern that courts might have too much discretion in determining what is a legitimate interest and what is not. Vagueness leads to abuse. 7. New Article 8: There should not be an attempt to increase stealth costs on foreign investments thus reducing their competitiveness. The obligations related to “to introduce good environmental, social and governance practices and approaches;” should be an obligation on ALL enterprises in Mongolia (with possibly sensible exemptions for SMEs). Holding foreign-owned enterprises up to higher standards than Mongolian enterprises is unfair and discriminatory. <p>Mongoljin Comments on New Chapter 4</p>	<ol style="list-style-type: none"> 1. Агуулгын хувьд туссан. Шударга өрсөлдөөнийг дэмжсэн, авилгын талаар тодорхой үүрэг амлалт өгөхийг тусгасан. 2. Дэмжсэн санал 3. Дэмжсэн санал. 4. Хуулийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт. 5. Агуулгын хувьд туссан. 6. Агуулгын хувьд туссан. Хууль ёсны ашиг сонирхол гэснийг тодорхойлох нь эрх ашгийг хязгаарлах эрсдэлтэй. Олон улсад хэвшсэн ойлголт. 7. Агуулгын хувьд туссан. 8 дугаар зүйлд нь бүх хөрөнгө оруулагчдад хамааралтай. Ялгаварлал байхгүй. 8. ЗГХЭГ-ийн асуудлыг энд тодорхойлоогүй. Харин гүйцтэгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хувьд Засгийн газарт хуульд заасан чиг үүргийг бий болгох ёстой. Ингэснээр хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэнэ. 9. Саналыг тусгасан. ААНОАТ тухайн тухай хуульд олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн дагуу татварын хувь хэмжээг бууруулах, хойшлуулах арга нь үр дүнгүй гэж. Иймд ААНОАТ-энэ төрлийн хөнгөлөлтийг хассан. Харин татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд лоозон төдий байсныг татварын хууль буюу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд татварыг 2 жилээр хойшлуулах заалт оруулсан нь хэвээр байгаа. Хөрөнгө оруулалтын хууль дахь хэрэгждэггүй заалтыг

		<p>8. Interesting that the Cabinet of Ministers is taking additional powers to itself. It is to be hoped that the additional powers are enabling of foreign direct investment rather than predatory and creating additional layers of bureaucracy.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 5</p> <p>9. New Article 15: The three year limit on tax incentives should be benchmarked against international best practice. Have the Government of Mongolia actually undertaken a study or series of studies on good international practice in this area? International development partners such as the World Bank, IMF, OECD have undertaken several studies and provide guidelines. It would be instructive to see what evidence and advice the Government of Mongolia has utilised (if any) to draft the legislation. Previous studies suggest that there is quite a high sensitivity to tax incentives amongst potential foreign direct investors.</p> <p>Deleting the VAT incentive on imported capital may be a policy “own-goal”. The Government should look carefully into the costs and benefits of this. Mongolia is already lagging developmentally in terms of capital intensity...</p> <p>10. New Article 16: The main comment we have is that we welcome the potential liberalisation of the labour market. For too long Mongolia has hampered its ability to develop through protectionism in the labour market. There are serious skills gaps in the domestic labour market and the ability of foreign investors to bring in skilled workers (which, of course, can assist in the development of the pool of skills of Mongolians too) should be welcomed.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 6</p> <p>11. New Article 18: The continued issuance of Stabilisation Certificates is to be welcomed. However, we note that there is a narrowing of criteria and hope that this is based on appropriate evidence.</p> <p>12. New Article 20: It’s not clear which other sectors will benefit from stabilisation certificates. Economic diversification is both necessary and desirable for Mongolia and incentives should be spread wider than just mining for the longer term future of the country. It is notable that given the fall in the value of MNT that the real value of investment required for extensions to stabilisation certificates has fallen significantly since 2013 (if 500 billion MNT has not been amended from 2013).</p> <p>13. New Article 21: Again, general environmental impact assessments should not be used in a discriminatory fashion to add extra costs of doing business for foreign investors.</p> <p>New Article 24: It is to be hoped that the procedure set out here will be conducted with the interests of existing and future generations of Mongolians in mind and will be conducted in a reasonably transparent way to avoid abuse.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 7</p> <p>14. As an organisation committed to the development of free enterprise, we are not supportive of state owned enterprises (this also includes the mushrooming of SOEs in Mongolia which we consider to be a regrettable trend).</p> <p>Mongoljin Comments on New Chapter 8</p>	<p>хассан.</p> <p>10. Дэмжсэн санал</p> <p>11. Санал туссан. Тогтворжуулах гэрчилгээний шалгуур үзүүлэлтийг илүү хялбаршуулсан. Хувийн үзэмжээр дүгнэх боломжгүй болгосон.</p> <p>12. Санал туссан. Бүх төрлийн салбарт тогтворжуулах гэрчилгээг олгоно.</p> <p>13. Агуулгын хувьд одоо байгаа зохицуулалт. Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн дагуу энэ төрлийн үнэлгээ хийх шаардлагатай бол уг үнэлгээг тогтворжуулах гэрчилгээ олгоход шаардана.</p> <p>14. Хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, бодлоо илэрхийлсэн.</p> <p>15. Саналыг тусгасан.</p> <p>16. 16.Саналын тусгасан.</p> <p>17. 17.Саналыг тусгасан. Арбитр нь олон улсын арбитр байна.</p> <p>18. Агуулгын хувьд туссан. Эрүүгийн хуулийн хариуцлага байгаа. Харин эрүүгийн хариуцлага хүлээхгүй тохиолдолд хүлээлгэх нэмэлт захиргааны хариуцлагыг төсөлд нэмж тусгасан.</p>
--	--	---	--

			<p>15. Three months is quite a short period of time for large enterprises to submit audited financial statements. In developed countries such as the UK it is common to give enterprises 9 months to submit financial accounts for corporation tax return purposes for instance.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 9</p> <p>16. Chapter 9 is to be welcomed as it is more specific and also enables complaints to be delivered electronically.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 10</p> <p>17. Proper regulation of investor disputes is to be welcomed. However, trust is important and Mongolian arbitration courts should be seen to be equal and fair in their treatment. Allegations have been made in the past that arbitration in Mongolia was frequently against the interests of foreign investors.</p> <p>Mongoljin Comments on New Chapter 11</p> <p>18. Proper enforcement is critical if Mongolia is to regain international investor trust. Officials should not be able to abuse their position, and if caught doing so should face sanction (criminal and/or disciplinary). Justice should be seen to be done.</p>	
22.	М-Си-Эс групп	2023.05.02	<p><i>I. Хуулийн төслийн ололттой зохицуулалт</i> <i>Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах ололттой зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:</i></p> <p>1. “Хөрөнгө оруулагч аж ахуй нэгжид хийх төрийн хяналт шалгалтын тоо жилд 2-оос ихгүй байна” гэж зохицуулж, төрөөс хийгдэх хяналт шалгалтын хэмжээг бууруулсан.</p> <p>2. Хөрөнгө оруулагч “<i>төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл</i>” гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргах эрхийг олгосон.</p> <p>3. Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн <u>эсхүл</u> гадаадын хөрөнгө оруулагч болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх боломжийг зохицуулсан.</p> <p><i>II. Ерөнхий саналууд</i> <i>Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд дараах ерөнхий саналуудын дагуу холбогдох зохицуулалтуудыг нэмж тусгах шаардлагатай байна. Үүнд:</i></p> <p>1. Одоогийн байдлаар хууль санаачлагч, хуулийн төсөл боловсруулагч Засгийн газрын зүгээс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг нийтэд ил болгоогүй байх тул үүнийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу олон нийтэд нээлттэй болгох.</p> <p>2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг мөн адил нийтэд ил болгох. Ингэхдээ 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд өнгөрсөн хугацаанд олгоод байгаа <u>тогтворжуулах гэрчилгээ</u> болон нэгэнт байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаа дуусаагүй байгаатай холбоотойгоор эдгээрийн хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дараах харилцааг зохицуулах. Үүнд:</p>	<p>Дэмжсэн санал.</p> <p>Ерөнхий саналын хүрээнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Саналыг авч, Үзэл баримтлалыг олон нийтэд байршуулна. 2. Саналыг авч, дагаж мөрдөх журмын хуулийн төслийг боловсруулсан. 3. Хөрөнгө оруулалтын маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх боломжийг хуулийн төсөлд тусгасан. Харин дагнасан шүүх байгуулах асуудал нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийн үзэл баримтлалаас тусдаа шүүхийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд холбогдох тооцоо, судалгаанд хийгдэх учиртай. 4. Хөрөнгө оруулалтын хууль нь нийтлэг хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн, хөрөнгө оруулалтын нийтлэг баталгааны талаар зохицуулах бөгөөд аливаа салбараар ялгаварлах боломжгүй. Харин салбарын асуудлыг холбогдох салбарын хууль тогтоомжийн хүрээнд ялгамжтай тогтоох асуудал нээлттэй 5. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтыг татах, үл ялгаварлах зарчимд үндэслэх тул дотоод гадаад гэж ялгахгүй.

		<p>- 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хууль үйлчлэх хугацаанд үүссэн харилцааны хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол, үүргийг уг хуулийн шинэчилсэн найруулгын дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх талаар;</p> <p>- хөрөнгө оруулагчид учрах сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл байдал, арга зам;</p> <p>- хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах, гүйцэтгэх нөхцөл; болон</p> <p>- хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдол зэргийг зохицуулах.</p> <p>3. Маргаан шийдвэрлэх. Бизнесийн эрх зүй, арилжааны эрх зүйн маргааны шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах, шүүгчдийг бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх нь хөрөнгө оруулалтын маргааны хурдан шуурхай шийдвэрлэх, цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэсгэх нь хөрөнгө оруулагчдад учруулах хүндрэлийг бууруулах давуу талтай. Иймд, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, тухайлбал:</p> <p>- Шүүхийн тухай хууль,</p> <p>- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,</p> <p>- Арбитрын тухай хууль,</p> <p>- Эвлэрүүлэн зуучлах тухай хууль, болон</p> <p>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль</p> <p>4. Салбарын дэмжлэг. Эдийн засгаа төрөлжүүлэх, уур уурхайн салбараас хэт хараат байдлыг бууруулах үүднээс Хөрөнгө оруулалтын хуулийн хүрээнд (i) нэн тэргүүнд дэмжих чиглэл болон (ii) тодорхой хүрээнд дэмжих эдийн засгийн чиглэлүүдийг тодорхойлж, тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн талаар тусгах.</p> <p>5. Дотоодын хөрөнгө оруулагч. Дотоодын хөрөнгө оруулагчид олгох дэмжлэг, хөнгөлөлтийн зааг ялгааг тодорхой болгох.</p> <p><i>III. Нарийвчилсан саналууд</i></p> <p>1. 2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар <u>олгосон</u> хөрөнгө оруулалтын <u>дэмжлэг</u>, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн <u>зохицуулалтуудыг</u> бусад хууль тогтоомжид уялдуулж, нарийвчилсан зохицуулаагүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалтын дэмжлэг бодит байдал дээр хэрэгжихгүй, улмаар хөрөнгө оруулагчийн эрх ашиг зөрчигдөхөд хүрдэг. Иймд, хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийг зохицуулсан хуулиудыг нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>"2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Газрын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад</i></p>	<p>Ерөнхий саналын хүрээнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Агуулгын хувьд туссан.Монгол Улсын бүх хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэх тул хуулийг тоочих нь чухал шаардлагатай бусад хуулийг орхигдуулах эрдэлтэй тул Үндсэн хуульд нийцсэн акт гэсэн агуулгыг төсөлд тусгалаа. 2. Агуулгын хувьд дээрх зарчмууд тусгагдаж, хэрэгжилтийг хангуулах хүрээнд хөрөнгө оруулагчийн нийтлэг баталгаа, эрх, үүрэг болон төрийн байгууллагуудын чиг үүрэг гэсэн зүйлүүдэд тодорхой тусгасан. 3. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай. 4. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг төслийн 5 дугаар зүйлд тусгасан. Харин уг зохицуулалт нь компани байгуулах замаар хөрөнгө оруулах тохиолдолд хамааралтай. 5. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин захиргааны байгууллагын тавигдах стандарт, маяг зэрэг процессыг тогтворжуулах нөхцөл биш бөгөөд 10, 20, 30 жилийн хугацаанд төрийн байгууллагын тайлагналын систем цахимжих дараагийн шатанд өөрчлөгдөх үед энэ заалтаас хамаарч, хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Иймд уг татварын орчин гэсэн заалтыг эргэлзээ үүсгэхгүйн тул хасах нь зүйтэй байна. 6. Хууль тогтоомжийг тогтворжуулах боломжгүй бөгөөд 10,20,30 жилийн
--	--	--	---

		<p><i>актаас бүрдэнэ.”</i></p> <p>2. Төрөөс хөрөнгө оруулалтын салбарт баримтлах зарчмуудыг тодорхойлж хуулийн төсөлд тусгах Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, хөрөнгө оруулалтыг татах, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд дараах зарчмуудыг “Төрөөс хөрөнгө оруулалтын талаар баримтлах зарчим” болгон хуулийн төсөлд тусгах:</p> <p><i>“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:</i> <i>- Хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах;</i> <i>- Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах;</i> <i>- Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах;</i> <i>- Тогтвортой хөгжлийг хангах;</i> <i>- Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.”</i></p> <p>3. 3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ. Уг заалтын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагын хүрээнд зөвхөн хуулийн этгээд байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хязгаарлаж, хувь хүн өөрөө хөрөнгө оруулагч байх боломжийг үгүйсгэсэн байна. Иймд, уг заалтыг хуулийн төслийн 5.1.2, 5.1.4, 5.1.6 болон 5.1.7 дахь хэсгүүдтэй уялдуулан дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.”</i></p> <p>4. 4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг; Уг заалтын дагуу зөвхөн “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг <i>хөрөнгө оруулалт</i> гэж тооцохоор байна. Түүнчлэн уг заалт нь 5.1-д заасан хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй зөрчилдөж байна. Хөрөнгө оруулалтыг зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулах байдлаар хязгаарлах нь улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлэх хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Цаашлаад төслийн санхүүжилт зэрэг бусад хэлбэрээр хийх хөрөнгө оруулалтыг үгүйсгэдэг, татварын хувьд маргаан дагуулдаг заалт юм. Иймд, уг заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулах: <i>“4.1.1 “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдэд хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;”</i></p> <p>5. “Татварын орчин”-ы тодорхойлолтыг одоогийн хуулийн адилаар шинэчилсэн найруулгын төсөлд хэвээр тусгах</p>	<p>хугацаанд төрийн бодлого, чиглэлтэй холбоотойгоор хуулийг өөрчлөх үндэслэлтэй. Эсрэгээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөс сэргийлэх баталгааг хангах нь хууль ёсны байх зарчимд илүүтэй нийцнэ.</p> <p>7. Саналыг тусгаж, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах асуудлыг дахин тодорхойлсон. Хууль тогтоомжийн хуулиар ч мөн зохицуулагдаж байгаа.</p> <p>8. Саналын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны сонирхлыг зөрчсөн төрийн байгууллага албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, учирсан хохирлыг барагдуулах, албан тушаалаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авахаар төсөлд тусгасан.</p> <p>9. Саналын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны сонирхлыг зөрчсөн төрийн байгууллага албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, учирсан хохирлыг барагдуулах, албан тушаалаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авахаар төсөлд тусгасан.</p> <p>10. Саналын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны сонирхлыг зөрчсөн төрийн байгууллага албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, гт.</p> <p>11. Агуулгын хувьд тусгасан. Тогтворжуулах гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хялбаршуулсан.</p> <p>12. Хөрөнгө орлогыг гадаад улсад шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтаа татах тохиолдолд яригдах зохицуулалт юм. Иймд татварын өр төлбөр болон бусад этгээдэд өр төлбөртэй бол түүнийг барагдуулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.</p> <p>13. Хуульд заах үндэслэлийг хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Ийнхүү заах нь ач холбогдолгүй юм.</p> <p>14. Хуульд заах үндэслэлийг хөрөнгө</p>
--	--	--	--

		<p>2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7-д заасан <u>“Татварын орчин” гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг хэлнэ</u> гэсэн тодорхойлолтыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаагүй орхижээ. Уг заалтыг хассан нь зарчмын хувьд одоо байгаа зохицуулалтыг дордуулсан байна. Учир нь, уг тодорхойлолт нь татварын орчныг тогтвортой байдлыг хангах төрийн баталгааны үндэслэл болдог. Өөрөөр хэлбэл, тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээгээр олгож буй татварын орчныг тогтвортой байлгах баталгааны цар хүрээг тодорхойлж буй чухал тодорхойлолтыг хасах нь зарчмын хувьд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах бус дордуулахаар байна. Ялангуяа нэг талд тогтворжуулах гэрчилгээгээр гэрчилгээнд заасан хугацаанд татварын хувь болон хэмжээг <u>тогтвортой байлгах төрийн баталгааг өгсөн хэр нь</u> нөгөө талд татвар ногдуулах, тайлагнах болон төлөхтэй холбоотой дүрэм журам, арга аргачлалыг өөрчлөх замаар ногдох татварын хувь болон хэмжээг нэмэх үр дагавар үүсгэх хандлага улам нэмэгдэхээр байна. Хэрэв уг байдлаар татварын хувь болон хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгож, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гэвэл уг баталгаа нь хөрөнгө оруулалт татах хэмжээнд эрх зүйн баталгаа бүрдүүлж чадахгүй. Иймд, хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “татварын орчин”-ны тодорхойлолтыг одоо үйлчилж байгаа хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.7 дахь хэсэгт заасан агуулгаар дараах байдлаар нэмж тусгах:</p> <p><i>“4.1.**. “татварын орчин” гэж хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг;”</i></p> <p>6. 6.1. Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана:</p> <p>1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 64 заалтад 110 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан бол 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 27 заалтад 40 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. Ийнхүү Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн орчин тогтворгүй байх нь хөрөнгө оруулагчийн хувьд итгэлийг бууруулах, эрсдэлийг нэмэгдүүлэх, тодорхой бус байдал үүсгэдэг бол улсын хувьд хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулах, хөрөнгө оруулагчдыг алдах, хөрөнгө оруулалтын маргаан гарах эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. Иймд, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой зохицуулалтыг тогтворжуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд дараах заалтыг нэмэлтээр оруулах:</p> <p><i>“6.1.**. Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох, эсхүл түүнтэй Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар холбогдох хуулийн зохицуулалтуудыг тогтвортой байлгах баталгаа олгоно.”</i></p> <p>7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явцыг хөрөнгө оруулагчдад ил тод мэдээлэх, олон нийт, хөрөнгө оруулагчдын саналыг тусгах үүднээс дараах заалтыг нэмэлтээр оруулах:</p> <p><i>“6.1.**. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд хөрөнгө оруулагчид болон олон нийтэд нээлттэй мэдээлж, хуулийн төслийг нийтэд ил тод байршуулж, хөрөнгө оруулагчид болон олон нийтийн саналыг хүлээн авч, нээлттэй хэлэлцүүлэх боломжоор хангах ба хууль</i></p>	<p>орчуулалтын хуулиар зохицуулах боломжгүй. Банк, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой харилцааг ийнхүү заах нь ач холбогдолгүй юм.</p> <p>15. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийн эрхийг хангахтай уг зохицуулалтын хүрээнд хуулиар л хязгаарлалт тогтоож болно.</p> <p>16. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө оруулагчийн эрх нь дотоод гадаадын хөрөнгө оруулагч байхаас үл хамаараад ижил тэгш боломжоор хангагдана.</p> <p>17. Төрийн байгууллага нь хуульд заагаагүй мэдээллийг шаардах нь хууль бус асуудал болно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч мэдээллийг өгөхгүй байх, ийнхүү гаргаж буй төрийн байгууллагын хууль зөрчсөн шаардлагын талаар гомдол гаргах эрхтэй.</p> <p>18. Хөрөнгө оруулагч шударгаар өрсөлдөх асуудлын төсөлд тусгаж, саналыг хүлээн авсан.</p> <p>19. Саналыг тусгаж, хөрөнгө оруулалт бодитоор хийсэн байх гэснийг тодорхойлсон.</p> <p>20. Саналыг тусгасан. Харин компанийн удирдлагын сайн засаглал нэвтрүүлэх, стандарт нөхцөлийг мөрдөж ажиллах гэсэн агуулгаар ажиллахыг үүрэг болгов.</p> <p>21. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын хөгжлийн аливаа бодлогыг УИХ батлахаар заасан. Иймд хөрөнгө оруулалтын бодлогыг УИХ батлахаар байна.</p> <p>22. Агуулгын хувьд зохицуулалт байгаа. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийг 10 жил тутам дүгнэдэг байхаар заасан.</p> <p>23. Санал нь агуулгын хувьд зохицуулалттай бөгөөд өмчийн</p>
--	--	---	--

		<p><i>тогтоомжийн төсөл боловсруулах явцдаа хөрөнгө оруулагчдын саналыг тусгана.</i>"</p> <p>8. Хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, нийгэмд хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын талаар сөрөг мэдээлэл түгээх, олон нийтийг төөрөгдүүлэх, хөрөнгө оруулагчийн нэр хүндэд халдах явдлаас урьдчилан сэргийлэх үүднээс дараах заалтыг нэмж хуульчлах: <i>"6.1.**. Төрийн байгууллага, албан тушаалтан нь хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх худал мэдээ мэдээлэл тараах, олон нийтийг төөрөгдүүлэхийг хориглоно."</i></p> <p>9. 6.2.3.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авахад (i) нийтийн ашиг сонирхлын үүднээс (ii) хуульд заасан журмын дагуу (iii) үл ялгаварлах зарчмын хүрээнд (iv) зах зээлийн үнэлгээ бүхий нөхөн төлбөртэйгөөр хураан авах зарчим үйлчилдэг. Иймд, уг заалтад <i>"үл ялгаварлах зарчмыг"</i> нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"6.2.3. хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно."</i></p> <p>10. 7.1.8.Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах; Уг заалтын хүрээнд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах замаар гомдол нэхэмжлэлээ шийдүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс дараах байдлаар нэмж найруулах: <i>"7.1.8. Төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандан шийдвэрлүүлэх;"</i></p> <p>11. 17.5.Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэрээс нь хамааран тогтворжуулах гэрчилгээг дараах этгээдэд олгоно: 17.5.1.хөрөнгө оруулалтын төслийг нэг хуулийн этгээд дангаар хэрэгжүүлэх бол тогтворжуулах гэрчилгээг тухайн хуулийн этгээдэд; 17.5.2.хөрөнгө оруулалтын төслийг харилцан хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хэрэгжүүлэх бол тэдгээрийн толгой компанид. Уг заалтын дагуу төслийн 17.5.1, 17.5.2-т заасан хуулийн этгээд тус бүрийн хувьд зохион байгуулалтын хэлбэрээс бусад нөхцөлийг үл харгалзан тогтворжуулах гэрчилгээ олгохоор тусгасан байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгож, ямар шаардлагыг хангасны үндсэн дээр тогтворжуулах гэрчилгээ олгох тухай зохицуулалтыг оруулах: <i>"Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр, хөрөнгө оруулалтын хэмжээнээс нь хамааран тогтворжуулах гэрчилгээг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан дараах этгээдэд олгоно."</i></p> <p>12. 6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн</p>	<p>хэлбэрээс үл хамаарч шударга өрсөлдөөний зарчим үйлчилнэ. Харин санал дурдсан энэ талаарх арга хэмжээ гэдэг нь хэт ерөнхий хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалт байна.</p> <p>24. Агуулгын хувьд туссан. Засгийн газрын тухай хуульд заасны дагуу холбогдох чиг үүргийн хүрээнд бодлогын санал боловсруулж өгөн барих эрх нээлттэй.</p> <p>25. Агуулгын хувьд тусгасан</p> <p>26. Агуулгын хувьд тусгасан</p> <p>27. Агуулгын хувьд тусгасан. Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p> <p>28. Агуулгын хувьд тусгасан. Агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулагчийн гомдлын дагуу Засгийн газраас холбогдох төрийн байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллахаар төсөлд тусгасан.</p> <p>29. 29.Саналыг тусгасан.</p> <p>30. Агуулгын хувьд тусгасан. Хуулийн төсөлд агентлагийн хэрэгжүүлэх чиг үүргийг хэтэрхий нарийвчлан заах нь хуулийн хэрэгжилтийг хязгаарлах эрсдэлтэй.</p> <p>31. Агуулгын хувьд туссан. Хяналт шалгалт нь Төрийн хяналт шалгалтын хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулагддаг бөгөөд хяналт шалгалтыг зохион байгуулах нарийвчилсан харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжгүй.</p> <p>32. Агуулгын хувьд туссан.</p> <p>33. Саналыг тусгаж, 3 жилээр хойшлуулах заалтыг болиулсан. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий</p>
--	--	--	---

		<p>биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй: <i>"Татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсэн"</i> гэдэг үндэслэлийг хэрхэн тогтоох нь тодорхой бус байна. Татварын хяналт шалгалтын явцад хожим нь татварын өр төлбөр илэрсэн нь хөрөнгө оруулагчийг ногдох хөрөнгө, орлогоо гадаад улсад гаргах үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй байна. Иймд, уг заалтыг илүү нарийн тодорхой болгох.</p> <p>13. 6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй. <i>"Хуульд өөрөөр заасан"</i> гэх үндэслэлээр хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлогоо мөнгөн хэлбэрээр гадаад валютад хөрвүүлж шилжүүлэхийг хүндэтгэн үзэх онцгой шалтгаангүйгээр хязгаарлах эрсдэлтэй байна. Иймд, хууль заасан үндэслэл гэдгийн өмнө тодорхой зорилгыг тусгаж дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"6.2.6. хөрөнгө оруулагч нь үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй."</i></p> <p>14. 7.1.4.Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Бусад хууль тогтоомжийн хүрээнд гадаад валютаар гүйлгээ хийх, гадаад валютын шилжүүлэг, худалдан авалтыг хязгаарлах тохиолдол гардаг. Иймд, гадаадын мөнгөн тэмдэгт худалдах, худалдан авах харилцааг хязгаарлахгүй тохиолдлыг тусгаж уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"7.1.4. Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах; Тус үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал болон гадаад валютын хомсдолоос сэргийлэх зорилгоор хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа байдлаар хязгаарлахгүй."</i></p> <p>15. 7.1.5.хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Бусад хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааг үндэслэн гадаад руу хийх шилжүүлгийг хязгаарлах эрсдэлтэй тул дараах байдлаар өөрчлөн найруулах. <i>"7.1.5. хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах; Уг шилжүүлэгт хуульд зааснаас бусад тохиолдолд хязгаарлалт тогтоохыг хориглоно."</i></p> <p>16. 7.1.3.Хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох; Хөрөнгө оруулагч тухайн үед Монгол Улсад үйлчилж буй хөнгөлөлт, урамшуулал, таатай бодлогыг дотоодын аж ахуй нэгж, байгууллагын нэгэн адилаар эдлэх боломжийг бүрдүүлэх</p>	<p>болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: - 300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, -гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна.</p> <p>34. Саналыг тусгасан. Татварыг татварын хуулиар зохицуулах зарчмын хүрээнд элэгдэл хорогдол тооцох, хасагдах зардал зэргийг ААНОАТ-ын хуулиар зохицуулна.</p> <p>35. ААНОАТ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар алдагдал ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт хэвээр байна. Татварыг татварын хуулиар зохицуулах шаардлагын хүрээнд хөрөнгө оруулалтын хуульд энэ талаар тусгах шаардлага байхгүй.</p> <p>36. Агуулга нь байгаа бөгөөд нэмэлт, урамшууллыг мөн бий болгосон. Монгол Улсад татварын урамшууллын бодлого байгаа. Үүнд: -300сая хүртэл орлоготой этгээдийн 1 хувийн татвар, - гадаад дотоодын зах зээлээс хөрөнгө босгох өрийн бичиг гаргахтай</p>
--	--	--	---

		<p>үүднээс дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"7.1.3. хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох; Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй шийдвэр, эрх зүйн баримт бичгийн дагуу импортлох, экспортлох үйл ажиллагаанд хөнгөлөлт, урамшуулал, бусад нөхцөлийг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын нэгэн адил эдлэх."</i></p> <p>17. 8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх; Практикт, татварын байгууллага хуульд нарийвчлан тусгаагүй өргөн хүрээний мэдээллийг гаргуулах шаардлага тавих тохиолдолд гардаг. Энэ тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар учруулдаг. Иймд, татварын байгууллага гагцхүү "хуульд заасан үндэслэлийн дагуу" мэдээлэл шаардах эрхтэй байхаар уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"8.1.3. татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан үндэслэлийн дагуу шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;"</i></p> <p>18. 8.1.4. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих; Уг заалтад тусгагдсан "хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх" нэр томъёоны хувьд бизнесээс шууд хэрэглэгчид чиглэсэн (В-С) үйлчилгээнд хамааралтай ба бизнесээс бизнест чиглэсэн (В-В) үйл ажиллагаанд нь төдийлөн хамааралгүй байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>"8.1.4. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж зах зээлд шударгаар өрсөлдөх, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих;"</i></p> <p>19. 8.1.8. хөрөнгө оруулалтаа бодитоор хийсэн байх; Хөрөнгө оруулалтаа "бодитоор" хийснийг үнэлэх, хэмжих шалгуур тодорхой бус байгаа тул үүнийг тодорхой болгох. Бусад улсуудад дараах аргыг түгээмэл хэрэглэдэг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Хөрөнгөд суурилсан:</u> хөрөнгө оруулалтын явцад шаардагдаж байгаа эсхүл бий болгосон хөрөнгийн үнэлгээ 2. <u>Орлогод суурилсан:</u> хөрөнгө оруулалтын орлогоор бий болсон хөрөнгө 3. <u>Ажлын байр бий болгох эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлт:</u> бий болгосон ажлын байр болон орон нутагт үзүүлсэн эдийн засгийн үр нөлөө 4. <u>Хяналт:</u> Хөрөнгө оруулалтаа анхны зорилгын дагуу хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих 5. <u>Нийтэд мэдээлэх шаардлага:</u> Хөрөнгө оруулалтын хариуцлагатай, ил тод байдлын талаар олон нийтэд мэдээлэх <p>20. 8.1.9. байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх Уг заалт нь сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх ажил тул хуулийн этгээдэд үүрэг ногдуулж</p>	<p>холбоотойгоор төлөх хүү, ногдол ашгийн орлогод 5 хувийн татвар, - татвар төлөгчийн зардлыг тодорхойлох шалгуур хангасан бол бүх зардал хасагдахаар, - элэгдэл хорогдлыг тооцох нөхцөлийг хялбаршуулж, хугацааг богиносгосон, - арилжааны банкны эх үүсвэр татахаар гадаад, дотоодоос татсан мөнгөн эх үүсвэрийн хүүгийн орлого 5 хувь, - оюуны өмчийн эрх борлуулсан бол 5 хувь, - программ хангамжийн компанийн гадаад зах зээлээс худалдан авах программ хангамжийн зардалд 5 хувийн татвар суутгах, - хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, оюуны өмчийн зуучлал, оюуны өмчийн барьцаалсан зээлийн хүүгийн орлого зэрэг нь орлогын албан татвараас чөлөөлөгдөж байна. Мөн Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт буюу гааль, НӨАТ хойшлуулах зохицуулалт нь холбогдох хууль хийгээд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулсан. Хуулийн төслийн хүрээнд оршин суугч бусад шилжүүлэх орлогын татварыг 10 хувь болгон өөрчилсөн нь дотоодын татвар төлөгчдөд бодитоор учирч буй ачааллыг бууруулах ач холбогдолтой. Эргэлзээ үүсгэхгүйн тулд хууль хооронд зерчил үүсгэхгүйн тулд Хөрөнгө оруулалтын хуульд заасан татварын аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтыг хаслаа.</p> <p>37. Саналын дагуу Тогтворжуулах гэрчилгээний хугацааг уртасгасан.</p> <p>38. Саналын дагуу Тогтворжуулах гэрчилгээний хугацааг уртасгасан.</p> <p>39. Тогтворжуулах гэрчилгээ олгохоос үндэслэлгүй татгалзахгүй бөгөөд ийнхүү үндэслэлгүй татгалзсан тохиолдолд уг зөрчлийг Маргаан</p>
--	--	--	--

		<p>зайлшгүй тусгах шаардлагагүй байна. Олон улсын сүүлийн үеийн чиг хандлагаар “байгаль орчин, нийгэм, сайн засаглал” (<i>цаашид “ESG” гэх</i>)-ын тайлан гаргах санал санаачилга өргөжин тэлж байна. Энэ нь тухайн хуулийн этгээд хөрөнгө оруулалт татах боломжоо нэмэхийн тулд санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна тогтвортой, найдвартай байдлыг илтгэх санхүүгийн бус үзүүлэлтүүдээ үнэлэх, өөртөө давуу байдлыг үүсгэх сонирхолтой холбоотойгоор гол төлөв томоохон групп компаниудын зүгээс сайн дурын үндсэн дээр гаргаж буй тайлан мэдээ юм. Энэ асуудлыг ямар нэг тодорхой шалгуургүйгээр нийтлэг байдлаар үүрэгжүүлэн шаардах нь эерэг үр дагавар үүсгэхээс илүүцээр хэлбэрийн төдий чирэгдэл дагуулсан ажиллагаа болж мэдэх тул хуулийн төслийн уг заалтыг хасах саналтай байна.</p> <p><i>“8.1.9. байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх”</i></p> <p>21. 9.1. Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх. Монгол Улсын УИХ, Засгийн газраас хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлалыг тусгайлан баталж байгаагүй бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай хуулиас бусдаар хөрөнгө оруулалтын суурь бодлогыг бүхэлд нь илэрхийлэх баримт бичиг байхгүй юм. Харин Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэгт хөрөнгө оруулалтын талаар цухас дурдагдсан байдаг. Иймд, хөрөнгө оруулалтын салбарт төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтын салбарын суурь үзэл баримтлалыг Засгийн газраас баталж, түүнийг хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтад нөлөө үзүүлэх шийдвэр гаргагч төрийн байгууллагын бүх шатлал, түвшинд сурталчлан таниулж, улмаар Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг төрийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа нэг мөр тайлбарлаж, хэрэглэхэд ач холбогдолтой. Хөрөнгө оруулалтын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогоор хөрөнгө оруулалтын салбарын зорилго, хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, хөрөнгө оруулалтад үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, хөрөнгө оруулалтын салбарын зохицуулалт, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар, хяналт үнэлгээ зэргийг тодорхойлох боломжтой. Иймд хуулийн заалтыг дараах байдлаар нэмж найруулах: <i>“9.1.1.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.”</i></p> <p>22. 9.1.**Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үнэлэх, сайжруулах үүднээс дараах заалтыг нэмж тусгах: <i>“9.1.**. Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хөндлөнгийн дүгнэлтийг хоёр жил тутамд нэг удаа хийлгэх бөгөөд дүгнэлтэд туссан зөвлөмж, саналын дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.”</i></p> <p>23. 9.1.**Хөрөнгө оруулалтын салбарт хөрөнгө оруулагчидтай төрийн өмчит компаниуд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараах заалтыг нэмж тусгах: <i>“9.1.**. Төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтын орчинд шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангаж, хөрөнгө оруулалтын орчныг сааруулах аливаа үйл ажиллагаа явуулах,</i></p>	<p>шийдвэрлэх зөвлөлд мэдэгдэх, улмаар Засгийн газарт гомдол гаргах үндэслэл болно. Иймд уг хугацаанд багтаж шийдвэр гаргаагүй нь шууд эрх авах нөхцөл болох нь тохиромжгүй байна.</p> <p>40. Агуулгын хувьд туссан. Хөрөнгөө буцаан татсан тохиолдолд цаашид тогтворжуулах асуудал яригдахгүй.</p> <p>41. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. харин бусад салбарын дэмжлэгийн хувьд шаардлагатай тооцоо, судалгааг хийсний үндсэн дээр оруулах нь зүйтэй бөгөөд хөрөнгө оруулалтын хууль нь нийтлэг баталгааг хангана.</p> <p>42. Хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтад нөлөөлөх эдийн засгийн баталгааг өгөх зорилгоор татварын хувь хэмжээг тогтворжуулах юм. Харин хууль тогтоомжийг сонгохтой холбоотой хуулийн орчныг тогтворжуулах шинжтэй уг санал нь хууль хэрэглээнд хүндрэл үүсгэх нь эргээд захиргааны байгууллагын зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Иймд хөрөнгө оруулалтын гэрээнд иргэний хуулийн суурь зарчмыг баримтлах нь зохимжгүй. Энэ нь татварын асуудалтай холбогдох тул.</p> <p>43. Агуулгын хувьд туссан. Гэрээ байгуулахтай холбоотой ерөнхий нөхцөлийг хуульд шууд заасан. Нөгөө талаар хууль нь хэрэгжиж эхлэх үед бүх дүрэм, журам батлагдсан байх шаардлагатай тул журам батлах хугацааг тавих шаардлага байхгүй.</p> <p>44. Агуулгын хувьд тусгасан</p> <p>45. Холбогдох хууль тогтоомжуудад тусгайлсан горим хэрэгжих нөхцөлийг хуульчилсан. Уг горимын дагуу холбогдох урамшууллыг хүртэнэ.</p> <p>46. Агуулгын хувьд зохицуулалт байгаа.</p>
--	--	--	---

		<p><i>хөрөнгө оруулалтыг хязгаарлах нөхцөлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Төрийн өмчит компаниудын жагсаалтыг бүрэн гаргаж, олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлнэ. .”</i></p> <p>24. 10.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.1.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх; Төслийн 9.1.1-т өөрчлөн тусгуулах дээр дурдсан заалттай уялдуулан дараах байдлаар өөрчлөх: <i>“10.1.2.хөрөнгө оруулалтын салбарын нэгдсэн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх”</i></p> <p>25. 10.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх; Зарим тохиолдолд төрийн байгууллагууд хөрөнгө оруулагчийн өмнө Засгийн газрын хүлээсэн үүргийн талаар төдийлөн сайн мэдлэг, мэдээлэлгүй байдгаас үүдэн хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргахдаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих тохиолдол гардаг. Иймд, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн байгууллагын бүхий л түвшин, салбар, шатлалд холбогдох албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс шаардлагатай мэдээлэл, дэмжлэгийг хөрөнгө оруулалт хариуцсан захиргааны байгууллагаас авах боломжийг бүрдүүлэхийн тулд уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“10.1.3. хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт өгөх, сургалт, мэдээллээр хангах;”</i></p> <p>26. 12. Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллын чиг үүрэг 12.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг төрийн бусад байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“12.1. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө. Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр шаардлагатай тохиолдолд чиглэл, заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авна.”</i></p>	<p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх эрх хэмжээ нь Засгийн газрын эрх хэмжээнд хамаарч байна.</p> <p>47. Инновацийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт төрийн дэмжлэгийн асуудлыг тодорхой заасан. Түүнчлэн, санхүүжилт дээр төрөөс дэмжлэг үзүүлэхээс гадна, татварын бодлогоор дэмждэг бөгөөд энэ чиглэлийн салбарт НӨАТ чөлөөлөлтийн дэмжлэг мөн үзүүлдэг.</p> <p>48. Агуулгын хувьд туссан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1. Засгийн газар нь Монгол Улсын визийн ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсын виз олгох журам батлах; гэж заасны дагуу саналд дурдсан асуудлыг хуулийн хүрээнд бус журмын дагуу зохицуулах боломжтой байна.</p> <p>49. Хөрөнгө оруулалтын урамшуулал нь холбогдох салбар хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын хувьд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй шууд холбогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим ёсоор төрийн алба нь хууль дээдлэх зарчмыг баримтлах бөгөөд төрийн албан хаагчаас хэрэгжүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын хуулиар бус салбар хуулиар тодорхойлно. Иймд тус хуулийг зөрчиж шийдвэр гаргах боломжгүй тул эргэлзээ үүсгэхгүйн тулд хөрөнгө оруулалтын хуульд энэ төрлийн хуулийн зөрчил үүсгэх зохицуулалт оруулах шаардлагагүй.</p> <p>50. Саналыг тусгаж, хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх асуудлыг үе шат бүрээр тодорхойлж, хугацааг заалаа.</p> <p>51. Саналыг тусгасан бөгөөд хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэлтийн</p>
--	--	---	---

		<p>27. 13. <i>Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх</i></p> <p>13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.</p> <p>Хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн Засгийн газрын үүргийг нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагааныхаа явцад зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>"13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэгийг үзүүлэх, Засгийн газрын хүлээсэн үүргийг орон нутагт Засгийн газрын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хэрэгжүүлэх, хамгаалах чиглэлээр Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хандан заавар, тайлбар, удирдамж, дүгнэлт авах, сургалт, мэдээлэл авах ба тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ."</i></p> <p>28. 13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.</p> <p>Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулахгүй байх, Хөрөнгө оруулалтын гэрээний үүрэг болох Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг зөрчихгүй байх үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>"13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх төрийн бүхий л үйлчилгээг тасалдалгүй явуулах ба хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихүйц шийдвэр, үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна."</i></p> <p>29. 11.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1. хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх</p> <p>Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтыг татахаас гадна нэгэнт орж ирсэн хөрөнгө оруулалтыг хамгаалах, түүн дээр суурилан хөрөнгө оруулалтын урсгалыг тогтвортой нэмэгдүүлэх нь нэн чухал. Иймд, уг заалтыг дараах байдлаар нэмж найруулах:</p> <p><i>"11.1.1. хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах, дэмжих цогц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх"</i></p>	<p>талаар нийтэд мэдээлнэ.</p>
--	--	--	--------------------------------

		<p>30. 11.1.3.-11.1.6.</p> <p>11.1.3. хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p> <p>11.1.4. хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх</p> <p>11.1.5. хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх</p> <p>11.1.6. хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, төслийн мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>Эдгээр заалтыг бодит нөхцөл байдал дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар процессын зохицуулалт тодорхой бус байна. Тодруулбал, хэрхэн "төлөвлөлт хийх", "дэмжлэг үзүүлэх", "үйлчилгээний талаар зөвлөх", "үйлчилгээ үзүүлэх", "төслийг хөгжүүлэх", "бэлэн байдлыг хангах" зэрэг процессын зохицуулалт тодорхой бус байгаа нь эдгээрийг бодит байдал дээр хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хүргэнэ.</p> <p>Иймд, уг заалтуудыг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, процессын үе шатыг тодорхой болгох.</p> <p>31. 12.2.Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлнэ.</p> <p>Төрийн байгууллагын давтамжтай, олон төрлийн хяналт шалгалтын улмаас хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хэвийн байдал тасалдах, гарах зардлын хэмжээ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай тул уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>"12.2. Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг тасалдалгүй байдлыг хангаж, хяналт шалгалттай холбогдуулан хөрөнгө оруулагчид учрах аливаа зардлыг хамгийн бага түвшинд байлгах зарчмыг баримтална."</i></p> <p>32. 15.1. Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг үзүүлнэ:</p> <p>15.1.2. тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах;</p> <p>Хуулийн заалтыг илүү ойлгомжтой болгох үүднээс дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>"15.1.2.тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг уг гэрчилгээ, гэрээнд заасан хугацаагаар тогтворжуулах;"</i></p> <p>33. 15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах;</p> <p>Албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах нь татварын дэмжлэг гэхээс илүүгээр татварын гурван жилийн хугацааны татварыг овооруулж төлснөөр хөрөнгө</p>	
--	--	--	--

		<p>оруулагчид санхүүгийн дарамт үзүүлэхээр байна. Түүнчлэн уг дэмжлэгийг хөрөнгө оруулагч бүрд үзүүлэх үү эсхүл зөвхөн тодорхой шаардлага хангасан хөрөнгө оруулагчид үзүүлэх үү гэдэг нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“15.1.1. () шаардлагыг хангасан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах эсхүл чөлөөлөх;”</i></p> <p>34. 15.1.3.албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдэл хорогдлын хэмжээг түргэвчилсэн аргаар тооцох; Уг заалтын дагуу ямар шалгуур, шаардлага, нөхцөлийг хангасан хөрөнгө оруулагч аж ахуй нэгжид татварын дэмжлэг үзүүлэх нь тодорхой бус байна. Иймд, уг заалтыг илүү тодорхой болгох: <i>“15.1.3. шаардлагыг хангасан аж ахуй нэгжийн ажилтны мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох;”</i></p> <p>35. 15.1.**.Алдагдлыг ирээдүйд шилжүүлж тооцох зохицуулалт Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1.4-т “Албан татвар ногдох орлогоос хасагдах алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох” тухай заасныг энэхүү шинэ төсөлд тусгаагүй орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төслийн судалгаа, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын шатанд хугацаа болох хөрөнгө их шаардагддаг мега төслүүдийн тухайд алдагдлыг ирээдүйд шилжүүлэх зохицуулалт нь хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлт болдог. Иймд, уг асуудлыг мега төслийн хүрээнд татварын хуульд тогтоомжид заасан нийтлэг горимоос илүү тааламжтай нөхцөл олгох боломжийг нээсэн байдлаар өндөр шалгууртайгаар тусгах.</p> <p>36. 12.2.Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эдгээр нь татварын дэмжлэг бүхий зохицуулалтуудтай уялдуулан Татварын ерөнхий хууль болон Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулах өөрчлөлтийг тусгаагүй байх тул бодитоор хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байна. Иймд, уг хуулиудад холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгаахаас гадна уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: <i>“Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна.”</i></p> <p>37. 20.3.Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 1.5 дахин уртасгаж тооцож олгоно. Зарим төслүүд томоохон хөрөнгө оруулалт шаардаж, урт хугацаанд хэрэгждэг тул уг</p>	
--	--	---	--

заалтыг хэмжээг 2 дахин уртасгаж тооцсоноор үр нөлөөтэй дэмж болж чадахаар байна. Иймд уг заалтад дараах байдлаар өөрчлөлт оруулах:

“20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг 2 дахин уртасгаж тооцож олгоно.”

38. 20.3. Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг энэ хуулийн 20.2-т заасан хугацааг 1.5 дахин уртасган тооцож олгоно:

20.3.1. улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр;

Уг заалтын хүрээнд тогтворжуулах гэрчилгээ олгох салбаруудыг ялгамжтай тодорхойлж, түүнд олгох хөрөнгө оруулалтын хэмжээг 500 тэрбум төгрөгөөс бууруулж шатлалтай тогтоох.

39. 22.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг цахимаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.

Уг хугацаанд хариу өгөөгүй бол цаашид авах арга хэмжээ, санкци хариуцлага нь тодорхой бус байдгаас үүдэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 ба түүнээс дээш хугацаагаар хүсэлтэд хариу өгөхгүй байх тохиолдолд гардаг. Иймд, уг заалттай холбогдуулан дараах хэсгийг нэмж тусгах:

“22.1. ... Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тогтворжуулах гэрчилгээ олгох эсэх шийдвэрийг гаргаагүй тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан гэж үзнэ.”

40. 23.1.Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан үндэслэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно:

23.1.3.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд Монгол Улсад оруулсан хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс бүрэн татаж, шилжүүлсэн;

Уг заалтын дагуу оруулсан хөрөнгөө “бүрэн татаж”, “шилжүүлсэн” гэсэн зохицуулалтыг хэрхэн тайлбарлаж, хэрэглэх нь тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдээс анх тогтворжуулах гэрчилгээ авах үед оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээ бууруулсан эсхүл хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх зэргээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ багассан тохиолдолд үүнийг хөрөнгөө шилжүүлсэн гэж үзэх үү гэдэг нь эргэлзээтэй байна. Иймд уг заалтыг тодорхой тусгах.

41. Эдийн засгийн хараат байдал, валютын гадагш урсгалд жин дардаг гадаад худалдааны тэнцэлд чухал ач холбогдолтой салбарын бүтээн байгуулалтын явцад татварын бодлогоор дэмжих боломжийг хэвээр үлдээх

2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2-т “Доор дурдсан тохиолдолд импортлосон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн

		<p><i>албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</i></p> <p><i>11.2.1 Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>11.2.2 Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>11.2.3 Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих” гэж заасан.</i></p> <p>Монгол Улсын эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий дээрх салбарт хэрэгжих төслийн барилга угсралтын үе шатанд импортлох техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох тухай дээрх заалт нь тухайн төслийн хувьд ямар ч орлого олж эхлээгүй байгаа барилга угсралтын үеийн зардлыг бууруулах бодит ач холбогдолтой. Иймд уг зохицуулалт нь хөрөнгө оруулалт оруулах хөшүүрэг болохоос гадна уг заалтын хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлаас тухайлсан хууль гаргаж хугацааны хязгаарыг тогтоож өгөх бөгөөд Засгийн газраас чөлөөлөгдөх бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг батлах тул уг заалтыг доорх байдлаар хуулийн төсөлд нэмж оруулах:</p> <p><i>“23.1.**. Доор дурдсан тохиолдолд импортлох техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</i></p> <p><i>23.1.**.1. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>23.1.**.2. Нано, био болон инновацын технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;</i></p> <p><i>23.1.**.3. Эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих”</i></p> <p>42. 24.9. Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын гэрээнд иргэний эрх зүйн зарчим дараах зарчмыг баримтлах ёстой боловч баримталдаггүй. Үүнээс үүдэн Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөд хүрдэг.</p> <p><i>5. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх</i></p> <p><i>5.2. Шинээр батлагдсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.</i></p> <p><i>5.3. Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.</i></p> <p>Хэрэв иргэний хуулийн дээрх зарчмыг Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгавал Хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон хөрөнгө оруулагчид сөрөг нөлөөтэй аливаа зохицуулалтыг дагаж мөрдөх шаардлагагүй болно. Иймд, уг заалтад доорх хэсгийг нэмж найруулах:</p> <p><i>“24.9. Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа,</i></p>	
--	--	--	--

		<p>зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээнд хамааралтай шинээр батлагдсан эсхүл нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, холбогдох зохицуулалт нь хөрөнгө оруулагч талын ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байх бөгөөд хөрөнгө оруулагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомж, зохицуулалтаас илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан зохицуулалтыг хэрэглэж болно.”</p> <p>43. 24.10. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, Хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар батална. Хууль батлагдсаны дараа холбогдох журам батлах ажиллагаа удаашралтай байдаг. Иймд, уг заалтад журам батлах хугацааг тодорхой болгох эсхүл дагаж мөрдөх журмын тухай хуульд нарийвчлан тусгах: “24.10. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, Хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар энэхүү хууль батлагдсанаас хойш _____ хугацааны дотор батална.”</p> <p>44. 27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Хөндлөнгийн аудитын байгууллагын зүгээс зарим нэг учир шалтгааны улмаас тайлан баталгаажуулахад хугацаа орох тохиолдол багагүй гардаг тул хугацааг 05 сарын 31-ний өдрийн байдлаар болгож дараах байдлаар өөрчлөх: “27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”</p> <p>45. 16.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх; Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Чөлөөт бүсийн тухай хууль болон Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, эдгээр хуулиудад хөрөнгө оруулагчид бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх дэмжлэгийн зохицуулалтыг нарийн тодорхой хуульчлах.</p> <p>46. 16.1.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх; Уг дэмжлэг, хөнгөлөлт олгосон харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий</p>	
--	--	---	--

		<p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй байна. Иймд, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбогдуулан хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>47. 16.1.5.экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; Уг дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Иймд, хөрөнгө оруулагчийн экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг Инновацийн тухай хуульд нарийн тодорхой тусгах.</p> <p>48. 16.1.6.Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг олгох; Уг зөвшөөрөл олгох харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бүхий Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хэдий ч уг төсөлд "гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд оршин суух зөвшөөрөл олгох"-той холбогдсон харилцааг нарийвчлан тусгаагүй байна. Иймд, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд оршин суух зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг нарийвчлан тусгах.</p> <p>49. 16.2.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн хүрээнд холбогдох нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудын уялдаа холбоог хангах үүднээс дараах байдлаар уг заалтыг өөрчлөн найруулах: <i>"16.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. Эдгээр хуульд хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр нарийвчлан зохицуулна. Энэхүү хуулиар хөрөнгө оруулагчид олгосон дэмжлэг, бусад таатай нөхцөлийг энд дурдсан бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүй байх нь төрийн байгууллагын зүгээс хөрөнгө оруулагчийн хөнгөлөлт, эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Хөрөнгө оруулагчийн эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд төрийн байгууллага шаардлагатай бүх арга хэмжээг авна."</i></p>	
--	--	--	--

			<p>50. 28.1. Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.</p> <p>28.2. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p> <p>Энэхүү гомдлыг шийдвэрлэх хугацааг хуулийн төсөлд тодорхой заагаагүй байна. Уг заалтад хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр томъёолсон боловч тухайн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хүргүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн байж болзошгүй хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэхгүй байх, тодорхойгүй хугацаагаар хойшлуулах гэх мэт бусад процессын алдаа гарах магадлалтай тул гомдлыг хүлээн авснаас хойш шийдвэрлэх хугацааг тодорхой болгох үүднээс 30 хоногийн дотор саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх байдлаар доорх байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“28.2 Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хүргүүлнэ.”</i></p> <p>51. 28.6. Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална. Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, сайжруулах үүднээс уг заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“28.6. Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа болон хугацааг тогтоосон журмыг Засгийн газар батлах ба журмын хэрэгжилт, хөрөнгө оруулагчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэсэн байдалд холбогдуулан жил тутам хяналт шалгалт хийж тайлан гаргах ба түүнийг нийтэд ил мэдээлнэ.”</i></p>	
23.	Бадрах Энержи ХХК	2023.05.15 2023/168	<p>1. Хуулийн төслийн 2 дугаар зүйлд дараах нэмэлт заалтыг оруулах саналтай байна:</p> <p>“2.3. Хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.4-т зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ:</p> <p>2.3.1. Монгол Улсын олон улсын гэрээ;</p> <p>2.3.2. Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ;</p> <p>2.3.3. энэ хууль,</p> <p>2.3.4. Монгол Улсын бусад хууль;</p> <p>2.3.5. захиргааны хэм хэмжээний акт.</p> <p>2.4. Энэ хуулийн 2.3-т заасан хөрөнгө оруулалтын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл хөрөнгө оруулагчид илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ.”</p>	<p>1. Хууль хэрэглээний хувьд саналд туссан эрэмбээр хэрэгжих боломжгүй. Хуулиас давсан гэрээ байхгүй. Мөн хөрөнгө оруулалтын хууль нь бусад хуулиас давуу үйлчлэх боломжгүй.</p> <p>2. Төслийн 5.1-д заасан хэлбэрээр хөрөнгө оруулсан ч хөрөнгө оруулагчийн хувьд уг хөрөнгө оруулалтын баланс дээр бүртгэх ёстой. Тэр утгаар орсон зохицуулалт. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтоох нь</p>

		<p>Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангахад дээрх нэмэхээр санал болгож буй заалт ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээлбэл, хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хуулиар зохицуулаагүй гэсэн үндэслэлээр хэрэгжүүлэхгүй явж ирсэн асуудлыг энэхүү заалтыг нэмж оруулснаар шийдвэрлэх, мөн Хуулийн төсөлд тусгах татварын болон татварын бус дэмжлэгийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэх юм. Эрх зүйн хэм хэмжээний актуудыг эрэмбэлсэн төсөөтэй заалт Хөдөлмөрийн хуульд мөн байдаг.</p> <p>2. 4.1.1. “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд этгээдэд энэ хуулийн 5.1-т заасан хэлбэрээр оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг; гэж өөрчлөх</p> <p><u>Тайлбар:</u> Энэ нэр томъёо нь Хуулийн төслийн 5, 7.1.1 (хөрөнгө оруулалт хийх хэлбэрийг сонгох эрх, баталгаа)-д заасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Зөвхөн “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг хөрөнгө оруулалт гэж тооцох нь улсын бүртгэлийн газарт тухай бүр хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэх шаардлага үүсгэдэг. Жишээлбэл бизнесийн үйл ажиллагааг нь гадаад дахь толгой компаниас нь хөрөнгө оруулалтаар сар бүр санхүүжүүлдэг ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд сар бүр хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлэх нь бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд боломжгүй юм.</p> <p>3. 4.1.11. “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээний эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг” гэж нэмэх</p> <p>4. 6.1.2. төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, хуульд заагаагүй шаардлага, эс үйлдэхүй, шийдвэрийн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, буруутай байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, хөрөнгө оруулагчийн зөрчигдсөн эрхийг сэргээж, хууль ёсны итгэлийг нь хамгаалж, хөрөнгө оруулагчийн хохирол, үүнд бодит болон эрх зөрчигдсөнөөс үүдэн гарах хохирол, олох ёстой байсан ашиг орлого, алдагдсан боломжийн өртгийг хуульд заасны дагуу төр хариуцан барагдуулна. гэж өөрчлөх</p> <p>Зарим төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрээс болж хөрөнгө оруулагчийн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох, үйл ажиллагааг нь зогсоох гэх мэт ноцтой үр дүнд хүргэхүйц захиргааны шийдвэр гардаг. Иймд буруутай этгээдэд хариуцлага тооцох болон Захиргааны ерөнхий хуулийн гол зарчмуудын нэг болох “хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг хөрөнгө оруулалтын тухай хуульд ил тод тусгаснаар төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа илүү хариуцлагатай болно. Түүнчлэн хохирлыг хэн барагдуулах нь тодорхойгүй байсныг төр хариуцан барагдуулах тухай нэмэлтийг оруулснаар хөрөнгө оруулагчдад бодит хамгаалалт болно.</p> <p>Одоогийн байдлаар төрийн албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гэм хор учруулсан бол гэм хорыг төр хариуцан арилгах тухай жишиг заалт Иргэний хуулийн 498.2- т, мөн түүнчлэн хөдөлмөрийн маргаанаас үүдэлтэй төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх заалт Төрийн албаны тухай хуулийн 50-д зааснаар тус тус мөрдөгдөж байна. Иймд хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг төр барагдуулах нь зүй ёсны</p>	<p>тодорхойгүй байна.</p> <ol style="list-style-type: none"> 3. Тусгасан 4. Агуулгын хувьд тусгасан 5. Алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох асуудал нь ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд хэрэгжих бөгөөд уг асуудлаар зөрчил үүсгэх хэлбэрээр хөрөнгө оруулалтын хуульд тусгахгүй байх нь зүйтэй. Нөгөө талаар алдагдал ирээдүйд шилжүүлэх тооцох асуудал нь татварын хөөн хэлэлцэх хугацаатай уялдах шаардлагатай тул 4 жилээр тогтоодог бөгөөд саналын дагуу 10 жилээр тодорхойлох боломжгүй. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн гааль, НӨАТ-ын дэмжлэгийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2 дахь заалт хэвээрээ бөгөөд энэ нь төлөх ёстой гааль, НӨАТ-ыг 2 жилийн хугацаанд хойшлуулан төлөх боломжийг бий болгосон. 6. Татварын зөвхөн татварын хуулиар зохицуулах зарчмын хүрээнд Хөрөнгө оруулалтын хууль дахь татварын дэмжлэг хэсэг хэрэгждэггүй. Гэхдээ төрөөс уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах өөрчлөлт холбогдох хуульд оруулсан байна. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн гааль, НӨАТ-ын дэмжлэгийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2 дахь заалт хэвээрээ бөгөөд энэ нь төлөх ёстой гааль, НӨАТ-ыг 2 жилийн хугацаанд хойшлуулан төлөх боломжийг бий болгосон. Энэ урамшууллын бодлого хэвээр үйлчилж байгаа. Тодорхой салбар дэмжих бол энэ талын тооцоолол судалгаа шаардлагатай. 7. Агуулгын хувьд тусгасан. 8. Агуулгын хувьд туссан. Хөрөнгө
--	--	--	---

			<p>бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд тусгай хохирол барагдуулах сан байгуулж болох юм.</p> <p>5. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд дараах нэмэлт заалтыг оруулах саналтай байна: 15.1.5. Ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан арван жилийн хугацаанд хасаж тооцох 2013 оны хуулийн 11.1.4-т заасан дэмжлэгийг хэвээр үлдээх саналтай байгаа бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.2-т 10 жилийн туршид (одоогоор 4 жилийн туршид боломжтой) алдагдлыг ирээдүйд шилжүүлэн хасаж тооцохоор өөрчлөлт оруулах саналтай байна. Ашиг олж эхлэхээс өмнө, удаан хугацаанд хөрөнгө оруулалт шаардагдах, уул уурхайн чухал төсөл гэх мэт төрлийн төслийг хэрэгжүүлэхэд энэ нь онцгой ач холбогдолтой байж болох юм.</p> <p>6. 15.1.6. Дор дурдсан тохиолдолд импортлосон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:</p> <ul style="list-style-type: none"> • чухал / стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; • нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; • эрчим хүчний үйлдвэр, төмөр зам, дэд бүтэц барих. <p>Энэхүү дэмжлэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2013 оны хуулийн 11.2-т тусгагдсан бөгөөд Хуулийн төсөлд энэ дэмжлэгийг хэвээр үлдээн, чухал / стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, дэд бүтэц зэргийг нэмэх саналтай байна.</p> <p>7. 15.2. Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг энэ хуулиар зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд журмаар эсхүл татварын тухай хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулна. гэж өөрчлөх</p> <p>8. Хуулийн төслийн 20.3-т заасан “1.5 дахин уртасган” гэснийг “2 дахин” гэж өөрчлөх. Компанийн хэрэгжүүлэх Зөвч-Овоо төслийн хувьд хөрөнгө оруулагчид доод тал нь 30 жилийн хугацаанд татварын орчныг тогтворжуулах шаардлагатай байна.</p> <p>9. 29.1.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд эхний ээлжид хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.</p> <p>10. 29.2.Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлэхээр тохиролцсон тохиолдолд хэлэлцээ хийх хугацаагаа харилцан тохиролцох бөгөөд тохиролцсон хугацаанд багтаан шийдвэрлэж чадаагүй тохиолдолд олон улсын арбитра хандах эрхтэй.</p> <p>29.2.1.гадаадын хөрөнгө оруулагч нь 1965 оны 3 дугаар сарын 18 ны өдөр батлагдсан Улс болон гадаад улсын иргэд хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцод нэгдсэн улсын харьяалалтай тохиолдолд Хөрөнгө оруулалттай холбогдсон маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ХОМШОУТ), эсхүл;</p> <p>29.2.2.НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Олон улсын худалдааны эрх зүйн НҮБ-ын Комиссын арбитраын дүрэм (ЮНСИТРАЛ)-ийн дагуу арбитраын шүүх буюу олон улсын түр арбитра.</p>	<p>орруулалтын гэрээ байгуулахад хамгийн багадаа 20 жилээр гэрээ байгуулах ба хугацааны хувьд хязгаарлалт байхгүй.</p> <p>9. Агуулгын хувьд тусгасан</p> <p>10. Агуулгын хувьд тусгасан</p>
24.	Монцемент билдинг материалс ХХК	2023.04.27	<p>1. Хуулийн төсөлд тодорхой байх, дотоод болон гадаад хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга ёсны зарчмыг оруулах саналтай байна. Зарчмын асуудлыг тусгаж өгөхийн зэрэгцээ аливаа заалтуудыг “болно” “боломжтой” гэдэг байдлаар</p>	<p>1. Агуулгын хувьд тусгасан. Гол нь бусад салбар хуулиар зохицуулагдах асуудлыг Хөрөнгө оруулалтын хуулиар шууд</p>

		<p>биш тодорхой байдлаар буюу үүрэгжүүлсэн байдлаар оруулж өгөх.</p> <p>2./Монгол хэлний тайлбар тольд “дэмжлэг” гэдгийг үг нь илүү бодитой байдлаар тайлбарлагдаж байна. “тус дэм үзүүлэх явдал, бусдын ахуй амьдрал, ажил үйлсийг өөд татах, сайжруулахад туслах мөнгө санхүү, эд зүйл, оюуны дэмжлэг” гэсэн байдаг./</p> <p>15.1.1-15.1.4 хүртэлх заалтууд нь ялангуяа 15.1.1 нь бодитой дэмжлэг үзүүлэх үйлдэл огт байхгүй байна. Татварыг хойшлуулах нь дэмжлэг үзүүлэх явдал биш 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.1, 11.2- дахь заалтыг хэвээр үлдээх</p> <p>/Энэ тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид зөвхөн хамаарахгүйгээр хуульд заасан тухайлсан зохицуулалтын дагуу Тухайлбал Барилгын материалын үйлдвэрлэл барихад импортолсон техник, тоног төхөөрөмжийг 11.2 дахь заалтыг баримтлан гаалийн албан татвараас чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэл хувь бууруулах боломж нь хэвээр хадгалагдана./</p> <p>3. Мөн 15.2-т Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг татварын хууль тогтоомжоор зохицуулна” гэснийг Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын дэмжлэгийг энэхүү хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна” гэж өөрчлөх саналтай.</p> <p>4.Төслийн 4.1.11-т “Татварын хувь хэмжээг тогтворжуулах” -гэж хуульд заасан тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг”- гэдэгт ... тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний... гэж нэмэх</p> <p>5. Төслийн 17.4-т Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд татварын тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлт хамаарахгүй”-гэж заасанд ... “Тогтворжуулах гэрчилгээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд ...” -гэж нэмж оруулах</p> <p>6. Мөн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна.” -гэсний дараа энэхүү заалтад Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчид нэгэн адил үйлчилнэ” гэж нэмэх</p> <p>7. Мөн хуулийн 17 дугаар зүйлд “Хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд хуулийн 18.1-т заасан тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-иас тусгайлан эрх олгосон тохиолдолд, тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар татварын хувь, хэмжээг тогтоож болно.” гэж нэмэх</p> <p>Дагалдах хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухайд:</p> <p>8. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11-р зүйлд “11.3-т Барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортолсон техник, тоног</p>	<p>зохицуулах боломжгүй тул боломжит зохицуулалтыг дурдах нь зүйтэй.</p> <p>2. Татварын зөвхөн татварын хуулиар зохицуулах зарчмын хүрээнд Хөрөнгө оруулалтын хууль дахь татварын дэмжлэг хэсэг хэрэгждэггүй. Гэхдээ төрөөс уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах өөрчлөлт холбогдох хуульд оруулсан байна. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн гааль, НӨАТ-ын дэмжлэгийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2 дахь заалт хэвээрээ бөгөөд энэ нь төлөх ёстой гааль, НӨАТ-ыг 2 жилийн хугацаанд хойшлуулан төлөх боломжийг бий болгосон. Энэ урамшууллын бодлого хэвээр үйлчилж байгаа. Тодорхой салбар дэмжих бол энэ талын тооцоолол судалгаа шаардлагатай.</p> <p>3. Татварын ерөнхий хуулийн 4.1-д хөрөнгө оруулалтын хуульд заасан татвар тогтворжуулах дэмжлэгийг хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу эдлэхээр заасан.</p> <p>4. Агуулгын хувьд тусгасан</p> <p>5. Агуулгын хувьд тусгасан.</p> <p>6. Агуулгын хувьд тусгасан.</p> <p>7. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар татвар тогтворжуулах асуудал тусгасан. Харин татварын хувь хэмжээг өөрчлөн тогтоох эрх хэмжээг олгоогүй.</p> <p>8. Тодорхой салбар дэмжих бол энэ талын тооцоолол судалгаа шаардлагатай.</p> <p>9. Тодорхой салбар дэмжих бол энэ талын тооцоолол судалгаа шаардлагатай.</p> <p>10. Агуулгын хувьд тусгасан. Татварын ерөнхий хуулиар энэ эрх нээлттэй.</p> <p>11. Агуулгын хувьд тусгасан. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулсан.</p> <p>12. Холбогдох маргаан нь зөвхөн татвартай холбоотой маргаан байх боломжгүй тул хөрөнгө оруулалтын маргаан гэснийг</p>
--	--	---	---

			<p><u>төхөөрөмж</u>, импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татвар тооцох үнэлгээнд 0-10 хувиар ногдуулна.</p> <p>9. 11.4-т <u>Барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортолсон техник, тоног төхөөрөмж</u>, импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татварын хувийг энэ хуулийн 11.3-т заасан хязгаарт багтаан салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно” гэж нэмэх</p> <p>10. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль</p> <p>“35.6.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээ, <u>Хөрөнгө оруулалтын гэрээтэй</u> бол уг <u>гэрээ</u>, гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө” гэж нэмэх</p> <p>11. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг буцаан хэрэглэх зохицуулалтыг шинээр тусгах “Шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын хууль нь Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийг буцаан хэрэглэнэ” гэж нэмэх</p> <p>12. 4.1.15-д “Хөрөнгө оруулалтын маргаан гэж хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллага болон хөрөнгө оруулагч нарын хооронд үүссэн болон хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, холбогдох татварын хуулиудтай энэ хуулийн заалт зөрчилдсөнөөс хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирснаас бий болсон маргааныг хэлнэ.” гэж маргааны агуулгыг тодотгон оруулах</p>	саналын дагуу тодорхойлох нь бусад асуудлаар үүсгэх маргааныг хязгаарлах эрсдэлтэй байна.
25.	Хөшигийн хөндийн захиргаа	2023.05.15 01/32	<p>1. Дөрөвдүгээр бүлэгт дараах зүйлийг нэмэх “Хөрөнгө оруулалтын талаар чөлөөт бүсийн удирдлагын хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компанийн чиг үүрэг” 12.1. Чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компани дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1. чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх; 12.1.2. чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах; 12.1.3. хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх; 12.1.4. хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх.</p> <p>2. Дараах 2 заалтыг нэмж оруулах 24.8. Хөрөнгө оруулагч нь чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийх хүсэлтийг чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компанид гаргана. 24.9. Чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компани нь хүсэлтийг хянан үзээд холбогдох хууль тогтоомжид заасан татгалзах үндэслэл тогтоогдоогүй бол Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээнд урих талаар Засгийн</p>	<p>1.Чөлөөт бүс нь бие даасан хуультай бөгөөд уг хуулийн хүрээнд чөлөөт бүсийн асуудлыг хариуцсан төрийн байгууллага нь чиг үүргээ тогтооно. Харин хөрөнгө оруулалтын бодлогын хувьд Засгийн газрын тухай хуульд зааснаар эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарах тул уг асуудлаар хууль хоорондын зөрчил үүсэхээр байна.</p> <p>2.хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг нээлттэй, ил тод, чөлөөтэйгөөр шийдвэрлэх нь хөрөнгө оруулалтын хуулийн нэг зорилт. Иймд хөрөнгө оруулалт хийхийн тулд зөвшөөрөл авах нь хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.</p> <p>3-10.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу өөрчлөх асуудал биш бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэснээр дээрх зохицуулалтыг бий болгох эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна.</p>

			<p>газарт танилцуулж, зөвшөөрөл авна.</p> <p>Дагалдах хуулиудад оруулах саналууд</p> <p>3. Газрын тухай хуульд 22.1-р зүйлийн гарчгийг “Чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх Төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн бүрэн эрх” гэж өөрчлөх</p> <p>Чөлөөт бүсийн тухай хуульд</p> <p>4. 7.1.6, 7.1.7, 7.1.10 заалтуудыг хасах</p> <p>5. 7-р зүйлийг дараах байдлаар өөрчлөх 7 дугаар зүйл. Чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх Төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ, түүний бүрэн эрх 7.1. Чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх Төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.</p> <p>6. 6.4. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компани байгуулах асуудлыг Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>7. 6.5. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах, чөлөөт бүсийн удирдлагыг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой компани байгуулах асуудлыг энэ хуулийн 6.4-т зааснаас гадна хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл бий болсон тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.</p> <p>8. 8.4, 8.5, 8.6 заалтуудыг хүчингүй болгох</p> <p>9. Дараах заалтуудыг нэмэх: 8.7.4. Чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжид заасан журмаар батлуулах, ерөнхий төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 8.7.12. чөлөөт бүс дэх төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах 8.7.13. чөлөөт бүсэд зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийг удирдлагаар хангаж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих</p> <p>10. 15.2-ын “орлого бүхий” гэснийг хасах</p>	
26.	Б.Мягмардорж	2023.05.03	<p>1. Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёоны тухай: Төсөлд “хөрөнгө оруулагч”, “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж”, “хөрөнгө оруулагч хуулийн этгээд” (жишээлбэл, 4.1.12, 20.1, 20.3.2, 21.1), “төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээд”</p>	<p>1. Хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал нь хөрөнгө оруулсан этгээд хүлээсэн авсан этгээдийн хувьд ч хамаарах бөгөөд үүнийг</p>

		<p>(жишээлбэл, 22.2) гэх зэргээр ялгаатай нэр томъёог хэрэглэсэн байна. Төслийн 7, 8 дугаар зүйлд мөн “хөрөнгө оруулагчийн эрх”, “хөрөнгө оруулагчийн үүрэг” гэх байдлаар хөрөнгө оруулагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон хэдий ч эдгээр эрх, үүргүүд зарим нь хөрөнгө оруулагчид шууд хамаарах бол зарим нь хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй (гадаадын) хөрөнгө оруулалттай аж, ахуй нэгжид хамааралтай эрх, үүргүүд байна.</p> <p>Санал: Иймд, төсөлд хэрэглэсэн нэр томъёоны систем, уялдаа холбоо, оновчтой байдлыг дахин нягтлах, шаардлагатай бол хөрөнгө оруулагчид хамаарах эрх, үүргийг алийг нь хөрөнгө оруулагч өөрөө эдлэх, хүлээх, алийг нь хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулсан хуулийн этгээд эдлэх, хүлээхийг тодорхой ялган зааглах нь хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал үүсгэхгүй байх ач холбогдолтой байна. Түүнчлэн, хөрөнгө оруулагч энэ хууль заасан эрхээ шууд болон хөрөнгө оруулсан хуулийн этгээдээрээ дамжуулан эдэлж болно гэх төслийн 7.1.12-т нэмэлтээр шинээр оруулах боломжтой гэж үзэж байна.</p> <p>2.Төслийн 3.1 дэх хэсгийн тухай буюу хуулийн үйлчлэх хүрээний тухайд: Уг хэсэгт “Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчаас хийж байгаа хөрөнгө оруулалтад хамаарна” гэх агуулгаар тодорхойлж, хуулиар зохицуулах асуудлын хүрээ, хязгаарыг тогтоож өгчээ. Харин, төслийн агуулгыг харвал энэ хууль нь хөрөнгө оруулалт хийсний дагуу аж ахуй нэгжээр эрхлэн явуулж буй үйл ажиллагаанд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг зэрэг болон бусад харилцаа буюу үйл ажиллагаанд хамаарах агуулгатай байна.</p> <p>Санал: Иймд, уг хууль хамаарч үйлчлэх харилцааны хүрээнд “хөрөнгө оруулалтын дагуу явуулж буй үйл ажиллагаа” гэж нэмж оруулах нь зүйтэй байна.</p> <p>3.Төслийн 4.1.5 заалтын тухай буюу гадаадын хөрөнгө оруулагчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийн хамгийн бага хэмжээний тухайд: Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэж тооцохтой холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө оруулалтын босго хувь хэмжээг байхгүй болгосон нь хамтарсан компани байгуулах дотоодын хөрөнгө оруулагчдад ирэх хөрөнгө оруулах үүргийн хүндрэлийг байхгүй болгох ач холбогдолтойг ойлгож байна. Харин, ийнхүү хөрөнгө оруулалтын хувь хэмжээг байхгүй болгохдоо компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн босго хэмжээ тавих нь зүйтэй болов уу гэж харж байна. Учир нь, 1,000 төгрөгийн хувь нийлүүлсэн компани байгуулаад, түүний 25% буюу түүнээс дээш хувийн хувьцааг гадаадын иргэн эзэмших тохиолдолд энэ нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж гэж тооцогдож, улмаар гадаадын хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдэд олгох татварын болон татварын бус дэмжлэгтэй холбоотой эрхийг эдлэх гэхийг үгүйсгэхээргүй байна.</p> <p>Санал: Иймд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хуульчлан шинэчилсэн найруулгын төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.</p> <p>4. Төслийн 24.1 дэх хэсгийн тухай буюу Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах эрхтэй субъектийн тухай болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтийн дагуу гэрээ байгуулах Засгийн газрын үүргийн тухайд: 4.1.Одоогийн хуулийн 20.1 дэх хэсэг буюу төслийн 24.1 дэх хэсгийн тухай: Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.1 дэх хэсгээр</p>	<p>ялган хуульчлах нь ач холбогдол багатай бөгөөд асуудлын зохицуулалтын хүрээг хязгаарлах эрсдэлтэй. Хуулиар оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудалд илүүтэй анхаарна.</p> <p>2. Агуулгын хувьд тусгасан</p> <p>3. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгын хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн босгыг хязгаарлалтыг авах нь энэ хуулийн үндсэн үзэл баримтлал болно.</p> <p>4. Тусгасан</p> <p>5. Агуулгын хувьд тусгасан</p> <p>6. дагаж мөрдөх журмын төслийг боловсруулсан.</p> <p>7. Газрын тухай хуульд газар ашиглахтай холбоотой асуудал нь Хөрөнгө оруулалтын тухай хуультай нийцэх учиртай. Иймд нийцлийг хангасан.</p> <p>8. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд хамаарах зохицуулалт байна. Энэ талаар хууль хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийгээгүй тохиолдолд энэ хуулийн үйлчлэл өөрчлөх боломжгүй.</p>
--	--	---	---

		<p>Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үүрэгтэй байсан буюу энэ нь 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчийн хувьд тогтвортой байдлын баталгаа олгож байсан.</p> <p>Харин, энэ заалтыг шинэчилсэн найруулгын төслийн 24.1 дэх хэсэгт “Засгийн газар ... Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно” гэж нээлттэй болгосон нь хөрөнгө оруулагчдад олгох тогтвортой байдлын баталгаа үгүй болгож байгаа бөгөөд хөрөнгө оруулалт татахад сөрөг ач холбогдол үүсгэхээр байна.</p> <p>Санал: Иймд, Засгийн газраас шаардлага хангасан хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах баталгаа олгож буй одоогийн хуулийн 20.1 дэх хэсгийг хэвээр нь үлдээх буюу шинэчилсэн найруулгад агуулгаар нь тусгай оруулах нь зүйтэй байна.</p> <p>4.2. Одоогийн хуулийн 20.5 дахь хэсэг буюу Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах эрхтэй субъектийн тухай:</p> <p>Шинэчилсэн найруулгын төсөлд одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.5 дахь хэсгийг хасахаар тусгасан нь тус заалтын дагуу Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах боломжтой байсан хөрөнгө оруулагчдын эрх зүйн байдлыг дордуулахаар байна.</p> <p>Шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулагч Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах тухай асуудлыг зохицуулсан 24.1 гэх нэг л хэсэг байна.</p> <p><i>“24.1. Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.”</i></p> <p>Харин, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлттэй холбоотой хоёр хэсэг байдаг.</p> <p><i>“20.1. Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна.”</i></p> <p><i>“20.5. 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт бүхий тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь өөрөө хүсэлт гаргавал түүнтэй Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.”</i></p> <p>Өөрөөр хэлбэл, Хөрөнгө оруулалтын гэрээ хийх хүсэлт гаргах эрхтэй дараах 2 субъектүүд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийх гэж байгаа хөрөнгө оруулагч буюу хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө хүсэлт гаргах субъект. 2) 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт бүхий тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд буюу хөрөнгө оруулалтаа хийсэн эсхүл хийх хугацаа нь үргэлжилж яваа тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд байна. <p>Харин, одоогийн хуулийн 20.5 дахь хэсгийг хасаж, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах тухай асуудлыг зөвхөн шинэчилсэн найруулгын 24.1 дэх хэсэгт зааснаар зохицуулна гэвэл одоогийн хуульд тусгасан Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах эрх бүхий 2 дахь субъект нь Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах боломжгүй болохоор байна.</p> <p>Санал: Иймд, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулахаар хуулийг шинэчлэн найруулахдаа одоогийн хуульд тусгасан хөрөнгө 500 тэрбумаас дээш хөрөнгө оруулалтын дүн бүхий хөрөнгө оруулалт тогтворжуулах гэрчилгээтэй хөрөнгө оруулагчдын эрх зүйн</p>	
--	--	--	--

		<p>байдлыг дордуулахгүй байх зарчмын хүрээнд одоогийн хуулийн 20.5 дахь хэсгийг шинэчилсэн найруулгад хэвээр нь оруулах буюу үлдээх нь зүйтэй байна.</p> <p>5. Хөрөнгө оруулалтын тухай болон хөрөнгө оруулагчтай холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжоор хөрөнгө оруулагчид эдлүүлж буй тусгай эрхийг төрийн шат шатны байгууллагаас бүдүүлгээр зөрчихгүй байх баталгааны тухайд: Шат, шатны төрийн байгууллагууд болон нутгийн захиргааны байгууллагууд хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн талаар мэдлэггүйгээс болж уг харилцааг тусгайлан зохицуулсан хууль болох хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулагчид олгосон/эдлүүлж буй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн буюу зөрчсөн шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах тохиолдол байдаг. Ийнхүү зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхэд хандан сэргээлгэхийн тулд хөрөнгө оруулагч багагүй цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулдаг. Санал: Иймд, хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжоор тусгайлан зохицуулсан хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой (ялангуяа, сөрөг нөлөөтэй) шийдвэр, үйл ажиллагаа гаргахдаа холбогдох шатны төрийн байгууллагууд болон нутгийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсхүл хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас санал, дүгнэлт авдаг байх баталгааг энэ хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж баталгаажуулах нь зүйтэй.</p> <p>6.Шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх журмын тухайд: Санал: Хуулийг шинэчлэн найруулсантай холбоотой ийнхүү шинэлэн найруулахаас өмнө хөрөнгө оруулагчдад олгосон аливаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй байх баталгаа, тогтвортой байдлыг хангах үүднээс одоогийн хуулиар тогтворжуулах гэрчилгээ авсан, тогтворжуулах гэрээ байгуулсан болон бусад эрх, хууль ёсны ашиг сонирхлоо баталгаажуулсан хөрөнгө оруулагчдын эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа заалт нь буцаж үйлчлэхгүй байх баталгааг тусгасан заалтыг шинэчилсэн найруулгын төсөлд оруулах, эсхүл шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх журмын тухай хуулиар зохицуулж өгөх.</p> <p>Дагалдах хуулийн төслийн тухайд: 7. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1-р заалтын тухайд: Тус заалтад Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар тусгажээ. Гэтэл, тус заалтын одоо хүчин төгөлдөр үйлчилж буй найруулгыг шүүхээс Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 302 дугаар тогтоол буюу “Газрын тухай хуулийн 44.5-д заасныг үндэслэн Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжид ... газар ашиглуулах хугацааг 30 жил ... байхаар тогтоосугай” гэсэн тогтоолтой холбон тайлбарлаж хэрэг, маргааныг шийдвэрлэх тохиолдол байдаг. Санал: Иймд, уг 44.5 дахь хэсгийг өөрчлөн найруулах нь ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэх эрсдэлтэй тул Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах заалтыг 44.51 гэх зэрэг байдлаар юм уу эсхүл өөр тохиромжтой байдлаар дугаарлах байдлаар нэмж оруулан, тус 44.5 дахь хэсгийг хэвээр нь үлдээх нь хууль зүйн техникийн хувьд зүйтэй, ач</p>	
--	--	---	--

			<p>холбогдолтой гэж үзэж байна.</p> <p>Бусад: 8.Гадаадын хөрөнгө оруулагч үнэ, төлбөр тооцоог гадаад валютаар илэрхийлэх, гүйцэтгэх боломжийг хязгаартайгаар тогтоох хэрэгцээ, шаардлагын тухайд: Гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгөөр оруулж буй хөрөнгө оруулалт нь ямагт гадаад валютаар байдаг бөгөөд дийлэнхдээ америк доллар, хятадын юань зэрэг байдаг. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүд нь гол төлөв хөрөнгө оруулалттай төсөл, бизнесээ өргөжүүлэх хүрээнд гадаад валютын зээл авсан байх нь түгээмэл. Гэтэл, Монгол төгрөгийн эдгээр валюттай харьцах ханш нь тогтмол суларч байдгаас гадна тус хөрөнгө оруулагч нь Монгол Улсад эрхэлж буй аливаа бизнесийн үйл ажиллагааны төлбөр, үйлчилгээний үнэ, тарифаа Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн дагуу зөвхөн төгрөгөөр илэрхийлэхээс өөр аргагүй болдог. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт, зээл нь гадаад валютаар илэрхийлэгдсэн ч, үйл ажиллагаа, үйлчилгээнээс олж буй орлого нь зөвхөн төгрөгөөр илэрхийлэгдэхээс аргагүй байгаагийн улмаас хөрөнгө оруулагчид ханшийн зөрүүнээс шалтгаалан багагүй алдагдал хүлээдэг. Санал: Иймд, гадаадын хөрөнгө оруулагчдыг ядаж тодорхой хүрээ (тухайлбал, зөвхөн үндсэн үйл ажиллагаандаа гэх зэргээр болон бусад байдлаар), хязгаартайгаар гадаад валютаар үнэ илэрхийлэх, төлбөр хүлээн авах буюу гүйцэтгэхийг зөвшөөрөх нь хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын таатай, тогтвортой орчин бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.</p>	
27.	М.Мөнхнаран	2023.05.18	<p>Хөрөнгө Оруулалтын тухай Хуулийн Төслийн 10 дугаар бүлэг буюу 29 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх талаар заалтуудыг оруулжээ. Хэдий маргаан шийдвэрлэх асуудлыг анхааран авч үзэн нэг бүлэг болгон бэлтгэсэн нь сайшаалтай ч маргаан шийдвэрлэх заалтууд энэ маягаараа батлагдвал дараагаар хуулийг хэрэглэх явцад хоёр үндсэн бэрхшээл тулгарах магадлалтай байна. Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтын маргааны талуудын хооронд байгуулагдсан арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдал буюу талуудын маргаан шийдвэрлэх арбитрын байгууллагыг сонгон хийсэн хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдал үүсгэхээр байна. Учир нь хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш 3 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дараах олон улсын гэрээний дагуу арбитрт хандах эрхтэй: 29.2.1. Гадаадын хөрөнгө оруулагч нь 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Улс болон гадаад улсын иргэд хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцид нэгдсэн улсын харьяалалтай тохиолдолд Хөрөнгө оруулалттай холбогдсон маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ХОМШОУТ), эсхүл; 29.2.2. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Олон улсын худалдааны эрх зүйн НҮБ-ын Комиссын арбитрын дүрэм (ЮНСИТРАЛ)-ийн дагуу арбитрын шүүх буюу олон улсын түр арбитр.” хэмээн заасан байх ба энэ нь нэгэнт өөр арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохирсон талууд (жишээ нь Монгол Улсын Засгийн Газар болон Айвенхоу Майнз Монголия Инк Ххк, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед Компани хооронд байгуулагдсан Оюу Толгой Төслийн Хөрөнгө оруулалтын гэрээнд талууд Лондонгийн Олон Улсын Арбитрын Шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр тохирсон байдаг)</p>	<p>1. Агуулгын хувьд тусгасан 2. Агуулгын хувьд тусгасан</p>

		<p>хуулийн заалтыг үндэслэн Хөрөнгө оруулалттай холбогдсон маргааныг шийдвэрлэх олон улсын төв буюу ICSID-д хандах мөн боломжтой мэт байх нөхцөл байдлыг үүсгэх магадлалтай юм. ICSID-н конвенцийг ашиглана гэдэг нь өөрөө маргаан ICSID-н харьяаллын болно гэсэн үг бөгөөд хэдий "эрхтэй" гэж заасан ч энэ талаар ирээдүйд талуудын хооронд харьяаллын маргаан үүсэж арбитрын ажиллагааг сунжруулах зэрэг асуудалд хүргэх боломжтой гэдгийг анхаарах нь зүйтэй болов уу?</p> <p>Түүнчлэн энэ маягаар талуудын өөртөө засах эрхийн хүрээнд буюу парти автономи эрхийн хүрээнд гэрээгээр зохицуулагдах асуудлыг авч үзэн 3 сарын дотор эвлэрэхээр оролдохыг дурдах, хэрэглэх арбитрын дүрмийг дурдах зэргээр маргаан шийдвэрлэх заалтаар зохицуулагдах харилцааг хуульд нарийн оруулах нь төдийлөн оновчгүй билээ.</p> <p>Хоёрдугаарт, төслийн 29 дүгээр зүйлийн 29.3-т "Гадаадын хөрөнгө оруулагчид болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу Монгол Улсын арбитр, түүнчлэн гадаадын арбитрт хандан шийдвэрлүүлж болно. Хэрэв ийм арбитрын хэлэлцээргүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ." хэмээн заажээ. Хэдий гадаадын хөрөнгө оруулагч болоод Монгол Улсын иргэн, хуулийн этгээд хоорондын маргаанд талуудын маргаан шийдвэрлэх хэлбэрийг чөлөөтэй сонгох эрх буюу парти автономи эрх мэдлийн хүрээн дэх эрхийн асуудлыг дурдсан нь сайшаалтай ч арбитрын хэлэлцээргүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ гэснээр зөрчилдөөний эрх зүйн хүрээнд хөрөнгө оруулагчийн улсын хууль тогтоомж хэрэглэгдэхээр тодорхойлогдсон нөхцөлд хэрэглэх боломжгүй болох нөхцөл байдлыг үүсгэх аюултай байж болох юм.</p> <p>Гадаадын хөрөнгө оруулагч тухайн маргаанд нэхэмжлэгч хариуцагчийн аль нь байх, мөн ямар төрлийн гэрээ байгуулсан, ямар харилцаа байсан, тухайн үед хаана оршин байснаас шалтгаалан өөр, өөр улсын хууль хэрэглэх асуудал гарч ирэх ба зарим тохиолдолд МУ-н хууль тогтоомжоос илүү зөрчилдөөний эрх зүйгээр заагдсан гадаадын хөрөнгө оруулагчийн орны хууль тогтоомжийг хэрэглэх нь маргааны талуудад илүү ашигтай байх боломжтой байдаг. Мөн 29 дүгээр зүйлийн 29.3-т маргаан шийдвэрлэх харьяаллын асуудлыг тодотгон арбитраар шийдвэрлэх боломжтой талаар дурдсан хэр нь дараагийн өгүүлбэрт залгаад "арбитрын хэлэлцээргүй бол МУ-н хууль тогтоомжоор шийдвэрлүүлнэ" хэмээн хэрэглэх хуулийн талаар дурдсан нь логикийн хувьд төдийлөн уялдаагүй байна. Иймд тус заалтыг өөрчлөх шаардлагатай байна.</p> <p>Харин гадаад улс орнуудын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж дахь маргаан шийдвэрлэх талаарх зохицуулалтуудыг судалбал, Бүгд Найрамдах Турк Улсын Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалтын тухай 2003 оны 4875 дугаартай хуулийн 3 дугаар зүйлийн (е) хэсэгт маргаан шийдвэрлэх талаарх заалт байдаг ч хөрөнгө оруулалтын маргааны талуудын маргааныг шүүхээр эсвэл арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхээр тохиролцон сонгох ерөнхий суурь эрхийн талаар дурдсанаас2 бус энэ талаарх хэрэглэх хууль, арбитрын дүрэм, эвлэрэн хэлэлцэхээр оролдох хугацаа зэргээр талуудын парти автономи буюу өөртөө засах эрх мэдлийн хүрээнд тохирох боломжтой асуудлуудыг зохицуулахаар оролдоогүй байх юм.</p> <p>Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг сүүлийн жилүүдэд ихээр татах болсон Бүгд Найрамдах Казакстан Улсын Хөрөнгө Оруулалтын тухай 2003 оны (2014 онд нэмэлт өөрчлөлт орсон) хуульд талууд эвлэрэн хэлэлцэж чадаагүй нөхцөлд маргааныг олон улсын гэрээ, конвенц болон Казакстан Улсын хууль тогтоомжийн дагуу дотоодын шүүхээр шийдвэрлүүлнэ, мөн маргааныг талуудын тохиролцсон олон улсын арбитрын байгууллагаар</p>	
--	--	---	--

			<p>шийдвэрлүүлнэ хэмээн хөрөнгө оруулалтын маргааны талуудын маргаан шийдвэрлүүлэх арга хэлбэрээ чөлөөтэй сонгох талаар суурь ерөнхий зохицуулалтыг дурдан энэ талаар нарийн зохицуулалт хийхээр оролдоогүй байх юм. 3 Харин тус хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хөрөнгө оруулалтын маргаанд хамаарахгүй маргаан нь Казакстан улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэнэ гэж заажээ.4</p> <p>Ерөнхийд нь эцэслэн дүгнэхэд талуудын өөртөө засах эрхийн хүрээнд буюу парти автономн эрхийн хүрээнд гэрээгээр зохицуулагдах асуудлыг авч үзэн 3 сарын дотор эвлэрэхээр оролдохыг дурдах, хэрэглэх арбитрын дүрмийг дурдах зэргээр маргаан шийдвэрлэх заалтаар зохицуулагдах харилцааг хуульд нарийн оруулах нь төдийлөн оновчгүй, мөн зарим тохиолдолд МУ-н хууль тогтоомжоос илүү зөрчилдөөний эрх зүйгээр заагдсан гадаадын хөрөнгө оруулагчийн орны хууль тогтоомжийг хэрэглэх нь маргааны талуудад илүү ашигтай байх боломжтой байдаг тул гадаадын хөрөнгө оруулагч болоод Монгол Улсын иргэн, хуулийн этгээд хооронд арбитрын хэлэлцээр байгуулагдаагүй нөхцөлд маргааныг МУ-н хууль тогтоомжоор шийдвэрлэнэ гэж заах нь зүйтэй эсэх нь эргэлзээтэй байх юм. Иймд хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх асуудлыг ерөнхий зарчмын шинжтэй байдлаар тусган 29 дүгээр зүйлийг өөрчлөх шаардлагатай байна. Ингэхдээ доорх хэлбэрээр өөрчилж болох юм:</p> <p>29.1. Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба талууд маргаан шийдвэрлэх хэлэлцээрээр тогтоосон хугацаанд хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй эсвэл хэлэлцээрээр тохиролцоогүй ч цаашид эвлэрэн хэлэлцэх боломжгүй хэмээн талуудын аль нэг үзсэн тохиолдолд маргааныг талуудын тохиролцсон олон улсын арбитрын байгууллагаар эсвэл ад хок арбитраар шийдвэрлүүлэх ба арбитрын хэлэлцээр талуудын хооронд байгуулагдаагүй тохиолдолд холбогдох зөрчилдөөний эрх зүйн хүрээнд дотоодын шүүхээр олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийг ашиглан маргааныг шийдвэрлүүлнэ.</p> <p>29.2. Гадаадын хөрөнгө оруулагчид болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцсон арбитрын байгууллага эсвэл ад хок арбитра хандан шийдвэрлүүлэх ба арбитрын хэлэлцээргүй нөхцөлд маргааныг зөрчилдөөний эрх зүйн хүрээнд дотоодын шүүхээр холбогдох олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийг ашиглан шийдвэрлэнэ.</p>	
28.	Г.Алтанхуяг “Монгол Газрын Тос Боловсруулах Үйлдвэр” ТӨХХК Геологич	2023.05.24	<p>Үндсэн үзэл санаа: Олон улсын стандарт, журам = Монголын Хөрөнгийн Бирж = Хөрөнгө оруулалт</p> <p>1. Энэхүү хууль нь Монгол орны эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлэхүйц томоохон орд газруудыг дарамт, хүнд суртал багатай, алсыг харсан, компаниудад тэгш боломж олгосон, холбогдох журам, стандартууд нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын шаардлагад нийцсэн, нээлттэй ил тод, олон улсын эрх зүйн баримт бичгүүдтэй дүйцсэн тийм хууль болоосой гэж хүсэж байна.</p> <p>2. Сүүлийн үед үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчид нь хаалттай хувийн компаниудад шууд хөрөнгө оруулалт хийхээсээ илүү аль нэг хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй, олон нийтийн компанид (public-listed company) хөрөнгө оруулах сонирхол нэмэгджээ. Тийм учраас Монголын эрдэс баялаг, геологи, уул уурхай болон бусад салбарт</p>	<p>1. Хуулийн төслийн талаар сэтгэгдэл бичсэн.</p> <p>2, 3 Шууд бус хөрөнгө оруулалт нь зохицуулалттай зах зээлийн зарчмаар явдаг. Энэ нь хөрөнгө оруулалтын хуульд хамаарахгүй.</p> <p>4. Сэтгэгдэл</p> <p>5. Сэтгэгдэл</p> <p>6. Сэтгэгдэл</p> <p>7. Сэтгэгдэл</p> <p>8. Сэтгэгдэл</p> <p>9. Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтийн талаар холбогдох хуулийн</p>

		<p>хөрөнгө оруулалт татах хамгийн боломжит эх үүсвэр нь Монголын Хөрөнгийн Бирж (МХБ), үндэсний хөрөнгө оруулалтын сангууд болох төлөвтэй байна. Хөрөнгө оруулалтын орчныг МХБ-ийн үйл ажиллагаатай уялдуулах, дэмжих чиглэлд анхаарах нь зүйтэй болов уу.</p> <p>3. Монголын томоохон банкнууд, хөрөнгө оруулалтын сангууд, хүнсний үйлдвэрүүд, санхүүгийн байгууллагууд, технологийн компаниуд ар араасаа МХБ-д хувьцаа гаргаж, олон нийтийн хувьцаат компаниуд болсоор байна. Жишээлбэл, тус биржээс 100 тэрбум гаруй төгрөгийг богино хугацаанд татан төвлөрүүлж чадаж байгаа нь Монголд үндэсний хөрөнгө оруулагчид чадамжтай болсны баталгаа. Хөрөнгө оруулагчид Монголд үйл ажиллагаа явуулж байгаа хайгуулын, уул уурхайн компаниуд гэлтгүй бүхий л салбарын МХБ-д бүртгэлтэй ХК-тай хамтран ажиллах хандлагатай байна. Мөн биржээс хөрөнгө оруулалт татах боломжтой болж байгаа тул энэхүү хуулийн үндсэн үзэл санаа хөрөнгийн зах зээл рүү чиглээсэй гэж хүсэж байна.</p> <p>4. Мөн сүүлийн үед гадаадын хайгуулын компаниуд МХБ-д бүртгүүлж хайгуулын төсөлдөө санхүүжилт татаж чадаж байна. Жишээлбэл Канадын Erdene Resources Development Corporation (Эрдэнэ Монгол ХХК) нь МХБ-д давхар бүртгэлтэй компани болж Монголын хөрөнгө оруулагчид уг төсөлд хөрөнгө оруулж, хувьцаа эзэмших боломжтой болсон. Улмаар 2023 онд “Энержи Ресурс” компани уг компанийн Баянхонгор аймаг дахь Баян-Хөндийн алтны ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар боллоо.</p> <p>5. “Энержи Ресурс” ХХК нь 2010 онд Hong Kong-ийн хөрөнгийн (HK) биржид анх бүртгүүлж хувьцаат компани болж анхны хөрөнгө оруулалтаа хөрөнгийн биржээс амжилттай татсан түүхтэй. Хөрөнгийн бирж, хөрөнгө оруулагчдын шаардлага, олон улсын стандартыг нэвтрүүлсэний ачаар дээрх компаниудын засаглал, үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй болж, компанийн ашиг, орлого нэмэгдэж Монголын эдийн засагт чухал нөлөөг үзүүлсээр иржээ.</p> <p>6. Дэлхийн дээрх хамгийн том хөрөнгө оруулалтууд зөвхөн хөрөнгийн биржээр дамжин хийгддэг. <i>Дэлхийн хамгийн том геологи, уул уурхайн компаниуд бүгд нээлттэй, олон нийтийн хувьцаат компани бөгөөд тухайн бүс нутгийн хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалтаа татаж байна. Оюу толгойн 64%-ийг эзэмшиж байгаа “Рио тинто” компани нь АНУ (NYSE), Австрали (ASX), Торонто (TSX), Лондонгийн хөрөнгийн биржэд (LSX) бүртгэлтэй.</i></p> <p>7. Энэхүү хуулийн шинэчлэлээр олон улсын стандартуудыг нэвтрүүлсэн реформийн чанартай, үндэсний болон ОУ-ын томоохон хөрөнгө оруулагчидтай нэг хэлээр ойлголцдог, стандарт, дүрэм журамтай болбол Монгол улсын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт орж ирэх маш том боломж бүрдэнэ гэж харж байна.</p> <p>8. Мөн түүнчлэн энэхүү хуулийн үзэл санаа нь бүх салбарын компаниудыг гадаад, дотоод, том, жижиг, хөрөнгө, чадамжаар нь ялгалгүй, бүх компаниудад тэгш боломж олгох тал дээр анхаарах нь зүйтэй. Жижиг хайгуулын компаниуд дэлхийн том ордыг нээсэн түүх дэлхий</p>	<p>хэрэгжилтэд дүгнэлт өгснөөр хэрэгжүүлэх нь зүйтэй.</p> <p>10. Сэтгэгдэл</p> <p>11, 12, 13. Шууд бус хөрөнгө оруулалт нь зохицуулалттай зах зээлийн зарчмаар явдаг. Энэ нь хөрөнгө оруулалтын хуульд хамаарахгүй.</p> <p>14. Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтийн талаар холбогдох хуулийн хэрэгжилтэд дүгнэлт өгснөөр хэрэгжүүлэх нь зүйтэй.</p>
--	--	---	--

		<p>дээр маш олон байдаг. <i>Дэлхий дээр нээгдээд байгаа ашигт малтмалын ихэнх ордуудыг жижиг хайгуулын компаниуд нь илрүүлж, том компаниуд нь ашиглаж ирсэн дэлхийн туршлага Монголд давтагдсан. Жишээлбэл: Оюу толгойн зэс-алтны ордыг Канадын жижиг хайгуулын (junior) компани болох Айвенхоу Майнз нээсэн хэдий ч одоо төслийн 66%-ийг Риотинто (World#2) компани эзэмшиж байна. Тийм учраас Монголд үйл ажиллагаа явуулж буй жижиг хайгуулын компаниудад орд нээх боломж одоо хүртэл байгаа, иймд тэдгээрийг дэмжсэн хөрөнгө оруулалтын орчин илүү сайжраасай гэж хүсэж байна.</i></p> <p>9. Нэг талаасаа уул уурхайг дэмжсэн “Хөрөнгө оруулалтын тухай” хууль гарч байгаа хэдий ч нөгөө талаасаа Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэгдүүлж байгаа нь эргээд аж ахуйн нэгжүүдэд дарамт болж, улмаар жижиг компаниуд шахагдаж зөвхөн том монопол компаниудад давуу эрх очих магадлалтай болж байгаа. Үүнээс харахад Хөрөнгө оруулалтын тухай хууль нь Ашигт малтмалын тухай хуультай хэрхэн уялдуулах шаардлагатай боловуу.</p> <p>10. Ялангуяа хайгуулын салбарт хөрөнгө оруулалт оруулж эхэлж байгаа компаниудад хууль эрх зүй, татварын таатай орчин бүрдсэнээр ИРЭЭДҮЙД ТОМ ОРДЫГ ИЛРҮҮЛЭХ БОЛОМЖ нэмэгдэнэ гэж харж байна. Хайгуулын компаниуд ашиг олдоггүй зөвхөн зарлага гаргадаг. Харин ордын нээлт хийж, уул уурхайн компани болсноор санхүүгийн байдал дээшилж, улсдаа татвараа төлөх чадамжтай, том компани болох суурь нь тавигдана. Эцсийн эцэст орд, газрууд нээгдэх тусам Монгол улсад ашигтай.</p> <p>11. Монгол орны томоохон Стратегийн том ордуудаас гадна Төрийн өмчит уул уурхайн компаниудын 34 хүртэлх хувийг Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр нээлттэй арилжаалж, олон нийтийн компани болгоход “Хөрөнгө оруулалтын хууль”-иар зохицуулалт оруулах нь дараах ач холбогдолтой. <i>а) МХБ-р дамжуулан хувьчилсанаар гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ, авилга, хүнд суртал буурна, ашигт малтмалын хулгай, хууль бус үйлдэл багасна, аливаа хууль бус ашиг сонирхол хумигдана, цаашлаад алга болно, компаны үйл ажиллагаа шилэн, нээлттэй ил тод болж ашиг орлого нь нэмэгдэнэ.</i> <i>б) Компанийн удирдлага, инженер техникийн ажилчдын мэдлэг, ёс зүй, ажлын чадвар, харуцлага нэмэгдэж, цаашлаад олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөнө.</i></p> <p>12. Эдийн Засаг Хөгжлийн Яам нь Сангийн Яам, УУХҮЯ, АМГТГ, Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллаж хайгуулын болон уул уурхайн төслүүдэд шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг МХБ дээр босгох тал дээр гүүр болж, холбогдох журмуудыг хамтран боловсруулж энэхүү хуулиар зохицуулах шаардлагатай. <i>Жич:</i> <i>Монголын Хөрөнгийн Бирж нь хайгуулын болон уул уурхайн компаниудын хөрөнгө босгох эрхийг нээсэн байгаа бөгөөд АМО-ын нөөц, баялагыг тайлагнах Канадын NI43-101, Австралийн JORC стандартыг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. 2014 онд Монгол улс нь ОУ-ын Нөөц, баялгийг тайлагнах стандартын хороонд (CRIRSCO) нэгдсэн бөгөөд олон улстай дүйх үндэсний MRC кодыг боловсруулсан. Улмаар МХБ нь</i></p>	
--	--	--	--

		<p>энэхүү кодыг албан ёсоор 2018 оны “Үнэт цаасны тухай бүртгэлийн журам-ын 13.2.2”-т тодорхой тусгаад удаж байна. Гэтэл АМГТГ, УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл (ЭБМЗ) нь Нөөц, баялгийг хуучины систем ёсоор бүртгэж давхар стандартыг хэрэгжүүлсээр байна. МХБ нь ЭБМЗийн бүртгэсэн нөөцийн тайланг хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь геологи, хайгуулын салбарын хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулсаар байна.</p> <p>Мөн түүнчлэн 2023 оноос МУ нь Ашигт малтмалын ордын хөрөнгийн үнэлгээний ОУ-ын CIMVAL, VALMIN кодуудыг хүлээн зөвшөөрсөн ба “Санхүүгийн зохицуулах хороо”, “Ашигт малтмалын үнэлгээчдийн холбоо” ТББ хамтран ОУ-тай дүйх MONVAL кодыг боловсруулж МУ-ын Үнэлгээний тухай хуулийн 5.2.4-т тусгасан бөгөөд 2023 оны 01-р сарын 01-ээс мөрдөж эхэлсэн. Энэхүү хуулийн заалт нь хэрэгжиж эхэлснээр МУ-нь Ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахын 4 тулд ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг ОУ-ын аргачлалын дагуу үнэлэх боломжтой болоод байна.</p> <p>Дээрхээс харахад Сангийн Яам нь “Үнэт цаасны бүртгэлийн журам-д бүртгээгдсэн, олон улстай дүйх хэмжээний дээрх 2 (MRC, MONVAL) үнэлгээний стандартуудын хэрэгжилтэд анхаарал хандуулж хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт тал дээр нь МХБ-тэй хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байна.</p> <p>13. Монголын Хөрөнгийн Бирж дээр Монголын үндэсний жижиг хайгуулын, уул уурхайн бусад салбарын компаниуд нээлттэй болсноор хөрөнгө оруулалт татаж, хөрөнгө оруулалтын найдвартай эх үүсвэртэй болж, олон нийтийн хувьцаат компани болж үйл ажиллагаа, компанийн засаглал сайжран, цаашлаад нэмэлт санхүүжилт босгох бүрэн боломжтой гэж харж байна.</p> <p>14. Монгол улсын хилийн зурвасын 15 км дотор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шаардлагатай.</p> <p>Эдийн засаг, Хөгжлийн Яам нь Батлах Хамгаалах Яам, УУХҮЯ-тай улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газраас бусад хилийн дагуух зурвас газарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Ашигт малтмалын хайгуул хийх эрхийг нээлттэй болгох хэрэгтэй.</p> <p>Өнгөрсөн зууны эхээс эхлэлтэй Монголын геологийн судалгааны ажлын үр дүнд Монгол улсын хилийн бүс нутагт ашигт малтмалын хувьд хэтийн төлөв өндөртэй, маш олон тооны орд, илрэлүүд нээгдсэн. Гэвч харамсалтай нь ихэнх нь энэхүү хязгаарлалтын бүсэд орчихсон. Тийм учир МУ-ын хилийн бүс нутагт шинээр ашигт малтмалын ордууд нээгдэх боломжтой.</p> <p>Хилийн зурвас бүсэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгосноор Монгол улсад дараах ач холбогдолтой. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Хилийн бүс нутагт дахь хайгуулын төслүүдэд гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Ажлын байр нэмэгдэнэ. 2) Орд нээгдвэл ашиглалтын мөн бүтээн байгуулалтын төслүүдэд мөн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Ажлын байр нэмэгдэнэ. 3) Ордууд ашиглалтад орж уурхай нээгдсэнээр тус уурхайнуудаас МУ-д орж ирэх АМНАТ-ийн хэмжээ нэмэгдэнэ. Ажлын байр нэмэгдэнэ. 4) АМНАТ-ийн хэмжээ нэмэгдсэнээр МУ-ын эдийн засгийн нөхцөл байдалд шууд нөлөө 	
--	--	--	--

		<p>үзүүлнэ.</p> <p>5) Монгол улсын дархан хилийн дагуух бүс нутаг эзэнтэй, хяналттай болж, хилийн дагуух бүс нутагт малчдаас гадна хайгуулчид, судлаачид, уурхайчид өөрсдөө хяналт тавьж эхэлнэ.</p> <p>6) МУ-ын зарим хилийн бүсийн дагуух бүс нутгийн эзэнгүй байдлыг далимдуулах аливаа албан тушаалтны хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлнэ, хилийн бүс нутагт хөрөнгө оруулалт орсноор хилийн бүс нутагт хөгжил ирнэ.</p> <p>Манай улс нь өөрийнхөө хилийн бүс нутгийн эрэл, хайгуулын судалгааг маш муу хийж байна. Хилийн тухай хуулиар энэ бүх судалгааг зогсоосон. Гэтэл БНХАУ-ын судлаачид манай хил орчмын судалгааг сонирхоод хийгээд байна. Дараах зургаас МУ болон БНХАУ-ын хилийн бүс нутгийн дагуу Хятадын судлаачдын хийсэн геологи, ашигт малтмалын судалгааны талаар гаднын томоохон сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллэгийг харна уу. /Сэтгүүлийн хэсгүүд/</p> <p>Энэхүү “Хөрөнгө оруулалтын тухай” хууль нь Эрдэс баялгийн хайгуулын салбарын жижиг, том компаниудад тэгш боломж олгох бөгөөд үүнийг дагаад дотоод болон гадаадын шууд хөрөнгө оруулалт бодитой хэмжээгээр нэмэгдэж, хайгуулын ажил сэргэж, улмаар Монгол улсад дараагийн Эрдэнэт, Оюу толгой болон Таван толгой шиг том ордууд нээгдэх боломж бүрдүүлэх тийм хууль байгаасай гэж хүсэж байна.</p>	
--	--	---	--